DOCUMENTA OIRATICA COLLECTA

Ойрад судлалын чуулган - VI

GaVaL.net

Ж.ЦОЛОО, А.МӨНХЦЭЦЭГ

УРИАНХАЙН ӨВ СОЁЛ

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

УРИАНХАЙ АНЧДЫН АН АВЫН СОЁЛ 15-96

Урианхайн туульчид 15

Урианхай туульчдын ан авын соёл 20

Туульчин, анчин, үзмэрчин гурвын түүх

Алтайн магтаал (аман хувилбар)

Алтайн хааны сан оршвой (тод-монгол хувилбар)

Урианхайн анчдын зан үйлийн соёл 38 - 96

Замаа цагаатгахуй

Зүүдээ манахуй

Далаар мэрэгэлэхүй, ховлог татахуй

Ганзага дуудуулах зан үйл

Ан гөрөөсний сан хэмээх судар оршвой

Анчдын ганзага нийлэх, эс нийлэх

Анд одохуй

Анчид олзоо тааварлан шинжихүй

Таван хар халзан

Ирвэс агнахуй

Цагаан тарвага

Онгон ганзагын тахил оршвой

Ангийн мах хуваахуй

Шорлогт орохуй

Ангийн махны хэрэглээ

Зэр зэвсэг = Буун соёл

Буугийн сангийн судар

Буугийн тухай дуун

Үнэгний ав, үнэгний сан

Үнэгний сангийн судар оршвой

Үнэг өвчихүй

Чоны ав, чоны сан оршвой

Бугын ан ав

Бугын тухай дуу
Туулай агнахуй, туулайн дуу
Мажаалай агнахуй
Аргаль агнахуй, аргалийн тухай дуун
Чихтэй (=хээрийн луус) агнахуй

Урианхайн анчдын авлах соёл 91
Нүхэнд унагахуй
Зээгт ав
Нохойг анд дасгахуй

Урианхайн анчдын харвах соёл 93
Сур харваан
Чөдөр даанж хах
Өтвөг
Ганз магнай
Тэмцээний хожил тооцохуй
Зүс хах
Том хах
Хамба суухуй
Урианхай үүшүүр тоглоом

ХОЁРДУГААР ХЭСЭГ

УРИАНХАЙ ТУУЛЬЧДЫН МЭДЛЭГ ОЮУН 97 - 422

Талын Харбодон тууль ба Цагаан шүхэрт судар 97

Талын Харбодон тууль 97
Таван бодонгийн тухай
Амин сүнсийг оршоох нь
Хэрэглээ
Бодон уу, үжин үү?
Гурван алтан шат, Гурван лустын орон
Есөн их гал
Хайр цагаан сэлэм
Аянгын цагаан сум

Урианхайн Талын Харбодон ба Махагала сахиусан 104
Талын Харбодон мөчлөг туулийн мотив 106
Газрын хөвгүүн довон Харбөх туулийн мотив
Тэнгэрээс заяатай талын Харбодон туулийн мотив
Талын Харбодонгийн хүү, гунан Харбоон туулийн мотив
Талын Харбодон тууль (хувилбар) 109

Цагаан шүхэрт судрын тухай 405
Монголын их эзэнт гүрний хаан төрийн нандин шүтээн
Хутагт цагаан шүхэр.
(XVI зууны үеийн Аюуш гүүшийн орчуулга)
Зонхов Богдын зохиосон Төгсгөлийн шүлэг
(Халх аялгуугаар)
Зонхов Богдын зохиосон төгсгөлийн шүлэг
(Сонгодог монгол хэлний бичгийн галиг)
Хутагт Цагаан шүхэрт хэмээх оршив.
(Ойрадын Зая бандида Намхайжамцын орчуулга)
Зонхов Богдын айлдсан төгсгөлийн магтаал шүлэг
(Ойрад-монгол аялгуугаар)
Ойрадын Зая бандида Намхайжамц хутагтын зохиосон
төгсгөлийн ерөөл
Арван гурван сан оршив.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

УРИАНХАЙ ТҮМНИЙ БИЧГИЙН СОЁЛ 423 - 486

Урианхай хэл аялгуу судалсан туршлага
Тод-монгол үсгийн цагаан толгойн урианхай дуудлага
Тод үсгийн дэлгэр толгой хэмээх номын тухай
Урианхай салбар аман аялгууны авиазүйн зарим онцлог
Үнэгний бие бүтцийн хэдэн нэр
Хавсралт 1. 436 - 485
Аюуш гүүшийн орчуулсан Цагаан шүхэртийн
худма-монгол хувилбар

Хавсралт 2. 486 - 529
Намхайжамцын орчуулсан Цагаан шүхэртийн тод-монгол хувилбар

Хавсралт 3. 530
Notes on mongol uriankhai vocabulary

Хавсралт 4. 540
Ж.Цолоо, А.Мөнхцэцэг нарын эрдэм шинжилгээний хээрийн судалгааны замын зураг

Төгсгөлийн үг 541 - 544

Номзүй 545

Товчилсон нэрийн тайлбар 546

FOREWORD

This book is a conclusion of first hand, painstaking data collection and research conducted separately by two people - J. Tsoloo and A. Munkhtsetseg. Dare I would assume that most readers would be familiar with J. Tsoloo. He is a senior researcher of the Mongolian language phonology and oral literature. He is an old timer researcher of the dialects of the Republic of Mongolia. A. Munkhtsetseg, is a junior researcher of the Mongolian language and the Mongolian language transcription and transliteration. Over the years and with persistent practice, she has become skilful in the transcription of the Mongolian language and the transliteration of its scripts. Both researchers share a sound knowledge of the Mongolian language and a deep love for the culture and tradition of their people. To compile this book, they have joined efforts and pooled together their knowledge and resources so that the scholars and students of Mongolia would benefit from the uniqueness of the materials gathered in this book. What sets this book apart is the amount of very valuable materials it contains about Uriankhai folklore. There exists very limited literature related to the Uriankhai ethnic group. This book fills this gap and makes a great contribution to the study of this Mongolian minority ethnic group.

The two researchers met coincidentally in 2007. A. Munkhtsetseg had just finished her field work in the same area that J. Tsoloo had researched during the winter 1971 and fall 1973. Most texts were collected in Munkhkhairkhan county, Khovd Province and Sagsai county, Bayan-Ulgii Province. As a result of their meeting, they decided to set up a project and edit these materials for a publication about the Uriankhai culture and traditions.

Both researchers used quantitative methods (mainly interviews) for data collection. Meeting people of the Uriankhai origin, hunters as well as singers, they collected stories, epic poems, and songs from a wide variety. All these materials were at first tape-recorded, then later on transcribed into manuscripts. Some archival manuscripts and sutras were also acquired and they accurately supplemented the oral sources. At this stage, I would like to invite the reader to pay a particular attention to the similarities between the sutra "Tsagaan shukhert", a classic of the

Mongolian literature, and a Uriankhai epic poem "Talyn Kharbodon tuuli", collected by the compiler in the 1970s. This book in fact provides two versions of the before mentioned sutra: its 16th century translation by Ayush Guush ("Khutagt tsagaan shukher") and the 17th century translation by Zaya Bandita Namkhaidjamts. The similarity between the classic sutra and this modern day epic poem is highlighted by the resemblance of the main character in both texts. This is seen as an indication of mutual influence between the Uriankhai oral (religious) literature and Buddhist texts, effect of Buddhism-Lamaism missionary activity in Mongolia (see Heissig 1973: 388, Moses 1977:119). In the present sutra, the Buddhist deity Mahakala has close similarities with the local hero, Talyn Kharbodon, declaimed by Uriamkhai bards.

Most of the collected manuscripts and sutras were either in the todu Mongol bichig (clear script) or in the Khudma-mongol bicig (classic Mongolian script). Naturally, the transcription of all the materials was essential in order to harmonize the book. In contemporary Mongolia, this is a delicate task because of difference in opinions regarding the transcription system.
This book is organised into a comprehensive scheme that plunges the reader into the life of the Uriankhai hunter. It provides him/her with literature related to the Uriankhai hunting culture. It lets us glimpse into the life pattern of its people. It does not however give a descriptive account of the Uriankhai hunting culture or explain the meaning beyond these hunting patterns. Thus before the reader plunges into this book to savour the beauty of the Uriankahi (oral) literature, it could be useful to provide few comments that would help understand the it's cultural context.

*

Who are the Uriankhai? The Secret History of the Mongols (SHM), makes mention of a people of the Uriankhai origin among the inhabitants that wandered the Mongol plateau well before the birth of Temujin, the future Chinggis Khaan (SHM §9, 12, 38, 97, 120, 170, 183). Were these people a single ethnic group or were there several ethic groups with similar ethnonym? Sources of Mongolian history are ambivalent. Nevertheless, when Temujin became a rather important chieftain among the turco-mongol nomadic tribes, some members of the Uriankhai ethnic group are reported to have joined his camp, not that of Jamuqa, Temujin's main challenger (SHM§120). Furthermore, the presence of cousins Jelme and Subudei, of the Uriankhai origin, in the core of the imperial army (SHM §125, 145, 170, 195, 199,

202, 211...) testifies to the confidence Chinggis Khaan placed in some of the Uriankhai people. The Uriankhai were excellent warriors because they were first of all hunters who manipulated bows and arrows as a survival skill. One can affirm that they were instrumental in the building of the Mongol Empire and Mongol identity. After the consolidation of the Mongol Empire and the formation of the imperial army, the Uriankhai, as most ethnic groups conquered by the Khaan, were incorporated into the imperial social system in units of a thousand. This system did not completely respect the ethnic configuration at the time of the foundation of the Empire. Rather the Emperor merged people from different ethnic groups and entrusted their leadership to his most trusted generals and close companions (= and nukhur). In other words, the leadership of the new imperial social system did not necessarily respect the tribal scheme (Sh. Natsagdorj 1972:12, 1974:47). Consequently, the Uriankhai did not exist any longer as an independent ethnic group. There was no more mention of them except when talking about the prowess of the Uriankhai generals in the imperial army (e.g. SHM §211...).

After the collapse of the Mongol Empire (1368), from China where they had established the imperial capital, the Mongols came back home exhausted. Kharakhorin was no more the backbone of the imperial political power. From this time forward, there existed not a single political entity to encompass all the Mongols. Former imperial army units, the tumen (10,000 people), logically became the social units with political equivalence to country or Uls (Mongol ulsyn tuukh III 2004:107). Clan became a reference for people regrouping. The Uriankhai re-emerged as one of the six tumen or countries that occupied Eastern Mongolia. These were not exactly the same Uriankhai as those of the 13th century yet, for some reasons, they bore the same ethnonym. This Uriankhai entity was more independent and established commercial relationship with the Chinese Ming (Mongol ulsyn tuukh III 2004:31,42). Furthermore, they became very active in the wars of hegemony over post Yuan Mongolia. At one time, they also virulently opposed the other tumen or Uls that constitute Eastern Mongolia practically destroying the emblematic yurt of Chingiis Khaan, the symbol of power legitimacy.

Following political alliances, migrations and wars of hegemony between Mongol princes in the 15th century, the Uriankhai lost a great deal of their independence. However a considerable group of them reappeared within the bigger confederation of the Oirat Mongol who migrated to the Altai mountain range, Western Mongolia,

in the 15th century. In 1449 indeed, Ecen, chieftain of the Oirat succeeded in gaining the Uriankhai support for his cause (Dalai 2006: 46) against the Ming and eventually against the other Mongol princes and their countries (=uls). Since the 15th century, the Uriankhai have inhabited the Altai region and are thus known in academic circles as the Altai Uriankhai to distinguish them from many other small groups of people scattered all around the Republic of Mongolia and the Tuwa Republic of the Russian Federation who also bear the ethnonym Uriankhai. Whether all these minority groups who bear this ethnonym are of the same origin as the 13th century Uriankhai is not evident. This book however is only about the Altai Uriankhai.

Today the Altai Uriankhai live in big groups in the Western Provinces of the Republic of Mongolia mostly in the Duut and Monkhkhairkhan counties of Khovd Province, and in the Bulgan, Altai, Altantsugts and Sagsai counties of Bayan-Ulgii Province.

*

What is the cultural context of the Uriankhai culture?
Way back before they inhabited the steppes and the Altai mountainous region, the Oirat in general and the Uriankhai in particular, were originally "people of the forest" as the name Oirat (oi:forest, (*a*)rd: people) suggests (Dalai 2006: 23). They originally inhabited the thick Northern Mongolian forest around the lake Baikal and lived mostly of hunting (Mongol ulsyn tuukh III 2004:42). The Secret History of the Mongols mentions them as hunters (SHM §9, 12) or smiths (SHM §97). This is logical as these people developed an economic activity according to their direct environment which was the forest. Later on the Uriankhai learnt the art of herding, following their migration into steppes and their contact with herders. They never however gave up the art of hunting. It is still a major livelihood of these people today. Understandably, the sustainability of this livelihood has always depended on a sound management of the vital resources which required some routines and a system. For the Altai Uriankhai, as well as for many other societies, such a systemic economic activity includes the conventional three managerial phases. These are the production of the resources, the distribution of the products and lastly the consumption (cf. Sahlins 1972). To each phase of the activity is linked specific patterns and it involves more actors than the protagonists alone. In the present case, there are generally more people involved in the hunting process than just the male individuals: what do women do in relation to hunting, with whom and how

do the hunters exchange the products of hunting, who eats which portion of the meat and why, what is the social position of the hunters? Answering these questions and many other similar questions would bring us far from the hunting spots and plunge us into the people's daily life.

The argument goes that the major economic activity of a society constitute one of the referential matrixes of its social organisation, symbolic system, language and art [cf. Malinowski 1984 (1922)]. In other words, it is the major economic system that constitutes the locus of a culture defined as whole "system of meaning" (Geertz 1973:5) For the particular case of the Uriankhai, it is in the hunting culture that one finds meaning to daily life metaphors.

It is told that when an Uriankhai groom goes to look for a bride, he is a deer and the bride is referred to as a sable. The whole wedding process is symbolically linked, at least in its language, to some aspects of the hunting activity. The same goes for the motifs in the Uriankhai art as well as their musical instrument, the sound of their dialects and theme of their songs. They are inspired by hunting. Another example is the fact that the Uriankhai people describe the Todu yceg alphabet signs with the game anatomic terms. The hunting experience appears to have inspired the aesthetic life of the Uriankhai. Hunting is not an isolated social activity rather it is a multidimensional catalyst that widely influence the Uriankhai society. The reader is called to go beyond the texts to understand the symbolism and reference to the ideals this society has set for itself.

In a very tangible way, this book exposes hunting as a culture (=system). It provides us with a glimpse on how the Uriankhai people themselves explain the origin of hunting and its subsequent rituals and oral literature. The story of the first hunt indeed explains what happened and who were the three main protagonists involved in the development and conservation of the hunting patterns. The three people mentioned, -the regular hunter, the bard-hunter and the fortune teller-hunter have developed a hunting scheme which over the years has become a pattern, in other words, a culture. A whole system has been shaped over many generations and accumulated into both practical and symbolic knowledge. This knowledge is first of all about hunting but also about the environment and many other aspects of social life. This knowledge is codified in order to be easily transmitted to future generations. The codified knowledge appears under different forms of which the oral literature is a component. The other media are: the rituals, entertainment (Naadam)

celebrations ...etc. This book provides a good sample of these media and suggests that hunting is the matrix of the Uriankhai culture where the people draw their signs and symbols, their metaphor and moral concepts.

Since hunting is not only about shooting games and providing the household with fresh meat, there should be more to it. Its rituals, epic poems, panegyrics and songs are also lessons about people's identity. The epic poems praise the heroes and worship the deities. Somehow, they answer the primal question (who are the Uriankhai, where did they come from) and the heroes quoted in the poems provide the people with the qualities required for an authentic Uriankhai individual.

Furthermore, in hunting, there are also taboos. They are not only about hunting but they also indicate the limits society has set for itself. They tell us less about the animals and more about the individual members of that society. Beside, these texts contain names and description of the fauna and flora of Altai. They are media of education. When taught to the children or when the later play an entertainment game that has clear reference to the hunting experience, younger members of the society learn about their society and its environment. More importantly, they receive their first lessons about their main livelihood.

A very last consideration I would like to put forward is connected to the way the hunting experience is displayed. This experience is presented in a relationship scheme of pyramidal shape. On one end there is the nature, on the other end there is the game and on the third end there is the hunter. On the top end of the pyramid there is the deity (Ulaan Bodon) that overlooks, through his deputies, the whole hunting activity and impartially protects the interests of all parties involved. The hunting culture is the codification of the experience acquired through these relationships. A further reflection would somehow indicate that after all, the negotiations in the hunting experience are between the hunter and the deity who provides the game through nature. The hunter influences the deity's mood with his prayers, panegyrics, incantations, libations, offerings and sacrifices and the later provides him with abundant game. In certain cases, the hunter needs the permission of the deity to kill an otherwise scarce and forbidden game (e.g. leopard). Such communication between the hunter and the deities passes through rituals and this book contains a good deal of literature related to rituals. This brings hunting, to use the classification by Durkheim (1921), at the edge between the profane and the sacred sphere. Most texts in this book would have a strong religious dimension.

Finally, the reader should pay attention to the technics of hunting and the related technology. The compilers have made a repertoire of those and they are part of the tradition of the Uriankhai people.

*

To conclude this commentary, I would like to say few words on the Uriankhai oral literature.

The texts recorded in this book were previously orally transmitted from one generation to the other. This is the main character of the Mongolian oral literature (Dulam. 2007:178). In the transmission process, genre and style, melody and rhythm, topics and names are faithfully preserved. They constitute the memory of the society which the poets loyally yet creatively keep and retell to the next generation who in turn transmit it further. The poet freely adds present and significant life events to the main body of the text, yet keeps the format generally the same. Thus the memory of the Uriankhai society was transmitted until today.

As for the Uriankhai dialect, what is special is the way the people pronounce and write its sounds. They use the roots of both the Khalkha and the Oirat dialects.

For the reader anxious to find out more about the issues related to the Mongolian oral literature, I would recommend a parallel yet recent work of Prof. S. Dulam (Mongol aman zokhiolyn onol, 2007) which gives an overview of the etat de lieu of the Mongolian folklore.

*

It is a great service the two compilers have rendered to Mongolian studies. Making available these texts will allow the development of new insights into the study of the Uriankhai folklore. Our hope is that in this 21st century where people who were far away have become closer than ever, communication becomes crucial. Yet there is effective communication when people confer meaning to each other. Yet sounds, signs and symbols that carry theses meanings belong to a bigger cultural context that is not always evident to grasp. When the larger cultural context is understood, meaningful communication leads to an encounter. This book allow us to learn a great deal about the Uriankhai people and thus to understand their cultural context. It is a contribution to bringing people together.

Moreover, these texts belong to the cultural heritage not only of the Uriankhai people but of the whole humanity as well. Having them in print allows a better conservation for future generations. As the Uriankhai themselves have done, for many generations passing on their culture from one generation to the next, we respect the same process yet in a different medium and this book would like to pass this knowledge to a bigger community of Mongolia and the friends of Mongolia.

Gaby Bamana
Ulaanbaatar, March 20, 2008.

1.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

УРИАНХАЙ АНЧДЫН АН АВЫН СОЁЛ

УРИАНХАЙ ТУУЛЬЧИД

Монгол аманзохиолын төрөл зүйл нь баялаг юм. Энэ баялаг аманзохиолыг үеийн үед хадгалж амьдруулагч нь ард түмэн болно. Авьяас билэг, цэцэн цэлмэг ухаанаараа шалгарсан аманзохиолчид, хэдэн арван мянган мөр шүлэгтэй монгол ардын жавхлант баатарлагийн тууль, олон сайхан дуу, үлгэр, шог хошин яриа зэргийг цээжээрээ хэдэн цаг, өдрөөр хүүрнэн хайлж, уран сэтгэмж баялаг сайхан уран хэллэгээр баяжуулсаар иржээ.

Монгол аманзохиолчдын ихэнхи нь бичиг үсэг мэдэхгүй боловч бичгийн хэлний онцлог, найруулга зэргийг аман аялгуундаа маш чадамгай хэрэглэсэн байдаг. Монгол аманзохиолчид үлгэр, тууль, бөөгийн дуудлага, шог хошин яриаг энгийн байдлаар хүүрнэн өгүүлэх, эсвэл толгой холбосон яруу сайхан шүлгээр хайлан унщдаг хоёр байдал байна. Монгол аманзохиолыг нилээд судалсан боловч аманзохиолчдын тухай бага бичсээр байна.

Сүүлийн хэдэн арван жилийн дотор монгол аманзохиолыг эмхтгэн судлах ажлыг эрчимтэй өрнүүлсний үр дүнд монголын өргөн уудам нутгийн өөр өөр хэл аялгуу, ахуй заншилтай олон ястны аманзохиол, аманзохиолчдын тухай нилээд хэрэглэгдэхүүнийг мэдэж байна. Энэ сан хөмрөгөөс монгол аманзохиолчдын тухай, тэдний аманзохиол хүүрнэн өгүүлэх, хайлан шүлэглэх аргын тухай, ялангуяа монгол аманзохиолчдын бий болгосон монгол аманбичгийн хэлний тухай шинжилгээ хийж болно. Энэ тухай үл өгүүлэн бичих нь; монгол аманзохиолчдын дотроос туульчид хамгийн авьяаслаг, эрхэм хүмүүс болно. Монгол туулийн хэл нь энгийн мөртлөө ярианы хэлний найруулгаас өөр, хэвшин тогтсон холбоо үг, өвөрмөц хэллэгтэй, гүнзгий утга санаа илэрхийлсэн байдаг. Туулийг өгүүлэхдээ үлгэр домгийн ярианы байдлаас ондоо, хоёр мянгаас зургаан мянган мөр шүлгийг цээжээрээ түгдрэлгүй яруу сайхнаар хайлан унщдаг. Монгол нутагт туулийг

зөвхөн баруун монголын урианхай, баяд, дөрвөдийн туульчид өгүүлэх нэмэгдүүлж, туулийн аялгуу, хэллэгийг баяжуулан, туулийн шүлгийн хэмжээ, хурдцыг хайлан уншихад таацуулдаг. Баруун монголын баатарлагийн туулийн шүлэглэлийн бүтцийг судалъя гэвэл хөгжимтэй хайлан хэлсэн туулийг эхлэн анхаарч үзэх ёстой. Жирийн байдлаар шүлэглэн хэлсэн туулийн нэг мөрийн тодорхой үг, гурваас дөрвөн үе байснаа хөгжмийн аялгуунд хайлсан туулийн үгийн үеийн тоо нэмэгдсэн байдаг. Хоёрдугаарт, ихэнхи туульчид тууль хайлан өгүүлэхийг өөрийн онцгой авьяас, чадварын хэмжээнээс жаахан хөндий байдлаар ойлгож, өөрт нь ямар нэг далдын ид, шид туслаж байна гэж боддог байсан, энэ ид шидийг бүрдүүлэгч нь товшуур хөгжим юм хэмээн боддог байжээ. Урианхайн үе дамжсан алдарт туульчдаас уламжлагдсан товшуур хөгжмийн тухай зан үйл, сүсэг бишрэлийн сонин сонин домог байдаг. Жилькэр туульчийн барьж туулиа хайлж байсан, толгой чихнээс нь бөс даавуу уяж, утаа хирэнд хуучирч элэгдсэн өвөрмөц хийцтэй (шанаган хуурын байдалтай) товшуур Ховд аймгийн Дуут сумын ард Рэнцэнгийнд байхыг 1971 оны өвөл үзэж билээ. Энэ Рэнцэн бол Жилькэрийн удмын туульчин. Рэнцэн залуу насандаа өвгөн туульчин Жилькэрийн товшуурыг барьж "Алтайн магтаал" хайлж, тууль хэлж байсан туульчин-анчин болно. Ер нь монголчууд хуур зэрэг хөгжмийг эрт үеэс нандигнан эрхэмлэж байсан тухай сонин мэдээ бичиг зохиолд үлдсэн байна. XIII зууны үеийн алдарт Аргасун арзанд согтоод ордны хуурыг гадагш гаргаж хонуулсны учир амь хороогдох болсон боловч хуураар цэцэн сайхан үг, аялгуу хуурдан амь хэлтэрч байсан тухай мэдээ Лувсанданзангийн "Алтан товч"-д байдаг. Архангай аймгийн Тариат сумын нутагт байсан Рагчаа гэдэг туульчин 1932 онд хувьсгалын эсэргүүчүүдэд баригдаж ирээд "Ганц настай Эрх хар" гэдэг сайхан тууль олон хоног хэлээд амь гарч байсан гэдэг. Хуур зэрэг хөгжмийн тухай уртын дуу халх монголд бий.

Жилькэрээс "Баян цагаан өвгөн", "Хүрэл алтан дөш", "Наран хаан хөвүүн" зэрэг таван тууль Ховд аймгийн Дуут сумын туульчин Чойсүрэн сурчээ. Долоон үеийн алдартай туульчин Жилькэрийн удмын туульчин одоо байгаа эсэхийг сонирхов. Жилькэрийн ганц лам хүү нас барсан гэнэ. 1970 оны зун Улаанбаатар хотод болсон урлаг, уран сайханчдын улсын үзлэгт Ховд аймгийн Мөнххайрхан сумаас баргил эрдүү цээл хоолойтой, ховорхон хэдэн тууль хэлдэг 38 настай Б.Авирмэд гэдэг туульчин улсын үзлэгт шалгаран

мөнгөн медалиар шагнуулж билээ. Б.Авирмэд бол Жилькэр туульчийн бага охин Оролмаагийн төрсөн хүү. Эцэг Баатар, эх Оролмаа нар нь айлаар явж, Баян цагаан өвгөн, Талын хар Бодон, Жаргал ихтэй эзэн улаан Бодон зэрэг тууль хэлэхийг Авирмэд хамт явж сонсдог байжээ. Төвдөд хүү нь эцгээ салахгүй даган явж, цагаа болоход үлгэрчин-гэсэрчин болдог байсан сонин уламжлалыг профессор Ю.Н.Рерих агсан тэмдэглэсэнтэй урианхайн зарим туульчдын уламжлал их л төсөөтэй болно.

Увс аймагт аж төрж байсан, уг нь хотон угсааны Хайнзан гэдэг туульчин ярихдаа "...би бага байхдаа эцгээ дагаж тууль хэлэхийг нь сонсдог байлаа. Хожим нэг мэдэхнээ аавын хэлдэг туулиудыг цээжилсэн байсан. Дуутай мөндөр хаан гэдэг туулийг аавaасаа сурсан" гэжээ.

Туульчин хүнд тууль хайлахад цээлхэн эрүүл хоолой, шүдний бүрэн бүтэн байдал, амьсгаа авах чадал нь уушгинаас түрэгдэн ирсэн амьсгааг гаргахад чухал хүчин болдог. Б.Авирмэд арваас хорин мөр шүлгийг эрмэг яруу хоолойгоор нэгэн амьсгаагаар тасралтгүй хөврүүлэн хайлах нь туулийн үйл явдлын сүр жавхлан, туульчийн тууль хэлэх эрдэм чадалтай хослон монгол ардын жавхлант туулийг сүрлэг сайхан яруу төгөлдөр болгодог. Б.Авирмэд тууль хайлахдаа хавсран хөөмийлж туулийн ая данд эвлэгхэн түрлэг оруулдаг нь туульчийн насан залуугийн ид хав байлаа.

Урианхайн туульчид тууль хайлахдаа гүйцэтгэдэг тогтсон журам байжээ. Энэ нь тууль хэлүүлэх айл туульчийнд очиж тууль хайлж өгөхийг *сонсгоод* туульчийн зөвшөөрснөөр товшуурыг нь тусгай даавуунд ороон боогоод гэртээ урьдчилан аваачиж хүндтэй байранд залдаг байна. Туульчин хүрч ирэхэд бүтэн даалимба, бүтэн цай, тамхи зэрэг *нэг толгой бараа* гэртээ оруулж, товшуурын чихнээс буюу толгойноос нь цагаан бөс уядаг байжээ. Тууль хайлж дууссаны сүүлд 3-7 хоног тэр товшуурт хүн гар хүрэх ёсгүй, гэрийн эзэн сүүлд туульчийнд товшуурыг хүргэж өгдөг нарийн дэглэмтэй байжээ. Товшуурын хялгасыг хурдан морь, азарганы сүүлний хялгасаар хийдэг байна.

Монгол тууль судлалд анхаарагдаагүй байсан нэг шинэ зүйл бол урианхай, баядын гарамгай туульчдын тууль хайлахын өмнө хэлдэг *магтаал*, туулийн төгсгөлийн *ерөөл* болно. Урианхайн туульчид туулийн өмнө "Алтайн магтаал" гэдэг магтаал шүлэг заавал хэлдэг. Энэ магтаалд алтай нутгийн уул, ус, алим жимс, ан амьтныг магтан шүлэглэдэг. Баяд туулийн өмнө хэлдэг

магтаал, урианхай туульчдын хэлдэг Алтайн магтаалаас ялгаатай. Урианхайн Алтайн магтаалд алтайн арвин их баялаг нь өнчин ганц анчин эр хүнд хишиг ивээлээ хайрла хэмээн наманчилсан хангай дэлхийн сахиус тэнгэрийг хүндэтгэсэн *анчин-туульчны* ангийн уриа дуудлага. Үүнд:

Хазаартай тавьсан моринд
Хагд өвс нь ойрхон Алтай.
Харийн ганц залууд
Өгөөмөр хишигтэй Алтай.
Өрөөлтэй тавьсан моринд
Өвс нь ойрхон Алтай.
Өнчин ганц залууд
Өршөөлтэй Алтай.
Өгөөмөр баянхан буурал
Алтай, Хангай хоёр минь л
Уралдаад явсан моринд
Хүслэнтэй сайхан
Хүдэр дөрвөн тах болсон
Баянхан буурал
Алтай, Хангай хоёр минь л
Уядаад, дандаад явсан залууд
Хүслэнтэй сайхан
Хүдэр дөрвөн багана болсон
Анчин ганц эрд хишиг буянаа хайрла
Баянхан буурал Алтай, Хангай хоёр минь л ... гэж яруу сайхан жавхлант тууль магтаал хайлж эхэлдэг.

Баяд туульчид туулийн өмнө хэлдэг магтаалдаа адал дөрвөн зүсэм мал, алтай өргөн нутгийн арван гурван ой шугуйг хэд дахин нэрлэж дуудан шүлэглэдэг. Баяд, урианхайн туульчдийн "оршил магтаал" алтайн *арван гурван* балар хар ой шугуй, *арван гурван* цаст цагаан уул, *арван гурван* гүрмэл хар уул, *арван гурван* ориг шаргал уулыг хэдэнтээ нэрлэн дуудаж *арван гурав* гэдэг тоог бусад тооноос онцолсон байдаг.

Урианхайн туульчдын ихэнхи нь анчин байсан, тэд анд явахын өмнө эсвэл анд явж байгаад хээр Алтайн магтаалыг хайлж, *алтайн эзэн Алиа хонгор* гэдэг далдын *сахиус тэнгэр*ийг урин дуудаж дэлхий ертөнцөөс хишиг буян

гуйдаг нь урианхай анчдын *амьтны шутлэг* болно. Сүлд шүтлэгийн эзэн Алиа хонгорыг урин дуудахдаа:

...Дайраад ирэх нас нь
Үрэн үргэлж
Хорин тав,
Хариад ирэх нас нь
Үрэн үргэлж
Хорин таван настай
Алтайн эзэн
Алиа хонгор нь
Алтан шаргаан [=энэ нь салхи гэнэ] *хөлөглөж*
Алтайн арван гурван
Цаст цагаан уул өөд
Хараад эргээд байна л гэж хайлдаг байжээ. Урианхайн туулийн оршил Алтайн магтаал бол урианхайн анчны *тэнгэрийг шутэх* зан үйл, ардын шашны соёлын шившлэг дом.

Бид энэ удаа урианхай туульчдын мэдлэгийг урианхайн нэгэн туулийн агуулга, урианхайн анчин-туульчдын ан авын соёлтой харьцуулж сурвалжлан мэдээлж байна. Ардын шашны олон тэнгэр нарыг аргадаж олз омог, хишиг буянаа хайрлахыг тэнгэрт даатган дуудсан анчдын аман уншлага, нутгийн ардын дууг Ойрад-монголын ан авын бичгийн яруу найрагтай зэрэгцүүлэн бичив. Баядын туульчдын уншдаг туулийн төгсгөлийн ерөөлд бурхан шашны уншлага хожим нэмэгдсэн бололтой. Энэ нь их учиртай. Яагаад гэвэл туулийн гол гол баатруудыг шарын шашны дээдбурхад юм гэж баядууд боддог болжээ.

УРИАНХАЙН ТУУЛЬЧДЫН АН АВЫН СОЁЛ

Хулан гөрөөсийг идэж
Хулгар тарвагаар зулам хийж
Худгийн усыг уугч
Урианхай түмний ан ав

Туульчин, анчин, үзмэрчин гурвын түүх

1971 оны 12 сарын 9. Ховд аймгийн Мөнххайрхан сумын төв. Туульч Баатарын Авирмэдээс Туульчин, анчин, үзмэрчин гурвын тухай домог, хууч яриаг бичив. Б.Авирмэд туульчин энэ домгоо "түүх" гэж нэрлэсэн юм. Б.Авирмэдийн хэлсэн түүхээс арай өөр хувилбарыг анчин Б.Уртнасан ярьсан нь:

Гурван хүн анд явжээ. Өдөржин уул хадаар хэсэж антай хөөцөлдөөд явсан боловч анчид нэг ч ан гөрөөлж чадсангүй гэнэ. Ямаан гөрөөс, янгэ, мануул таарадсан боловч гурван анчин хоосон буцаж хээр хоножээ. Хоёр, гурван өдөр гөрөөлж явсаар хоногийн газарт ирээд: - Бид гурвын ангийн ганзага нийлэх гүй байна. Бид салсан ганзагатай гурван анчин байна гэж бие биедээ гоморхон ярилцжээ. Гурван анчны нэг нь туульчин байжээ. Тэгээд унтахын өмнө сан тавиад "Алтай"-гаа магтжээ. Алтайн магтаал хайлаад дундаа орж байтал дүрстэй, дүрсгүй олон биетүүд бас маш жижигхэн намхан хүмүүс энд тэндээс гэнэт гарч ирээд туульчийн мөр, толгой, магнай, хөмсөг, уруул, эрүү, хүзүүн дээр нь шах цалдан суугаахыг үзмэрчин-анчин үзжээ. Туульчийн аргил сайхан ая дуунд тэд уяран, баясгалантай царайгаар чагнан чагнан суугаахыг үзмэрчин нь их эд саймширан өөрийн нүдэндээ ул итгэн олон биетүүд амьтдыг олзуурхан харжээ. Түн удалгүй хүн дүрст нэгэн биет гэнэт туульчны толгойн оройгоос бууж ирээд хамрын үзүүр дээр их эмсгээр залрав гэнэ. Бас үзэсгэлэнтэй ч юм шиг атлаа асха[1] доголон эм дүрстэй хийбод биет, туульчийн чихний ирмэг өөд шалмагхан авирч шээмсэглэсээр дүүлэн очоод суудлаа эзлэхийг үзмэрчин бас үзжээ. Тэр анчин нь үзмэрчин байсан байна.

1. өрөөсөн хөл нь доголон

Үзмэрчин-анчин эдгээр олон дүрс биетүүдийг хараад гайхаж суутал туульчийн чихэн дээр байсан нөгөө эм биет унах аасаа ихэд болгоомжлон унжгананн сарвалзан татганаж хахир яхир дуу гарган ярзайн инээхийг хараад гэнэт чангаар дуу алдан инээжээ. Туульчин:

-Юунд чанга инээв, чи! Чи намайг шооллоо! Би амьдарч ядах даа ан хийж, ангийн мах аар хэдэн улаан цурав[2] хүүхдээ тэжээх гэж яваа нүгэлт хар гөрөөчин. Чамд харанхүй бүрэнхийд юу үзэгдэв? Юутай нөгцөж донтсон долигүү чи? Чамаас л болж өнөөдөр үзэгдсэн ан алагдахгүй байна. Чи биднээс салсан ганзагатай хүн байна гэж үүрсчээ. Туульчин-анчин Алтайн магтаалаа хайлан хэлэхээ больжээ. Харанхүй бүрэнхийгээр гурвуулаа хэвээр газар сууж байгаад:

-Чи яагаад көк элкэ хатаж[3] инээв чи гэж дахин үүрсчээ. Тэгтэл энд тэндээс цугларсан олон хийбод биетүүд шуугилдаж:

-Энэ сайхан дууп яагаад сонсогдохгүй болов? Чамаас л боллоо. Чи яагаад чанга дуу гарав гэж туульчийн чихний ирмэг дээрээс дүүжлэгдсэн эм хүмүүн дүрстийг бас зандарч үүрсчээ. Туульчийн хамрын үзүүр дээр суусан өөр нэгэн биет амьтан:

- Муу самган чиний доголон хар бух аар чинь энэ сайхан сонин дуутай „эзэн"-ийг мялаан баярлуулна аа гээд цугларагсад шуугилдсаар тарсан байна.

Үзмэрчин-анчин хий үзэгдлийн тухай юу үзсэн, юу сонссоноо хоёр нөхөртөө „түүх" болгон өгүүлээд унтацгаасан байна. Маргааш гурван анчин ангийн замдаа гараад явж байтал уулын сүүдэр гоодаа[4] бууж жаргах нарны улаан туяанд буга мэт нэгэн хар амьтан сүүмэлзэн үзэгдсэнийг гурван анчны мэргэн бууч нь намнасан байна. Туульчин-анчин, үзмэрчин-анчин хоёр уралдан очиж үзвэл нэгэн сайхан хангал дөнөн хоо буга арван хоёр салаа эврээ дэрлэн дэрлэн соргог хар нүдээ ул мэдэг аньсан байжээ. Тэгээд гурван анчин „Арван гурван Алтайн эзэн, алиа хонгор минь алтан шаргаа хөлөглөж ирээд хишиг буянаа хайрлав" хэмээн намнасан бугын сүнс хишгийг хурайлан дуудаж, буга намнасан анчдын заавал гүйцэтгэх ёстой эрхэм зан үйлээ гүйцэтгэсэн байна гэв.

Монгол урианхайчуудын шүтдэг туульчин-анчны хайлсан тэр алдарт Алтайн магтаалын аман хувилбарыг туульчин-анчин Б.Авирмэдээс 1972 оны 12 сарын 10-нд Мөнххайрхан сум нэгдлийн зочид буудалд бичиж авснаа доор сийрүүлье.

2.нүцгэн. шалдан. хөрвөжөөгүй. хэнз нялх хүүхэд. curam-a: curba. čuraγ-a. нугасны цурав: цурав ногоо

3. элэг хөшихдтэсч ядталаа инээж элэгний тусаягүй болох elige kösikü

4. хүүштэх. намдаа. намдор

Алтайн магтаал (Аман хувилбар)

Ай даа
Өглөөд униартаж байдаг
Өдөр дунд суунаглаж байдаг
Өнтэй хүдэр баяхан буурал
Алтай Хангай хоёр
Дэлхийн өргөн нургайнэ (=нуруу нь)
Дүнхийлдэж байдаг
Дээвэр болсон хамрууд нь
Шунхийлдэж байдаг
Баяхан буурал
Алтай, Хангай хоёр минь гэвээ.
Ээ булаг ус нь ээ
Булаг хар ус нь
Булгилж урсалдаж байдаг
Бургас улиас мод нь
Найгаж гурван тал ганхаад байдаг
Болжмор сайхан шувуу нь
Жиргэлдэж байдаг
Өнтэй өгөөмөр
Баяхан буурал
Алтай, Хангай хоёр минь гэвээ.
Арын шар нурганууд нь
Дүнхийлдэж байдаг
Рашаан хар гол нь
Уралдаж долгилж байдаг
Арын хар мод нь
Саглайж байдаг
Рашаан хар ус нь булгиж байдаг
Арвин баяхан буурал
Алтай, Хангай минь
Үзүүрээр нь төгөөлөөд (=тойроод) явахад
Үнэгтэй байдаг

Үерхэж жаргаж явахад
Жаргалтайхан болон
Сэргэлтэйхэн байдаг
Хоёр гурвааraa агнаддаад явахад
Жаргалтайхан болон
Сэргэлтэйхэн байдаг
Өнтэй баяхан буурал
Алтай минь гэв гэнээ.
Арын урт шар нуруунууд нь
Уралдаж байдаг
Ужим шар дов нь
Дүнхийж байдаг
Аргаль угалз хоёр нь
Солбилдож явдаг
Антай арвин ууҗим
Алтай минь гэв гэнээ
Яран улаан хад
Дүнхэлзэж байдаг
Шилийн улаан ямаа (=янгир ямаа)
Шилээн даган
Шаргилдаж явдаг
Элсэн нуранги нь шоргилдож байдаг
Эмгэлж харгана саглардаж байдаг
Арын хөвд нь
Униартаж байдаг
Арц даган суунаглаж байдаг
Баяхан буурал
Алтай минь гэв гэнээ.
Булгийн усыг долгилуулж байдаг
Бургас модыг ганхуулж байдаг
Булжим ууҗим тохойнууд нь
Дүнхийлдэж байдаг.
Булга суусар хоёр нь
Солбилзож байдаг

Өнтэй баяхан буурал
Алтай минь гэв гэнээ.
Хад хамар болгондоо
Хаваржаатай байдаг
Хаврын гурван сард
Өн өгнөөд өнтэй гардаг
Баяхан буурал
Алтай Хангай хоёр минь гэв гэнээ.
Үе болгонд
Өвөлжөөтэй байдаг
Үзүүр тохой болгонд
Урин дулаан байдаг
Өвөл хавар хоёр
Өнтэй тарган гардаг
Тайван баяхан буурал
Алтай минь гэвгэнээ.
Хар салхи нь
Ханхинаж л байвч
Хавтгай нимгэн чулуу нь
Жингэнэж байвч
Хавар өвөл хоёрт
Өн өнөтэй тарган
Тайван гардаг
Өнтэй Алтай Хангай хоёр минь гэв гэнээ
Үен булга хоёр нь гүйлдээд,
Өнтэй тарган гардаг
Тэвэр тэвэр түлээтэй боловч
Гүрэнгээрээ амар амгалан гардаг
Тар тагшил түлээтэй байвч
Тайван амар амгалан гардаг
Ар биеийн айл нь
Айраг таргаа сөгнөөд
Өн тарган гардаг
Өвөр биеийн айл нь

Өрөмтэйгээ өгнөөд
Өнтэй гардаг
Баяхан буурал Алтай минь гэв гэнээ.
Өө ээ
Шилийн хөх ногоо
Найгалж явдаг
Шилийн хөхөө шувуу
Донгодож явдаг
Зулай болгон
Зуслантай байдаг
Зуны гурван сард
Цэнгэлтэй байдаг
Өнтэй баяхан буурал
Алтай минь гэв гэнээ.
Нарийн шар
Хулсан толгойлж
Намрын шинж ороход
Нахиу болгон намаржаатай
Намрын урт уужим гурван сард л
Жаргалтай байдаг
Өнтэй баяхан буурал Алтай минь гэв гэнээ.
Харзны усыг дагаж
Харгай бургас голлож
Тэр л өргөн нутаг
Түвширч байдаг
Түг түмэн олныг
Жаргуулж байдаг
Жаргал, сэргэгтэй
Баяхан буурал Алтай минь гэв гэнээ.
Багал (=хоолойн сахал) цагаан өвгөчүүл
Хоймор суурийн эхэнд
Бардам сууж замилаад
Загал цагаан эмэгчүүл
Зүүн суурийн эхэнд

Бэлхэнцэглэн суугаад
Аагтай улаан цайгаа
Уун су   уж хүүрнэлдээд
Хатуу хахир хар архиа
Балгалдан найралж жаргаад
Баал улаан хөвүүд нь
Хурга ишиг тууж
Хушуу үзүүр төгөөлж
Өлөн ширэг дагаж гүйлдээд
Жаргал, сэргэгтэй байдаг
Баяхан буурал Алтай минь л гэв гэнээ.
Өө ээ
Эр тэгш төрсөн
Тээм л тэгш залуу
Ган цагаан эрэгт
Бай тавьж буудалцаад
Урт цагаан урмыг
Миний болж тусав уу?
Чиний болж онов уу?
Би цэцэн
Чи цэцэн гэж хэлэлцээд явна.
Ангийн сайхан өдөрт явж л
Алтай өргөн шилд
Агналдаж явна л.
Жаргал сэргэл хийдэг юм гэж
Хэлэлцээд явна.
Сарын сайныг
Сахин хонон хүлээгээд
Өдрийн сайныг
Өнжин хонон хүлээж сууж байгаад
Өдрийн сайхан
Өнөөдөр боллоо бүшүү [=шүү] гээд
Өлзийтэй сайн өдрийг олж л
Ар талдаа

Агнаад гараад
Явдаг түүхтэй л.
Арын шар нуруу
Сундаралдаж байдаг
Азарга хар давнууд нь
Дүнхийлдэж байдаг
Арын хар модон
Саглайлдаж байдаг
Хорин хоёр салаатаа
Хоо хүрэн гулз (=угалз)
Хошуу тоомыг дамжин
Харгай модны
Ард орж
Хамар даванд
Сүүдэрлэж явдаг түүхтэй.
Анч мэргэн залуучууд
Ээм талыг барьж л
Энд тэнд
Суулцаад явна.
Тоом л замыг
Тосон тосон хүлээгээд байдаг.
Өө ээ
Орой болоод явна
Оройгийн сүүдэр
Татаад явахад
Ширүүн салхи
Гараад ирэхийн үед
Хоо хүрэн буга
Ар өмнөөн анир татаад
Сэрэт гэхэд
Салхи татан залгиад
Идээлгэнд ороод гарахад
Онч мэргэн залуучууд
Тосон торлогдоод

Суудаг нь энэ гэнээ л.
Хорин хоёр салааг нь
Халайж л суугаад
Хүргэж ирээд
Дөрвөн өндрийн [=хавирга] нь толгойг алдалгүй
Хаж л [=буудан] харвалдаад явна.
Хүрэн улаан буга нь
Гурав, дөрөв л харайн алслаад
Ширээлдэж зогсоод
Халиаж боддог нь энэ:
Хорин хоёр салаа эвэр минь
Хүгараад одно үү гээд
Хавирга биеийн
Зөвөөр нь хэбтээд одно.
Хажүү талдаа хэбтээд одно
Хар зандан буга
Арвин тарааланд [=амьсгаа хураах] гараад одно.
Анч мэргэн залуучуудын
Бахыг сайхан хангаад явна.
Гараа улайлгаж
Ганзагаа цусдаад
Анч мэргэн залуучууд
Заар болсон махыг нь
Буга хүрэн арьсыг нь
Бөгтөрөлдөөд ирнэ.
Хорин хоёр салаа
Эврийг өргөнө гээд л
Өмнөө барьж
Арвин гүрван чүлүүг
Цавх арлаж сангаа тавиад
Алтайн арвин
Их хайрханд баярлаж
Хашгиралдан дуулалдаад
Харин хариад

Явдаг гэнэ.
Арвин заяат
Баяхан буурал
Алтай, Хангай хоёр гэнэ гэнээ.
Өө ээ
Өмнө биедээн эргэлдэж
Өндөр сайхан харуустаа гарч
Агналдаад гарч явна.
Яран улаан хад
Дүнхийлдээд байна.
Нуранги, элс хоёр
Шаргилцаад байна.
Хад даваа
Униартаж байдаг
Харгана эмгэлж
Сэгсийж байдаг
Халиун харлаг тэх нь
Харгалдаж байдаг
Илдэн улаан ямаа нь
Шилээ даган
Шөргөөлдөж явдаг гэв гэнээ л.
Анчин мэргэн залуучууд нь
Хадын онийг барьж
Гүйлдээд явна.
Тосоод ирдэг газарт одож
Тоом үеийн нь [=уулын] барьж
Торлуулж сууж
Инээлдээд явна л.
Ялан улаан ямаанууд нь
Хад тоомын
Үеийг дамжилдаж
Халуун салхи сөрөн
Гараад явдагчиг
Энэ нь гээд

Анч мэргэн залуучууд
Хүлээж суугаад
Хүргэж ирүүлж байгаад
Халиун харлагаас нь
Хаж л буудаж
Намлалдаад явна.
Гараа улаалгаж
Ганзагаа цустаад явна гэв гэнээ.
Тал биеийг [=уулын] бариад явна.
Догшин хар тарваганы
Дошд эргэлдээд хүрнээ л.
Хоёр чулууг
Холболдуулаад тавинаа л.
Урт цагаан урмаан
Шургуулж дэрлүүлээд
Хүлээж хэвтээд
Догшин хар тарвагыг
Хаж намнаад
Үдээн хүнс хийнэ л.
Харин хариад ээлжилдэг
Халимтай (аа) [=халим өөх] л
Өнтэй л (өө)
Баяхан буурал
Алтай Хангай хоёр минь гэв гэнээ.
Өө ээ
Өрөөлдөж тавьсан моринд
Өвс нь ойр байдаг.
Өнчин ганц залууд
Өршөөлтэй байдаг
Хазаартай тавьсан моринд л
Хагд өвс нь ойр байдаг
Харийн ганц залууд
Арвин тэжээлтэй (байдаг)
Өнтэй баяхан буурал

Алтай гэв гэнэ л.
Уядаад дандаад явсан залууд хүслэнтэй
Хүдэр дөрвөн бахана болсон
Баяхан буурал Алтай минь ээ.
Уядаад дандаад явсан моринд л
Хүслэнтэй хүдэр дөрвөн тах болсон
Гүн их нуур долгиолж л байдаг.
Галуу шувуу жиргэлдэж байдаг
Өнтэй баяхан буурал
Алтай Хангай гэв л.
Ар бэлд нь
Арван гурван өндөр
Цаст дүнхийж байдаг
Рашаан хар харз ус булгилж байдаг
Баяхан буурал Алтай минь.
Арын арван гурван
Цастай цагаан ууланд
Үрин үргэлж эзэн болж
Өнгийж [=харж] явдаг
Дайраад ирэх насанд
Үрин үргэлж
Хорин таван настай байдаг
Ямаан янсаг[5] хоншаартай
Янсаг дөрвөн туурайтай
Өрмийн эр соёотой
Өрөлбийн аман
Өргөн эрүүтэй
Дунгийн дүгэрэг хамартай
Дуран авай хар нүдтэй
Хонхоон очир хоёр чихтэй
Суу сайхан дэлтэй
Суман сайхан биетэй
Сунгуу сайхан нуруутай

[5] янз хэлбэр сайтай овор дүр. янз маяг

Махан талдаа
Бат төрсөн
Сүүл талдаа
Өтгөн төрсөн
Сүвээ талдаа
Тэлүү төрсөн
Шүдэн талдаа
Тэгш төрсөн
Хөл талдаа [=хөлдөөн] хурдтай
Хөмсөг талдаа
Зузаан төрсөн
Аранз улаан
Унаган шинжтэй
Агт бүрний шинж байдал
Бүтэн бүрдээд төрсөн
Сайхан шаргаа хөлөглөөд
Алтайн эзэн
Алиа хонгор
Алтайн цастын
Цагаан ууландаа харив гэв гэнээ л.
Ар биедээ
Болгааж явдаг
Арвин их буянаа
Хайрлаж явдаг
Өмнө биедээ
Өршөөж явдаг
Өргөн их буянаа
Өршөөж явдаг
Өвөр дээрээ үр л садаа
Тэврүүлж явдаг
Өнтэй баяхан буурал
Алтай Хангай хоёр минь гэв гэнээ л.
Өө ээ
Алтайн эзэн

Алиа хонгор
Ар талдаа
Арвин их
Буянаа дэлгэж
Үхэлгүй мөнх
Үгүйрэлгүй баянаар явж
Дээрээс ноёлох ноёнгүй
Доргэдээс халдах дайсангүй
Амар тайван суух
Ужим баяхан буурал
Алтай Хангай хоёр минь

XVII зууны үеийн дурсгал байх магадлалтай ойрад-монголын нэгэн нутгийн аялгуугаар тод-монголоор бичсэн Алтайн магтаалын бичгийн хувилбарыг уншигч, судлагч нарт толилуулж байна.

Алтай хааны сан оршвой (Тод-монгол бичгийн хувилбар)

О-оос хоосон чанар болох:
Ма-аас эрдэнэ сав шим хотол төгсөхүй:
Хум-аас хүслийн таван эд өөрчилөнгөөр бүтэх:
Их амгалант самада барийн тахилга их бүтэх::
О ма о хум о ма о хум о-ма о хум
Гайхамшигтай тэнгэр орон, тэргүүтэн хан алтай
Эх дагинас олон нөхдөөр өглөгийн эзэн
Маний өргөгсөн
Энэ тахилыг туурбил үгүй
Энэ оронд өөд болоод зооглон соёрхо:
Товчилбол өөр өөрийн
Юу дурлаж хүссэнээ даатгаж.
Арван гурван Алтайг ариулмуй:
Гучин гурван Хөхүйг ариулмуй:
Сутай хан их нөхөд сэлтийг ариулмуй:
Дарви нөхөд сэлтийг ариулмуй
Агуйт нөхөд сэлтийг ариулмуй:

Уул мөрөн далайн элч бүгдийг ариулмуй:
Орны тэнгэр оддын
Эзэн бүгд ханах болтугай:
Сангийн адистидаар бид
Ёгозари нөхөд сэлтэд зэтхэрлэн үйлдэв:
Дайсан чөтгөрийг ариулан насан хийгээд
Цог учрал дэлгэрүүлэн үйлд:
Өдөр гурван удаа алгасалгүй харууслан үйлд:
Шөнө гурвантаа алгасалгүй цагдан үйлд:
Цааш явахад одож үйлд:
Нааш ирэхэд угтан үйлд:
Хадад авирахад шат болон үйлд:
Оронд суухад нөхцөн үйлд:
Живаа олон мөрт орон явахад
Хулгай дээрэм үгүй болгон үйлд:
Гурван орныг эрхэд минь хураан үйлд:
Хоёр хөлт хүний шидийг өг:
Дөрвөн хөлт адгуусын шидийг хайрла:
Бат сайн хуяг зэмсгийн шидийг хайрла:
Яруу дууны шидийг хайрла:
Яруу алдар хүчний шидийг хайрла:
Насан буян эдийн шидийг хайрла:
Зөөлөн асармагай нөхдийн шидийг хайрла:
Дээд хийгээд ерийн шидийг хайрла:
Хүссэнээ дууд:
Залбирлал хамгийг айлдан
Түйтгэр үгүй болгон соёрх::
Иву ядуу болоод хүссэн хэргийг минь
Дөрвөн зүгт хотол төгөс болгон үйлд:
Хүссэн бүгдийг хур мэт болгоод
Цагаан зүгийг тэтгэ: Тэнгэр минь:
Хүссэн хэргийг бүтээж:
Чандмань эрдэнэ мэт
Галбарас модон мэт үр жимс тогтоон

Цаг үргэлжид юу санасныг минь
Бүтээх болтугай::
Гайхамшигт огторгуй дахь
Таван юу луу мэт:
Дайч тэнгэр нөхөд сэлт хүнээс бүү хагац:
Цаст ууланд арслан нөхцөх мэт
Дайч тэнгэр хүнээс бүү хагац:
Буга арван сар болоод
Эврээ орхих мэт
Дайч тэнгэр хүнээс бүү хагац :
Загасанд усан нөхцөх мэт
Дайч тэнгэр хүнээс бүү хагац:
Луун дуу нөхцөх мэт
Дайч тэнгэр хүнээс бүү хагац :
Далайн тэнгэрт
Падма цэцэг ургуулах мэт
Дайч тэнгэр хүнээс бүү хагац :
Эцэг эх хөвүүнээ ачид инаглан асрах мэт
Дайч тэнгэр хүнээс бүү хагац:
Тэнгэр огторгуйд наран саран нөхцөх мэт
Дайч тэнгэр хүнээс бүү хагац:
Олон хүний дунд дайтан
Байлдахаас тийн ялгаруулан үйлд :
Дайч тэнгэр хүнээс бүү хагац:
Ертөнцийн харанхуйг арилгагч
Нар сарын хишгийг
Өлзийт орон энд өг:
Хүссэн хэргийг өгөгч
Чандмань эрдэнийн хишгийг
Өлзийт орон энд өг:
Эсүрүн хурмастан тэргүүтэн
Тэнгэрийн хишгийг энэ өдөр
Өлзийт орон энд өг:
Хүрд орчуулагч хаан тэргүүтэн

Хүний хишиг энэ өдөр
Өлзийт орон энд:
Баясгалан байгуулагч тэргүүтэн
Луун хишгийг энэ өдөр:
Өлзийт орон энд өг:
Хор өгөгч тэргүүтэн
Зохилын нэр байгуулагчийн хишиг
Энэ өдөр өлзийт орон энд өг :
Гэсэрийн зүг дарагч цэргийн хишиг
Энэ өдөр өлзийт орон энд өг:
Язгуур үндэс үргэлжлүүлэгч хөвүүн
Таван ачийн хишгийг
Энэ өдөр өлзийт орон энд өг:
Мэсээр үл даагдах
Бат сайн хуягийн хишиг
Энэ өдөр өлзийт орон энд өг:
Санасанд минь нэг агшинд
Хүргэж чадах морины хишиг
Энэ өдөр өлзийт орон энд өг:
Их хүчит ачилгын хишиг
Энэ өдөр өлзийт орон энд өг:
Их хүчтэй сайн дуутай нохойн хишгийг
Энэ өдөр өлзийт оронд энд өг:
Ариун явдалтай уран бэрийн хишгийг
Энэ өдөр өлзийт орон энд өг:
Хотол төгс цогоос
Тийн илагусан бурханы хишгийг
Энэ өдөр өлзийт орон энд өг:
Орон тэдний өлзий хутгийг олоод
Дайч тэнгэрийг нөхөдтэй нь залаж
Араасаа түшүүлэн:
Өмнөөсөө гэгээрүүлэн:
Цааш явахад үдэж:
Нааш ирэхэд угтан:

Шөнө гурван удаа цагдан
Өдөр гурван удаа харууслан үйлэд:
Өвчин ад их гай зэтгэр бүгдийг ариутгаад
Санасан хэргийг жавхлантай бүтээн үйлэд:
Үлэгсэн хийгээд дутагсан
Үйлэдүүрийн гэшүүн буурсан хийгээд
Миний үйлдсэн аймшиг хэдүй буй:
Бүгдийг хүлцэн соёрхо::
сарваа о ма-ги ла о о ма-ни пад-мээ о хум:
о о-а-па па-ца на ди:
оо базар па-ни хум пад:
Бэлгэ үлгэрээр чимэгсэн биетэй:
Барагдашгүй номд дүүрэх агч зарлигтай:
Балмад харанхуйг арилгагч сэтгэлтэй:
Баатар багшийн өлмийд биширэн мөргөмүй::
залбирмуй :: итгэмүй ::

Алтайн магтаалын энэ хувилбар, 21х8.2 хэмжээтэй болгомол цаасанд хулсан үзгээр хар улаан бэхээр тод-монгол үсгээр бичсэн 6 хуудастай. Монгол улсын Алтайн нурууны өмнө хэсэгт орших Ховд аймгийн Дарви сумын нутагт байгаа Сутай хан, Дарви, Агуйт зэрэг тайлгат уулыг тахих ад үншдаг тарни, сангийн ёслол, зан үйлийг дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Урианхай нар Тэнгэрийн хишиг, нар сарын хишиг, чандмань эрдэнийн хишиг, цэргийн хишиг, язгуур үндэс ур үгсаа залгамжлагч хүү, зээ, ачийн хишиг, хуяг мэсийн хишиг, унаа морины хишиг, ачлага малын хишиг, нохойн хишиг, ариун явдалтай бэрийн хишгийг орон дайдын эзэн савдаг сахиуснаас тайлгат энэ өдөр анд одох доо хүсэн гуйж залбирдаг (ашиг, олз, эрүүл мэндээ даатгадаг) байжээ.

УРИАНХАЙН АНЧДЫН ЗАН ҮЙЛИЙН СОЁЛ

Замаа цагаатгахуй. Урианхайн удамласан анчид цагаан сарын шинийн нэгний өглөө сайн морио унаад буугаа агсан үүрээд, хутга хэтээ зүүж, тогоо шанага, зангуугаа[1] авч, дайлин богцоо цай идээ, хүнсээр дүүргэж ганзагын сураа бүсэндээ хавчуулаад өмнө зүгт өндөрлөг уул, хамар дээр босгосон, цагаан сарын овоон дээрээ очиж ангийн сангаа тавьдаг. Энэ нь анд гарах бүтэн жилийнхээ *замаа цагаатгах* анчдын зан үйл болно. Сар бүрийн шинийн нэгэн, шинийн гурван, шинийн таванд анд явахад сайн өлзийтэй өдөр гэдэг. Шинийн хоёронд анд гарах хориотой, цээр өдөр болно.

Зүүдээ манахуй. Анд явахаас нэгээс хоёр хоногийн өмнөх өдрүүдэд хар ба цагаан зүсмийн гунжин гүүний сүүлнээс гурван хялгас тасалж авна. Тэр хялгасаа гурав гогцоолж зангидна. Урианхай эрчүүд цагаан буюу тод өнгөтэй алчуураар толгойгоо ороодог байсан. Энэ алчуур нь тэдний нэгэн зүйл малгай. Тэр алчуурынхаа баруун үзүүрт буюу эсвэл малгайныхаа бүчийн үзүүрт гурван хялгасаа зангидаад анчин дэрлээд унтдаг. Тэр шөнө анчин юу зүүдэлснээ зүүд тайлагч хүнд хэлдэг. Ангийн олз, олборыг анчинд зүүд тайлагч хэлж өгдөг. Сайн зүүд:

- Эмэгтэй хүнээс анчин юм авч зүүдлэх
- Эмэгтэй хүнтэй уулзаж зүүдлэх
- Усанд орох, гол гаталж зүүдэлбэл Алтай, Хангай, Хайрхан уулс, Лус савдаг ангийн олз омгоо хайрлаж анчныг ивээн өглөг, олзоор тэтгэнэ гэдэг. Яагаад гэвэл Алтайн эзэн савдаг эмэгтэй хүн, ус бол лусын орон байр гэж бэлэгшээсэн тайлалтай байдаг. Муу зүүд:
- Уулаас гульдаж унаж зүүдлэх
- Харанхуй нүх зүүдэндээ үзэх
- Хад асгатай учирах
- Улаан мах үзэгдэж зүүдлэх нь анчин хүнд муу, ан олз олдохгүйг ёрлосон муу совин гэдэг.

1. баавгай. мангис (дорго) зэргийг агнахад хэрэглэдэг нэгэн зүйл зэвсэг. занга ловушка: западня капкан.

Анд хамт явж байгаа анчин нөхдөдөө, наран мандсаны сүүлээр сайн зүүдээ хэлдэг. Хэрэв муу зүүд зүүдлэсэн бол морины хэлтэрхий тал хөх хомоол олоод *муу зүүдийг минь чи дааж, надаас холдуул* гэж тэр хотоолдоо шившин хэлээд хойшоо харсан нүхэнд хаяж чулуу шороогоор түгшиж дардаг. Үүнийг муу зүүдний *даруулга хариулга* гэдэг.

Далаар мэргэлэхүй, ховлог татахуй. Урианхайн анчид хонины дал шатааж, далчнаар ан авын олз омгоо таалгадаг байжээ. Туульчин-анчин Б.Авирмэдээс сонссон 41 шандастай[2] мэргэн шар гэдэг мэргэ, ховлогийн тухай аман домгийг сийрүүлье.

Соронзонгомбо хаан Цагаан дара эхийг залахаар ухаант мэргэн түшмэлээ явуулсан байна. Нэгэн байшинд өөрхоорондоо нь ялгаж таних ад бэрх, хэн нь хэнээсээ ул ялгарах, гоё сайхан 21 хүүхэн явж оржээ. Тэдний хэн нь жинхэнэ Цагаан дара эх болохыг таньж чадахгүй олон хоног өнгөрчээ. Мэргэн түшмэл дэмий л бодож шаналаад суух болсон байна. Нэгэн өдөр эзэн хааны эгч чавганцтай мэргэн түшмэл дотносож ярилцаж суугаад "Цагаан дара эхээс би адис авч мөргөл үйлдэж барьц өргөмөөр байна. Энэ 21 дагины аль нь цагаан дара эх вэ? Та, над зааж өгнө үү " гэж эрхэмлэн гуйжээ. Хааны эгч чавганц хэлж, зааж өгөх арга, боломж над алгаа. 41 шандастай, 41 хэлтэй Мэргэн шар гэдэг төлгө, бэлгэ манай хаанд байдаг юм. Цагаан дара эхийг таних тэмдгийг би, чамд заагаад өгвөл эзэн хаан Мэргэн шараараа намайг, чамайг хялбархан олж мэдээд чи, бидэн толгойгоо авахуулах болно гэжээ. Чавганцын үгийг хичээнгүйлэн сонсоод мэргэн түшмэл хэлсэн нь:

- Газар ухаж дээр нь дүүрэн устай хүрэл тогоо нэрж суулгана би. Газар нүхэнд хүрэл тогооны доор шавар баримал бариад дотор нь би орж сууна. Би нүхтэй эвэр чихэндээ углаж, хэлээ зэсээр бүрнэ. Та эвэр нүхээр Цагаан дара эхийн гоц таних тэмдгийг надад дамжуулж хэлээрэй. Таны дэргэд хэн ч байхгүй байна. Эзэн хаан хэнийг ч сэрдэхгүй гэжээ. Мэргэн түшмэл газар доорхи шавар нүхэндээ орж суугаад чавганцын юу хэлэхийг эвэр чихээрээ чагнаж суужээ.

Чавганц: - 21 хүүхний нэг хүүхний нь үүдэн шүдэнд ум хум[3] гэсэн хоёр үсэг байгаа. Тэр хүүхэн бол Цагаан дара эх мөн юм шүү гэж дамжуулсан байна. Мэргэн түшмэл Цагаан дара эхийг таньж олоод Цагаан дара эхийг оргуулан

2. амьтны шөрмөс

3. Бурхан шашны номд ум нь төрөх үхэхээс тонилгох. хум нь тамын хатуун хүйтэн зовлонгоос гэтэлгэж чадах хүчтэй гэжээ. (О.Сүхбаатар. 1997: 190)

аваачих гэж байгааг эзэн хаан 41 хэлтэй, 41 шандастай Мэргэн шар төлгөөрөө мэргэлж үзээд шавар биетэй, эвэр чихтэй хүн далайн ёроолд байна. Зэс хоншоортой хүн орон нутгаасаа Цагаан дара эх ийн таних тэмдгийг харийн хүнд зааж өгчээ хэмээн айлдсан гэнэ. Хаан тийм хүн манай нутаг оронд байхгүй, Мэргэн шар төлгө худал хэлэв хэмээн урж тасдаад усанд хаяж урсгасан байна. Мэргэн шар төлгө усанд урссаар ус ууж байсан цагаан халзан [=галзан] хонины аманд оржээ. Үүнээс хойш Цагаан халзан хонины баруун далаар мэргэлэх зан үйл дэлгэрсэн гэдэг. Бас тэр цагаан халзан хонины 41 хөх хорголоор мэргэлж ховлого татах зан үйлийн ёс үүссэн байна. Б.Авирмэд гарамгай туульчин төдийгүй бас сайн далчин, мэргэн ховлогчин байсан. Агнасан тарваганы дал, харьт чөмөг шатааж ангийн олзыг бас мэргэлдэг байжээ.

Далаар мэргэлэх тухай бичгийн хувилбар. Тод-монгол бичгийн *Далын бэлгэдэх тодорхой толь* гэдэг тод-монгол гар бичмэлийг Мөнххайрхан сумын үлгэрч С.Наадгай гуай хэлзохиолын хүрээлэнгийн тод-монгол номын сан хөмрөгт өгсөн юм. Х.Лувсанбалдан энэ судрын агуулгыг дараах байдлаар тодорхойлжээ. Энэ бичмэл судар таван зүйлтэй, эхний хэсэгт далны мэргэ хэрхэн үүссэн тухай домог байна. Үүнийг сийрүүлье:

Эрт цагт ариун сүүнээс гаралтай олон цагаан хонь далайд ус уухаар одов. Хонин сүрэг өөрийн дүрсийг далайн усанд туссаныг үзээд ижил маань байна хэмээн майлалдан өөд уруу гүйж явахыг Лусын хаан үзээд:

Адгуусны аймагт төрөл

Асар сүүнээс цагаан өнгөт

Ийм нэгэн хонь бөлгөө хэмээн магтан олон хонины өвчин тахлыг өршөөж хонины даланд нэгэн билиг цацав гэсэн домогтой. Энэ судрат Хонийг адилтган үзэх, Хонины далын дээр эзнийг билигдэх, Далны хайс /тогоо/ үзэх зэрэг сонирхолтой бүлэг бий.

Мэргэ төлгө нь ардын домын арга.

Дээр цагт маш олон таамаглалыг төлгөөр хэлдэг байсан. Чингис хаан гурван далаар их үйл хэргийнхээ ирээдүйг шинжиж шийддэг байсан. Дал бол монгол үндэстний ирээдүй төлөгчлөлийн хэрэглүүр байгаа юм. Дал бол өөртөө байгалийн эрчим хүчийг агуулсан яс юм. Дөчин хоёр чулууны ховлог, мэргэ төлгө бол тухайн хүнд сэтгэлзүйн чиглэл өгч хүний сэтгэлд нөлөөлдөг нэгэн

зүйл хэрэгслэл. Төлгө нааштай буусан бол тэр хүн уг үйлдлийг маш итгэлтэй хийнэ. Хүнийг жолооддог зүйл нь сэтгэл гэж Л.Түдэв эрдэмтэн бичсэн.

© 1. **Ганзага дуудуулах зан үйл**. 1971 оны 12 сарын 10. Мөнххайрхан сумын Б.Авирмэд ярьсан нь: Б.Авирмэд туульчин, урианхай анчдын Ганзага дуудуулах зан үйл, Манахаан тэнгэрийн тухай өгүүлсэн нь :

Манай урианхайд олонхи анчид анд явахаас өмнөх өлзий буянтай сайн өдөр Ганзага дуудуулж Манахаан тэнгэрийн сан туульчаар уншуулдаг байсан. Энэ бол Алтай магтуулахаас дутуугүй урианхайн анчдын зан үйлийн эрхэм ёслол. Ан гөрөөсний сангийн тод-монгол бичгийн бичмэл судрууд нь манай Алтайн урианхайн анчин айлын ангийн зэр зэвсгээс дутахгүй чухал шүтээн байсан юм. Ан гөрөөсний сангийн уншлагыг ахмад, нэр хүндтэй, тод-монгол бичиг мэддэг төрийн хар хүнээр бас дуудуулж байсан гэв. Энэ бичмэл судрыг уншуулж, байхад анчин арцаар сан тавиад :

Гөрөөсний хаан Арслангийн,
Шувууны хаан Гардийн,
Хурдан цагаан Зээрэний,
Саглагар шар Үнэгний,
Сэглэгэр хар Булганы,
Шийтгар хөх Чоныи,
Хулан цагаан Чихтэйн,
Сүр сүнс өршөөгтүн намайг !
Хамаг гөрөөсний эзэн хутагт
Манхан тэнгэрт залбирнам би.
Амь насаа алтан дэлхий,
Ангийн эзэнд даатганам би.
Өршөөж хайрлагтун
Цаглашгүй олон гөрөөсөөр
Дөрвөн ганзага юуг минь
Цусдаж өршөөхийг залбирнам, би хэмээн амандаа шившин

уншдаг байжээ.

Ойрад монголын анчид Газрын эзэн, Тэнгэрнэрээс ангийн хишиг гуйж, даллан дууддаг, энэ эрхэм ёслолын үед *Ан гөрөөсийн сан судар оршвой* гэдэг ном уншуулдаг байжээ.

༄ Ан гөрөөсний сан хэмээх судар оршвой

о базаар амирада гүндали:
аа хум маа о ум пади о маа хум:
би- да сарадаа дирми:
О еиа хосгүй болтугай:
Хоосны гарт тахилын газар дэлхий гармуй:
Бууны эзэд: Манзушири[1] Ямандака[2]
Энэ ариун сан тахилыг амсан соёрхо:
Ариулан тахимуй:
Хонгшим бодхи садва тэргүүтэй
Хир нугууд арилгагч
Бурхадыг ариулан тахимуй
Манзушири Ямандака тэргүүтэй
Дайсныг дарагчийн эздэд
Ариун тахил тахимуй:
Бие нь арслангийн бие мэт
Дуу нь луун дуу мэт
Нум нь Манзуширийн араншин мэт
Сум нь огторгуйн өд
Маши[3] нь луугийн хумсан мэт
Милтэ[4] нь луугийн цахилгаан мэт
Үе нь хир нугууд арилгагч
Оточийн эм мэт
Хорим[5] нь хамаг гөрөөсний
Өөрөө ирэхэд баригч
Бөктү арслан адил буй:
Тэд тэргүүтнийг бүрнээ бодонгуйрбаасу
Хүж тэргүүтэй элдэв зүйл
Эмээр ариулан тахимуй:

---

1. Зөөлөн цогт. Бурхны шашны дөрвөн их бодисадвын нэгний нэр.
2. Үхэр толгойтой. хүний биетэй. нүцгэн дагина тэвэрч суусан бурхан
3. Цахиур буугийн гал. бялтыг хавчуулж буудахад гал үүсгэх хавчуур төмөр
4. бялт буугийн гал
5. буугийн замаг

О ховасади шидам
Насны хутаг болтугай:
Хагархай амт минь: Та:
Харснаа өгөгч тэнгэр минь: Та:
Халтирхай хөлд
Тушаа өгөгч бологсон: Та
Тэнгэр минь өгөхөө өгөн соёрхо:
Гөрөөсний хаан арслан Та, бүгдээрт минь
Аманд өгөхөө өгөн соёрхо:
Шувууны хаан круди Та:
Аманд өгөхөө өгөн соёрхо:
Гөрөөсний хаан хараа хула[6] Та
Аманд өгөхөө өгөн соёрхо:
Атгар өвөрт аргалийн
Сүр сүнсүн гуйнам би:
Хуруй, хуруй, хуруй:
Саглагар шар үнэгний
Сүр сүнс гуйнам би:
Хуруй, хуруй, хуруй:
Хулан цагаан чихтээн[7]
Сүр сүнс гуйнам би:
Хуруй, хуруй, хуруй:
Саглагар хар булганы
Сүр сүнс гуйнам би:
Хуруй, хуруй, хуруй:
Шийтгар хөх бүртэг чоныг
Сүр сүнсий нь гуйнам би:
Хуруй, хуруй, хуруй:
Дөрвөн ганзагад
Нижээдийг ганзагалуулан соёрхо::
Дөрвөн зовхис

6. барс шиг бидэртэй. таван хумстай. өргөн цагаан нүүртэй. нэгэн зүйл араатан амьтан. гавшгай бөгөөд догшин
7. Луусын ойролцоо. цагаан хонгор зүстэй. нэгэн зүйл адуу. хулан чихтэй. (Я.Цэ. 1956.726)

Найман хязаараас гийгүүлж өгөн соёрхо::
Өлсөх ундаасах хоёрт минь
Өдөр бүгд авран соёрхо:
Явах ирэх хоёрт минь
Шат болгож залруулан соёрхо:
Чанагшаа одоход
Цаглашгүй их өлзийгөө өгөн соёрхо::
Гэрт гадаа
Үгүйг гийгүүлэн соёрхо::
Арван зүгээс асхамж ихтэй
Өлзий хутагаа өгөн соёрхо::
Амин насан урт бат болтугай:
Адал мал минь олон болтугай:
Алив санагсан бүгд төгс бүтэх болтугай:
Алт мөнгө биет Манахаан минь:
Ан гөрөөсний эзэн Манахаан минь:
Хамаг гөрөөсний эзэн Манахаан минь:
Хязаар үгүй явагч:.
Цөцөг гөрөөсөө өгөн соёрхо::
Цөцөг минь зөв гэвэл
Тогоонд үл багтах
Тодхоту үүдээр үл багтаж орох
Өвөртөний хишиг өгөн соёрхо::
Өгөөмөр Манахаан минь::
Өгчурахай (?) минь
Ариун цусыг арав хориор нь өгөгч
Хутагт Манахаан минь
Ходорахайны чинь цус
Тавь жараа өгөгч
Хутагт Манахаан минь
Орох гөрөөсөө олом жирэм
Төхөдгөр оруулагч
Хутагт Манахаан минь:
Тууж үл цөциг

Хязаар үгүй хулахагсан
Хадар үгүй дэлдэгсэн
Эвэр үгүй мүхирагсан
Үдэр үгэй сүүлдсэн
Гүйж үл болох хөх нохой-ээц:
Шилжиражи үл болох шар
Гөрөөсөө өгөн соёрхо:
Хуруй,хуруй, хуруй
Гөрөөс ан олон алагдах болтугай:: :: :: : ::
о-а о хум о о пазар амиради гүндали
Хиа хум ний о ииу ад о о
сүбидаа шүдади дирман сүбида шүдаадиа
о хиа хосумкү болтугай
Хоосон агаара бас сангийн эд
Хотол төгсгөсөн огторгуйн
Агаар лугаа сацуу болтугай::
О о ма о ми хум
Дээр хөх мөнх тэнгэр минь
Доор өтэгүн эх минь
Элдэв цалам барьж цаг үгүй
Их хишиг өгмүй
Манахаан минь гэж байнам би:
Дээшээ цацалаа барьж
Дэлхийн их хишгээ
Өг гэж байнам Манахаан минь
Цагаан дээжээ барьж
Цаг үгүй их хишгийг өгүхүй болтугай
Өгүхүйе сайхан зүстэйгээс нь хайрла:
Манахаан минь:
Тууж үл болох цөцигөөс хайрла:
Манахаан минь
Хажуугаар зөрөхү
Хийг[8] ариулж ацар Манахаан минь:

8. авч ир. ойртуулж өг

Буруу одохыг боож ацар
Манахаан минь:
Улаан өнгөтэй цалам барьж
Оготор хоншоортоос хайрла:
Манахаан минь
Цагаан дээжээ баримуй::
Цаглашгүй олон гөрөөснөөсөө хайрла:
Манахаан минь
Урьд хүний ганзагыг
Уланхайтлаа ганзагалуул:
Хойд хүний хормой доороос ганзагалуул:
Дотор муутын
Дотрыг андиталаан [=шантагатал] нь ганзагалуул
Сэтгэл муутыг [=атаат сэтгэлтнийг]
Шээс алдтал ганзагалуул:
Манахаан минь:
Олон зэмсэг минь үл хөдлөх юу билээ:
Урьд ганзага минь үл улайх юу билээ:
Манахаан минь:
Санаж суутал салгаж[9] өгмүй
Манахаан минь
Хашиж өгөгч Манахаан минь:
Хариу[=буцаж] явсныг эргүүлж өгөгч
Манахаан минь:
Саадагтай хүнийг саадтал
Сайн муу хүнийг цухалдтал хайрла:
Манахаан минь:
Урьд ганзагыг минь
Улайтал ганзагалуул:
Улс Монгол хуртал хайрла:
Хамгийн хаан минь:
Ши му паад зар лами
Төүлний енг мүү дээ балууган

9. ганзага нийлэх. ганзага салах үйл ажил. ан авд сэтгэл явдал зохицож мөр нийлэх: мөр салгах зан үйл

Эхэлж үүнийг уншаад
Есөн эрхтэд залбирлаа *хашаар* даллан
Шилүүс тус бэлхүүс буруу тус:: : ::
О о мади сади цулаа цулаа
Дирмаа дү крида
Мава мава мааши хуу мажи сава иия о о
Бурум бурум сава иия о
о бимүваа мадирээ о иину пад::
Гөрөөсний хаан Манахаан минь

Өргөх нь: шагаат өөх мах ихтэй, дөрвөн өндөр хавирга өргөх мах энэ бүй: Цагаан идээний дээж элдэв цалам хамаг зислын үүсгэр хийн төгсгөөд унших тарни :: :: :: ла гий о ла:: :: ::

Алт мөнгөн биет Манахан тэнгэрийг урин дуудаг сангийн судрыг 20х9 хэмжээтэй шугамгүй цаасан дээр хар улаан бэх ээр хулсан үзгээр тод-монгол үсгээр бичсэн байна. Ойрадын аль нэг нутгийн аялгууны дуудлагаар бичсэн учир зарим үгийг ойлгоход бэрх шээлтэй. Манахан тэнгэрийн дуудлага уншлага нь анчдын хамтран явж ангуучлахын олз омог олж ганзага нийлүүлэх ерөөлийн уншлага болно.

Анчдын ганзага нийлэх, эс нийлэх. Ганзага нийлэхгүй гэдэг нь гурван хүн анд явахад ан гөрөөс тааралдахгүйн гачаал, тохиолдсон ан алагдахгүйн зовлон, ан гөрөөсийг онилсон бууны сум онохгүй хадууран давж сум тэнэх буу баарах зэргийг хэлдэг. Үүнийг *ганзага харлах* гэнэ. Энэ тохиолдлоос анчид ихэд болгоомжилж Ганзага дуудуулж сангийн ерөөлийг анд явахдаа уншуулдаг байна. Салсан ганзагатай анчин гэж байдаг, тэр анчин нь бусад анчидтай анд хамт яваад ан гөрөөс олж намнадаггүй, зөвхөн ганцаараа явж ангуучилдаг гөрөөчин юм.

Анд одохуй. Урианхай анчид ангийн байрандаа хүрч очоод дөрвөн зүгт сан тавина. Ойрад-монголчуудын арван гурван сан, сүлд тахилгын *нэгэн зүйл сан нь ертөнцийн дөрвөн зүг*ийг шүтэх сүсэг болно. Гурван чулуу тулж тулгаа өрнө. Энэ гурван тулгын үүдэн зүгийн чулууг *боол* тулга [=харц хүний суух суудал]; зүүн гарын чулууг *хатан* тулга [=эхнэр хүний гэрт эзлэн суух суудлын зүг]; хоймор зүгийн чулууг *хаан* тулга [=гэрийн эзэн хаан хүний

эзэгнэн суух суудал] гэнэ. Ус үндаа бэлтгэж цайгаа чанана. Урианхай анчид чанасан цайгаа пор пор гэж дуу гарч оргилон буцлахыг бэлэгшээдэг. Яагаад гэвэл тогоонд ангийн олз олохын учрал тэмдэг дуу авианы дохио гэнэ. Тогоотой цай буцлахгүй удахыг муу гэдэг. Урианхай анчид андаа одохдоо хонины мөч буюу хэдэн хэрчим мах заавал авч явдаг. Хүйтэн хошуутай ямаа, тэмээний мах авч явдаггүй. Хонь, үхрийн махаар эхний өдөр шөл хийж *улаан идээгээр* тогоогоо тослодог. Анчдын ахмад настай нь цайны дээжээс Алтан дэлхий, Манахаан тэнгэр, Газар, Лусын эзэнд цацал өргөж:

Гучин гурван Хурмаст минь:
Арван гурван Алтай минь:
Сан болсон уулууд минь:
Сангарцаг болсон дов жалга минь:
Ширэм болсон асга хадууд минь:
Жиргэр цагаан түнгэ жэрс минь:
Дав давын дархинууд[10] дара эх минь
Булаг булгийн чойжингууд[11] минь
Сайртай нүцгэн хөлөөрөө
Тэнэж явсан [=өссөн] нутаг минь
Өршөөж хайрлагтун, Хайрхан гэж шившин уншдаг. Анчид хамтран:

Бурам амттай бүркэнээсээн[12]
Бурцаг шүдтэй тарчаасаан[13]
Булган хар мөндлөөсөөн[14]
Дэлтэй хөх чононоосоон
Сортой улаан үнэгнээсээн
Арван хоёр салаа бугаасаан
Алаг эрээн жирхнээсээн
Хайрлагтун хайрхаан хөөрхүүм:
Цөөг хайрхаан Цөөд хайрхаан гэж Манахаан тэнгэрээс ан гуйж шившдэг.

10. Гэтэлгэгч dar-a: Унанги том мод
11. Номын сахиулсан. ном тэтгэгч: Ламын шашны бөө
12. Гурван наснаас дээшхи эр тарвага: бөзлог. бурхи
13. тарвага. бөзлог зэргийн амьтны гурван нас хүрсэн эм нь тарчи. тарч
14. тарвага. бөзлогийн зулзага

Дараа нь өөр нэг анчин:
Бороогоон, боож хайрлагтун:
Хураан хумхиж хайрлагтун:
Алтан дэлхий минь:
Авралт хайрханууд минь:
Унасан унаагийн минь хамгаалагтун:
Энэ биеийг минь өршөөгтүн:
Амь насыг минь хамгаалагтун: Хайрхаан:
Өөд газарт түшиж явагтун:
Уруу газраас татаж явагтун:

Цөөг хайрхаан Цөөг хайрхаан гэж Хангай, Дэлхийгээс аврал гуйж хэдэн жижиг цагаан чулуунд шившин хэлээд чулуугаа нар ургах зүгт цацдаг үүнийг задын хариулга[15] гэнэ.

Анчид олзоо таавarлан шинжихүй. Цацлаа цацаж, цай унд хоол хүнсээ идэж уугаад, анхны гарах эхний замд ямар амьтан тааралдсанаар хойшдын ангийн олзоо шинжин хэлэлцдэг Цагаан цайвар шар зурам тааралдахыг бэлэгшээнэ. Үнэг тааралдахыг муу ёр, ан ав олдохгүй, анчны амь насанд цовтэй гэдэг. Тэр үнэгийг алдаггүй цээртэй. *Цээр гаргах хариулга* нь анчин дээлээ тайлаад захыг нь доош харуулж, дээлийн дотор буюу үсийг нь гадагшаа гаргаж гурав сэгсрээд өмсдөг домтой. Энэ нь анчинд учирч болох бороо, цас, аянга, цахилгаан, салхи, шуурганаас хамгаалахыг аргадсан гай тэнгэрийг зайлуулж холдуулах дом гэнэ.

Таван хар халзан. Нохой зээх (Gulo gulo), өмхий хүрнэ (Bnstela putoris), дорго (Meles meles), ирвэс (Panthera pardus), мануул (Felis manul)-ыг таван хар халзан ан гэдэг. Энэ таван хар халзан анг сайн мориор хөөх цээртэй, сайн эр цохиж алах цээртэй, анч хоточ сайн нохойгоор хөөлгөх цээртэй, мэргэн тусгалтай цэцэн буугаар буудах цээртэй. Нохой зээхийг нохойгоор мөрдөж хөөлгөхөд муухай үнэртэй хортой хийгээр унгадаг. Зээхийн өмхий үнэрт цасны өнгө шарлаж мөрдөн хөөсөн нохой унгасны үнэрт нь хордож толгой нь дийж мансуурдаг. Таван хар халзаныг агнах муу, хар мөртэй ан гэнэ.

15 Бороо хур, цас, цасан шуурга орох зэргээр тэнгэрийн байдал гэнэт хувирах үзэгдэл

Ирвэс агнаж буудах болбол *Би эзэн ноён, тэнгэр сахиусны зарлигаар Таныг алах гэж байна шуу, хайрхаан* гэж амандаа шившдэг. Ирвэс алсан анчин ангаасаа буцаж ирээд гэртээ оролгүй холхон газарт, ирвэсийн дүрс хайчилж жаран хоёр нүхлэх эсвэл улайтгасан халуун төмрөөр жаран хоёр удаа цоохорлон цоолож хуйхлаад ангаас буцаж ирсэн зүгт долоон алхам зайнд ирвэсний сүг дүрсийг босгож сум үгүй буугаар буудаж зүүн хөлөөрөө тийрч унагадаг домтой. Ирвэс алсны тоогоор ирвэсний хайчилсан сүг дүрсийг тийрэх дом хийдэг. Эмэгтэй хүн, анчин хүн, сайн бөх хөлөөрөө аливааг тийрэхийг ихэд цээрлэдэг. Буян хишиг гундан зайлж хийморь сүлд доройтно, үр удам тасарна гэдэг. Зарим урианхай анчид эсгийгээр мулиа ташуур хийгээд намнасан ирвэсээ ташуурддаг. Энэ нь ирвэс намнасан анчин өөртөө тохиолдож болох муу явдлаас бие сэтгэлээ засаж ариусган хамгаалах дом гэнэ. Ирвэсийг хар мөртэй хатуу ан хэмээн *зөөлөн нь хатуугаа дийлдгийн* учир шалтгаанаас үүссэн *зөөлөн эсгий*, ташуураар *хатуу ан* малиачин ирвэсийг номхтгож болно гэсэн анчин иргэдийн нэгэн хар арга засал, дом болно.

Цагаан тарвага маш ховор ан. Цагаан тарваганы үс нь цагаан ямааны үс шиг байдаг юм. Цагаан тарвагыг буудаж алах цээртэй байсан. Хавханд орсон цагаан тарвагыг туламлаж өвчдөг. Цагаан тарваганы туламласан арьсанд алсан ан бүрийн хумс, хоншоор, алт мөнгө, зэс, будаа тариагаар дүүргэж хадгалдаг. Алс хол аян замд одох эзэн хүн цагаан тарваганы арьсан туламтай ангийн дээж эд мөнгөө гаргаад гэрийнхээ үүдэнд халуун ам бүлээрээ "гадны хүн үгүй" цугларч хурайлан: *худалдаа хийхэд минь, бүтэмжит үнэт олзоо өгөн соёрх* хэмээн аян замын хишиг буянаа дууддаг байжээ. Тэгээд онгон ганзаганы тахил сан уншуулж цайлцгаадаг уламжлал урианхайд одоо байна.

Онгон ганзагын тахил сан оршвой

о раках о хум ::
о сав сади шидим
Нэрт цагт күрү сүрпа падма самби багш:
Эрхэт л бякар дадийн хаанд
Эрдэнэт шүлэг зарлигаар онгон ганзагы нь тахиж :

Эрхэн тансаг жаргалангийн
Сайн мөр нээхүйн тул
Элдэв буян хишгийн ганзага тахиж :
Энэ тив эзлэгсэн буй:
Дээр Тэнгэрийн хаан
Эсүрүн Хурмаст тэнгэр хотол төгсгөсөн:
Амь насны цог жавхлант
Буян хишигт ганзагын хишиг ирэн соёрхо:
Дорд зүгийн Лусын орноос
Анди сан балин тэргүүтэн
Лусын эдлэхү жаргалант
Буян хишгийн ганзага ирэн соёрхо:
Цаданги шар пээ тэргүүтэн яках-шийн
Хүчингүйн буян хишгийн
Ганзага ирэн соёрхо:
Цэцэн мэргэдийн мэргэн жаргахын
Буян хишгийн ганзага ирэн соёрхо:
Сайтар төгс эрдмийн
Буян хишгийн ганзага ирэн соёрхо:
Баатруудын өлмий зоригт
Буян хишгийн ганзага ирэн соёрхо:
Балинт олон олзот эд таваар
Мал адгуусны
Их хүчит хурдан морины
Буян хишгийн ганзага ирэн соёрхо:
Бууршгүй буян хишгийн
Ганзага ирэн соёрхо:
Үдэлшгүй өлзий хутгийн
Буян хишгийн ганзага ирэн соёрхо:
Худалдаа хийгээд үнэ гүйхү (=хүрэх)
Буян хишгийн
Ганзага ирэн соёрхо:
Их хүчит ламын
Хурдан даллаганы

Буян хишгийн сан ирэн соёрхо:
Онгон ганзага хийгээд
Өлзий буян хишгийн ганзагын
Эзэд нөхөд сэлтэд
Гэрэлт: зул шатаан
Хэрэгтэй үг-тарни өгүүлмүй би
Хэлэх үг нь: "*их олзын хишиг өгөн соёрх*:"
Үнэрт хүж шатаан
Үнэн үг өгүүлмүй: би:
Үргэлж их олзын хишиг өгөн соёрх:
Ариун арц шатаан
Адисту үг өгүүлмүй: би:
"*Аливаа олон олзын хишиг өгөн соёрх*:"
Амтат идээ бэлдэн
Ариун үгээ өгүүлмүй: би:
"*Арвин их олзоон*
Хишиг өгөн соёрх:"
Тунгалаг тахил бэлдэн
Тустай үг өгүүлмүй: би:
"*Турвил үгүй олзын хишиг өгөн соёрх*:"
Төрөхөд үе төгсгөн
Оногсон түгээмэл
Их олзын хишгийг ганзагал:
Үүсэгсэн хишиг төгс өлзийт
Энэ эмээлийн минь
Онгон ганзага түшиж
Буянт их олон гөрөөс
Ганзгалуулан соёрх:
Хир үгүй [=ивээлт] их олон олз ганзгалуулан соёрх:
Эелтэй сайн энэ эмээлийн минь
Онгон ганзагад элдэв олон
Олз гөрөөс ганзгалуулан соёрх:
Бүдэрхий бүүрэгтэй эмээлийн ганзагад
Бүрэн олз хишгийг ганзгалуулан соёрх:

Өргөн суудалтай энэ эмээлийн минь
Онгон ганзагад бүдүүн
Олон олз ганзгалуулан соёрх:
Харвахад минь хавтас өргөн энэ эмээлд
Хамаг их олз ганзгалуулан соёрх:
Энэ эмээлийн минь
Онгон ганзагад харилгүй
Олз гөрөөс ганзаглуулан соёрх:
Хээр хоноход дэр бологсон:
Хэрцгий дайсанд түшиг бологсон:
Хэцүү газарт түшлэг бологсон:
Энэ эмээлийн минь
Онгон ганзагад хэрэгтэй
Олон олз гөрөөсөө ганзгалуулан соёрх:
Аа гайхамшигт Хан тэнгэрийн сүлд заяач:
Хаан Газар, Усны эзэд минь
Олон олз гөрөөсөө ханатал өгөн соёрх:
Дээрээс минь ивээгч:
Дэргэдээс минь тэтгэгч:
Сайн жаргалант хишиг
Өлзийг өгөгч Та бүгдээр:
Энэ онгон ганзагад минь
Бузар болсон байвал ариулан:
Хахир харш болсон бөгөөс
Өлзийт болго:
Будангуй бузар болсон бөгөөс арилган:
Хариу [=хараал] харш болсон бөгөөс номхтгогтун:
Гуйлга хийгээд
Худалдаа хийхэд минь
Бүтэмжит үнэ олз олгон соёрх:
Ав аян хийхэд
Аливаа гөрөөснөөс золгуулан соёрх:
Гэрт суухад хишиг буянаа дэлгэрүүлэн соёрх:
Гадна явахад хэрэг үйлийг бүтээн соёрх:

Нураг талд одохуйд
Учир үйлийг бүтээн соёрх:
Хэрцгий дайсныг хэлбэргүүлэн соёрх:
Хорт дайсныг хоцролгүй даран соёрх:
Атаат дайсныг алан соёрх:
Өшөөт дайсныг өмхөрүүлэн соёрх:
Хар санаатныг хагацуулан соёрх:
Хатуу санаатныг шаналгаж соёрх:
Хамаг зориг үйлийг бүтээн соёрх:
Харах бүрийг хайрлан соёрх:
Өнгө бүрийг өгөн соёрх:
Хагархай аманд минь халис өгөн соёрх:
Ундах [=ундаасах] аманд минь ундаан хийгээд
Олон идэш өгөн соёрх:
Онгон ганзагы минь олзоор хангаж:
Орох гөрөөсийг номхноор учруулан соёрх:
Найман ганзгы минь цусаар ханган соёрх:
Ямбар бээр олон гөрөөсийг учруулан соёрх:
Хүсэл бүрий минь хүртэн соёрх:
Гүн их олзын хишиг
Хутаг орших болтугай:: :
О сарваа мангиола:: :

Эсрүн хурмаст тэнгэрийг тахиж ан гөрөөсөөр ганзага милааж хайрлан соёрх о хэмээн наминчлан ан авын буян хишгийг даллан ганзагын олз дууджээ. Тууш шугамтай цаасанд хар бэх, хулсан үзгээр бичсэн 20.3x8.4 хэмжээтэй бичмэл судар болно.

Ангийн мах хуваахуй. *1971 оны 12 сарын 11-12.Мөнххайрхан сумын төв.* Б.Авирмэд, Б.Уртнасан нар үргэлжлүүлэн өгүүлсэн нь: *Манай урианхайн анчид, нэг ангийн махыг арван хэсэгт хуваадаг. Үүнийг арван мөч*[17] *мах ан гэнэ. Ямар арван мөч мах ан бэ гэвэл хоёр хаа, хоёр гуя дөрвөн мөч мах, баруун зүүн хоёр хааны дөрвөн өндөр хавирга тус тус хоёр мөч мах, өвчүү нэг мөч мах, ууц нэг мөч*

17. Малын махны хуваарь: арван хоёр мөч мах нь дөрвөн хөл мөч. ууц 2 мөч. сээр хүзүү тус тус нижгээд мөч (Я.Цэ. 1956.347)

мах, сээрүүд нэг мөч мах, хүзүүнүүд нэг мөч мах. Өвчүү, элэг, уушги, зүрх, амин хүүү, багалзуурыг хамтаар нь сугалж авсаныг зүлд мах гэнэ. Энэ зүлд махыг ангийнхаа арьсны хамт анчин өөрөө авдаг. Зүлдэлсэн махнаасаа хэсэглэн огтолж хатаагаад, цагаан тарвагаины буюу эсвэл даллагын илгэн савандаа хадгалдаг. Энэ махыг даллагын хишиг өглөг мах гэнэ. Ангаа өвчөөд махаа ганзагалж тэгнэхээс өмнө ирсэн хүнд мөч махнаасаа хувь өгдөг. Үүнийг шорлогын мах гэнэ.

Шорлогот орохуй. Анчнаас насаар дүү хүнд гуя ба гуяны махнаас огтолж шорлогын шороотой гуя, май автан, авагтун гэж хэлээд өгдөг. Анчнаас ахмад, ахимаг насны хүндтэй хүн ирвэл ууц буюу ууцны махнаас нь шорлого хувь болгож түгээнэ. Тушаал хэргэмээрээ ах зах хүндтэй хүнд сээр ууц хоёрын хоорондох нуруу яс, нэг нугалам харцага буюу харцаганы махнаас нь хэсэглэж хувь болгож өгдөг ёстой. Ангийн махнаас хувь хүртээгсдийг шорлогот орсон хүн гэнэ.

Ангийн махаа тэгнэж ганзагалсны дараа ирсэн хүн, золби хайсан эрэлчин хүмүүст шорлого түгээдэггүй. Яагаад гэвэл ангийн ганзага сэтлэнэ цээртэй, ан солжир болно гэдэг. Анчид анхны ангийн мөч махаа тэнцүү хуваалж авдаг ангийн арван махны баруун хаа "мөч" махыг хүнд өгдөггүй. Баруун хааг буян хишгийн онгон ганзаганы мах гэдэг. Даллага дуудуулах, даллага авахуулах ёслолд хонины баруун хааг хүндэт идээ, даллагын шүүс гэдэг байлаа. Хүзүүг бас хүнд өгдөггүй, хэрэг явдал, ажил үйлс сунжирна, ангийн мөр холдоно гэдэг. Сээр "мөч" махыг хамт явсан анчдадаа өгнө. Ангаа өвчөөд гэдэс дотрыг нь цэвэрлэх үед гүзээний бөөжийг тусгай нүхэнд булах буюу эсвэл хойшоо харсан мухар нүхэнд залж, шороо чулуугаар сайтар таглдаг. Цэвэрлэсэн гүзээг сэгсэрдэггүй хаданд цохидоггүй, өөжний шавхруунг нь гараараа шувтарч цус нөжийг нь нохой, үнэг, хээрийн амьтанд идүүлэхээс нууж булдаг домтой. Ангийн гүзээг үлээдэггүй, ан догшироно. Сүрэг малд чоно, нохой эргэнэ гэдэг. Гүзээг нь усаар зайлж хатаадаггүй, гэрийн эхнэр гүзээг цэвэрхэн газар өлгөж эвэрдэг. Урианхайчууд цагаан идээ, айргийн тос, түүхий өрмөө гүзээлж хадгалдаг.

Ангийн махны хэрэглээ. Урианхайн анчид буга, аргаль, ямаан гөрөөс зэрэг тураг ангийн махыг мөч мөчөөр[18] нь эвдээд гэрийн зүүн багсанд байдаг

---

18. мөчлөх: мөч. мөчөөр нь хуваах

цах хэмээх модонд дүүжилж хагсаадаг. Ангийн махыг тогоо дүүрэм бялхсан усанд чанаж сайтар болгодог. Буцалж байгаа ангийн махны шөлөнд ус нэмдэггүй, цээртэй. Ангийн махаа шүүрхий болгодоггүй, цээртэй . Туулайн (Lepus) мах, янгирын (Ibex) мах, хойлог шувуу (Tetraogallus)-ны махаар нярайлсан эх хүнд шөл хийж уулгадаг байсан. Нялхарсан биеийг түргэн чийрэгшүүлдэг. Чоньın (Canislupus) шөрмөс, шагай, хэлээр ардын хар дом засал хийдэг. Хүдрийн (Moschus moschiferus) заар, бугын (Cervus) эврийг эмчилгээнд хэрэглэдэг байсан.

Зэр зэвсэг = буун соёл. Алтайн монгол урианхай анчдын ангийн гол зэмсэг нь буу болно.

Буу цэвэрлэхүй. Урианхайн анчин-туульчин Б.Уртнасан өгүүлсэн нь: *Урианхай анчид анд явахын өмнөх нэгэн өлзийтэй сайн өдөр үнэг, чоно зэрэг амьтныг хайчилсан эсгий, бэс дурсийг малын хороо хотныхоо захад босгосон мануухайд өлгөөд хий бууддаг. Үүнийг буу хах /хаах, буудах/ буу цэвэрлэхүй гэнэ. Энэ бол дом юм. Ямар учир зориулалттай дом бэ гэвэл нэгдүгээрт ангийн хишиг олз дуудаж, хоёрдугаарт анд явсны хойгуур мал сүрэг хөнөөх зэрлэг араатан чоно нохой юмс сэргийлж хамгаалахыг сахиус сахидаг, тэнгэрт даатгасан даатгал болно.*

Буу гаарахуй[19]. Анд явж байгаад буу гаарлаа, ан гаарлаа гэж ярилцдаг. Ямар нэгэн анагнаад алсан ангаа буруу өвчих, салсан ганзагатай анчинтай хамтран анд явах, алсан ангийнхаа шорлог махнаас хэн нэгэнд илүү их өглөө дөө би гэж харуусан харамлаж сэжиглэснээс, бас тааралдсан ан гөрөөсөө (анчид) булаацалдан буудацгааж, бие биетэйгээ өрсөлдсөн атаа хорон хомхой сэтгэлийн учир буу баардаг. Ан гөрөөсийг ойрхноос буудаад ч буу онохоо больж, ан алагдахгүй ангийн олзгүй дэмий тэнүүчлэн сэлгүүцэхийг буу гаарч баарснаас болов гэж хэлэлцээд нэгэн зүйл дом хийдэг Энэ дом нь анчид бууныхаа аман доор аргалын цог чулуун дэр тавьж дээрээс нь арц, эсвэл давс нэмж уугиулан буугаа зөв гурав, буруу гурав зургаан удаа тойруулж ариутган буугаа амаар нь гурван зүгт газар тогшиж домнодог. Энэ нь буу баарах, ан ав гаарахуйг арилгадаг ардын хар дом болно. Баарсан бууг улаан идээ: мах, цус; цагаан идээ: айраг, тос; ногоон идээ: цагаан зандан, агар, арц, цагаан хөх агь; хар идээ: архиар ариулж тахидаг.

---

19. буу баарах: буу гал авалцан дуугарахгүй болох, сум тэнэх, замаг гацах: буугийн гал үл авалцах

Буу мялаахуй. Урианхайн анчид буугаар тарвага гөрөөс, үнэг, буга, чоно алаад бууны сум оножж туссан ором газраас гарч байгаа цусанд бууныхаа амыг гурван удаа хүргэж алсан ангийхаа цусаар буугаа мялайдаг. Удам дамжсан гарамгай мэргэн буудагч нэг урианхай анчин өвгөн: *амь нь сайн гараагүй буга, чоно, үнэг, аргаль, ямаан гөрөөс, чихтэй /хулан/, мажаалайн /хүн хар гөрөөс/ амьсгалд нь бууныхаа ам, бууны шийрийг хүргээд бууныхаа бөгс хундагыг бүрэн цусдан мялайж бай* хэмээн залуу анчдад захидаг байсан гэв.

Буугийн эзэн тэнгэрийг тахиж ариулах ёслолын үед *Буугийн сангийн судар* хэмээх ном уншдаг.

Буугийн сангийн судар

Аа о хум хэмээн гурав өгүүл:
Хамаг Тэнгэрийн зохиосон
Хан эзний зэр зэв
Буугийн тэнгэр айлдаж
Энд өөд болон бол ::
Эх тэнгэрийн зохиосон
Есүкээ тэнгэрийн зэр зэв
Буугийн тэнгэр энд өөд болон бол ::
Хөх Мөнх тэнгэрийн зохиосон
Хөрст алтан дэлхийн эзэн
Буугийн тэнгэр энд өөд болон бол
Хөх төмрөөр хийсэн
Бат модон хундагат:
Баатар Тэнгэрээс сахиустай:
Барагдашгүй зэвсэг
Баатар хүний зэр зэв
Буугийн тэнгэрийг ариулмуй:
Гэдгэр төмөр машиту:
Гэмт хортон хийгээд
Дайсан бүхнийг дарагч:
Гэсэр хааны зэр зэв
Буугийн тэнгэрийг ариулмуй::

Каадүр модон билтэт:
Газар хөдөлгөгсөн дуут:
Гал бадрагсан цахилгаант:
Гадаад дайсан хийгээд гөрөөсийг алагч:
Буугийн тэнгэрийг ариулмуй:
Хатан төмрөөр хийсэн
Хар дарь идэштү:
Хайлмал хорголжин сумту:
Хан эзний зэр зэвийг ариулмуй:
Хад ивтү (нэвт) дуутай:
Хамаг дайсан хийгээд
Гөрөөсөн бүхнийг эрхдээн хураагч:
Буугийн тэнгэрийг ариулмуй:
Уран хүний хийсэн
Уул ивтү дуутай:
Олон дайсан хийгээд
Гөрөөс араатан:
Гөрөөснийг учируулж өгөгч:
Буугийн тэнгэрийг тахимуй::
Хөх луу мэт дуутай
Хөвчин дэлхийн гөрөөс хийгээд:
Араатан бүхнийг алагч
Буугийн тэнгэрийг тахимуй ::
Хатан төмөр эрхэдээ хураагч
Буугийн тэнгэрийг ариулмуй::
Цагаан зандан: агиру: арц:
Цагаан хөх аги: тос:
Гурил:мах:цусун:архи:
Айраг тэргүүтнээр тахимуй:
Энэ тахилыг зооглоод
Буугийн шидийг өгөн соёрхо::
Гансурул үгүй аялан дайлалдахад минь
Хортон дайсныг минь дарж өг ::
Авлан одухуйд минь

Алив араатан гөрөөснийг учруулж өгөгч:
Матгар төмөр машитай:
Мах цусун идэштү:
Марал бугыг алж өгөгч:
Буугийн тэнгэрийг тахимуй::
Хөх луу мэт дуутай:
Хөвчин дэлхийн гөрөөсөн хийгээд
Араатан бүхнийг алагч:
Буугийн тэнгэрийг тахимуй::
Хатан төмөр хайлшаар хийсэн:
Хан Богд эзний зэр зэв:
Хамаг дайсан хийгээд:
Гөрөөсөн араатан бүхнийг алагч
Буугийн тэнгэрийг тахимуй::
Гэдгэр төмөр машитай:
Гэмт дайсан хортон бүхнийг дарагч
Гэсэр хааны зэр зэв:
Буугийн тэнгэрийг тахимуй::
Хөх луугийн дуун мэт дуутай:
Хөвчин дэлхийн гөрөөсөн
Хортон бүхнийг дарагч:
Харлиг тэнгэрийн бүтээсэн:
Хан эзний зэр зэв:
Хамаг дайсан хийгээд:
Гөрөөсөн бүхнийг:
Эрхэдээн хураагч:
Буугийн тэнгэрийг тахимуй::
Алт мөнгөөр хийсэн:
Арван зүгийн хааны зэр зэв:
Аливаа хортон хийгээд:
Дайсан тэргүүтнийг дарагч:
Буугийн тэнгэрийг тахимуй::
Ганагар төмөр машиту:
Галаар үүдсэн:

Гани сумаар нээсэн:
Гажирхсан хүнд тус болгогч:
Буугийн тэнгэрийг тахимуй::
Болдоор хийсэн бут ивтү дуутай:
Хатан төмрөөр хийсэн:
Хад ивтү дуутай:
Уран хүний хийсэн:
Уул ивтү дуутай:
Олон гөрөөсөн хийгээд:
Араатан бүхнийг эрхэдээн хураагч:
Буугийн тэнгэрийг ариулмуй: о-маа хум
Энэ мэт тахиснаар
Аялан мордоход минь
Хүн морь туслаж өг:
Буугийн тэнгэрийн сан дуусав :: : ::
Харин үгүй болтугай::
Цаглашгүй адистидын:
Гурван эрдэнэ хийгээд:
Цагаан уснирту газрын эзэн:
Таныг тахигсанаар зохидхуйн:
Шилтгаан ба бүрин тэргүүтэн
Цагаан буян арвидан
Дэлгэрэх болтугай:: : :: о ма-ги о ла.

Буугийн тухай дуу. Анчид буугаа эрхэмлэн хүндэтгэж магтан дуулсан дуу урианхайд байдаг. Бидний сан хөмрөгт байгаа анчдын буу зэвсэг унаа хөлгөө магтсан арав гаруй дуунаас түгээмэл дэлгэрсэн нь *Буга биетэй халтар* хэмээх дуу юм.

Буга биетэй халтар

Буга биетэй халтарыг
Асхан үдэшдээ сойно
Буулин баригсан бүргэдийг
Баяхан Алтайдаа талбина

Зандан хундагтай *замардгаараа*
Захалж гарсныг нь буудъя.
Заяаны ганц аакийгаа
Аль насандаа мартах билээ!
Сэндэн хундагтай *сэрэгсээрээр*
Сэрвээж гарахыг нь буудъя
Сэтгэлийн ганц аакийгаа
Аль насандаа мартах билээ!
Арцан хундагтай *алвитаарааraa*
Арвайлгаад гарсныг буудъя.
Аятай дагиныи аакийгаа
Аль насандаа мартах билээ!
Харгай хундагатай *хавлаараар*
Харлаад гарахыг нь буудъя
Хайрлаж өсгөсөн аакийгаа
Аль насандаа мартах билээ
Бургасан хундагатай *урмаараа*
Бултайгаад гарахыг нь буудъя.
Буянтай дагинын аакийгаа
Аль насаараа мартах вэ

Ойн иргэд, өөлөг урианхайн анчид замардаг, сэлэгсээр алвитаар, хавал, урам зэрэг нэртэй галт зэвсэг цахиур буу ган авдаг хэрэглэдэг байжээ.

Үнэгний ав, Үнэгний сан. Алтайн урианхайчуудын нутагт үнэг ыбэг. Урианхай анчдын амьжиргаанд үнэгний арьс хөрс үнэтэй түүхий эдийн нэг болно. Алтайн улаан үнэг, гурван төрлийн хар үнэг, мөн цагаан үнэгний арьс гүйлгээ сайтай хятад, орос худалдаачдын наймаа арилжааны нандин ховор бараа байжээ. Гэвч урианхай анчид Үнэгний ан авыг шунахай хорон сэтгэлээр хийдэггүй. Үнэг ангуучлан мэгнэдэг эртний удам дамжсан анчдынхаа ёс заншлыг сайтар сахиж мөрдсөөр байна.

Туульчин Б.Уртнасан надад ярьсан нь: *Алтайн монгол урианхайн нутагт хар үнэг байдаг. Манай нутагт гурван өөр зүстэй хар үнэг байдаг. Энэ нь тосон хар үнэг, усан хар үнэг, хөөн хар үнэг болно. Хөөн /хөө шиг/ хар үнэг намнасан анчин, утаатай хурмаи /эгий/- аар үнэгний дүрс хайчлаж долоон алхам*

зайтай газарт модонд өлгөж тогтоогоод буугүй сумаар буудаж өшиглөн унагаадаг. Хөөн хар үнэг намнасан анчин энэ зан үйлийг заавал хийж байсан. Хөөн /тас/ хар үнэг таарaлдвал анчны хувь заяанд муу гэж заавал буудаж алаад өмнө өгүүлсэн хариулга даруулга хийх ёстой гэдэг байсан. Яагаад гэвэл манай урианх айчууд хөөн хар өнгө, цул хар өнгө муу гэдэг. Сайхан тосон хар үнэг таарaлдвал ямар нэг аргаар буудаж намнаад туламлаж өвчөөд эдийн хишиг буян хураах даллагын сав тулам хийж, хүнд үзүүлэлгүй хоймрын авдрандаа нууи хадгалдаг, их баяжиж, мал сүрэг өсдөг гэж ярилцдаг юм. Усан хар үнэгийг галт хар ч гэнэ. Маш ховор ан. Усан хар үнэгтэй нутаг нурганд цас бага ордог, өнөтэй өвөл болдог гэнэ. Усан хар үнэг алахыг цээрлэдэг. Яагаад гэвэл усан хар үнэг / Галт хар/ үнэг бол тэр нутаг уулын эзэн, савдаг нь юм гэнэ. Алтайн урианхайчууд үнэг гэж хэлэхээ цээрлэж араат гэнэ. Зарим урианхай анчин үнэгийг хар мөртэй хатуу ан гэж байлаа. Иймд үнэг агнаад арьсын нь туламлан өвчөөд дөрвөн хөлий нь өвдөгний үеэр нугалж шөрмөсий нь огтолж тасалж оршоодог нь чоно нохойны гэнэтийн халдлагаас сүрэг малаа харсан хамгаалах дом хариулга гэнэ. Эсгий бөс даавуу хурга ишигний арьс хөдсөөр үнэгний сүг дүрс хайчлаад хүүхдийн орны хаpалдаа гэрийн унинаас оосорлон дүүжилж унжуулдаг. Ойрад-монголчууд үнэгний сүг хайчилж эрх танхи хүүхэд саатуулдаг. Хүүхдэд ханиад томуу, тагшуур хүрэх мөн айж цочиход нь үнэгээр домнодог. Үнэгний сан нэртэй тод монгол үсгээр бичсэн уншлага домын ном урианхай айл тахидаг байжээ.

☯ Үнэгний сангийн судар оршвой

о-маа о хум, уу-ма о а хум
намо хутагт Манзушрид мөргөмүй:
Би дээр Тэнгэрийн хүү сангийн мандалд[20]:
Гурван зуун жаран Тэнгэрнэрт
Буртаг үгүй бүлгээ:
Хэрэв буртаг болбаас
Мандалаар тахин ариулмуй:
Огторгуй, тэнгэрнэрийн мандалд[21]

---

20. Эд тавaap халгалах газар, хүү сан: Таван өнгийн няндар хадаг. бас онголж сэтэрлэсэн таван хошуу мал. таван тарианы дээж зэрэг олон зүйл өргөл: Тэнгэр. сахиус. лам. бурханд зориулсан тахил тавиглал
21. Юмны өнгөн талын ерөнхий түвшин: бүрхэвч. Далайн мандал. сарны мандал. газрын мандал. усан мандал (усан бүрхэвч). агаар мандал (хийн бүрхэвч)

Гурван зуун жаран догшин:
Ододту буртаг үгүй бүлгээ:
Хэрэв буртаг болбоос
Мандалаар тахин ариулмуй::
Дор лусун хаадын мандалд:
Гурван зуун жаран
Лусун хаадад буртаг үгүй бүлгээ:
Хэрэв буртаг болбоос
Мандалаар тахин ариулмуй::
Зүүн үүд [=юуны үүдийг] юунаар нээж
Тэнгэрийн үүд тахил нээмүй::
Тахилын үүд нээму:
Ариун сэтгэлд нээюү:
Ар нь өөд үл одмуй:
Хамаг мөрөн өөд үл урсмуй:
Цаст зүгийн оройн мөрөн өөд урсмуй:
Эн тэргүүн энэ үнэг ямар үүсгэлтэй хэмээвээс:
Нэн тэргүүн тэнгэр газар үүсэхэд
Зургаан зүйлийн эцэг шувууны хан нэрт:
Өөрийн охин (?) лугаа нь нэгдэж
Нүгэл буртаг хольсонд:
Буртагийн үнэгэн ес төрж[22]::
Ах нь Вагэ, Мүгэ хоёр болно
Түүний дэд нь:
Гэшүэ, Мүшү хоёр болно.
Түүний дэд нь
Квари Моубари хоёр болно
Түүний дэд нь
Хар амт, хар сүүлт хоёр болно::
Охин дүү нь сайхан

22. Шувууны хаан нэрт өөрийн охинтойгоо нэгдэж нүгэл, буртгийг хольсноор буртагт үнэгэн есүүлээ төрж "A.F" Der Fuchs in Kultur. (Religion un Folklore Zentral - und Ostasiens 2001. Wiesbaden.77.)

Улаан үнэгэн хийгээд есүүлээ[23] төрвөй::
Тэр галбын тэр цагт:
Таван зуун түмэн нэрт хүмүн:
Төвд, Хятад, Монгол гурван хүвүүн
Тэр гурвуулаа нэг эхээс төрөгсөн аж:::
Бас тэр цагт хийгээд тэр үед
Эрхэт Долоон догшидын одод үг өгүүлбэй::
- Энэ таны эмэг эх
Нүгэл буртагтай нь аж:
Өтөлж мунүлж үхмүй:
Хэрэв энэ таны эх тани үхвэл хүүрийг нь:
Бид догшидууд дунд бүү булагтун:
Бидний догшин ододын хаан үйтан бүй::
Хүний хүвүүн нь нүгэлийн буртагтай их:
Энэ эх тань нүгэлийн
Буртаг булүгээ хэмээн зарлиг болж:
Элч үнэгийг илгээжээ:
Тэр долоон ододын зарлигийг нь
Элч үнэгэн яван мартаж хоцорч:
Хүний хүү ийнхүү
Догшидын зарлигийг эс мэдэж:
Эхийнхээ хүүрийг нь
Догшидын ододын дунд булж аж:
Тэр нүгэл буртагийн сүүдэр нь:
Төвдийн цагаан тэнгэрийн уулд хүрэн
Хар сүүдрээр
Уулын Гвум нэрт тэнгэрт буртаг болов:
Хүний хүвүүнд:
Нэрт тэнгэр нэр ивээн хашин:

23. Чивэлт (нүгэлтэй) эцэг, буртагт охин хоёрын дундаас төрсөн муу ёрын хилэнцэт өсөн үнэгний нэр: Английн монголч эрдэмтэн Ч.Боудэны судалгаанд Вага. Могэ. Хашива. Мушива, Ганаг. Мунаг, Габира. Мубира, охин дүү; Германы монголч эрдэмтэн В.Хайссигийн судалгаанд Вэгэ. Мугэ, Ханаг. Мунаг. Гату, Мусу. Габри. Мубри. охин дүү Мүрэйн; Хурцбаатарын судалгаанд Вага. Муга, Гасув, Мошув. Кабари. Мудари.

Хамаг буртагийг тахин ариултугай::
Хэй энэ өдрийн хойно:
Үнэгэн үүгээр:
Долоон Эрхэт тэнгэрийн буртагийг ариулмуй::
Нүдэнээр нар сарын
Буртагийг ариулмуй::
Чихэнээр Дээд сахиусны
Буртагласныг ариулмуй:
Хамраар эхнэрийн сахиусан
Буртагийг ариулмуй::
Элигэнээр
Огторгуйн гилбэлгэний
Буртагийг ариулмуй::
Дөрвөн хөлөөр нь
Дөрвөн их эрдмийн буртагийг ариулмуй::
Зүрхээр нь
Урин эрхэт энэ буртагийг ариулмуй::
Уушигаар нь
Цаст уулын буртагийг ариулмуй::
Элгэнээр хадын буртагийг ариулмуй::
Гэдэсээр тэр хүүрийн буртагийг ариулмуй::
Хүзүүгээр далайн буртагийг ариулмуй::
Ясаар чулууны буртагийг ариулмуй::
Махаар газрын буртагийг ариулмуй::
Цөсөөр хамаг усны буртагийг ариулмуй::
Ноосоор
Хамаг модон бодисийн буртагийг ариулмуй::
Дээд ес, дор есөн далайн
Буртагийг ариулмуй::
Дөчин дөрвөн нурууны үесээр
Дөрвөн зүг найман хязгаарт агсадын нь
Хаан газар усны буртагийг ариулмуй::
Үнэгний баруун хавиргаар
Өдөрт аху тэнгэрийн буртагийг ариулмуй::

Үнэгний зүүн хавиргаар
Шөнө аху тэнгэрнэрийн
Буртагийг ариулмуй::
Үнэгний хэд хэдэн хавусанаар
Хамаг амьтаны сэтгэлийн нүгэл
Бурттийг ариулмуй::
Бид Ёгүзэри тэргүүлэн
Төгс өглөгийн эзэн бүгдээртээн
Урин сэтгэлээр
Ял янхан үйлдэгсэн бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Мунхаг сэтгэлээр халитарин
Үйлдэгсэн бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Ороход цагаан хар хэл ам ирэгсдэд
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Гал усны алтан модон харшилсан бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Гүжирээр нүгэл үйлдэгсэний
Буртаг бологсон бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Морин элжигэн луус кигэдийн [=тэргүүтний]
Мах идэгсэн бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Нохой гахайн махны
Уурт хэвтэгсэн бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Өвчтэй хүний хувцасы нь өмсөгсөн бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Галзуу хүний мэсэ мөч баригсан бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Буртагт хүнлүгээ тэрслэн ноололдсон бол
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Олон иргэнд ам [өр] алдсан бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::

Үхсэн хүний ясны
үнэрийг үнэсэгсэн бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Ном лам хийгээд
Идам мандалд буртаг болсон бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Есөн мэнгэд буртаг бологсон бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Эхнэр дагинас нарт
Буртаг бологсон бөгөөс::
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Таван изүүрт бурханд
Буртаг бологсон бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Ертөнцийн тэнгэрнэртү
Буртаг бологсон бөгөөс
Энэ үнэгний тахилаар
Буртаг бологсон бол ариултугай::
Өвөг эцгийн хоо жил [=суу заль, сүлд, хийморь]-д
Буртаг болсон бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай::
Эх хийгээд их нагацын
Хоо жилд буртаг
Бологсон бөгөөс үүгээр ариулмуй::
Гэрийн сахиусанд буртаг бөгөөс
Үүгээр ариултугай::
Үүд сахигч барс.буга хоёрт
Буртаг бөгөөс үүгээр ариултугай::
Эд таваар идээнийг сахигчидад
Буртаг бөгөөс үүгээр ариултугай::
Гүү морины хишигт
Буртаг бөгөөс үүгээр ариултугай::
Саах гүүний буян хишигт
Буртаг бөгөөс үүгээр ариултугай:: : ::
Хурдан морины буян хишигт

Буртаг бөгөөс үгээр ариултугай::
Үхэрийн тэнгэрт буртаг бөгөөс
Энэ үнэгний тахилаар ариултугай:: : ::
Тэмээний тэнгэрт буртаг бөгөөс
Үгээр ариултугай::
Хонины тэнгэрт буртаг бөгөөс
Үгээр ариултугай ::
Ямааны тэнгэрт буртаг бологсон бөгөөс
Үгээр ариултгай
Тарианы эзэн Эсэрүүнд буртаг бөгөөс
Үгээр ариултугай.
Хяланц буян хоёрыг :
Холибасу энэ үнэгний тахилаар ариулмуй::
Тэнгэр нэр эвдэрэлдсэнээр
Энэ үнэгний тахилаар ариулмуй ::
Ариун буртаг хоёрыг үл ялган хилэнц нүглээ:
Эс наманчилбаас
Өөр тус буян үйлдсэний:
Тус үгүй болюу:
Энэ ариун үнэгний тахилаар ариулмуй::
Төгс арилж эс чадамуй::
Мэсэг нэрт тэнгэрт өөдгүй муу үг өгүүлбэй::
Хүслийн дуунаар дээр тэнгэрнэр дуудаж:
Тус үгэй болов::
Төвд, Хятад, Монгол нэрт
Гурван хүвүүн нь үрэн таран хийж
чухаг мал нь үгүйрэв::
Үүсэгсэн эхийн нүд нь сохорч
Заяач хааны чих нь дүлий болов::
Шовууны хааны санаа нь битүүрэв::
Үүнд юуг сайн сахивал
Тустай хэмээлдэвэй:
Тэндээс дээр огторгуйд
Манжушири зарлиг болвой::

Эндээс долоон Эрхэт
Долоон догшин одон зарлиг болов::
"*Ай мунхаг хумуний хөвүүн Та:*
Бид танд унэгэн элч эс илгээл үү? :
Тэнгэрийн санаан уйтан буй
Та эхийн хуурийг :
Бид догшидын дунд нугэлт унэгийг
Битгий булагтун" хэмээсэн билээ.
"*Одоо үүнд тустай :*
Гүнж хаанаа залаад
Хамаг их хаан Газар Тэнгэрнэрийг
Ариун тахилаар тахи" гэв.
Тэндээс нүгэл буртгийг арилгагч
Гүнж нэртийг урж бүлгээ
Тэр Гүнж ийн өгүүлэв:
"*Ямарба энэ үйл нь*
Үнэгнээс болсон байна:
Мууд муүг зохиоюу:
Хороор хорыг арилгаюу::
Тэр нугэлт унэгийг барьтугай" хэмээв.
Тэндээс тэр үнэгийг барьж ирэв:
"*Энэ нугэлт унэгийг алтугай*" гэв.
Тэр үнэгэн үг өгүүлэв:
"*Намайг битгий ал :*
Буу нөхчүүл:
Намайг алваасу хилэнц нь их :
ухаантан хэрэв намайг алвал:
Хүзүүгий минь алтан ёнхороор :
Хазуулж ухуул:
Үснээс минь заримууд хялгасы нь:
Махнаас минь нэгэн хэсэг:
Цуснаас минь нэгэн дусал:
Яснаас минь нэгэн хэлтэрхийг авч :
Тэднийг хураагаж Тэнгэр, Газар бугдийг:

Ариун тахилаар тахин ариултугай::" гэв.
Тэр үнэгэн дахин өгүүлэв:
"*Над Эсэрүн тэнгэрийн*
Есөн бэлгэ төгс буй:
Миний чихний үзүүр харлагсан минь
Галаварс модны сүүдэрт хэвтсэнийх
Хоншоор минь ахар оготор бологч
Нугэл үнэсэгний бэлгэ:
Хамрын үзүүр харлагсан минь
Эчүшийн чөтгөр дарахуйн бэлгэ:
Аман шар бологсон нь
Аршаан далайгаас амсагсаны бэлгэ:
Омруун минь цагаан бологсон нь
Нарны гэрэлд гүйсэний бэлгэ:
Хоншоор минь нарийн бологсон нь
Муу буртгийг мэгчээссэнийх (?)
Омруу минь цагаан бологсон нь
Тэнгэрийн цагаан мөрнийг
Гаталсаны бэлгэ:
Миний хонгоны үсхөх бологсон нь
Өвлийн мөсөн дээр хэвтсэний бэлгэ:
Миний нооны үзүүр сүүдэртэй нь
Өглөө эрт сүүдэрт явсны бэлгэ:
Гуяны ар улаан бологсон нь
Дорно зүгийн нуурт хөлбөрөгсөнийх
Миний зоо цоохор бологсон нь
Эхийн надад талбигсан тэмдэг бэлгэ:
Миний сүүл гоо урт бологсон нь
Тэнгэрийн оёдолоор явагсаны бэлгэ:
Миний сүүлний үзүүр цагаан бологсон:
Тахилын хойт мөр ариулахын бэлгэ:
Би үнэгэн гүйхдээ:
Хойшоо эргэн хардаг минь:
Өмнөх элэнцэг хуланцаг буртагтайг:

Өдүгээ үзэх үеэ мэдэх үйн бэлгэ::
Миний тийм нь [= энэ шинж бэлгэ]
Эсэрүн Тэнгэрийн
Есөн бэлгэ төгөссний бэлгэ биш үү::
Надаар ариун тахил үйлдвэсү:
Тэдний эрдэм нь их эднэ::
Амьтаны сэтгэл нь дэлгэрч:
Биеий нь амарлуулмуй би:
Нүдэн нээж чихэн чинь сонор болмуй:
Хамаг амьтанд өлзий хутаг оршуултугай::
Дээр Тэнгэрнэрт дүүрэн орших
Догшин ододыг тахин ариулалтугай ::
Доор Өтөгүн эх дүүрэн орших
Хаан Газар, Лусун хаадыг тахин ариулалтугай:: гэв.
Үнэгээр тахин ариулсны хүчээр
Би Егүзэри хийгээд:
Өглөгийн эзэн бүгдэд:
Юуны өмнө эцэг, эх:
Өвкө элэнцэгт буртаг бологсон бөгөөс:
Үнэгний үсэн, махаар
Тахин ариултугай:
Эмэг эхийн эмэг эхэд
Буртаг бологсон бөгөөс:
Үнэгний үсэн ясаар
Тахин ариултугай::
Хойт хөвүүн ач нарт
Буртаг бологсон бөгөөс
Үнэгний эрхийгээр тахин ариултугай::
Морин, үхэр, хонинд
Буртаг болсон бөгөөс
Үнэгний гэдэс хүзүүгээр тахин ариултугай
Үнэгнээр ариулахуй тийм хүчтэй буй::
Хамаг үүдүгсэн хаан ба:
Огторгуйн үнэгэнд адил бөлүгээ::

Ариун нар, саранд адил болтугай::
Дэлгэртүгэй::
Түмэн оддод адил болтугай::
Биеийн дуу
Молор эрдэнэд адил болтугай::
Дуун тань Эсэруан тэнгэрийн
Дуунд адил болтугай::
Сэтгэл-тань тус илгалгүй
Хамаг амьтанд тус үүсгэтүгэй:: :
Мам гха лам ом ка ларка ла вай
Сва ха ма ма сэр нодла сва-хаа

Цайлгу: Могойн махан, солонгын махан, хүний махан энэ гурвыг тутаан талби Улаан хиб дунд дэрцүүлэг:: Үнэгний сан тавих өдөр: бар сарын 28, туулай сарын 26, луу сарын 24, могой сарын 22, морин сарын 20, хонин сарын 28, мичин сарын 26, тахиа сарын 14, нохой сарын 22, гахай сарын 11, хулгана сарын 8, үхэр сарын 5-нд тавих өдөр энэ буй:: Саркшаа миа-гша ола:

Үнэг өвчихүй. Үнэгний доод баруун, зүүн хоёр завжинд нь хар өнгөтэй, булдаруудаж ургасан 7-8 ширхэг нимгэн жижиг мах байдаг юм. Энэ булдруут махнаас нэг нэг ширхэгийг огтолж хаяад өвчдөг. Энэ маханд үнэгний буртаг бузар нь орщдог юм байна. Алсан үнэгний баруун хааны тавагнаас нь эхлэн залаа чөмөг хүртэл ярж бөгсийн нь дараа яраад арьсы нь бүрэн бүтнээр туламлаж авна. Арьсыг нь туламлан авсан үнэгний дөрвөн мөчийг нугалж огтолдог юм. Хоёр бөөр орших зайнд хоёр залаа чөмгийг нь дүрээд зооcлуулан дугуйлж хэвтээ байрлалаар араг ясыг нь хаядаг. Агнасан үнэгний хилэнц, нүглээр учирч болох олон бузар буртгаар гайтан зовохоос анчин сэргийлэн өөрийгөө хамгаалж "*буртагт үнэг чи дахин амилан босч сүнс болж чадахгүй, хойшид энэ мэтээр анчин хүний гарын дор хэвтэж байх болно*"гэсэн хариулга, даруулга анчны хар дом, сан тавьж уншлага дуудуулдаг. Монгол аман зохиол, бичгийн зохиолд өгүүлдэг үнэгний дүрийн тухай дэлгэрэнгүй судалгааны бүтээл 2001 онд Вейсвaден[24]д хэвлэгдсэн болно.

24. Халдварт тахал. ханиад томуу г.эргүү.тж. цээрлэсэн өвчний өөр нэр.
25. Der Fuchs in Kultur. Religion und Folklore Zentral_un Ostasiens: (AF) Band. 141

Чонын ав, чонын сан. Чоно авладаг олон аргыг урианхай анчид сайн мэддэг. Чоно авласан анчинд жилдээ тагшуур[25] томуу тусдаггүй, хийморьтой ангидэг. Голдуу буугаар агнадаг. Чонын бэлтрэг авладаггүй. Үнэг олон алдсан анчин нэг чоно авлаж үнэгний амь хороосон нүгэл хилэнцээ тайлдаг ёстой гэж номлодог. Чоныг *тэнгэрийн амьтан, тэнгэрийн цагаан нохой* гэх мэтээр цээрлэн нэрлэдэг нь мал сүрэгт учруулах чонын хөнөөл аюулаас малаа сэргийлэн болгоомжилсон сүсэг бишрэлийн цээр нэр. Ойрад-монголчууд араатан амьтан чоно нохойн довтолгоо халдлагыг өөрсдийн онгон шүтээнээ эс тоомсорлож догшируулснаас болов гэдэг. Онгон шүтээнээ аргадан номхруулдаг аргын нэг нь ***Чонын сангийн судар*** уншуулж сан сэржим өргөх ёслол юм. Урианхайн анчид чонын авд мордохдоо хэзээ хэнд ч учруулах чонын довтолгооноос сэргийлж, Чонын сангийн судрыг биедээ авч явах орон гэртээ хадгалан тахидаг юм гэж анчин туульчин Б.Авирмэд, Б.Ургнасан, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын урианхай бөө О.Хуяг нар хэлэв.

Чонын сан оршвой

О ум ма хум са риа гао
Номын агаарын орноос хувилсан:
Номын сахиусан: [=чоно]
Чоно их толгойт тангарагласан:
Нөхөр чуулган:
Башир зальт тангарагийн үгсийн эрхээр
Энэ оронд өнидү ирэн соёрх:
Бодон бэлдэн:
Сэтгэлийн хувилгаан:
Тахилын эрдэм:
Хүрэл эдлэлийг тавин өргөж:
Сэржим[26] аршийн[27]:
Мах цусан дором[28] тэргүүтэн:

---

[26] pser sgyims. serjim: 'алтан ундаа'. цацал хийх архи. цай
[27] rtsi. drung-spong: arši 'шударга залагч' Даянч хувилгааны алтан ундаа
[28] ptorma: балин. Бурхад. арши. чөтгөр. шулмас тэргүүнийг тайтгаруулах өргөлийн зүйл

Дээд заяа нүдэнд үзэгдэх:
Элдэвийн зул тахил:
Олон огторгуйд дүүртэл өрж:
[Чоно] танаа өргөмүй::
Зандан арцан агир тэргүүтэн:
Сайхан амттан бас:
Үнэртний зүйлийг:
Бэлэг билгийн галаар түлж:
Толилогсон үйл тасралтгүй:
Мөр бүгдийг хангаад:
Хувилгааны номоор тэтгэж:
Нөхөр хийгээд сэлтийг ариулмуй:
Буян сацад их зарлиг сонс:
Эрхэт [чоно] чамд
Шашны дайсан тангараг дордсон:
Бүхний амийг булаан
Яс идэн үйлдэгч [чоно]
Идээ үйлдэгчийг
Их хүчит ирид хувилгаат Егүзэри тэтгэн
Тэнгэрийн жим магтав::
Илагуґсадын шажныг барин тэтгэсэн:
Егүзэри багш шавь нөхөд сэлт ирэн:
Харших шалтгаан бүгд арилахуй::
Зохилдохуй шалтгаан бүтэхүй хийгээд:
Бие хийгээд түйтгэр ирэн:
Урди насандаа нөхөрлөсөн аюулаар:
Чоны хорлол ихдэгсэн тул:
Амьтан бүгдээр
Асрахуй өршөөхүй сэтгэл үүсгээд:
Махагалын хувилгаан биет
Гурван төрлөө мэдсэн:

29. lčam sring; jamsarin. Бурхны шашны арван догшин сахиусны нэг. Монголчууд Улаан сахиус гэнэ. Дайсныг номхтгох амьтанд тус бүтээлгэхээр урин залдаг. Зэс ууланд оршдог. арзайсан дөрвөн соёотой, улаанаар эргэлдсэн гурван мэлмийтэй. хөмсөгнөөс нь оч бадарсан дүртэй. (О.Сүх. 1997.99). Ойрадууд 'чоно' гэхийг цээрлэж Жамсран гэнэ.

Их эрдэнэт лам дурдан товчлов:
Эрдэнэ номын Богд:
Долоон төрлөө мэдсэн:
Хувилгаан бие:
Жамсран[29] нүүрт:
Гэтэлгэгч ламбээр
Малд чоны хилэн ихэдсэний тул
Тустай хэмээн найруулав
Өлзий хутаг оршвой Сарава о ма ги ла

Бугын ан ав. Урианхай түмний уртын дуу бол тэдний ан авын соёлын нэвтэрхий толь бичиг юм. Бидний сан хөмрөгт урианхайн өдөр тутмын хүнсний хэрэгцээг эрт дээр үеэс хангаж байсан ангийн тухайт дуу олон бий. Урианхайчууд чиктээ (хулан) буга, аргаль, угалз, зээр, ямаан гөрөөс (янгир), чоно, үнэг, туулай, тарвага, шувуу (ятуу) агнадаг. Ан авын зэр зэмсэг буу, ангийн унаа морь шувуу зэргийг магтсан уртын болон богино дуунууд байна. Гурван хээрийн чиктээ (хулан), Тэмээн үнэтэй зээрд, Бадам хамрын аргаль зэрэг уртын дуунууд турааг ан гөрөөсийг сайн мориор хөөж авлах, буйлсан бүргэд шонхор шувуу, анч нохой, нум сум, буу зэргээр ангуучилдаг байсан сэдэвтэй.

Бугын тухай дуу. Анчдыг үдэж мордуулах ёслол бол Урианхайн ав агнах соёлын нэг хэсэг болно. Гэргий нь нөхрөө анд үдэж мордуулаад ан авдаа эсэн мэнд явах замын өлзийг алтан дэлхий, хангай дэлхийн эзэн сахиусанд даатгаж дуулдаг.

Алаг Алтайн шил

Алаг Алтайн шилд
Алаглаа будан татна.
Агнаад мордсон залуу нь
Анчин мэргэн дийвэр[30]
Унаад гарсан морь нь

[30] Хөөригтэй. бардам: идэр залуу: шаламгай. гавшгай. (Г.Рамстедт. R.Kwb.107: Б.Муниев. 1977:220. Ж.Цолоо. 1988:198)

Аргамаг хурдан хөлөг.
Агсаад гарсан зэмсэг нь
Ардгай дэрдгэй нум сум
Үүрээд гарсан зэмсэг нь
Урт хар буу.
Агнаад мордсон залуу нь
Улаан шар дийвэр.
Тохоод мордсон эмээл нь
Тохаа зандан мод
Тохиноод мордсон залуу нь
Улаан шар дийвэр.

Өндөр Алтайн оройд

Өндөр Алтайн оройд
Өнгийн цэцэг дэлгэрдэг
Өглөө босоод харахад
Өөрийн нутаг санагдана.
Хүрэн морины тарганд
Хүрнэ ээ [=очно] гээд мордлоо.
Хүдэр харын цэцэнд
Хүнсгүй мордлоо.
Хар морины тарганд
Хаана билээ гээд мордлоо
Хайрт харын цэцэнд
Хүнсгүй мордлоо
Алаг морины тарганд
Агнанаа гээд мордлоо.
Ачит харын цэцэнд
Хүнсгүй мордлоо.
Адарган бүрийн анг
Алдалгүй намнан буудаж
Ав шорлого бүхэн
Аман хүнс болтугай

Арван салаа буга

Арван салаа бугыгаа
Алсын хөтөлд намнана.
Алиа бүргэр тэр минь
Морьтой, биетэйгээ мэгшинэ.
Хорин салаа бугыг
Хойд хөтөлд намнана.
Хөөрхөн бүргэр тэр минь
Морьтой, биетэйгээ мэхэлзэнэ.
Тэрэм хадны сүүдэрт
Тэрлэгтэй, цувтай чичирнэ.
Тээмийн[31] бүргэр[32] Тэр минь
Морьтой, биетэйгээ мэхэлзэнэ.
Үзүүр хадны хүйтэнд
Үчтэй[33] цувтай дагжлаа.
Үнэнч бүргэр түүндээ
Морьтой, биетэйгээ мэхэлзэнэ.
Торц хадны сүүдэрт
Тоорцогтой цувтай чичирлээ.
Торгорхон бүргэр түүндээ
Морьтой,биетэйгээ мэхэлзэнэ
Завсар хадын хүйтэнд
Заргагтай[34] цувтай дагжлаа:
Залуухан бүргэр түүндээ
Морьтой, биетэйгээ мэхэлзэнэ.
Тэнгис их далайн хүйтэнд
Тэрлэгтэй цэгдэгтэй[35] дагжив.
Тэрхэн гилгэр[36] түүндээ
Морьтой,биетэй мэхэлзнэ

31 Нас үеийн. ойр насны (арван насны доторхи) хүмүүс
32 Цэвэр ичимтгий: хулцэнгүй: төрх төвшин энхрий: гэнэн.
33 Өнгө татсан дээл: үнэгэн үс. хурган үс
34 Өнгө татаагүй илгэн дээл. Ямаан заргаг: Ишгэн заргаг: (K.Rwb. 467. Ж.Цолоо 1988:239)
35 Ууж (R.Kwb. 426.)
36 Нарийн, залхуу, ...

Минжийн хангайн буга

Минжийн хангай буга
Мэхэлзэж чашкуурдана[37]
Мэнд амар хагацсан ах нартайгаа
Мэндийн ерөөлөөр золгоно л
Цастай хангайн шилд
Цастай хур төсөрнө.
Цаад уулын шилийг
Цагаан бор минь давах болов уу?
Хар уулын шилд
Харцага шувуу цугларна.
Хаан сайхан аавдаа
Цагтаа мэнд золгох болов уу?
Хойд уулын даваа
Хорин давхар даваа
Хөгшин буурал ээждээ
Цагтаа мэнд золгох болов уу?
Өмнө уулын даваа
Өндөр сайхан даваа
Өнөр олон ах нартайгаа
Өдөртөө шулуун уулзаасай.
Баруун уулын даваа
Бартаатай өндөр даваа
Уулзаад ханилъя гэсэн ахтайгаа
Амар мэнд золгоосой
Талын ууҗим хөдөөг
Тасам бороороо туулъя
Тангарагтай олон та нартайгаа
Ерөөлийн баяраар харгалдана.

Сайхан хангайн буга

Сайхан хангайн буга нь

37. Урамдах

Салаагаа дамжаад урамдана.
Самган буурал ээжийгээ
Санах тусмаа дурсана.
Буурал хангайн буга
Бут бутдаа чишкэнэ
Буянтай буурал аавынхаасаа
Бугад мордохдоо дууллаа.
Өндөр хангайн буга
Өлкөн өлкөндөй[38] чишкэнэ.
Өвгөн буурал аавдаа
Өдөр өдөртөө золгоно.
Хөх хангайн буга
Хөдөө хөдөөдөө чишкэнэ
Хөгшин буурал аавдаа
Хүрч ирээд золгоно л.

Туулай агнахуй, туулайн дуу. Алтайн урианхай анчид туулай агнаж махы нь хүнсэндээ хэрэглэж арьсаар нь дээл малгай хийдэг. Саяхан нярайлсан эхнэрт туулайн махаар шөл хийж, уулгадаг байжээ.

Бор бөөргийн туулай

Бор бөөргийн туулайг
Бүргэд шувуу шүүрнэ.
Бүргэр хөөрхөн нүднээсээ
Бөөн нулимсаа асгаруулна.
Хар бөөргийн туулайг
Харцага шувуу шүүрнэ.
Хархан хөөрхөн нүднээсээ
Халуухан нулимсаа асгаруулна.
Түнгэт бөөргийн туулай
Түүкэн тэндээ устай.
Түүгээр өнгөрөгснийг чинь бодоход
Бодон бодон асгаруулна л.

38. уулын энгэр; зэвэр

Манай газрын манхан туулай

Манай газрын
Манхан туулай
Магнай дээрээ
Сартай туулай
Энд нь бөмбөрье үү?
Тэнд нь дэгье үү?
Хаахнуур яваад
Туулай болъё уу ?
Хойд газрын
Хонгор туулай
Хондлой дээрээ
Сартай туулай
Цакар хадаан
Цакалгааныг ягана?
Цагцгай бүргэдийн
Шүүрдгийг ягана?
Хар хадын
Хашилгыг ягана?
Харцага бүргэдийн
Шүүрдгийг ягана?
Боран[39] болсон
Махтай юу би ?
Борц болсон
Шөлтэй юү би ?
Миний юундам шүлтнээ[40] л
Ганз[41] болсон
Чихэнд минь болов уу ?
Гарьхэ[42] болсон
Нүдэнд минь болов уу ?

39. Хар мах
40. Шунах; амтархах
41. Гаанс
42. Жарттар

Миний юундам шүлтнээ л?
Таваг дүүрэхгүй
Маханд минь болов уу?
Тагш дүүрэхгүй
Шөлөнд минь болов уу?
Миний юундам шүлтнээ л?
Эмгэн цаттах
Махтай ч болоосой!
Элдүүр даах
Арьстай ч болоосой!
Миний юундам шүлтнээ л?
Одоо цагийн
Гэлэнгүүд хоомой
Суумшаан болоод
Чулуугаа авлаа биш үү?
Сунаамшаан болоод
Цохиод авах нь уу?
Сурсан тайганы
Мэрийхийг яана?
Сумын зангийн
Гүйлгэчийг яана?
Өврийн замаар
Оръё уу, байя уу?
Өтөг бууцаар
Дайръя уу, байя уу?
Хойд уулын
Холыг яана!
Хоорондох газрын
Арвиныг яана!
Хүнд модны
Хэцүүг яана?
Хөр цасны
Ихийг яана?
Энд нь дэгье үү?

Тэнд нь бөмбөрье үү?
65. Хаахнуур яваад
Туулай болъё уу би!

Домог нь. *Анчин хүн явж байтал ямар нэг амьтны айж сандарсан дуу сонсогджээ. Эргээд харвал хадны цаагуур туулай зугтан оров гэнэ. Анчин чулуу шүүрэн аваад туулайг чулуудтал аймшигт том бүргэд шувуу тэр хаднаас нисэн оджээ. Энэ муу туулайг саяын айх тар шувуу шүүрч сандаргасан байна шүү хэмээн туулайг хөөрхийлөн өрөвдөж эргэнх арвал туулай үхсэн хэвтээ. Анчин шувуунаас өрсөж туулайг чулуугаар цохиж алжээ. Анчин ихэд харамсаж, тавгандаа үстэй энэ муу хөөрхий туулай араатан шувуунаас айж сандарч явахад нь би өрсөөд амийг нь хороов. хэмээн гашуудаж түүнээс хойш ан агнахаа больсон гэдэг* домог буй.

1973оны 9 дүгээр сарын 8-9. Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төв. Унгар улсын монголч эрдэмтэн Дж.Кара бид хоёр урианхайн угсаатны судлал-хэлшинжлэлийн албан томилолтоор Баян-Өлгий аймгийн Сагсай, Цэнгэл, Буянт сумын монгол урианхай, мончоогo урианхайд очиж ажилласан юм. Сагсай сумын ард урианхай бөө, дархан Хуягтай уулзахыг Б.Ринчен багштан зөвлөсөн билээ. Дж.Кара, тэр өдрүүдэд монгол уринхайгаас олон оньсого бичиж[43], хасаг монгол айл нэг бүрийг гэрийн хаалганы гадагшаа харсан самбар модны дээрхи хээ угалз, өнгийн хослолыг сонирхон зурж тэмдэглэж байлаа. Хуяг гуай сайн дархан, бас анчин-бөө болно. Хуяг гуайн урианхай бөөгийн зан үйлээс ан авын тухай надад ярьж өгсөн хууч ярианаас одоо сийрүүлье.

Мажаалай[44] агнахуй. Алтайн урианхай анчид мажаалайг тодорхой улирал сард агнадаг улирлын чанартай ав. Урианхайн анчид мажаалайг жилд гурван удаа агнадаг. Тавдугаар сарын сүүлч зургадугаар сарын эхээр ногоо ургаж модны улаан шоргоолж гардаг. Энэ саруудад мажаалайг бэлчээрт нь отож агнаад домты нь авч ардын эмчилгээнд эмч домч нар хэрэглэж байсан. Есдүгээр сарын сүүлчээр мажаалайн тарга гүйцэж ичээндээ орж хэвтэж эхэлдэг. Мажаалайг ичээндээ орохоос нь өмнө агнаж өөхий нь

43. Kara.G. Mongol Uriankha riddles AOH т. XLI (1987). 15-39.
44. Баавгай, аюу

байдаг. Тарган мажаалайн өөх их тослогтой байдаг. Мажаалайн өөх шахаж тос гаргана. Мажаалайн тосоор үе мөчний өвчин, түлэнхий, яр, шарх зэрэг өвчин эмнэхэд ардууд хэрэглэж байсан. Өвлийн улиралд мажаалайг ичээнд нь агнадаг. Яаж агнадаг бэ гэвэл мажаалайн ичээг товлож олоод ичээ нүхний нь амсарт хэдэн гуулин мод дамнаж хөндөлсүүлэн тавьдаг. Тэгээд бэлтгэсэн нэг үүрэг бут мод мажаалайн ичээ нүхэнд түлхэж оруулдаг. Мажаалай хоёр орчим метрийн гүнд нойрмоглон унтаж байдаг юм байна. Сэрж цочсон мажаалай уурсаж ичээнээсээ гарахаар толгойгоо цухуйлгамагц анчин мажаалайн тархинд буугаа тулган буудаж намнадаг. Мажаалай агнадаг энэ арга аюул багатай. Анчин мажаалайг алан[45] буудах ёстой. Дутуу буудуулсан мажаалай догширч, анчин уруу улайран дайрвал анчны амь насанд онц аюултай ч байж мэднэ. Мажаалайн үхсэн эсэхийг сайтар болгоомжтой шалгаж үзээд үхсэн мажаалайн амин сүнсэнд залбирч, наминчлан алсан анчин дээлийнхээ гадуур хормойг газарт дэвсэж мөргөдөг. Үхсэн мажаалайн баруун хөлөг эхлэн яраад, өвчдөг. Эрүүг нь заалгүй дээд, доод дөрвөн соёог нь чичэнгүйлэн сугалж аваад эрүү толгойг нь салгаж заалдаг. Мажаалайн толгойноос эрүүг нь заавал заалж салгадаг домтой. Эс тэгвээс хэзээ нэг цагт хожим хойно мажаалайн амин сүнсэн амилж анчны ураг элкэнээс хорслоо авдаг тангарагт хилэнтэй гэдэг. Дараа нь мажаалайн дөрвөн хөлийг сарвуугаар нь нугалаад таван хурууны арван хумсыг нь авдаг. Мажаалайн хумсыг улаан ногоон цагаан утсаар оосорлон хүүхдэд зангиачлан зүүлгэдэг. Мажаалайн хумс хүүхэд шуухад нь тогтдоггүй айлд ивээл өршөөлтэй гэж ярилцдаг. Мажаалайн арьсыг намнасан анчин өөрөө авдаг. Мажаалайн махыг иддэггүй яс нь хүний ястай тун адилхан толгой нь нохойны толгойноос ялгагдахаар юм ор байхгүй. Хар гөрөөсөн к ү м ү н хар гөрөөсөн гэж нэрэлдэг нь ийм учиртай юм болов уу гэж бид сонин болгон хүүнэлдэж таацгаадаг. Мажаалай ховор хатуу ан боловч ухаалаг амьтан. Сайн хүндээ өршөөл ивээл ач тусаа өгдөг гэж анчид хуучилдаг. Манай Алтайн нуруунд Бэг гэж нэртэй нэг жимс ургадаг байжээ. Энэ Бэг жимсний тухай үлгэрийг би сонссоноо одоо хэлье.

Үнэн худлыг хэн мэднэ. Нутгийн нэг хоньчин охин бэг жимс ухаад сууж байжээ. Тэр хоньчин охиныг мажаалай тэврээд аваад явжээ. Мажаалай охиныг авч явсаар нэгэн нүхний амсарт нууж том модоор даржээ. Мажаалай

45 Ганц удаа: мэргэн буудах

удалгүй өөрийн жаранжаагаа[46] энхрийлэн сугавчилсаар ирж хээрээс олсон охинтой өөрийн жаранжаагаа ижилсүүлэн суутал жаранжааны гарт өргөс мод шаасныг олж үзээд сандарчээ. Хоньчин охин Мажаалайн жаранжааны өргөс модыг сугалан авмагц цус гарсан байна л даа. Хоньчин охин Мажаалайн жаранжааны гараас гарсан цусан дээр шорой хийж дараад гоожиж байсан цусыг нь тогтоожээ. Мажаалай хоньчин охиныг тэврэн явсаар байранд нь эргүүлэн хүргэж өгсөн гэдэг. Мажаалай орон хэвтэр хоёр салаа байдаг. Хэвтэрт нь хүн орвол хүнийг өөрийн хэвтдэг байрандаа оруулаад өөрөө нөгөө салаа нүхэндээ ордог хүнд аюул багатай гэж манай хуучуул ярилцахыг сонссон би. Мажаалайн нүхэнд хэзээ хэн орж байсныг хэн үзсэнийг хэн мэднээ. Энэ бол бидний сонссон үлгэр шүү дээ. Алтан дэлхий дээр олон амьтан байдаг. Дүрстэй дүрсгүй биетийн тухай домог үлгэр сонссоноос биш ялган зааглаж нэрлэж мэдэхгүй. Харин тэдэнд сүсэглэн биширч суухад буруудахгүй болов уу гэж боддог. Мажаалайг бөө хүн алдаггүй цээртэй. Анд явж байхад мажаалай тааралдвал цочоож болохгүй, алах бүр цээртэй. Яагаад гэвэл урианхай бөөгийн эрхэм *таван онгон нь хар баавгай, гунан хар мажаалай, гунан хар бүргэд, долоон хар хэрээ шар шувуу* гэдэг. Урианхай бөө өмсгөл дээлийнхээ дал нуруунд хар баавгайн арьс зүүж онгодоо дууддаг. Бөөгийн ар далыг элдэв хорлолоос хамгаалах дом гэнэ. Одоо мажаалайн арьс олдохгүй болов хар буюу хүрэн булгаараар хийдэг. Тангараг болж хараалаар үхсэн тайлаг хар буур урианхайн бөө нарыг амар тайван байлгахгүй зовоогоод байхаар нэгэн зүйл онгоноо болгож тайлаг хар буурыг номхтгожээ. Тайлаг хар буур урианхай бөөгийн долоон шар тэнгэрийн нэг болж уцааргүй номхон заларч буудаг болжээ. Тэгээд манай урианхай бөө бол мажаалай, тэмээ, туулайн мах амсах идэхийг цээрлэдэг болсон гэдэг. Хуяг бөө үргэлжлүүлэн өгүүлсэн нь:

> *Урианхай бөө нар есөн хар тэнгэр, долоон шар тэнгэрийг шүтдэг юм. Есөн хар тэнгэр нь мажаалай, хар бүргэд, тайлаг хар буур, долоон хар хирээ, алтан таяг зэрэг болно. Долоон шар тэнгэр нь Зэл шарга энэ юу болохыг би мэдэхгүй. Алтан шар таяг тайлаг шар буур бөөгийн элч таван хэрээ хэлмэрчин нь гэдэг. Есөн хар тэнгэр долоон шар тэнгэрийг эзэгнэн захирагч нь Цагаан туулай юм гэнэ. Иймд урианхай бөө нарыг туулайн мах амсаж идэж болохгүй хэмээн сургаж номлодог юм* гэжээ.

46. бамбарууш, бамбарши

❁Аргаль агнахуй, аргалийн тухай дуун

❁**Ангуучин лам хоёрын үлгэр.** Нэг ангуучин ан хараад гүйж явтал өмнө нь нэг аргалийн эм хонь хэвтэж байжээ. Ангуучин алтан дэлхий олз хишгээ хайрлав хэмээн баярлаж тэр аргалийг буудан намнажээ. Агнасан аргаль дээрээ баярлан хүрч очоод, хартал дөнгөж сая эхээсээ төрсөн аргаль хонины хурган майлжээ. Ангуучилж яваад боос [=хээлтэй] аргаль намнав би. Эх нь үхэж хурга амьд үлднээ гэдэг юун их аюултай хагацлын гаслан, үүнээс илүүтэй нүгэл гэж хэрхэн байх билээ. Нүгэлт хар гөрөөчин би амьд явахаас үхсэн минь нам илүү дээр гэж аман дотроон бувтнаж өөрийн шунахай санаа ангийн тачаалдаа зэвүүрхэн тэчьядаж эхийн цагаан сүүнээсээ амсаж чадаагүй нялх хургыг эргэн эргэн хэд харжээ. Тэгээд нүгэлт хар гөрөөчин буугаа авч элгэн хар хаданд тас цохиж устгачихаад дэлэн хөхөө сарвайлгасан эм гөрөөс намнасан унал гэм буруугаа наманчилж, анчин өндөр цонж хаднаас доошоо нисчээ. Тэгтэл нүгэлт хар гөрөөчин цохио цонж хадны ёроолуур одсонгүй гэнэ. Харин өндөр хөх тэнгэр өөд хэн нэгэн биетэй юман нүгэлт хар гөрөөчнийг нисгэн аваачиж, диваажинд хүргэжээ.

Хадны ёроолд нэгэн урианхай лам даяу бясалгаад суудаг байжээ. Даюуч [даяанч] лам нэгэн хүн тэнгэр өөд нисэн одохыг хараад гайхшран, яагаад энэ гайхамшигт хүн тэнгэрт нисэн гарч, тэнгэрийн алтан шатуудын амыг хэрхэн давж туулан гатлах юм?, нисэн одсон хүн хэн билээ? гэж бодлжээ. Цохио цонж хадаа лам тойроод үзтэл дөнгөж сая амь нь гарсан эм аргаль, бас үхлүүт хурга, тас цохиж устгасан буу байхыг олж харжээ. Лам цочоод нулимсаа мэлмэрүүлэн гайхшаа тасран баахан юм бодож *олон жилээр буяны төлөө ном бясалган суусан миний дэргэд энэ хилэнцийг хэн үйлдэв?, буруу муу үйлийн эзэн нүгэлт хар гөрөөчин яагаад буугаа тас цохив?, яагаад тэнгэр өөд нисэн явав? Арван хар нүглийн нэг эзэн муу хар гөрөөчинд диваажингийн орон тэнгэрт нисэх увдис узүүлэх нууц эрдэм чадал гэж ер юу л байв* гэж мөчөөрхөн атаархжээ. Тэгээд даюуч лам боджээ. Гурван жил хадын агуйд сууж даюу буцалгасан [=бясалгасан] даюуч лам би номын увдисаараа нисэж диваажингийн оронд хүрч лав чадах ёстой гэж алгасангүй сэтгэлээр бодол санаа нь огцомдож сатааран самуурч нүгэлт хар гөрөөчинийг дууриаж цохио хаднаасаа нисэж амь тавьсан гэдэг.

•

Бадам хамрын аргаль

Бадамлээ хамрын аргалийгаа
Багаханлаа бораараа торлоно
Багашиглаа зантай чамтаагаа
Хамталаа суух дуртаав
Хөхлөө хамрын аргалийг
Хөхөлт бораараа торлоно
Хөөрхөнлээ зантай чамтаагаа
Хүүнэлдээд суух дуртаав
Улаанлаа хамрын аргалийг
Улаанханлаа бораараа торлоно
Уяханлаа зантай чамтаагаан
Уулзаад хүүнэлдэх дуртаав

Сухаат өндрийн аргаль

Сухаат өндрийн аргаль нь
Судлаан дамжаад идээшлэнээ
Сурагтаа бяцхан чамтаагаа
Сураглан сурагласаар уулзана
Асхат өндөрийн аргаль нь
Асхаан дамжаад идээшлэнэ
Амрагийнлаа бяцхан чамтаагаа
Айлсаж буугаад харгалданаа лаа
Элсэт өндөрийн аргаль нь
Тоомаан дамжаад идээшлэнээ
Өөрийн болгосон чамаагаан
Энхэрлэж байгаад авлаав.

Чихтэй [=хээрийн луус] **агнахуй**. Монгол хэлний тайлбар тольд чихтэйг хулангийн өөр нэр, хээрийн луус ч гэдэг; луус (лагус) илжиг, гүү хоёрын дундаас төрсөн эрлийз адуу; илжиг (элжигэ) морьтой адилхан болоод бие жижиг, чих том, үхэр шиг сүүлтэй нэгэн зүйл адуу; хулан, луусын ойролцоо цагаан хонгор зүстэй нэгэн зүйл адуу, чихтэй (Я.Цэ. 821, 323, 303, 726) ч гэдэг. Өөр нэгэн тольд: хулантай адилавтар боловч чих нь түүнээс том, нэгэн зүйл

зэрлэг адуу; хулан: биеэр луустай төсөрхүү, цагаан хонгор зүсэмтэй, хэвэл нь цагаан, зоогоороо нарийн бор зурвастай нэгэн зүйл хөхтөн, элсэрхэг газар болон тал газраар сүрэглэн амьдрана, бас чихтэй, хулан чихтэй (Ж.Норжин нар 2765, 1465) гэжээ.

Манай шинжилгээний ангийн хэрэглэгдэхүүнд өмнө өгүүлсэн зэрлэг адууны төрлийн хулан, чихтэй, тахийн тухай сэдэвтэй дуу байдаг юм. Энэ дууны урианхай хувилбар, Б.Пунцагдоржийн Алтайн урианхай аман зохиолын цоморлиг номын 194-р талд Гурван хээрийн чихт гэдэг гарчигтай бий. Урианхай хувилбарыг одоо сийрүүлье.

Гурван хээрийн чихт

Гурван хээрийн чихтийг
Хэний чинь морь гүйцэх вэ
Гурван хэлсэн үг чинь
Зүрхний эхэнд уялга
Буржийн эхэн шилд
Буурлаа минь дандахгүй
Буцаад ирэхийг чинь мэдэхэд
Хамарлаа минь хэншүүрнэ
Хащдагийн эхэн шилд
Харлаглаа минь дандахгүй
Хариад ирэхийг чинь мэдэхэд
Хамарлаа минь хэншүүрнэ
Тайраад авахад тавилхай мод чичирнэ
Та нараар хамт найрлаад суух юм сан
Огтлоод авахад удган мод чичирнэ
Олноороо хамт найрлаад суух юм сан

Баяд хувилбарыг одооноос 73 жилийн өмнө буюу 1925 оны 1-2-р сард Д.Номханов Баядын Дөжээлин хийдийн гэлэн Довдонгоос бичиж авчээ. Баяд хувилбар нь 36 шад, 9 бадаг шүлэгтэй арай дэлгэрэнгүй эх болно. Үг нь болбоос:

☺ *З*алуу намайгаан болгав чи!

Гурван хээрийн чихтэйг
Хэний чинь морин гүйцдэг вэ?
Хэлэлцээд үгүй суутал
Хэлэн чинь юунд сулддаг вэ?
Үзүүрээр гүйсэн үнэгийг
Үрээ зээрдээрээ гүйцдэг би.
Уулзаад (üdzülvād) үгүй суутал
Үг чинь юунд сульддаг вэ?
Хэрцээр гүйсэн хэрмэн чинь
Хэнз хээрээрээ гүйцдэг би.
Хэлцээд мордсон залууг чинь
Хэнийн чинь залуу гүйцдэг вэ?
Көг яврын чихтэйг
Хөөсөнлөө адуугаа болгав чи? [=санаа юу?]
Хөдөөгөөр явсан хүнийг
Хөөрхүү намайгаа болгав чи? [=андуураа юу?]
Хаг яврын чихтэйг
Хаакшин [=хашсан] адуугаа болгав чи?
Хажуугаар явсан хүнийг
Хайртай чамайгаа болгав чи?
Заг яврын чихтэйг
Залсан адуугаан болгав чи? [=гэж санав уу чи]
Замаар явсан хүнийг
Залуу намайгаан болгав чи?
Улиасан гэдэг модон
Унахаа (ungahinān) мэдэж
Үндэс, унги (uluna) нь уртасч чичирнэ лэ.
Учиртай бяцхан чамтайгаан
Уулзахаа мэдэж
Улам ч урдаасаа баясна. [=өмнөхөөсөө илүү баярлана]
Харгаа гэдэг модон
Хагалхайгаа мэдэж
Хариу урдаасаа чичирнээ лэ

Хайртай бяцхан чамтайгаа
Харгалдхаан (=уулзахаа) мэдэж
Харин ч урдаасаа баясна.

Гурван хээрийн чихтэй гэдэг энэ дуу бол дөрвөд баяд, өөлд, урианхай, мянгад, захчин, хотончуудын дунд их эд дэлгэрсэн, найр наадмын уртын дуу болно. Энэ дууны олон хувилбарыг утгаар нь нэгтгэн зэрэгцүүлбэл 14 бадагтай 56 шад (мөр) шүлэг бүхий ойрад-монголчуудын ан авын тухай бэсрэгхэн яруу найраг юм. (Зэрэгцүүлсэн эхийг үзнэ үү.)

Гуравлаа чикэн хээр

Гуравлаа чиктэй хээрийг
Хэний чинь морин гүйцэх вэ?
Хэлэлцээ үгүй суутал
Хэлэн чинь юундаан сулдав?
Дөрөвхөн чиктэй хээрийг
Хэний чинь морь гүйцэх вэ?
Дөрөвхөн хэлсэн үгийг
Хэний чинь залуу сонсох вэ?
Үзүүрээр гүйксэн үнэгийг
Үрээ зээрдээрээ гүйцнэ.
Үзүүлцээд үгүй суутал
Үг чинь юундаа сулдав?
Хөх яврын чиктэйг
Хөөсөн адуугаа болговууч.
Хөдөөгөөр явагсан хүнийг
Хөөрхий намайгаа болговууч.
Хаг яврын чиктэйг
Хашсан адуугаа болговууч.
Хажуугаар явсан хүнийг
Хайртай намайгаа болговууч.
Заг яврын чиктэйг
Залагсан адуугаан болговууч.
Замаар явсан хүнийг
Залуу намайгаа болговууч.
Улаасан гэдэг модон

Унахыг нь мэдэв үү чи.
Учиртай бяцхан чамтайгаа
Уулзаж баяснаа л.
Харгай гэдэг модон
Хагалахыг нь мэдэв үү чи.
Хайртай бяцхан чамтайгаа
Харгалдаж баяснаа л.
Одон толботой хээр
Орчлон дунд мэгшинэ.
Уушги зүрхийг минь догдлуулагч
Хүний бяцхан тэр минь
Саран тйилтэй саарал
Сарын газарт мэгшинэ.
Санааг минь амруулагч
Хүний бяцхан тэр минь
Бэлээр чинь гүйх үнэгийг
Бэгшин тавруулаад ядлаа.
Бэлхэн хэлсэн үгийг чинь
Хэний чинь залуу сонсох вэ?
Араар чинь гүйх үнэгийг
Авлан хйигйид ядлаа.
Авалцаж хэлсэн үгийг чинь
Хэний чинь залуу сонсох вэ?
Бутаар гүйх булгыг
Буучхан залуу намнана.
Буцалгүй явтал
Зан чинь сэлгүүн болуузай.
Хажуугаар гүйсэн халиуг
Харийн залуу намнана.
Харилцаагүй байхад
Зан чинь сэлгүүн болуузай. (Ж.Цолоо. Арван гурван хүлгийн дуун УБ. 1982)

УРИАНХАЙ АНЧДЫН АВЛАХ[1] СОЁЛ

Урианхайн анчид ан авлах эртний ойн анчин иргэдийн дор өгүүлэх хэдэн сонгодог аргыг сайн эзэмшсэн байжээ. Энэ аргууд нь газар нүх малтаж зээр гөрөөс өөдүүлэх, зээглэх, басвагдах, дүүвэрдэх, урхидах, саалидах, хавхдах, шувуучлах, нохойчлох, мориор хөөж намнах, буудах зэрэг болно.

◐ ***Нүхэнд унагахуй***. Ямаан гөрөөс, янгир, зээр, үнэг, чоно, аргаль, угалз, буга марлын гүйдэл усны орц зам дээр алд урт, алд гүнзгий нүх ухаад дээгүүр нь харгана, бургас дамнаж дэрс өвс үнэр танар нь арилсан хуучирч өгөршсөн даавуугаар өнгөлөн далдлаад элс шороо цацаж бүтээдэг. Усанд ирсэн гөрөөс үргээлгэнээс зугтаж дүрвэсэн ан бэлтгэсэн нүхэнд унамагц сахиулын анчин намнадаг. Энэ аргыг дээр цагт хэрэглэж байжээ. Нүхэнд унагасан ан гөрөөсөө намнаад, хүн малд аюул учруулах нүхийг нь шороогоор булж дүүргэдэг.

◐ ***Зээгт ав***. Баян-Өлгий аймгийн Алтай, Буянт сумын хил дээр Урт өөм, Хөөлөн говийн аман гэдэг ангийн бэлчээрт цувруулан хашиж босгосон чулуун гортигийн их хуучирсан улбааг Унгарын монголч Дж.Кара бид хоёр үзсэн. Нутгийн хүмүүс цувруулан хашаалсан чулуунуудад ан гөрөөс зээглэн хашиж намнадаг байсны улбаа гэж билээ. Хоёр талаар нь өндөр уул, хадан хясаа хашсан хавцал жалгын аманд чулуун хашлага бариад үргээлгэнээс бууж ирсэн ан гөрөөсийг тал талаас нь зээглэн намнадаг байжээ. Одоо урианхай торгууд захчингууд ороо догшин морь малаа хадны битүүд оруулан шахаж аргамж сураар зээглэн хорьж барьдаг.

◐ ***Нохойг анд дасгахуй***. Эр кичигийн [=гөлгийн] имийг сөөрхөж[2] засдаг. Тэмээ засдаг аргаар имийг нь сугалж нохойг агтлана. Өдөр судар үзэж хөөлөн гараг өдөр чимхнэ[3]. Билгийн тооллын шинийн сайн ээлтэй зөөлөн

1 Нэгдэж хоморголон ан хийх. агнах. авлах; abalaqu
2 Тэжээврийн амьтныг агтлах. засах.
3 [illegible]ний төмс. төмс засаа. имийг нь нэг гарын хоёр хуруугаараа чимхэж авах

гараг өдрүүдэд төл мал нялх амьтдын имийг сугалан авч чимхдэг. Гөлөг засахад нэг араг шээзгий, дөрвөн эр хүн оролцдог. Гөлгийн хүзүүг араглаж нэг эрэгтэй хүн түүнийг дараад сууна. Хоёр эрэгтэй хүн засуулах гөлгийн хойт хоёр хөлийг нь татаж өөр нэг эрэгтэй хүн имийг нь сугалж авна. Засаа имийг нь сугалж агталсан хүнийг гөлөгт харуулдаггүй. Нохой им засаагий нь авч хөнгөлөн агталсан хүнээ сайтар нүдэлж таньдаг. Иймд сүүлд зууж довтлон дайрахаас болгоомжилдог.

Анч нохой болгох гөлгөө анчин дагуулж ан барих арга дадалд дасгаж сургадаг. Хашаа хорооны гадаа хөр цас хэц газар уруу хонины бөөрөнхийлсөн түүдэг ноос өнхөрүүлж араас нь гөлгөө тухиран хөөцөлдүүлдэг. Гөлөг түүдэг ноосыг хөөж бариад зуухад нэрээр нь гөлгөө дууддаг. Барьсан түүдгээ, гөлөг эзэндээ авчирж өгвөл хоёроос гурван хэрчим мах гөлгөндөө өгдөг. Түүдэг ноосоо гөлгөөс аваад хэд хэдэн удаа өнхрүүлэн гөлгөөр хөөлгөн бариулж зугаацуулдаг. Эзэндээ барьсан түүдэг ноосоо авчирч хэрчим мах идсэн нохой маханд амтшиж түүдэг[4] барих дадлагатай болдог. Түүдэг ноосоо зуучихаад эзэндээ авчирч өгөхгүй хээр хаявал гөлгөө нэрлэн дуудаж мах үнэртүүлж горьдуулж байгаад түүдгээ дахин дахин шидэж барьсан түүдгээ эзэндээ авч ирж дастал нь түүдэг хөөлгөдөг.

Хоёр наснаас нь эхлэн нохойгоороо ятуу, хулгана, зурамны араас тухиран хөөлгөж амьтан хөөж сургана. Тусгай нүхэнд урхи тавиад, урхитай нүхэнд дөхөж ирсэн мөндлийг хашгиран үргээж гөлгөө тухирч, мөндөл хөөлгөж бариулаад, махнаас нь өгч ангийн махны амтанд оруулдаг. Хоёр настай анч нохойг *муу шагаа* гэнэ. Ойрхон дагуулан явж ан хөөлгөж амьтан бариулж сургадаг. Гурван настай анчин нохойг *сайн шагаа* гэнэ. Сайн шагаа нохойн анх барьсан ангийн махнаас идүүлдэггүй. Барьсан ангаа авчирж өгөлгүй махы нь идвэл шавхруудан загнаад хоол өгөлгүй сойно. Хоёрдахь, гуравдахь удаагаа барьсан ангаа анчин эзэндээ авчирж өгөхгүй бол удаанаар сойж өлсгөж хашраадаг. Малайчиж болно. Барьсан ангаа анчин эзэндээ нохой авчирч өгөхөд авч явсан махнаасаа үнэртүүлж идүүлж сургана. Эзнийхээ гараас мах идээд амтшсан анчин нохой барьсан ангаа өөрөө идэхгүй хээр хаяхгүй амандаа зуусаар эзэн өөдөө шууд давхиж ирээд оцойн суугаад эзнийхээ гараас мах горьдож эрхэлдэг дадалтай болсон байдаг. Анчин

4. Томох ноос, үс, хялгасыг бөөгнөрүүлж бэлтгэсэн нь. tügüdeg

нохойд ангийн халуун цус идүүлдэггүй. Халуун цус уусан нохойн хөлд нь цусан бууж тавхай нь тасардаг. Ангийн халуун цус уусан нохойд хурс [=ааруул] нарж идүүлдэг. Хурсыг анчин, зун бэлтгээд, анд явахдаа махны хамт авч явдаг.

Сайн шагаа анчин нохойн чих нь том дэлбэгэр том толгойтой унжуу шавьжтай даравгар том амтай байдаг. Анчин нохойн цээж нь гурвалжин байвал газар уруу ан хөөж гүйцэхэд сайн, бөгсөн тал нь зузаан бол газар өөд сайн гэж анчин нохойг шинжилдэг. Анчин нохой хурдан байх ёстой.

Нохойгоор ангуучлан явахын өмнө тэжээгээд сойно. Сойлт нь таарсан нохойдоо тос шингээсэн эсгий идүүлдэг. Тостой эсгий идсэн нохойн гэдсэн дотор байгаа ясны хэлтэрхий туугдаж дотор өөх нь эсгийд шингэж хөнгөрөн цовэршидэг. Нохой хурдан гавшгай болно.

Сайн анчин нохой бол аргаль, янгир, марал буга, чоно, үнэгийг хялбархан барьж чадна. Анчин нохойг *ухэхэд* нь бие гүйцсэн хонь муулаад [=алаад] сүүлнээс нь нохойн аманд зуулгаж нохойн сүүлийг угаар нь огтолж дэрлүүлэн толгойг урагш харуулан хүндтэйгээр хөдөөлүүлдэг. Анчин эзэн ***энэ төрөлдөө чи сайн нохой байлаа. Дараа төрөлдөө хүн болж төрөөрөө*** гэж бэлгэдэн ерөөдөг.

Урианхай анчдын харвах соёл. Алтайн монгол урианхайн харваа бол гөрөөчин урианхай түмний ангуучлан аж төрөх амьдрал ахуйн нэгэн *дасгал сургууль* болно. Үүнийг тодруулах зорилгоор урианхай сур харвааны хэдэн нэр томьёог тайлбарлан бичив. Урианхайд шагаа нинцдах[=шаа няслах], корлаар наадах [=хорлоор тоглох], гүвээ гүйлгэх, хөзөр даанж, сур харваа, үүшүүр, окан мордуулах [=охин гэрлүүлэх] зэрэг болно. Шагаа харвах, гүвээ гүйлгэх, охин гэрлүүлэх нь хүүхэд залуучуусын тоглоом. Сур харваа нь эртнээс анчин залуучуудын хомроголон агнахын бэлтгэл сургууль байжээ.

Сур харваан. Урианхайн сур харваан нь халх-монгол, буриад-монгол сур харваанаас бага зэрэг ондоо. Урианхай сур харвааны чөдөр даанж, зүс хах, тоом хах, данж хахын тухай Баян-Өлгий аймаг, Ховдын Мөнххайрхан сумын урианхай анчид бусдаасаа илүү тодорхой мэдэж байлаа.

Чөдөр даанж хах. Цагаан сарын шинийн нэгнээс амьтад ичээнээсээ

гарах хүртэл эрчүүд хах онох цэцэн мэргэнээ булаалдан дасгал хийж тоглодог. Тоглоом эрхлэн явуулах гэж байгаа айл сур харвах тэмцээн наадмын тухай зар тараана. Сурчид цугларч тоглоомын талбайгаа засна. Талбайн урт нь хөвчилсөн эвэр нумын хэмжээний газар өргөн нь өрөг сурын урттай тэнцүү. Өрөг сурын урт нь сур харвааанд оролцох, сурчдын цувруулан өрсөн сурын тоотой тэнцүү байна. Энэ нь сурчин тус бүр гурван сур зайгүй өрж, цувруулсан урт газар. Арван сурчин тэмцээнд оролцвол гучин сур газар юм. Дараа нь өрөг сурын урттай тэнцүү хэмжээний газарт шороо чулуугаар хоёр далан зэрэгцүүлэн босгоно.

Өтвөг. Хоёр даланг Дээд, Доод *өтвөг* гэнэ. Дээд өтвөгөөс Доод өтвөг хүртэл өргөн нь есөн нум газар. Есөн нум газрын дунд сураа өрнө. Үүнийг өрөг сур гэнэ. Өрөг сураас Дээд өтвөг хүртэл 4-5 нум, өрөг сураас Доод өтвөг хүртэл 4-5 нум байна. Өрөг сурыг баруун, зүүн гар тийшээ хоёр хэсэг болгож тэнцүү тоотой өрнө. Баруун зүүн гарын өрөг сурын дунд нэг нудрага хоёр сур тус тус магнайнуулан шигтгэсэн болно.

Ганз магнай. Хоёр сурыг Галз магнай гэнэ. Галз магнай сураас баруун зүүн гар тийшээ бусад сурнуудыг бэхлэнэ. Өрөг сурын баруун зүүн хоёр хажууд онож өтвөг давуулсан сурнуудыг цуглуулж хадгалдаг чулуу шороогоор босгосон хоёр савыг Дараг гэж нэрлэж байлаа.

Тоглогч бүр өрөг сураа авчиржээ. Өрөг сур гэдэг нь тоглогч нэг бүрийн морь малын тоног чөдөр, цулбуур, хом сүрлэг нудрага хэлбэртэй бөөрөнхийлөн зангидсан нь болно. Энэхүү өрөг сурын нийлбэр нэр нь *чөдөр даанж*. Тоглогчид хоёр талцаж харвааны тэмцээнээ эхэлдэг. Тоглогчдын багийг баруун зүүн гал гэх юм. Хоёр гал тус бүрд арван тоглогчид оролцвол хорин тоглогчид нийт 60 жаран сур өрнө. Жаран сурын арвыг нь *чөдөр*, тавийг нь *даанж* гэж нэрлэж байлаа. Чөдрийг зангидна. Тавин даанжийн хорин тав нь цулбуур, хорин тав нь хом[5]. Хом гэдэг нь урианхай анчдын ан олзоо ганзагалан тэгнэж бэхэлдэг сур дээс. Тоглогчид хоёр ахмад хүнээр ахлагчаа томилно.

Сур хормойлогчоо нэрлэн дуудаж сонсгов. Сур хормойлогч дээд өтвөг

шивуулан гаргасан сур бөөгнүүлж, гал тус бүрийн Дараг саванд хийж байлаа. Баруун талын галын ахлагч нь эхлэн мөскээгээ тавьж тэмцээнийг эхлэв. Мөскээгээ доод өтвөгийг давуулж, өрөг сурын галз магнайг онож, дээд өтвөг давуулах ёстой. Хэрэв мөскээ нь доод өтвөгийг шүргэвэл *өтвөгдсөн* гэж дуудаад хүчингүйд тооцно. Мөскээ нь доод өтвөгийн дотор захыг цохиж үлмаар өрөг сур онож тэр сур нь дээд өтвөгийг давж гарвал *оноо гаргалаа* хэмээн нэг хожил авсанд тооцно. Эхний дөрвөн оноо сур дөрвөн өөр нэртэй. Анхны оноо сурыг *магнай* сур, хоёрдугаар сурыг *тэгнээ* сур, гуравдугаар сурыг *ганзага* сур, дөрөвдүгээр сурыг *дахуул* сур гэж нэрлэсэн юм. Нэгдүгээр магнай сур гэдэг нь тэргүүн тэргүүлсэн анхны сур болно. Тэгнээ гэдэг нь ангийн олз омог олохын эх үүсгэвэр. Ганзага гэдэг нь ганзага хоосон биш байхын бэлгэдэл нэр. Дахуул гэдэг нь цаашид ганзага хоосон биш олз омгийн хишиг дуудаж дагуулахыг бэлгэдсэн нэр. Харваачид сур онож, дээд өтвөг давуулбал тоглоом тэмцээнд оролцогчид: *дахуул, дахуул, дахуулаа* гэж уянгалуулан хашгирцгаадаг.

Эхлэн харваж байгаа галын ахлагч нь өөрийн талын магнай сурыг түрүүнд нь онохыг чухалчилдаг. Бас өөр сур онож болно. Галын ахлагч нас өндөр болсон, харвах чадалгүй бол зөвхөн ахлагчийн үүрэгтэй тоглоом тэмцээнд оролцдог. Хоёрдугаар харвагчийг Багалуурын хүн гэнэ. Бусад тологчдод оноосон нэр байхгүй.

Тэмцээний хожил тооцохуй. Олон чөдөр даанж авсан нь ялагч болно. Дээр үед нэг чөдрийг нэг хадаг нэг даанжийг нэг самбай хадагт дүйцүүлж, морийтэй тоглож байжээ. Баруун гар талын тоглогч арван хүн өөрсдийн өрөөсөө арван сумаа аваад, зүүн гар талын чөдөр даанжаас нэмж сум авсан хожлын сумаар хожлыг дүгнэнэ. Тоглогч тус бүр нэг удаа гурван сум харваж тэмцэлддэг. Сумын их биеийг мөскээ үзүүр хэсгийг булцуу гэнэ.

Зүс хах [=хаахуй]. Тэмцээнд оролцогчид тус бүр нэг сур зүсэлж, тэр зүст сумаа онилож цэцэн харвахыг *зүс хаахуй* гэнэ.

Тоом хах. Тоглоомд оролцогчид тус бүр нэг нэг сур тавьж зөвхөн ганц мөскээгээр харваж онохыг *тоом хах* гэнэ.

Хамба суухуй. Баруун, зүүн хоёр гар талаас тус бүр таван хүн оролцож, харваа сумаа оноож тэмцэлддэг байсан. Зүүн гар талын таван тоглогчийн хэн нь ч сур онохгүй тохиолдолд оноо авсан баруун гар талаас, оноо авсан тоглогчдын хэн нэг нь зүүн гар талын тоглогчийн хэн нэгийг амлан дуудаж, түүний нэрийн өмнөөс орлон харваж, өрөг сум оноож дээд өтвөг давуулан оноо авах тэмцээн. Оноо авсан тоглогч дахин зүүн гар талаас өөр нэг тоглогчийг дахин нэрлэн амлаж, оноо авбал зүүн гар талын ялагдсан тоглогч тэмцээнээс гардаг. Тэмцээнээс гарсан хүнийг *хамба суугч* гэнэ. Хамба суугч тоглоомд дахин оролцохгүй. Аль тал нөгөө талаас олон хамба суулгасан нь хожил авдаг хэмээн О.Хуяг, Х.Үлэмж нар хуучилсан байна.

Урианхайн Үүшүүр тоглоом. Энэ тоглоомын нэгж болох нэр бүхий арван амьтнаас буга, ирвэс, туулай, хүдэр, үнэг, шувууг урианхайчууд агнадаг. Анчин урианхайчууд нохой харцага шувууг дасган сургаж, анчин-харцага, анчин-нохой болгож, биедээ ижилсүүлдэг. Арслан бар тэдний нутагт байдаггүй. Үүшүүр тоглоомын нэгжид тодорхой тоотой дараах амьтны дүрс оролцуулан оноож зугаацан тоглодог. Арслан нэг, жаран дөрвөн лан 1•64; бар хоёр, нэг бар гучин хоёр лан 2•32:64; ирвэс дөрөв, нэг ирвэс арван зургаан лан 4•16:64; буга найм, нэг буга найман лан 8•8:64; хүдэр арван зургаа, нэг хүдэр дөрвөн лан 16•4:64; туулай гучин хоёр, нэг туулай хоёр лан 32•2:64; шувуу жаран дөрөв, нэг шувуу нэг лан 64•1:64; харцага зургаа, нэг харцага долоон лан 6•7:42; нохой хоёр, нэг нохой арван нэгэн лан 2•11:22; үнэг нэг, арван хоёр лан 1•12:12 лан. Арван амьтан тус бүрийг лангаар үнэлж тоглодог мөрийтэй модон наадгай. Нэгээс зургаан нүдтэй, зургаан шоо байлаа. Зургаан шоогоо модон таваг дотор найран хаяж [=орхин чулуудаж] тоглодог. Тавгийн гадна шоо унавал хүчингүйд тооцно. Шооны нүдээр дүйцүүлдэг. Тоглоом хонхир, улаалгалт, улаа зэрэг урианхайн ан авын учир холбогдолтой томъёолж оноосон нэрүүдтэй.

2.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

УРИАНХАЙН ТУУЛЬЧДЫН МЭДЛЭГ ОЮУН

ТАЛЫН ХАРБОДОН ТУУЛЬ БА ЦАГААН ШҮХЭРТ СУДАР

Энэ насны жаргалд бүү шуна
Өөрийн сэтгэлийг номонд оруул
Төвдийн алдарт Дом лам

ТАЛЫН ХАРБОДОН ТУУЛИЙН ТУХАЙ

⌘ **Талын Харбодон тууль.** Монгол урианхайн баатарлаг туулийг 1960-1985 онуудад манай эрдэмтэд эрчимтэй сурвалжлав.

Урианхайн тууль нь 600-1500 мөр шүлэгтэй ардын аман яруу найраг болно. Ойрад-монгол, халх-монголын 20 орчим туульчдын намтар, тэдний хайлан хэлдэг 50-60 тууль бидэнд мэдэгдэж байгаа ба олонхи нь эдүгээ хэвлэгджээ. Олон мянган мөр шүлэгтэй том хэмжээний баатарлаг туулийг урианхай туульчид товшуур, икэл, морин хуур хөгжмөөр хөгжимдөж, цээжээрээ яруу сайхнаар хайлан дуулдаг. Ийм гарамгай туульчид одоо бараг байхгүй. Энэ нь урианхай тууль мартагдаж байгаа гэсэн үг биш. Монгол туулийн үйлчлэх хүрээ улам өргөжиж туульчин, сонсогч, судлагч гэсэн гурван хүрээлэл бүрэлдэн бий боллоо.

Монгол улс дахь тууль судалгааны гол бүтээлүүд нь туулийн үйл явдлыг тайлбарлан давтаж бичсэн удиртгалтай эмхтгэлүүд болно. БНХАУ-ын Өвөрмонгол, Шинжааны ойрад-монгол, өвөр-монгол туульчдын хайлан хэлсэн туулиудын эмхэтгэл худам-монгол бичгээр[1] хэвлэгдсээр байна. Энэ

1. 'Арван зүгийн Гэсэр хааны тууж оршвой'. дээд дэвтэр (1955). доод дэвтэр (1956) Бээжин. Хөххот. Бадма Буянхишиг 'Жангар тууль' (1980) Үрэмчи. 'Такил Зула хааны үлдэл тансаг Бумба хааны ач Үзүн Алдар хааны хөвүүн үеийн өнчин Жангарын тууль' (1986) II: (1987) Үрүмчи хот. 'Зураг шархал морьтой Зула Алдар хаан'. 'Нарангэрэл Хааны тууж'. 'Алтууж мэргэн хаан' (Дамиранжав). 'Баян-Улаанхан' (Цэцэнмөнх) Бээжин. '**Хан Харангуй**'. 'Ойрадын баатарлаг туулийн текст хийгээд үгсийн тайлбар'. Балжирын Дамиранжав цуглуулан эмхтгэв. 2006. Бээжин хот. Энэ зохиол Хятадад өмнө хэвлүүлсэн Жангар. Гэсэр туулийн эмхтгэлээс нилээд ялгаатай. Энэ нь I. Хан Харангуй туулийн 18 хувилбар бий. II. Туулийн зүүлт тайлбарт 3162 үгийг сонгож тайлбарласан туулийн олон ном БНХАУ-д гарчээ.

нь омог[2] монголчууд бидний туульс судлалын их амжилт юм. Монгол улсын эрдэмтдийн хэвлүүлсэн арав гаруй туулийг Н.Поппе, В.Хайссиг, Ч.Боуден, Дж.Кара[3], Б.Владимирцов[4], С.Неклюдов нар[5] англи, герман, орос хэлээр орчуулж, дэлхийн утга зохиолын сан хөмрөгийг монгол туулиар баяжуулж байна.

Монгол туульчид бол туулиа хайлан өгүүлж сонсогч нараа зугаацуулан цэнгээж баясгагчид төдийхөн биш. Монгол туульчид чадамгай *сайн хөгжимчид*. Монгол туульчид сонсогч нараа өөртөө татаж биширүүлж чаддаг *жүжигчид* ардын билэгзүйч, шашны сургаалыг сайн мэддэг *номлогч* нар юм. Монгол туульчдын мэдлэг оюуны соёлын тухай судалсан нь бараг үгүй. Урианхайн гарамгай туульчид туулийн баатруудаа юунаас үүсэн, хэнээс бүрэлдэн төрж, мэндэлсэн домгийг сайн мэддэг юм. Зарим туулийн баатрыг элгэн хар хаднаас (чулуунаас) бутарч гарсан гэнэ. Зарим туулийн баатраа газар шороо, өвс ургамал модноос үүсэж мэндэлсэн гэнэ. Зарим туулийн баатраа тэнгэр, нар, сар, үүл манангаас заяасан гэнэ. Зарим туулийн баатраа тэнгис, далай, уснаас үүсгэлтэй гэлцэнэ. Зарим туулийн баатраа чоно, буга, гахай зэрэг зэрлэг амьтнаас удамласан гэлцэнэ. Мөн Ойрад-монголын гарамгай туульчид туулийн баатруудын угсаа удам, орон байр, нутаг ус, мал хөрөнгө, хувцас хунар, эхнэр хүүхэд, унаа хүлэг морины ид шид, увидас, шүтлэг, сүнс сүлдийн тухай сайн мэддэг. Энэ тухай мэдэж дуулснаа сонсогч нартаа тууль хайлахаа түр завсарлаж, амрах, цайлах, тамхилан суух завсар чөлөөндөө тайлбарлан ярьж, тэдэнтэй хамт амардаг. Туулийн баатар юуны учир хэнтэй яагаад тулалдаж ялсан, ялагдсаны шалтгааныг туульч учирлан, сонсогч нартаа бас хэлж өгнө. Байгаль, сав. шим, одон ертөнц, лусын орны байрлал, тэнгэрээс газарт буух, газар уснаас тэнгэрт хүрч очих савдаг, сахиусны тухай үлгэрийг домоглон ярина. Үүнийгээ *түүх* гэдэг. Энэ бол урианхай

2. obug. omug. obog. omog ясан / эцгийн / төрлийн удам угсаан үе уламжилсан нэр омог: омог =овог үндэс (Я.Цэ. 1956: 405. 414); овгийн эцэг өвөг: үндэс угсаа. угсаа гарал: obug omug удам угсааны харьцаагаар холбогдсон бүлэг хүмүүс. (Сэцэнцогт 'Монгол үгсийн язгуурын толь' 1987: 336. 355. Бээжин): омг племя Б.Муниев 'Халимаг-Орос толь' 1977:396 Москва; omag Gescshkecht. Stamm нэг омагаас гарсан омог R.Kwb 285: обог. ист. род. племя О.М.Черемисов Буряад-Ород словарь 1973:348 Москва п. -мо. obug =omug род околение племя свойство. фамилия; obogtanud племена народности: ...др. -тюк оба род. племя. як. омук. народ. племя. род: саха. Омук; 'Сравнительный словарь' В.Цинциус (?)1977:18:

3. Mongolische Epen 1-12-р боть. Wiesbaden 1973-1992

4. Б.Я. Владимирцов. 'Монголо-Ойратский героический эпос' СПб 1929:

5. С.Ю.Неклюдов '...Монгольские сказания о Гесере новые запаси' Москва. 1982

туульчийн мэдлэг оюуны соёлын нэг л хэсэг юм. Туульчийн энэ тайлбар учирлан ухааруулж хэлсэн домог ярианаас, тухайн хайлсан туулийн үйл явдлаас хол давуу, монгол туулийг туульч юуны учир, яагаад хайлан хэлдэг тухай туульчны танин мэдэхүйн өргөн мэдлэгийг нь та олж ухаарах болно.

Таван Бодонгийн тухай. Урианхайн алдарт туульч Б.Авирмэд 1972 оны 12 дугаар сард Ховд аймгийн Мөнххайрхан сум нэгдлийн зочид буудалд 13000 мөр шүлэгтэй Тальн Харбодон гэдэг тууль хайлж, завсар зуураа цайлж, тамхилах чөлөөндөө надад өгүүлснээс заримыг нь сийрүүлье.

Урианхайн их туулиудын эзэн баатрууд нь Таван бодон юм. Энэ таван Бодонгийн тухай таван өөр үйл явдалтай, таван өөр амьдрал ахуйтай, таван өөр оронд аж төрдөг, таван өөр сахиусны эзэн баатрын тухай таван тууль байдаг. Энэ таван тууль нь эзэн Улаанбодон, талын Харбодон, өлгийн Цакар Цагаанбодон, тэнгэрийн Хөхбодон, далайн Шарбодон болно.

Газрын эзэн бол *талын Харбодон*, уулын эзэн нь *цакар Цагаанбодон*, од гариг эрхсийн эзнийг *тэнгэрийн Хөхбодон*, ус далай, лусын эзэн нь *далайн Шарбодон*, Тэнгэр, газар, уул, усны эзэн хар, шар, цагаан, хөх, дөрвөн өнгөтэй дөрвөн бодонгуудыг ахлан захирагч нь *эзэн Улаанбодон*. Эзэн Улаанбодон туульд дөрвөн гүрэн амьтныг дагуулж захиран эзэмшсэн гэжээ. Замбуутивийн газар, ус, огторгуй, салхи (хий), шороо, төмөр бол хүн, амьтан, ургамлын биеийг бүрдүүлэгч цагаан, шар, хөх, улаан, хар өнгөтэй таван махбод юм. Энэ таван махбодын эзэд бас таван өнгөтэй байдаг гэж туульч Ширэндэв сургасан гэнэ. Алтайн Урианхайн туульч Эринчэний Зараа бөөгийн „Газар усны эздийн дуудлага"-д, Эм болсон *өвсний эзэн*, эрдэнэ болсон *чулууны эзэн*, алтан болсон *асгын эзэн*, мөнгөн болсон *хадны эзэн*, тосон болсон *лусын эзэн*, торгон болсон *усны эзэн*, бурхирч урссан *булгийн эзэн*, сархирч урссан довын эзэн, гарын хуруувч болсон *садаргын эзэн*, сарвайж өгсөн *хадны эзэн*, арвайж өгсөн *савдгийн эзэн* тэр бүгд минь өршөө! Ивингийн мөрөнд торго дэвссэн мэт өнгө бүрийн *цэцгийн эзэн*, өндөр их *уулын эзэн*, өргөн их *далайн эзэн*, хан их *уулын эзэн*, хавтгай их *ёлонгийн эзэн*, бургасан их *модны эзэн*, арзалдсан их *харгайн* (хар мод) *эзэн*, бут замыг боосон *бургасны эзэн*, түг түмэн ангийн дорд найман *лусын эзэн*, хэмээн ертөнцөд эзэнгүй, хоосон юм үгүй гэдэг нэгэн нэвтэрхий санаа бол Монгол урианхайн туулиудийн судлагдаагүй соёл мөн. Тод-монгол бичгээр үзэглэсэн сангийн судруудад зам, замын бэлчээрийн эзэн, гэр, гэрийн шүгүү, орон хийд эзэнтэй гэж бий.

Цагаан, хар, улаан, шар, хөх жавхлант таван өнгө бүхий *Бодонгууд* бол тодорхой биет юмс, ургамал амьтан сав, шим ертөнцийн *эзэн Тэнгэр* мөн гэнэ. *Талын Харбодон* бол хурмастын хаан, Дээд замбуу тивийн захирагч хар цоохор луугийн хувилгаан дүрээр заларч үзэгддэг *хар Махагал шүтээн*, Талын Харбодонгийн сүр сүлдэнд урианхайчууд залбирч онголон дархалдаг. Юмнаас ангид оршдог хар цоохор луугийн хүчин увдис шингэсэн тэнгэрийн таван луугийн нэг нь Талын Харбодон дүр юм. Дээд замба тив хурмастын хаан хар цоохор луугийн дүрээр үзэгддэг.

Талын Харбодонгийн хатан нь *шар цоохор луу* Ногоон Дара эх гэнэ.

Талын Харбодон туульд *Газрын эзнийг* дов сондуулаас гаралтай хар өнгөтэй, доод Лустаас угшилтай догшин *довон Харбөх* (1-930-р мөр шүлэг) гэнэ. Монгол хэлний дов /dobu/ нь чийгтэй нуга, намагт байх овгор, товгор газар (Я.Цэ.1956:195) болно. Талын Харбодонг тэнгэрээс газарт бууж уул, даваа үгүй уудам цэлгэр талыг бүхэлдээ эзэрхсэн гэнэ. Тэнгэр язгууртай талын Харбодон бол хөрст газрын эзэн довон Харбөхийн хүү (931-7955-р мөр шүлэг) юм. Газар, тэнгэр хоёрын дундаас үүсэн бүрэлдэж төрсөн хүүг нь гунан Харбодон (7956-9825-р мөр шүлэг) гэнэ. Гунан гэдэг тодотгол нь зарим амьтны эр хүйст гурван настыг заасан үunan, үun-а нэрээр нэршсэн эрэлхэг, идэр залуу баатар эрийн хүч, сүр, чадал төгөлдрийг заасан нэр болно.

Урианхайн туульчид чулуу, мод, ус. булаг, рашаан. мөрөн гол, уул, даваа, онь хөтөл, эрэг ганга, судаг жалга, замын уулзвар бэлчир, цэцэг ногоо, бургас, сөөг мод, өвс ургамал цөм эзэн савдагтай байдаг гэж сэтгэн, сонсогч нартаа үүнийгээ туулиараа бүрэн итгүүлж чаддаг. Энэ санаагаа тайлбарлаж мод, чулуу, өвс ногоо, булаг усны эздийг өмгөөлөн бусдаас харсан хамгаалж байх ёстой гэж сургамжилдаг. Урианхай сонсогч нар туульчийн хайлсан туулийн үйл явдалд бүрэн итгэж, тууль,туульчийг хүндлэн бүх юмны эздээс хишиг буян, заяа гуйж залбирдаг. Энэ нь мод, чулуу. ус, амьтан, тэнгэрнэрийг шүтэн хамгаалах урианхай ардын соёл. Тэгээд өөртөө, гэр бүлдээ, үр хүүхдэдээ, мал хөрөнгөндөө учирсан золгүй явдал, өвчин зовлон, гай гарз барзадыг *юм, юмс*, түүний эздийг гомдоосноос болов, хангай дэлхийтэй буруу харьцсанаас боллоо хэмээн өөрийгөө зэмлэн буруушаадаг. Монгол урианхайчууд *юмс, юм*ны эздийг баясгах гэж мэргэн туульчийг гэртээ урьж, тууль хэлүүлдэг соёл нь ийм учиртай байжээ.

Туулийн үгийн ид шид, туулийн уян налархай аяэрэлхэг айзамд, *юм*, *юмс*ын эзэд уяран баясдаг, бас айн цочирдож улмаар гэр орон, хашаа хороо, биеэс зайлан холддог гэж тоольчин, сонсогч нар бас итгэдэг байжээ. Үгийн ид шид, хөгжмийн увдис, туульчийн шившлэг, тарнийн хүч нэвт шингэсэн ийм туулийн нэг бол Урианхайн алдарт туульчин Авирмэд, Чойсүрэн, Буян нараас бидний сонссон Тавин дөрөө дөрөөлж морддог. Тас хар хээр морьтой ТалынХарбодон гэдэг тууль болно.

Нүүдэлчин монгол ахуй заншил сайн мэддэг, монгол хэл овоо сайн гадарладаг гадаад хүн яавч Талын Харбодонгийн морины эмээл 50 дөрөөтэй байсан гэж ухаарахгүй нь лавтай. Монгол эмээлд буруу, зөв талын хоёрхон дөрөө байдаг. 50 дөрөө дөрөөлж морддог гэдэг хэллэгийг харь хэлэнд юу гэж орчуулах вэ?

Амин сүнсийг оршоох нь. Талын Харбодон зэрэг урианхайн таван бодонгийн тухай туульд туулийн баатрын сүлд хийморь, онгон шүтлэг нь оршдог нутаг бэлчээр, гэр орон, байгаль дэлхийн баялагт шунан халдаж дээрэмдсэн этгээдийг гэсгээн шийтгэдэг олон арга байжээ. Догшноор хэрцгийлэн хороох нэгэн аргын тухай одоо товчхон хэлье. Энэ нь мангас, шулам буюу өширхөн халдаж ирсэн дайснаа ялагч баатар *өрлөөж* гараар нь элгийг нь базуулж, гашуун цөснөөс нь нүдэнд нь дусааж, сэмжээр нь нүүрийг нь бүтээж, халуун шар наранд эзгүй ээрэм шар талд амин сүнсий нь /amin sünesün / цээрлүүлэн гээж оршуулав гэж өгүүлдэг юм. Ингэж оршуулах нь ялагдсан дайсны *амин сүнс* дахин сэргэж гай зовлон, өвчин тахал гаргадаггүй юм гэсэн эртний урианхай оршуулгын нэгэн зүйл дом гэнэ.

Хэрэглээ. Талын Харбодон туулийг юуны учир, ямар зориулалтаар хаана, хэзээ хайлан хэлдэг *хэрэглээ*ний дэг журмын тухай урианхай туульчид өргөн мэдлэгтэй. Талын Харбодон туулийг дараах хэдэн зорилгоор сонсогч нар гэр орондоо хайлуулан хэлүүлдэг.

- Үр хүүхэд хүссэн залуу гэр бүл
- Үр садан нь тогтдоггүй айл өрх
- Хижиг өвчин, ад тотгор, гай барцад, цаг бусын үхэл зовлонгоос хамгаалах

- Догшин араатан, жигүүртний халдлага, чоно, нохойн аюул хөнөөлөөс сэргийлэх, нутаг бэлчээр, мал хөрөнгөд учирч болзошгүй ган гамшгаас урьдчилан хамгаалах

- Догшин лус, савдгийг тайвшруулан, зайлуулах дом, шившлэгийн хариулга гэж баттай итгэж хайлуулдаг.

Талын Харбодон туулийн тухай энэхүү ардын соёлын мэдлэг, шүтлэг нь урианхайчуудын сүсгийн нэг хэсэг юм. Талын Харбодон туулийг гэртээ нэг удаа туульчаар хайлуулбал бурхан шашны тарни тогтоолын ид шидэт увидас шингэсэн Бусдад үл ялагдагч ад зэтгэрийн хариулга болсон Цагаан шүхэртийн тогтоол тарнийг лам багшаар гурван удаа гэр орондоо уншуулсантай тэнцдэг увдистай гэж урианхай туульчид, сонсогч нар баттай итгэдэг.Цагаан шүхэрт судрын агуулгыг Цагаан шүхэрт судрын тухай гэсэн хэсэгт хойно өгүүлсэн бий. Төвд хэлнээс Аюуш гүүш, хутагт Намхайжамц нарын орчуулсан Цагаан шүхэрт судрын тод-монгол, худма-монгол хоёр хувилбарыг хавсаргасан болно.

Бодон уу? Үжин үү? Урианхайн таван Бодонгийн тухай туулийн шар, хар, улаан, хөх, цагаан өнгөөр тодотгосон „бодон“ гэдэг үг нь сүлд онгоны нэр болно. Эртний Урианхай-монголчууд Газар, Тэнгэр, Хүн гурвын эзэн, сүлд нь „бодон“ гахай юм гэдэг байжээ. Бодон гэдэг үгийг монгол язгуурын хэлний фужин-пүдүнг, пудин-үжин гэдэг үгийн гаралтай холбон тайлбарлаж, Бодон бол эмэгтэй хүний нэр, цол гэсэн Мелитинскийн санал үнэмшил муутай тааварласан тайлбар гэж бодож байна.

Талын Харбодон гэдэг Урианхай туулийн Бодон гэдэг үгийг монгол хэлний „үжин“-тэй харьцуулсан тайлбарыг дэлгэрүүлэн хэлэлцэж болно. Монгол хэлний түүхэн авиа зүйн хувьслын нэгэн хуулийг цухас өгүүлье. Энэ нь эртний монгол хэлний өдий төдий үгийн эхэнд байсан хоёр уруул хамжиж хэлэгддэг п, уруул шүргэн өгүүлэгддэг ф гийгүүлэгч нь дундад үеийн монгол хэлэнд төвөнхийн шүргэх х болсон юм. Улмаар орчин цагийн халх, буриад, ордос, халимагийн хэл аялгуунд, үгийн эхний п->ф->х нь ул мөргүй арилж эгшгээр эхэлсэн үгсээр дуудагддаг болов. Монгол хэлний авиазүйн түүхэн хувьсалын энэ үр дүнг хэлшинжлэлийн талаас таньж мэдвэл Бодон; Пүдүн->үжин гэдэг үгийн гарлыг сая зөв ухаарах юм. Бидний ойлгож байгаагаар

бол үжин, бодон нь өөр, өөр гаралтай монгол хэлний түгээмэл дэлгэрсэн үгс. Буриад-монголчуудын бичиг зохиолын хэлний бодон гэдэг үгийг К.Черемисов (1973:97) зэрлэг гахай гэж орос хэлээр орчуулсан байна. Халимагуудын бодон хэмээх үгийн Г.Рамстедтын герман орчуулга буриад-монголтой дүйж байна. Г.Рамстедтийн толиос нилээд хожуу зохиосон Б.Муниевын Халимаг-орос хэлний орчуулгын тольд (1977:104) Жангарын бодонгууд гэдэг хэллэгийг богатырь (баатар, эрэлхэг) герой гэжээ. Өвөрлөгчдийн хэлэнд бидний хэлэлцэн буй бодон гэдэг үгийг Сэцэнцогт зэрлэг гахайн эр; эр гахай; шилжсэн утга нь баатрын цол; хоёрдугаар дэс баатрыг заадаг байжээ. Бодон Зул хааны жич (Монгол үгсийн язгуурын толь 1988:767) гэсэн утгаар хэрэглэгддэг.гэжээ Г.Дөрфэр зохиож 1965 онд Виэсвадэн хотод хэвлүүлсэн Түрэг, монгол хэлнүүдийн үгийн харьцуулсан толь бичигт Бодон гэдэг үгийн утга, гарлыг шинжилсэн тайлбар нь Үжин, Бодон гэдэг хоёр үгийн гарал үүсэл, утгыг алтай язгуурын хэлнүүдийн өргөн хүрээнд харьцуулан судалбал нэгдмэл, зөв ойголттой болно.

© Гурван Алтан шат/ =Гурван лусын орон. Туульч Б.Авирмэдийн ярьсан нь: *Миний мэддэг Талын Харбодон туульд гардаг гурван Бодон бол ертөнцийн* ***гурван их Алтан шатын*** *ам сахиж суудаг баатар эрс, тэнгэр, сахиулууд юм. Энэ ертөнцийг доод Луст(лус), дунд Луст, дээд Луст Хурмастаас тогтносон гэнэ. Дээд Лустаас дунд Лустаар дамжиж доод Лустын орон очих замдаа доод алтан шатын амаар орж дамжин өртөөлж хүрдэг гэнэ.*

Доод алтан шатын ам сахиж суудаг баатар сахиул нь Довон Харбодон болно. Дунд лусын алтан шатны сахиул нь талын Харбодон. Дунд Лустаас өгсөж хүрдэг Лусын орон бол дээд Хурмастын хааны нутаг. Тэнд хүрэх замд дээд Алтан шат тааралддаг. Дээд хурмастын хааны Алтан шатын ам сахиж суудаг баатар сахиул бол гунан Харбодон. Дээд хурмастыг бас дээд Замбатив гэдэг. Дээд Замбутивийг Харцоохор луу эзэгнэнэ. Урианхайн туульчид Харцоохор луу талын Харбодонг Хурмастын эзэн хаан гэж шүтэж бишрэдэг. Шарын шашны сурталаар бол Харцоохор луу нь хар Махагал бурхан гэж сонслоо.

Дээд лустаа (=хурмастын хаан хар цоохор луу бол есөн их галаар хүрээлүүлсэн догшин дүртэй сахиус. Есөн их гал дээд алтан шатны амнаас давж өнгөрөөд Хар цоохор Лустаад хүрч учран золгох замд байдаг.

☯**Есөн их гал** *бол Лустааг (Лусын хааныг) хамгаалж* ***суудаг анхны сахиул.*** *Наран хаан хөвүүн гэдэг өөр нэгэн туулийн баатар Арын өнчин Яргаа дээд алтан шатын амыг ид шидээрээ давж хаан Хурмастын эзэн хар цоохор Луугийн өргөө гэрт орох гэтэл өмнөөс нь Есөн их галын дөл улөөж, Арын өнчин яргайг хуйхалдаг.*

☯*Дээд Замбутив = Харцоохор лусын* ***хоёрдугаар сахиул нь*** **Хайр цагаан сэлэм.** *Хайр цагаан сэлмийг урианхайн туульчид:*

Усанд хийж царцаагаад
Хатыг тааруулсан
Нурманд хийж улайсгаад
Торгууд дархан товруулдаад хийсэн
Халх дархан хадааслаад хийсэн
Ерөн алд энэтэй
Есөн алд мөргөтэй
Хар зандан бариултай
Хавчиг цагаан гэртэй
Хайр цагаан сэлэм гэж магтдаг.

☯ *Дээд Замбутив= Хар цоохор лусын* ***гуравдугаар сахиул нь Аянгын цагаан сум.*** *Аянгын цагаан сумны тухай урианхай туульчид өөр өөрөөр нэрлэж Аянгын хий цагаан сум, Тэнгэрийн сум гэдэг.*

Тохой модыг мөсх өөчлөөд (тэгшлээд)
Том нарийн үзүүрийг тэгшлээд хийсэн
Тас бүргэдийн өдийг
Таллаж наагаад хийсэн
Хунд хурэн зэвийг
Толийтол хавчуулж наагаад хийсэн
Аянгын тавин
Түргэн цагаан сум *гэж Урианхайн бух туульд гардаг юм*

Дээд Замбутив= Хурмастын хаан Хар цоохор Луугийн хатныг Шар цоохор Луу буюу Ногоон Дара эх гэдэг гэжээ.

☯ **Урианхайн Талын Харбодон ба Махагал сахиусан.** Урианхайн туульчид Талын Харбодонгоо Нууц тарнийн Тантрын Ядам сахиус Махагал монголоор Гомбо бурханы ер бусын ариун нандин бурханлаг мөн чанарт

улируулан шүтдэг. Тантрын ёс бол асар их хатуужил сэтгэлийн тэнхээ бясалгалын хүчээр аливаа амьтан энэ насандаа ялгуулсан Буддагийн гэгээн хутаг бодхисадхвагийн мөн чанарыг олж өрөөл бусдад тус буяныг үйлдэх замаар бусдыг энэрэн тэтгэх тухай номлол сургаал.[4]

Махагалын магтаал шүлэгт Махагал нь дөрвөн мутартай, нэгэн нүүртэй, дүгрэг улаан гурван нүдтэй, төрөлхи ургасан шар үстэй, эгэл хүмүүнийг зуусан араатай, урд баруун гартаа илдтэй, нөгөө гартаа гаваалтай, дээд зүүн гартаа жадтай, дээд доод гартаа дэлгэсэн орунгату сэрээтэй... гэх зэргээр Юан гүрний үеийн алдарт Чойжи -Одсэр Махагалын магтаалдаа дүрслэн шүлэглэсэн байна.

Эртний Энэтхэгийн Хинду шашины Шива бурхны шүтлэгээс үүсэл гаралтай Махагала сахиусыг Монголын эзэнт гүрний төв хэсэгт тахин шүтэж байгаад Юан улс мөхсөний дараагаар ч мөн Лигдэн хаан болон Манж хаадын үед Махагал их сахиусын нэр хүндийг улстөрд ашиглах талаар тууштай бодлого хэрэгжүүлж байжээ.

Урианхайн туульчид өрөөл бусдад туслаж буяныг үйлдэн бүтээж тэдний сэтгэлийг эзэмдэн энэрэн тэтгэхийн тулд айл гэрт уригдан очиж, алдарт Талын Харбодон туулиа хайлан уншдаг байжээ. Эртний монгол хаад дайн тулааны үеэр сүмд очиж догшин сахиус хар Махагалын тахилга мөргөлөө төрийн түвшинд үйлддэг байсан нь шашны уламжлалт тогтсон заншил мэт болжээ.

4. Ш.Бира Их Монгол улсын түүх үзэл суртлын зарим асуудал УБ 2006:88-89

Талын Харбодон мөчлөг туулийн агуулга, мотив

Газрын эзэн Довон Харбөх туулийн мотив

0-15 Туулийн эхлэл
16-25 Довон Харбөхийн нутаг орон
26-140 Довон Харбөхийн таван хошуу мал
141-212 Довон Харбөхийн өргөө гэр
213-265 Довон Харбөхийн ид хав, бие галбир
266-295 Довон Харбөхийн хээр морины увдис
296-328 Довон Харбөхийн хатан Харлустын охин Харнүдэн дагина
329-415 Их найр наадам
416-480 Довон Харбөхийн гуниглал
481-535 Довон Харбөх, Эсрүн хурмастын анир биш анир сонсов. Хүнд хөлтэй хүлгийн чимээ чагнав.
536-615 Догшин язгуурт хайрын Хар-Улаан залуу
616-668 Харнүдэн дагина *эрхээр мэргэлээд* хэлсэн үг
669-735 Хайрын Хар-Улаан залуу газар эцгийн Довон Харбөх, Харлустын охин Харнүдэн дагина эцэг, эх, хүү гурвын ерөөлт учрал
736-760 Довон Харбөхийн айлтгал үг
761-790 Хайрын Хар-Улаан залуугийн хариу хэлсэн үг
791-825 Довон Харбөх хүүгийнхээ Алтан хонголцог хайчилж алдар нэрийг дуудсан нь
826-930 Их найр наадам

Тэнгэрээс заяатай талын Харбодон туулийн мотив

931-960 Талын Харбодонгийн зүүд
961-1130 Талын Харбодон хувцас хунараа өмсөв.
1131-1200 Талын Харбодон хүлэг морио шинжив.
1201-1295 Талын Харбодон морио эмээллэж, зэр зэвсгээ агсав.
1296-1390 Талын Харбодон нутаг орноо эргэн явж, ан авын довтлох дасгалд мордов.
1391-1495 Талын Харбодон ан аваас эргэж ирэв.
1496-1685 Талын Харбодон, Аранзаа хааны Алтансолонго дагиныг авахаар явав.

1686-2175 Луу шар морьтой Луузан Тив хааны нутагт

2176-2553 Талын Харбодон, Луузан Тив хааны ууган хүү Чин-Алтанбүстэй (бислэгтэй) тулалдав.

2554-2745 Талын Харбодон, Луузан Тив хааны дунд хүү Төмөрзүрхэнтэй тулалдав.

2746-3335 Талын Харбодон, Луузан Тив хааны отгон хүү Хүрэл-Арслан магнайтай тулалдав.

3336-3550 Дээд хаан Хурмастын ухаан тарни баригч Арш дээд ламын мэрэг төлөг.

3551-3670 Талын Харбодон, Хүрэл-Арслан магнайг дийлсэн нь.

3671-3840 Талын Харбодон, Луузан Тив хааны нутагт оров.

3841-4125 Талын Харбодон, тэл хонгор морьтой Тэвэг Алтанзултай ах дүү бололцов.

4126-4240 Талын Харбодон, Луузан Тив хаан хоёр.

4241-4450 Тэнгэрийн хөвгүүдийн сүнс дуудах ёслол. Тэнгэрийн хөвүүн Тэвэг Алтанзул аюуш цагаан хадгаар даллан шившиж Хүрэл-Алтан магнай, Чин-Алтанбүс, Төмөрзүрхэн баатар гурвын сүнсийг дуудаж амьдруулав.

4451-4580 Тэнгэрийн хөвгүүдийн ах дүү бололцох ёслол. Луузан Тив хааны хүүхдүүд ах дүү гурван баатартай талын Харбодон анд бололцов.

4581-4735 Талын Харбодон, Аранзаа хааны Алтансолонго дагиныг авахаар аян замаа үргэлжлүүлсэн нь.

4736-4755 Тэнгэрийн хөвгүүдийн гэрлэх ёслол. Тэвэг Алтанзул гэрлэв.

4756-5315 Тэнгэрийн хөвгүүд ба мангас. Талын Харбодон, өндөр шаргал морьтой Шархааны Шаралдай Мэргэнбаатар, Шулаг улаан мангас гурав.

5316-5620 Талын Харбодон, Аранзаа хаанд хүрэв.

5621-5875 Талын Харбодон, Оронгоон хөх бухны халуун бөөрийг олж ирэхээр явав.

5876-6320 Талын Харбодон, Сариг цагаан ингэний баруун хөхний сүүг олж ирэхээр явав.

6321-6745 Лусын хорлол. Талын Харбодон, Хангарьдын отгон хар зулзагыг олж авчрахаар яваад хортон шар цоохор могойд хорлогдов.

6746-6830 Талын Харбодонгийн амийг Арш дээд лам тарни бясалгаж аврав.

6831-7065 Талын Харбодон гэрлэж өргөөлсөн найр.

7066-7125 Талын Харбодонгийн нутаг орныг дөнөн Шаргарьд дээрэмдэв.

7126-7955 Талын Харбодон, дөнөн Шаргарьд хоёр тулалдав.

❁ Талын Харбодонгийн хүү, гунан Харбодон туулийн мотив

7956-8655 Дөнөн Шаргарьдтай Гунан Харбодон тулалдав.

8656-8755 Дөнөн Шаргарьдтай Хүрэл-Арслан магнайн хүү гунан Улаанбодон барилдав. Атаа таван тэнгэр тахих ёслол.

8756-8775 Гунан Харбодон, гунан Улаанбодон хоёр дөнөн Шаргарьдын нутаг орныг ээзлж нүүлгэв.

8776-8895 Догшин Харбөх, талын Харбодон, гунан Харбодон, Луузан Тив хааны Төмөрзүрхэн баатар, Хүрэл-Арслан магнай, тэвэг Алтанбүс. Тэнгэрийн хөвгүүдийн нөхөрлөл.

8896-9275 Хүрэл-Арслан магнайн хүү, гунан Улаанбодон алга болов. Алтансүмбэ гунан Улаанбодон хоёрын нөхөрлөл.

9276-9825 Гунан Харбодон, гунан Улаанбодон хоёрын эхнэр авсан түүх. Тэнгэр, газрын хөвгүүд лусын дагинастай гэрлэж, өргөө гэрээ барьж, хошуу нутгаа амирлуулан төвшитгөсөн нь.

Талын Харбодон тууль (Хувилбар)

Газрын хөвгүүн довон Харбөхийн бүлэг

Эрт урьд эхэн түрүүн цагт
Гадаад далайг
Балчиг өрөм тогтож байхад
Галбарсан зандан модон
Найтаг жирээ байхад
Сүн далай өрөмтөж сүмбэр уулыг
Довон толгойн төдий байхад
Шинэхэн маань үүсэж
Шамбалын дайн эхэлж байхад
Аягын чинээн шар наран
Алтан дэлхийн өрийг
Шинэхэн гэрэлтүүлж байхад
Дунд замба тивийн хорон шүү ихдэж
Хортон дайсан олшроод байхад
Орон замба тивд хүйсэн болоод
Орчлонд бахана болсон сүвээгээ дараад
Сүүдрээн бөглөөд тогтсон
Далан долоон хар уул нутагтайхан байдаг
- Долоон муж хүрсэн албаттайхан
Алтайн эхэн шилээр
Дүүрээд өссөн алаг бараан
Адуутайхан байдаг
Хангайн эхэн шилээр
Дүүрээд өссөн
Хар бараан адуутай байдаг
Тэр л адуун сүргийн
Ахлаач нь өмнөөс нь харахаар
Мянган агтын өлзийтэй
Түмэн агтын хишигтэй
Ардаас нь харахаар агт бүрний

Аранзулын шинжтэй
Арван дүнчүүр хүрмээр
Ижилтэй төрсөн
Хүлэг биш
Хүрэл эрдэнээр бүтсэн
Морин биш
Молор эрдэнээр бүтэлдсэн
Эвэртэй төрсөн нарийхан хар
Хээр азаргатайхан байдаг
Харгантын голыг
Дүүрээд өссөн
Хар манхан тэмээтэй байдаг.
Өлөнтийн голоор дүүрээд өссөн
Хүрэн улаан тэмээтэй байдаг
Тэр л тэмээн сүргийн
Ахлаач болохоор
Өмнө бөхөнд нь
Хөөсөн шавдар хуяглаж
Нугархай явдаг
Ар бөхөнд нь
Шээсэн шавдар хуяглаж
Туг сэрээ[1] ганхаж явдаг
Туулайгаараа
Буйл л товх шургуулж
Бурантаг хамар зүүлгэж
Үзээгүй төрсөн.
Бөхөнд нь
Хом шат хүргэж
Ачаа бараа ачиж
Аян жинд явж
Үзээгүй төрсөн
Ширээ бөхөөн сажиж
Шийр л тавгаа тасалж

1. Ширээ бөх

Үзээгүй төрсөн
Зулааны нь
Зунгагтай хар зогдорт
Хүний дүнтэй
Хүрэн улаан залаа
Хэзээ дөрвөн цагийн
Улиралд хадаатай явдаг.
Үдийн газраас
Үнэр авдаг
Хоногийн газраас
Саг[2] л авдаг
Хажир хар манхан
Бууртай байдаг билээ.
Яргайтын голоор дүүрээд өссөн
Ялан улаан үхэртэй байдаг.
Түнгэтийн голоор дүүрээд өссөн
Түмэн улаан үхэртэй байдаг
Тэр л үхэр сүргийн
Ахлаач нь болохоор
Зуун алд чээжтэй
Зуур л хономоор нуруутай
Хангайн чинээн биетэй
Хаш эрдэнэ шиг эвэртэй
Өдөр шөнийн
Хорин дөрвөн цагт
Үргэлж урамдаад явдаг
Хоо улаан бухтай байдаг.
Хотоор дүүрээд өссөн
Хотгор цагаан хоньтой байдаг.
Хөдөөг бүрхээд өссөн
Хөвөн цагаан хоньтой байдаг.
Тэр л хонин сүргийн
Ахлаач нь болохоор.

[2] Аширчимээ

Хурган цагаасаа
Хуцтай мөргөлдөөд явдаг
Хуц л болж
Хуцаас айж л үзээгүй
Тэвх болсон сүүлтэй
Тэгш сайхан биетэй
Таван өнгөөр тагнайлаад
Арван өнгөөр
Аргамжлаад ургасан
Эвэртэй байдаг.
Атгар цагаан халзан
Хуцтай байдаг.
Явраар дүүрээд өссөн
Ялан улаан ямаатай байдаг
Хадаар дүүрээд өссөн
Харлаг цоохор ямаатай байдаг
Тэр л ямаан сүргийн
Ахлаач нь болохоор
Ишгэн цагтаан
Ялгарч л мөргөлдөөд явдаг
Тэнгэр өөдөөн солбилдож
Ургасан эвэртэй байдаг
Тэр л тивийн өрд
Цацарч л явдаг
Сахлаг сайхан
Сахалтай байдаг
Хөвөн зөөлөн ноостой
Хөж өтгөн хялгастай байдаг.
Тэгш орог саарал
Тэхтэй[3] байдаг билээ.
Таван зүсэн мал нь
Таг л тэр болоод явнаа.
- Түүний дараа талд

3. Ухна

Адарган далан долоон
Хар уулынхаа
Өмнө л талд
Долоон олон муж
Албатынхаа төв дунд
Тавилдаад орсон
Тавин голын бэлчирт
Уралдаад орсон
Олон голын бэлчирт
Унаган морин уралдаад
Уядаад дандаад ирмээр
Ужим хөх ширгийн[4]
Өр дунд.
Дааган морин дагаралдаад
Дандаад уядаад ирмээр
Данхан хөх ширгийн
Өр дунд
Далан найман тэрэмтэй[5]
Долоо найман зуухан уньтай
Далай цагаан өргөөг
Далбайж дүнхийтэл нь
Барьж байгуулаад ирэв лээ
Шинэ сайхан дээвэр туургаар
Шижигнэтэл хаагаад баринаа л
Хошлон[6] хар оосрын
Эргээ солио гаргаж
Эвээ дор нь тааруулаад
Уяад явнаа.
Тотго талд нь
Тогос гургуул
Тонголзуулан сийлээд явнаа.

4 [illegible]
5 [illegible]
6 [illegible] бүстүүр, уяа

Эрхэн[7] талд нь
Элээ ангир шувуу
Эргэн нисгэн сийлээд явнаа.
Хасавч талд нь
Хан гарьд шувуу
Хагшилдуулан сийлээд явнаа.
Тэрэм талд нь
Тэх хуц хоёрыг
Тэгш сайхан
Мөргөлдүүлэн сийлээд явнаа.
Унин талд нь
Уулын улир хойлог шувууг
Уралдуулан нисгэж
Сийлээд хийсэн
Гарайц[8] талд нь
Гарьд шувууг
Гарайдуулан[9] сийлээд
Цагираг талд нь
Цах шувууг
Чашгалдуулан сийлсэн
Дөрвөн хусан баганатай
Байдаг билээ.
Багана талд нь
Бар арслан хоёрыг
Базгалдуулан сийлээд явнаа.
Баруун талын барааг
Батлан дүгнэн хураагаад
Бар цоохор хивсээр
Бүтээж л хураагаад
Зүүн талын барааг
Зүглэн дүгнэн хураагаад

7. Босго
8. Тооно
9. Харайлгаж

Зүр[10] цоохор хивсээр нь
Зүйж л бүтээгээд явнаа
Наян найман хөлтэй
Нарийхан ширээн өр нь
Тавиастайхан байдаг
Наян давхар ор нь дэвсээтэйхэн
Нарийхан хар түнтэг[11]
Дэрлээтэйхэн байдаг
Нимгэн булган хөнжил нь
Хуйлаастайхан байдаг.
Дараа талд нь
Хаан эзэн баатар нь болохоор
Таван зүсэм малаар
Таг тэгш л төрсөн
Төрөөд төлжөөд
Төмөр дөрөө гишгээд
Төр гүрнээ алдаж
Үзээгүй төрсөн
Гараад галжаад
Ган дөрөө дөрөөлөөд
Газар усаан алдаж
Үзээгүй төрсөн
Хүн хүнээс
Хүзүү сээрээр илүү төрсөн
Хаа талд нь
Хадраад авдаг
Тоомгүй[12] төрсөн
Харцага талд нь
Нугалаад авдаг
Үегүй төрсөн
Хатан аман хүзүүгээр нь
Зэвтэй сумаар харваж

10. Зүр буга. гөрөөс
11. Жинтүү. дэр
12. Үегүй

Даадаг түүхгүй төрсөн
Цуур цагаан ястай
Цул хар махтай
Богино хавирага нь
Ганган бүтэлдээд төрсөн
Бор зүрх нь
Болдоор бүтэлдээд төрсөн
Ээм далаар барилдаад
Дийллэгддэг түүхгүй төрсөн
Эрхийтэйгээр харвалцаж
Нэг л сумны харваа
Алддаг түүхгүй төрсөн
Хорон хар дайсантай
Харгалдаж[13] автагддаг[14]
Түүхгүй төрсөн.
Халуун хол газар явж
Харидаг түүхгүй төрсөн
Хажир хар дайсантай
Харгалдаж халтирдаг
Түүхгүй төрсөн
Ужим хол газарт явж
Уяддаг түүхгүй төрсөн
Учираад ирсэн
Дайсантай харгалдаад
Дийлэгддэг түүхгүй төрсөн
Унаад явдаг уналганы сайн
Унаа хийх үлэг
Морин болохоор:
Магнай талдаа тэлүүн[15]
Махан талдаа бат
Самнаа талдаан шингэн

13. Уулзаж
14. Дийлэгдэх, ялагдах
15. Тэнүүн өргөн

Сайр талдаан төвшин төрсөн
Сүүл талдаа өтгөн
Сүвээ талдаа уужим.
Шөрмөсөн талдаан хурдтай
Шүдэн талдаа тэгш
Хөл талдаан хурдтай
Хөмсөг талдаан зузаан.
Хуугийн цорго далантай
Хонх л хоёр чихтэй
Өрмөөн ир соёотой
Өрлүүвээн аман эрүүтэй
Хүлэг биш
Хүрэл эрдэнээр бүтэлдээд төрсөн
Морин биш
Молор эрдэнээр бүтэлдээд төрсөн
Дав дээрээн
Далан нэгэн хурдтай
Нав дээрээн
Наян хоёр шидтэй төрсөн
Далан дөрөө
Дамжиж морьддог
Долдоо догшин хар
Хээр морьтой
Довон Харбөх гэж
Алдар их нэр нь
Арван тивдээн
Цууриатай байдаг.
Дорвитой их нэр нь
Долоон тивдээ
Доргиж байдаг билээ.
Далан дөрөө
Дамжиж мордмоор
Долдоо догшин
Хар хээр морьтой

Довон Харбөхийн
Төрийн нь товч
Төмрийн хадаас нь болсон
Зах л таван товчий нь
Шигтгээд суудаг
- *Заяаны хатан дагина* болохоор:
Гэр ивт гэгээтэй
Гишүүний нь улаан хацартай
Туурга ивт туяатай
Тунгалаг улаан хацартай
Гарахын нарны шинжтэй
Орохын нарны өнгөтэй төрсөн
Ардах юмыг
Арван таван ерэн есөн
Жилийн газраас алдалгүй
Айлдаж мэдэж суудаг
Урдах жилийн
Хорин таван
Ерөн есөн жилийн юмыг
Угтаж мэддэг
Харлустын дагина
Харнүдэн хатантай байдаг.
Довон Харбөх
Долдоо догшин хар
Хээр морьтойгоо
Харнүдэн хатантай гурвуулаа
Далан долоон
Хар уулдаан нутаглаад
Долоон олон муж
Албатаан ахлаад суухад
Довон Харбөхийн
Алдар их нэрийг
Холын амьтан сонсоод
Ойрын амьтны

Сүрийг дараад суухад
Гаднаас эвдээд ордог
Дай дайсангүй
Дотроос л эвдээд гардаг
Гай зэтгэргүй
Олон жилийн онь
Олон сарын адаг
Өнгөрч л байхад
Довон Харбөх
Долоон олон муж
Албатаан цуглуулаад
Алаг бараан адуу
Хар л бараан адуу
Хоёрыгоо хураагаад
Жаран алд л зэл татаад
Жараахай болсон унага
Даага зэллээд зуун алд зэл татаад
Дангийн ижил зүсмийн олон тугал чагтлаад
Зааны арьсан архадаан[16]
Татаж сэргээгээд
Зандан модон билүүрээ
Бүлэн дүүрэн сэргээгээд
Шинэ гүүний сүүгээр
Шихэр бурмын амттай
Шингэн цагаан чигээгээн
Хатуу амтай
Хар архийгаа
Хангинатал нь нэрж гаргаад
Далай болсон архи айраг
Даранх болсон
Мах идээгээн бэлтгээд
Архи айраг махан гурвыг
Тэмээгээр ачиж буулгаад

16. Хөхүүр

Тэргээр зөөж буулгаад
Дараа талд нь
Урт шар бүрээ татаж
Олон түмэндээн
Зар чимээгээн өгөөд явнаа.
Нарийн шар бүрээгээн
Сунган татаад явнаа.
Найман түмэнээ цуглуулаад
Далай цагаан өргөөний
Дотор талд
Баг шиг цуглараад
Багтаж ядан
Сууж суурилаад
Баруун гол суурийн эхэнд
Довон Харбөх
Ахалж сууж л суурилаад
Зүүн гол суурийн эхэнд
Харнүдэн хатан ахалж
Сууж л суурилаад
Баруун ар л суурийн эхэнд
Бажгар улаан түшмэдүүд
Багтан ядан сууж суурилаад
Баг хар отгодууд нь
Саглайлдаад явнаа.
Бадам эрээн жинсүүд нь
Гэрэлтээд явнаа.
Тогосын сүүл л отгодууд нь
Саглайлдаад явнаа.
Тольтой гэрэл жинсүүд
Гэр дотор гэрэлтээд байв
Зүүн ар л суурийн эхэнд
Зүйтэй олон бүсгүйчүүд нь
Зүтгэн сууж суурилаад
Баруун зүүн талаар нь

Баг шиг суугаад ирэхэд
Довон Харбөх
Харнүдэн хатан
Хоёроос эхлээд
Архи махан чигээн гурав
Адгаар нь арай чүү
Шувтлаад ирэв л
Ар дараа талд нь
Уялдсан сайхан
Дуугаа дуулаад ут сайхан найраан
Эхлээд авав л.
Тэр өдрийг
Тэсэн найрлаад
Тэр шөнийгөө
Дөлөн найрлаад
Түүний мангадар[17]
Бас л найрлаад байв.
Амаргүй арван таван хоногийн
Адаг өнгөртөл найрлаад
Адаг сарын шинийг
Үзэж найрлаад
Хочгүй
Хорин таван хоногийн
Адаг өнгөртөл нь найрлаад
Хойт сарын шинийг
Үзэж найрлаад байхад
Довон Харбөхийн
Хар л зөндөөн
Хангал хар элэг нь
Харлаад ирэв лээ
Эмнэг хар л элэг нь
Эвхрээд суув л:
Өдөөн хаясан чулуунгүй

17. Маргааш

Өрөөс гарсан
Цовоо сэргэлэн үрэнгүй
Өхийх л нуруу
Өвгөрөх насан
Ойртож явнаа.
Далан долоон хар уул минь
Эзгүй хоцордог байнаа.
Долоон олон муж
Албат минь
Хажир хар дайны
Гарт орох цаг
Ойртож явнаа.
Долоон олон муж
Албат минь
Ямар сайхан найр
Жаргалтай болович
Дунд замба тивийн
Хорон шүү нь ихдэж
Хортон дайсан олширч байхад
Хажир дайны гарт оролгүй явнаа.
Далан долоон
Хар уул минь
Ямар их өвсөөр сэрмүүн
Ус нь тунгалаг
Өнгөтэй сайхан байвч
Эзгүй хаягддаг байнаа гээд
Хайхирч[18] дуудаад
Хэлээд суув л
Довон Харбөхийн
Булган хар нүднээс
Булгилж гараад
Алаг хар нүднээс нь
Айга хар нулимсан

18.Хашгирч

Мөндөрлөөд суув л
Довон Харбөхийн
Хэлсэн үгийн хий
Сүүл тасраагүй байтал
Анир биш
Анир гараад явнаа
Арван тивийн орон
Хүнгэнээд явнаа.
Хүнд хөлтэй
Хүлгийн анир
Хүнгэнээд явнаа
Хүн сайн эрийн
Ай чимээн гараад явнаа.
Үерийн усаар
Үйрмэг[19] чулуугаар
Шуурга тавиад явнаа.
Бүр бүр хур ороод
Сэр сэр салхин гараад явнаа.
Довон Харбөхийн
Далай цагаан өргөө нь
Дайвалж шижигнээд явнаа.
Хотгор сайхан бараа нь
Хөдлөөд байв л
Хонгор улаан гол нь
Түгшээд байв л
Довон Харбөх
Хайхираад хэлэв л:
Арван согтуу улаан
Түшмэдүүд минь л
Амаргүй хэрэг боллоо
Ажил биш явдал боллоо
Хүнд хөлтэй
Хүлгийн анир сонсоод байна

19. Жижиг

Хүн сайн эрийн
Ай чимээн гараад байнаа
Аль л зүгээс
Ямар шинжтэй дайсан
Ороод ирэж л байнаа
Өдөр шулуун[20] *гараад*
Халиатан[21] гэв л
Баруун талын хүн
Зүүн тал руу халиагаад
Энэ гэдэг үггүй
Өдий төдий цагийн үе
Өнгөрөөд ирэхэд
Арван согтуу улаан түшмэд
Ахлаад эргээд гараад ирэхэд
Өмнө л амхаан цагаан
Хөтөл өөд л
Халиагаад үзэхэд
Өмнө л амхан цагаан
Хөтөл дээр л
Хоёр нүдний хооронд нь
Хоёр тэмээг хол хол хэвтүүлээд
Хомноод ачаад босгомоор
Өргөн уужим магнайтай
Цээж хооронд
Хоёр хотон хонийг
Хоёр хөвүүн
Хол хол л хариулаад
Хонж л өнжөөд явмаар
Өргөн уужим
Цээжтэй төрсөн
Дал л хооронд нь
Далан таван агт

20. Түргэн
21. Харагтун

Сойж л уралдуулаад авмаар
Өргөн уужим
Далтай төрсөн
Харгай сайхан тэвгий нь
Халиуртал нь гүрээд
Хар ногоон утсаар
Харван ганган ширсэн
Чиргай сайхан тэвэг нь
Чихээн даган чичирээд
Цэнхэр торгон утсаар
Цэрвэн ганган ширсэн
Орон гүрнийг
Ор л ганцаар эзлээд
Олон түмэн албатыг
Би л ганцаар ахлаа
Төрлөөв гэхийн шинжтэй
Нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Хайрын[22] хар улаан залуугийн
Уулын дүнтэй
Тас хар хээр
Морин болохоор
Тагнай талдаа
Соёо нь гүйцээгээдгүй
Тахимы нь шар
Шөрмөсөн тэнийгээгүй
Тас хар хээр морьтойгоон
Нэг л арслан хар уулан дээр
Бас л нэг арслан
Хар уул тависан шигээн эр
Өмнө л амхаан
Цагаан хөтөл уруугаан
Бөхийтөл нь суугаад

22. Хайрласан, хаан эцгээс илгээсэн

Бадартал нь довтолоод
Дуугтал нь цохиод
Шуугитал нь тавиад
Ирж явахыг алдалгүй үзэв.
Арван согтуу
Улаан түшмэдүүд нь
Хариу гэдэргээний
Алхаад эргээд ороод ирэв.
Босго тотгын
Ар талд
Боол тулгын
Өмнө талд
Өвдөг тохой газардуулаад
Өнчин сүвээ мэхэлзүүлээд
Төөнө өвдөг газардуулаад
Төт хар толгой тонголзуулаад
Хэлдэг нь энэ л:
Хаан эзэн баатар минь
Өмнө л амхаан цагаан
Хөтөл дээр
Хоёр нүдэн хооронд нь
Хоёр тэмээг хэвтүүлээд
Хомноод ачаад босгомоор
Өргөн уужим
Магнайтай төрсөн
Чээж хооронд нь
Хоёр хотон хонийг
Хоёр хөвүүн
Хол хол л хариулаад
Хоноож өнжсөөд явмаар
Өргөн уужим
Чээжтэй төрсөн
Дал л хооронд нь
Далан таван агт

Сойж л уралдуулаад авмаар
Өргөн уужим
Далтай төрсөн
Орон гүрнийг
Ор л ганцаараа эзэлээд
Олон түмэн албатыг
Би л ганцаараа ахлаад
Төрлөөв гэхийн шинжтэй
Нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Хайрын хар улаан залуу
Тагнайны нь ар тэнд
Тагтай соёо гүйцээгүй
Тахимы нь шар
Шөрмөсөн тэнийгээгүй
Гунан хар хээр
Морьтойгоон хамт
Нэг л арслан хар
Уул дээр
Бас л нэг арслан
Хар уул тавьсан юм шиг
Өмнө л амхаан
Цагаан хөтөл уруу
Бөхийтөл суугаад
Бадартал нь довтолоод
Дуугтал нь цохиод
Шуугитал нь тавиад
Ирэж л явнаа" гэж хэлэв.
Довон Харбөхийн хатан
Хар Лусын хүүхэн
Эрх Харнүдэн хатан
Түмэн тоотой
Тоть л зандан эрхээн
Хоёр гурав эргүүлээд явнаа.

Хаан эзэн баатар
Уруугаа халиагаад
Өнгийн цэцэг хэвтээ
Солонго татагдаад
Чилгэр[23] огторгуйн наран
Саран хэвтээ[24]
Малмайж л улаагаад
Хэлдэг нь энэ билээ:
Хаан эзэн баатар минь
Өөдөөн хаясан чулуугүй
Өөрөөс гарсан үрэнгүй гэдэг билээ
Та, Сонсогтун!
Өөдөөн хаясан чулуутай
Өөрөөс гарсан үртэй
Болсон шиг байнаа бидэн хоёр.
Хаан хурмаст аав
Хар лу*ст ээж хоёр минь*
Харцутай сайн хөвүүнийг
Хайрлаад явуулсан шиг
Болдог нь юун билээ? гэв.
Эрх Харцүдэн хатны
Хэлсэн үгийн хий
Сүүл тасраагүй байтал
Далай цагаан өргөөний
Үүдэн талаар
Нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Хайрын Хар-Улаан залуу
Алхаад эргээд ороод ирэв л
Боол тулгын өмнө талд
Босго тотгын өр талд
Тойг өвдөгөө газардуулаад

23. Цэлмэг
24. шиг

Төт хар толгойгоо
Тонголзуулаад
Өвдөг тохой газардуулаад
Өнчин сүвээ мэхэлзүүлээд:
Хаан сайхан аав
Хатан сайхан ээж хоёр минь
Амар сайн гэгээд
Амар мэнд л мэдээд явнаа.
Довон Харбөх
Эрх Харнүдэн хатан хоёр
Би мэнд л
Чи мэнд л гээд
Мэндийн хариу өгөөд явнаа.
Дараа талд нь
Далан дөрөө
Дөрөөлж мордмоор
Долдоо догшин хар
Хээр морьтой
Довон Харбөх
Арван согтуу улаан
Түшмэд талдаан халиагаад
Хайхирч дуудаад хэлэв л:
Энэ л нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Хар улаан *залууд*
Аманд нь ойртуулж
Аяга унд өтгөр
Шулуун өгийт.
Алтай өргөн нутаг
Алдар их нэрэн
Хэт хол нутаг
Хэрэг зориг
Хэнд л болохы нь
Асуугаад авнаав гэв л

Хайрын Хар улаан залуу
Атан тэмээн хэвтээ
Алхлаад эргээд
Агт морин хэвтээ
Гүйн гишгилээд
Довон Харбөхийн
Доод талд л байсан
Үй түмэн нүдтэй
Үхэр хөх түшлэгтэй
Олон давхар
Олбог дээр
Хорин тохой газар
Хотойтол нь суугаад
Наян тохой газар
Нагцаатал[25] нь ирээд суув л
Арван согтуу улаан түшмэдүүд
Шинэ л гүүний сүүгээр
Чихэр бурмын амтаар
Шинэхэн бүрээд хийсэн
Шингэн цагаан чигээнээс
Далан таван шигширэгтэй
Далан хүн дамжлаад
Дамжилдаад уумаар
Далгаа цахиур
Ногоон шаазанд
Эвтэй барив л.
Эрхий дундуур
Чик[26] баривал
Чигчээ дундуур өргөн барив л.
Хайрын Хар улаан залуу
Дав дээрээн
Далан нэг хүргэж уугаад суув.

25. Хотойтол
26. Тэгш, эгц

Дараа талд нь
Хатуу амттай
Хар архины дээжээс
Хийж л бариад явнаа.
Нав дээрээн
Наян нэг донгодоод суув л
Дараа талд нь
Алтан юу тавганд
Алим өргөөг[27]
Асгартал нь хийгээд өгөв.
Аагтай улаан цайгаас
Хийж бариад явнаа
Довон Харбөх
Хайрын Хар улаан
Залуу тал руу халиагаад
Хайхирч дуудаад хэлэв л:
Ай наадах
Орон гүрнийг
Би ганцаараа эзлээд
Төрлөөв гэхийн шинжтэй
Олон түмэн албатыг
Би ганцаараа ахлаад
Төрлөөв гэхийн шинжтэй
Нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Хайрын хар улаан залуугийн
Алтай өргөн нутаг минь
Хаана билээ?
Алдар богд нэр чинь
Хэн гэдэг билээ?
Хэн гэдэг хүний үр садан
Хэн гэдэг хүн
Чи болдог билээ ч

27. Жимс. идээ

Хэт холын
Хэрэг зориг чинь
Хэнд болдог билээ?
Өтөр шулуун
Хэлээд өг хүүкэм[28] *минь* гэв л
Хайрын Хар улаан залуу
Хайхирч дуудаад хэлэв л:
Хаан Хурмаст *аавтай билээв,*
Хар Луст *ээжтэй билээв,*
Дунд замба тивийн
Далан долоон
Хар уул нутагтай
Долоон олон мужс
Албаттайхан байдаг
Далан дөрөө
Дамжиж мордмоор
Долдоо догшин хар
Хээр морьтой
Довон Харбөх *гэж байнаа гэнэ.*
Эрх Харнүдэн *хатантай гэнэ.*
Тэр л хоёр өөрөөсдөөсөө
Үр садан гарах
Түүхгүй юм гэнэ.
Одоо довон Харбөх*ийн*
Өхийх нуруу
Өвгөрөх насан
Ойртож яваа гэнэ.
Далан долоон хар уулын
Ус нь тунгалаг
Ямар сайхан өвстөй болович
Эзгүй хоцрох цаг
Ойртож байнаа гэнэ.
Долоон олон мужс албат нь

28. Хүү минь

Амар их жаргал цэнгэлтэй болович
Хажир хар дайны
Гарт орох цаг л
Ойртож явнаа гэнэ.
Довон Харбөх
Эрх Харнүдэн *хатан хоёрт*
Очиж «хөвгүүн» бол гэж
Алдар их нэрий минь дуудаад
Алтан хонолцогий[29] *минь*
Хайчлаад ачлал үзүүлж
Далан дөрөө
Дамжилж мордмоор
Долдоо догшин хар
Хээр морьтой
Довон Харбөх*ийн хөвгүүн*
Тавин дөрөө дөрөөлж
Дамжиж мордмоор
Тас хар хээр морьтой
Талын Харбодон *гэж*
Нэрий минь дуудаад
Намайг явуулсан билээ гэв л.
Хэлсэн үгийн сүүл
Тасраагүй байтал
Довон Харбөх
Эрх Харнүдэн хатан хоёр
Талын Харбодонгийн
Хүрэн улаан хүзүүгээр нь тэврээд
Бууман улаан хацарт нь
Бүргэд улаан хоншоороон хүргээд
Хий харгаад[30] унадаг нь энэ л,
Довон Харбөх аваан
Талын Харбодон сэрээгээд

29. Сэвлэг, нялхын үс, даахи
30. Ухаан алдаад, мууждаад

Баруун гол суурийн эхэнд
Өргөж суулгаад
Эрх Харнүдэн ээжээн
Сэрээгээд эргэж очоод
Зүүн гол суурийн
Эхэнд суулгаад, өөрөө
Довон Харбох аавынхаа
Дорд л хажууд ирээд суув,
Довон Харбөх аав нь
Талын Харбодон
Хүүгийнхээ найр хийгээд авдаг
Юман гэгээд
Далай болсон архи айраг
Даранх болсон мах идээгээ
Дахин нэмж бэлтгээд
Долоон улаан муж албатаан
Дахин зарлаж цуглуулаад:
Хар л уулыг минь цасан дарэк
Хар биеийг минь насан авлаа
Өөдөөн хаясан чулуугүй
Өөрөөс гарсан үрэнгүй
Гэж л явлаав.
Хаан хурмаст ***аав***
Хар луст ***ээж минь л***
Хариутай сайн хөвгүүн
Хайрланаа гэж
Хэн санадаг билээ.
Далан долоон хар уул минь
Эзгүй хоцорч
Долоон олон муж албат минь
Хэнсир хар дайны
Гарт ордог байна гэж
Зовж л явлаа би гээд
Дахин нэг их

Жаран жилийн жаргал
Наян жилийн найр
Жаргал цэнгэлийг эхлээд авав л.
Арван таван хоногийн
Адаг өнгөртөл нь
Найрлаад байхад
Талын Харбодон
Алхаад эргээд гараад явнаа.
Тас хар хээр мориныхоо
Ханхинасан эмээл хазаарыг
Хуу мөлтөлж аваад
Уяхан зандан модон
Уянд нь уяж
Саглагар зандан модон
Сүүдэрт нь уяж
Сүүдэрлүүлж хаяад явнаа
Дараа талд нь
Алхаад эргээд ороод явнаа
Араан чис хар
Модон шигээн саадгаан
Авч л хаяад явнаа.
Алттай хөө хуягаа
Тайчиж овоолоод явнаа.
Их найрын дундаагуур
Наян давхар орон дээр
Нимгэн булган хөнжилд ороод
Нүднийхээ хорон гашууг гаргаад
Хорон хар нойроон
Бясалгаад унтав лаа.
Довон Хар бөх
Долоон олон муж албаттайгаа
Найрын ихээр найрлаж
Жаргалын ихээр
Жаргаж цэнгэл хийгээд байхдаа

Саглагар зандан модон
Уяхан зандан модон хоёрыг
Навч мөчирөөн унагаагаад
Намрын хонгор шар
Салхин гараад байхлаар
Намрын сар мөн гэж
Найрлаад явнаа.
Халимтай мах нь царцаж
Хар архи нь шуурамталгаж[31]
Хөрөөд явахаар
Өвлийн сар үнэн гэж
Тэмдэглэж найрлаад явнаа.
Голын хөвөөгөөр
Ганц л нэг ногоон
Ургаад явнаа
Гадна дотно
Нүцгэн хөвүүд гүйлдээд
Хар л зэрэглээн татагтаад
Хар бараан мал нь
Үр төлөөн
Бүрэн гүйцэд бойжуулж
Дагуулаад байхаар
Хаврын сар л боллоо гэж
Тэмдэглэж найрлаад явнаа.
Долдоо догшин
Хар хээр морин
Тас хар хээр
Морин хоёрын
Уяхан зандан модон уяа
Саглагар зандан модон уяа нь
Навч мөчрөө гүйцээгээд
Найгаж ганхаад

31. Өрөмтөн хөлдөх

Өнгө өнгийн дуутай
Хөхөө сайхан шувууд нь
Хэрэн дөгөн [=баясч]
Хэсэн донгодоод байхад
Хөөгтэй зуны дунд сар гэж
Тэмдэглэж найрлаад байв л.
Загал цагаан өвөгчүүд нь
Замилан сууж найрлав л
Хөөр бага л
Хөлчүү елдэн[32]
Заар бага л
Задгай елдэн хөвгүүд нь
Зах хөлөөн олж л
Таньж ядалдаад найрлав л.

Тэнгэрээс заяатай талын Харбодонгийн бүлэг

Тэр л их найрын дундаагуур
Талын Харбодонгийн
Харанхуй шөнийн нь
Зүүдэнд "юман"ороод
Зүрхэнд нь "зөн" бодогдоод ирэв л:
Үүрээд явдаг
Араан чис хар
Модон шигээний саадаг нь
Өмсөөд явдаг
Алтан хөө хуяг нь
Цовд болон хатгаас зовоогоод
Дор нь байсан
Наян давхар ор дэвсгэр нь
Нарийхан хар түнтэг нь
Нимгэн булган хөнжил нь
Хоосон хуурай хар сай болж

32. Сахилгагүй, энхрий

Холгож зовоогоод ирэв л
Түүн дээр л
Талын Харбодон
Цочин сэрээд
Бумба улаан чээжиндээ
Бодон түдэн бодоод явнаа
Түүний мангадарын
Өрүүн[33] шар гэрэл
Магнайлж явахад
Яаралгүй босоод явнаа.
Ядалгүй хувцаслаад явнаа.
Хэнчир торгон захтай
Хив торгон цамцыг
Өмсөөд явнаа.
Далан жил дайлдаж
Дал ээмээр шилэрдэггүй[34]
Дан хөө хуягаа өмсөөд явнаа.
Хоорооноо[35] татаад явнаа.
Тавин жил таталдаж
Түмэн жил түлхэлдэж
Түүхийрч хувхайрч
Түүхий зэвийн үзүүр
Алддаг түүхгүй
Ган төмөр
Хөө хуягыг өмсөөд явнаа.
Суугийн[36] таван товчоо
Товчлоод явнаа.
Зах л таван товчийг
Сул л хаяад явнаа.
Арван таван тэмээг
Ороогоод ирмээр

33. Өглөөний
34. Хангардлагтүй
35. Хойшоо
36. Сугын. суга

Алттай нарийн цагаан бүсээ
Хар л харцагынхаа
Эхээр чангааж л татаад явнаа.
Цээлд нь хүргэж тогтоогоод явнаа.
Уруугаан татаж эргэлдээд
Түрий талдаан хаваастай
Зулаг талдаан угалзтай
Зуузай талдаан хошоотой
Наян давхар ултай
Нарийхан сайхан
Нагал алтан шахай госыг[37]
Бүдүүн бухын магнай болсон
Бөдтэй бүдүүн цагаан хөлдөө
Арай чүү багтааж
Өмсөөд явнаа.
Өөдөөн татаж эргээд явнаа
Дөчин дөрвөн салаатай
Дөрвөн мянган уялгатай
Дөлөөн хар боодгийг
Ар л далын гэрэл даган
Цацартал нь зүүгээд явнаа.
Тором тэмээний
Толгойн дүнтэй
Тож алтан
Сувсан сайхан сийхийг
Халхаан[38] хар махыг
Даган чичиртэл нь
Зүүгээд явнаа.
Хоороон татаж эргэлдээд
Мөнгөнөөс цайлгаад
Мөснөөс гялайлгаад
Цаснаас цайлгаад

37. Гутал. гутлыг
38. Хацар. хацрынхаа

Цааснаас нимгэлээд
Цасаар өнгөлөөд хийсэн
Олон чулуун
Эрдэнээр нүдлээд
Очир алтаар
Жинслээд хийсэн
Цоргил алтан дуулхаан
Орой дээрээн авч л
Өмсөөд явнаа.
Хоороон татан эргэлдээд
Жартай дархан
Жаран жил
Далтай дархан
Далан жил
Давтаад хийсэн
Хурц болтугай хийгээд
Хурдан морины туруугаар
Хуруйвсалаад хийсэн
Даалттай болтугай гэгээд
Далан булгийн усаар
Дамжуулж амсуулаад хийсэн
Хаттай болтугай гэгээд
Цөөрөм далайн усанд
Хатаагаад хийсэн
Төө болтугай гээд
Төгрөг нуурын дунд
Царцаагаад хийсэн
Хайр зандан модон иштэй
Хавчиг зандан модон хуйтай
Есөн төө мөрөгтэй
Ерэн төө энтэй
Хайрын хар бараан илдээн
Баруун ташаа талдаан
Бахийтал нь зүүгээд авав л

Тавин гүүний үнэтэй
Таж торгон алчуурыг
Ташир хамт хавчуулаад явнаа.
Хойшоон татаж эргэлдээд
Тавин тэхийн эврээр
Тагнайлж наагаад
Жаран тэхийн эврээр
Жиндэрлэж наагаад хийсэн
Эелдэг болтугай гэгээд
Элгэн талд нь
Усан хайнагийн эврийг
Элкэлж наагаад хийсэн
Хүчтэй болтугай гэгээд
Хүний зоогийн
Шар шөрмөсийг
Найм давхарлаж
Наагаад хийсэн
Харилттай болтугай гэгээд
Хос барын шөрмөсийг
Хоёр давхарлаж
Наагаад хийсэн
Зааггүй болтугай гээд
Зааны яс шургуулаад
Загасны шар зусаар
Зууртал нь наагаад хийсэн
Тэвх талд нь
Тэгш л хоёр баатрыг
Барилдуулаад сийлээд хийсэн.
Хүнд болтугай гэгээд
Хүнд хүрэл хар чулуугаар
Тэвх хийсэн
Бариул талд нь
Бар арслан хоёрыг
Базгалдуулан сийлээд хийсэн

Ханцуйтай хүний гуурын дүнтэй[39]
Хар мяндсан хөвчтэй байдаг
Есөн их хүчтэй
Ендэрмаан хар нумыг
Баруун өвдөг талдаан
Авч гурав эвшээлгээд явнаа.
Ар л дал талдаан
Агсаад авав л
Найтаг зандан модыг
Нарийн бүдүүн үзүүрээс нь
Мөсгөөчилөөд[40] хийсэн
Бүдүүн нарийн гажигийг нь
Засаад хийсэн
Хүйтэн хөх зэвий нь
Толийтол нь шаагаад
Хий дөрвөн хашигы нь
Тал талруу нь дагуулаад
Тас бүргэдийн өдийг
Тасалж тавиад
Тааруулж наагаад өдөлж
Хөтөлийн дүнтэй онийг
Хуурайдаад гаргасан
Аянгын хий тавин
Түргэн цагаан сумыг
Адруутай шар хорждоон
Арай чамай багтааж
Ар далдаан агсаад авав л.
Далан дөрөө
Дамжиж мордмоор
Долдоо догшин
Хар хээр морьтой
Довон Харбөхийн хөвүүн

39. Бугуйн чинзэн
40. Өөлөөд

Тавин дөрөө
Дамжиж мордмоор
Тас хар хээр морьтой
Талын Харбодон
Намрын навчаан гүйцэсэн
Найтаг зандан модон хэвтэй
Найгаж ганхаад ирэхдээн
Баруун талын
Бараан дээр эвхээстэй байсан
Эр л хүний тохоод явдаг
Ханхинасан эмээл хазаарыг
Хам ташир аваад явнаа.
Атан тэмээн кэвтээ[41]
Алхлаад гишгэлээ
Арван тавны сар кэвтээ
Асар дүүрэн
Малмайж л улайгаад гарав л.
Тавин дөрөө
Дамжиж мордмоор
Тас хар хээр морин минь
Аль л зэргийн байдаг
Болов уу гэгээд
Ажиглаж халиагаад байхад
Хуй салхи залгиад
Хурдан таваан олоод
Хий хийлээд
Хүйтэн таваан аваад
Хүйтэн хар шүлсээрээ
Ундаа хийгээд
Гумын чинээн гэдэснээ
Гууцаг болтол аваад
Хомын чинээ гэдэснээ
Ханцан болтол аваад

[41] Шиг. адил

Хамаг эрээн
Хар махаа сайр л
Талдаан хураагаад
Могой болж л гилэвкээд
Морин биеэн болж л шилгээгээд
Тогос шувуун хэвтээ гялтавнаад
Тоодог шувуун хэвтээ
Тонголзоод
Санмаагаараа сар нар өөд
Сэвээд зогсоныг л
Сагаг дөрвөн туурайгаараа
Сайхан дэлхийн өрийг
Салбартал нь хүй ум дэлдээд
Уяхан зандан модон
Саглагар зандан модон
Хоёрыгоо шөргөөгөөд
Гургуул сайхан гуя нь
Гулжийгаад одсон
Гулз л сайхан чээж нь
Дэнхийгээд одсон
Хонх л хоёр чихээн
Хомон цохон хайчилаад
Хол л ойрын барааг
Харуулдаж халиагаад байхыг
Алдалгүй үзэв.
Талын Харбодон
Тас хар хээрийнхээ
Хажуу талд л эргэлдээд ирэв л
Дохиод явахаар
Дорд замба тивийн
Долоон их шулмын үрийг
Таслаад явдаг.
Занаад явахаар
Замба тивийн шулмын үрийг

Таслаад явдаг.
Шившээд хийсэн
Долоон их ган хөх төмөр
Гархитай байдаг.
Шинжээн нэртэй
Шигшрэгтэй байдаг
Шинэхэн хийсэн ногтыг
Шилийн хар махыг дахуулж[42]
Шигдтэл нь жийгээд явнаа.
Салаан нэртэй саалттай
Савхан нэртэй жолоо
Цулбууртайхан байдаг
Ханьчаан нэртэй хазаарыг
Халхаан хар махыг дагуулж
Дүрээд явнаа.
Ёсон гэж
Ёнхор торгон жолоог
Шилийн шингэн дэл дээр
Шигдтэл хоёр гурав
Зангидаад явнаа.
Хөөртөл цохиод
Хөвсийтөл зулаад
Төлөг хонины ноосоор
Төө зузаан зулаад
Ирэг хонины ноосоор
Эсгийлээд хийсэн
Хөдөө энэтэй
Хөвөн цагаан тохомыг
Хөтөл сайхан зоогийн үсийг
Хөө хуягынхаа ханцуйгаар
Хойшоон хоёр гурав
Хэвтүүлж илээд явнаа.
Хөвхийтөл нь тавьж

42. Дагуулж

Тааруулаад явнаа.
Тохой зандан модон бүүрэгтэй
Тошил зандан модон хавтастай
Зах цэмбэн дэвстэй
Зааны ясан хяртай
Усан санъхалуй гөлөмтэй
Уялгаан арслан дөрөөтэй
Дөчин дөрвөн ганзагатай
Дөрвөн толь л даруулагатай
Дөчин хүн сундалдмаар
Дөлөөн ууҗим зайтай
Хангай дөш
Хар эмээлийг
Хавсарч тохон тааруулад
Тод номын үсгийг
Тоолж тагнайлаад хийсэн
Жаран зургаан олмынхоо
Эргээ солио гаргаад
Эвтээ дор нь тааруулаад явнаа.
Өмөөрөөн[43] татаж эргэлдээд
Гучин гурван зүрхтэй
Гурван алтан бэлчиртэй байдаг
Хөж алтан хөмөлдөргөөн
Зүрхний эхэн цагаан тольтод
Зөвлөн дүнгэн тааруулаад явнаа.
Буруу талд нь эргэлдээд
Тангад номын үсгээр
Тавин тагнайлж гүрээд хийсэн
Жаран зургаан олмынхоо
Эргээ солио гаргаад
Эвтээ дор нь тааруулаад
Хойшооноо татан эргэлдээд
Хорин долоон шигширэгтэй

43. Урагшаа

Хоёр алтан бэлчиртэй
Баян цагаан хударгыг
Баг сайхан сүүлийн унгид
Багтааж дүрээд явнаа.
Зөв талд нь эргэлдээд
Жаран зургаан олом жирмийг
Жирийтэл нь татаад
Жилийтэл нь чангалгаад хаяв л.
Баруун ганзагад
Хадаатай байдаг
Хортой болтугай гэгээд
Хорхойн мөр гаргаад
Хортон шуламын цусанд
Шүүсэлээд дүрсэн
Шүүрэгтэй[44] болтугай гэгээд
Зуун могойн цусанд
Шүүсэлж шахаж гүрээд хийсэн
Гурнайн хүзүү сагалдаргатай
Гуншаа модон бариултай
Гунан хонины дүнтэй
Товруутайхан байдаг
Зэс төмөр альхтай
Цэнхэр хөх шур нүдтэй
Айрастай хар таварцагаан[45]
Ёсон гэж
Ёнхор торгон жолоодоо
Дүрэн өлгөөд хаяв л.
Тавин дөрөө
Дөрөөлөөд мордмоор
Тас хар хээр морион
Уяхан зандан модон уяанд
Саглагар зандан модон сүүдэрт нь

44. Хүчтэй, эрчтэй
45. Гашуур, ид шидийн хүчит малиа

Уян сүүдэрлүүлж хаяад
Хариу гэдэргээний эргээд
Баруун багс талд нь эргэлдээд
Гучин алд хүйтэн хөх зэвтэй
Гурван их талтай
Гунтын улаан жадаан аваад
Гурав сэгсрээд
Гурнын хүзүүн сагалдаргыг
Гуур талдаан шигтгээд
Тавин дөрөө дамжиж мордмоор
Тас хар хээр мориныхоо
Хажуу талд нь ирээд
Тавин алд
Тахийн хүзүүн цулбуурыг
Тай гув татаад
Тав зургаа хугасалж
Давшуур дороон хийгээд
Харгайн буурал хэрэм хэвтээ
Хаян төрөлж мордоод
Зөв амы нь татаад
Зөөлөн амы нь эргүүлээд
Хойт зүгээ тэмцүүлээд
Алтайн далан долоон
Хар уулынхаа цонж харуулыг
Тэнцүүлээд гараад явнаа.
Алтай өргөн нутгийнхаа
Дундаагуур ороод
Бахийтал нь суугаад
Бадартал нь довтлуулав.
Дуугтал цохиод
Шуугтал нь тавиад явнаа.
Тас хар хээр морин
Хүрэн улаан уудаан
Махан болтол нь зажилаад
Мокан болтол нь сунгаад

Хавлан цохин наадаад явахад
Хүрэн улаан уудаан
Хүй зажлаад
Татан тавин товчилоод
Тавин татан тэшүүлээд явнаа.
Хонин жороо хөвөлзүүлээд
Морин жороо бөжүүлээд
Нарийн жороо накалзуулаад
Бүдүүн жороо бөжүүлээд
Бажин төжин тэшүүлээд явнаа.
Алтай өргөн нутгаа
Шувтлаад явнаа.
Алтайнхаа далан долоон
Хар уул харуусаан
Өгсүүлээд гараад явнаа
Түүний мангадарын
Өрүүн шар гэрлээр
Далан долоон хар уулынхаа
Торолзогч торгон орой
Хяралзагч хий сайхан орой дээр
Аван идэн алдуулаад гарав.
Өмнө талдаан эргээд
Алтай өргөн нутгаа
Ажиглаад байхад
Далан долоон хар уул нь
Ээмцээгээ[46] өнгөлзөөд
Сууцаагаа[47] шунхийгаад
Суунаг татан дүнхийгээд
Суу дундуураасаа уруугаан
Утаан гэдэг юман
Униартаад үүлэн болж л
Цэнхэртээд байв.

46. Мөр
47. Суга

Агтын туруун харгилдаад
Азаргаан дуун бөлбөөлөөд
Албатын бараан мал нь
Хаpалж хүрийгээд
Хавтгай өргөн хошуу нутгийн нь
Олон цагаан гэрүүд нь
Одон мичин шигээн
Цайнараад байв л
Азаргаар ялгашгүй
Адуутай баян болж мэдэгдээд
Ач нараан таньшгүй
Өнөр олон болж мэдэгдээд байв.
Талын Харбодон
Далан долоон хар уулынхаа
Бэлрүү буугаад явнаа.
Талын шар хөдөөрүү ороод
Тахь хулан гэдэг амьтадыг
Тас хар хээр мориороо
Дайруулж нам нам цохиж
Алаад явнаа.
Тахь хулангийн махыг
Тас хар хээр мориндоон
Таарyулж дүгнээд
Таван тэгнээ болгож
Ганзагалаад явнаа.
Явах л гэхээрээ газар мэдэж
Хүн таньдаггүйдээ гайхаж
Суух л гэхээрээ
Тас хар мориныхоо
Тав их хурдыг багтааж яваад
Өвөр биеийнхээ өд хүчийг
Багтааж ядаад
Арга эвээн олж ядаад
Өө их дуугаан гаргаж

Хахираад явнаа.
Энэ л дунд замба тив дээр
Миний тас хар хээр
Морьтой уралдуулаад явмаар
Уяаны нэг л сайн
Унаа хий хүлэг морин
Яагаад эс л төрдөг болов уу?
Энэ л дунд замба тивийн
Ар тал дээр л
Талын Харбодон ***надтай***
Гар зөрүүлэх барилдаад
Халимтай махан
Хар архийнхаа аргааг гаргаад
Зоогийнхоо хөх мах тэнийлгээд
Зунгагтай шар хөлсийг
Гаргаад авмаар
Гар нь чанга
Ганзага нь чийлхаа
Ганц л хөвүүн яагаад
Эс л төрдөг юмаа гэгээд
Замба тив доргитол
Захын модон найгатал
Зах таван товч мөлтөртөл
Задгай их дуугаар хахирав
Таван тэгнээ
Тахь хулангын мах ганзагалаад
Тас хар хээр мориныхоо
Хавцал болсон амыг
Хариу гэдэргээний эргүүлээд
Далан долоон хар уулынхаа
Бэлээр бэлдээд
Ар л талын амхаан
Цагаан хөтөлөөр даваад
Алтай өргөн нутгынхаа дундуур

Бахийтал суугаад
Бадартал нь довтлуулаад
Дуугитал нь цохиод
Шуугитал нь тавиад
Далай цагаан өргөөний
Үүдэн талд нь ирээд
Холби тусан буугаад
Таван тэгнээ махаан
Тайлж буулгаад
Тас хар хээр морион
Уяхан зандан модон уянд нь
Саглагар зандан модон сүүдэрт
Уян сүүдэрлүүлж хаяад
Далай цагаан өргөөндөө
Алхаад эргээд ороод ирэв л
Босго тотгын ар талд
Боол тулгын өмнө талд
Талын Харбодон
Далай цагаан
Өргөөндөө ирж
Алхаад эргээд
Ороод явнаа.
Босго тотгын
Ар талд
Боол тулгын
Өмнө төлд
Тойг өвдөг
Газардуулаад явнаа.
Төт хар л
Толгой тонголзуулаад
Өвдөг тохойгоо
Газардуулаад байв.
Өнчин сүвээгээ
Махилзуулаад байв.

Хайхирч дуудаад
Хэлдэг нь энэ билээ:
Хаан сайхан аав
Хатан сайхан ээж хоёр минь
Тавин дөрөө
Дөрөөлөж морддог
Тас л хар
Хээр морин минь л
Уяхан зандан
Модон уяандаан
Саглагар зандан
Модон сүүдэртээн
Тав их л мах нь
Шүүрч барагдаад
Таван их л хурдан нь
Хашиндаан орох л
Гэж явнаа гэж хэлээд
Талын Харбодон
Хаан сайхан аав
Хатан сайхан ээж л
Хоёрынхоо хажууд
Найр жаргалын
Ард л ороод удав л.
Тавтай таван их л
Едэм[48] *харилтдаан*
Орох л гэж явнаа.
Гэвч одоо л
Тас хар
Хээр морь минь
Тав их махтай
Таван их
Хурдтай байнаа
Талын Харбодон *тань* [=хүү тань]

[illegible] [illegible] бярчадал

Эрийн дунд настай
Эгц цагаан шүдтэй
Таван их л хүч
Едтэй байнаа
- Тас хар
Хээр морьныхоо
Хурдыг багтааж ядаад
Талын Харбодон *би*
Өвөр биеийнхээ
Ед хаваан
Багтааж ядаад байна.
Явах гэхээр
Явах л эвээн
Олж ядаад
Суух л гэхээр
Суух эвээн
Олж ядаад
Байнаав гэв л
Одоо л яг над
Төрийнөөм товч
Төмрийн хадаасан бологсон
Зах таван товчийг
Шигтгээд өгдөг
Заяаны минь
Зандан дагиныг
Заагаад хайрлыт
Залаад авнаав
Гэгээд хэлэв л.
Далан дөрөө
Дамжиж мордмоор
Долдоо догшин
Хар л хээр морьтой
Довон Харбөх
Хаан сайхан аав нь

Талын Харбодон
Талдаан халайгаад хэлэв л:
Талын Харбодон
Чиний хэлдэг үнэн
Миний сонсдог
Зөв л гэгээд
Чамайг тэгэж л
Хэзээ хэлэх л
Болов уу гэж
Би бодож
Байлаав гэгээд
Өөдөөн татаж
Эргэлдээд явна.
Ширтийн улаан авдарын
Өнцөг талд л байсан
Алтан юү
Хайрцгаан аваад
Амы нь эвшээлгээд
Алтан шар л
Зурхайгаан зурж л
Мэргэлээд явнаа.
Талын Харбодон
Талдаан халиагаад
Ам сэхэн сэхээд
Зарлиг нээгээд
Хэлдэг нь энэ билээ:
Халиахаар
Хар нүдний минь
Цэцгий бологсон
Хатгах аар [=хайрлахаар]
Халуун бүлээн
Амь цус минь бологсон
Хайртай ганц л
Хүү минь, үр минь билээ чи.

Хайртай сайхан аав чинь
Айлтай[49] хол л байгаа
Газар заагаад хэлээд
Өгнөө одоо гэгээд
Гумдаад[50] шантраад явдаггүй
Биз ч хүүх минь гэв.
Талын Харбодон хариу
Хэлдэг нь энэ билээ:
Хаан сайхан аав минь
Сонсож суухад ээлтэй
Сонин сайхан сургаалтай
Үгээн хэлийт
Чагнаж суухад сосголонтой
Чихэр бурам шигээн амттай
Үгээн хэлнээт
Тэр л үгээн адгийг
Гүйцээж хайрлапан гэвэл
Довон Харбөх
Талын Харбодон
Талдаан ахиад
Хайхраад хэлдэг нь
Энэ нь билээ:
Алиа бага л
Албин дүүрэн төрөгсөн
Хэл бага л
Хэнз ганц төрөгсөн
Хүү минь л билээ чи.
Заяаны зандан
Дагина хатныг
Залаад авдаг болохоор
Энэхэн өмнө
Наран эргээд

49. Аюулгүй, аягүй, их хол
50. Гомдоод

Гардаг зүгт байдаг
Эр морин явахаар
Эцээд тураад
Туруун [=туурай нь] *эргээд*
Хүрмээр хол газарт
Эр хүн явахаар
Өвгөрч хөгшрөөд очдог
Элээ шувуун нисэхээр
Зуур гурав
Өндөглөөд зулзагалаад
Живэр[51] *нь гуужсаад*
Хүрмээр одмоор
Этгээдийн хол л газрын
Цаахан талд л байдаг
Товчлоод хэлэхээр
Төсөр хол л газар
Тоолоод дүгнээд
Хэлэхээр одоо
Тавтай /=бардам/ арван
Ерөн есөн эсгийн
Газрын цаахан
Талд л байдаг
Алтайн арван гурван
Арслан хар л
Уул нутагтай байдаг
Арван бум
Хүрээд үлэгсэн
Албаттай байдаг
Алтан шаргал морьтой
Аранзаа *хааны*
Алтан солонго
Дагина гэж л байна
Залаад авдаг болохоор

---

51 [illegible] жигүү, далавч

Заяаны чинь
Зандан дагина
Тэр л болдог билээ гэв л
Хооруон татан
Эргэлдээд явнаа
Довон Харбөх
Ширтийн улаан
Авдараан ончлож
Шижигнэтэл түлхээд
Алд дүнтэй
Аюуш цагаан хадгийг
Айгаан амнын чинээн
Алд дүнтэй татаастай нь
Аван гаргаад өгөв л
Талын Харбодон
Баярлав гэж л
Магнай эс хагарав
Бахадлаа гэж л
Зүрхэн эс дэлбэрэв
Өхөс гэж л аваад
Алтан хавтгынаа
Амыг эвшээлгээд
Арай гэж л багтаагаад
Хийв л гэнэ лээ.
Дараа талд нь
Довон Харбөх
Талын Харбодон хөвүүн
Талдаан халайгаад
Хайхраад хэлэв л:
Ай паадак [=ай хөөрхий]
Соёогоон гүйцээгээгүй
Шовшуур шогширгын
Шар бодон бологсон
Нялх балчир хүү минь л

Зогдор зунгагаан гүйцээгээгүй
Гунан хар нялх идэр
Тайлаг болсон
Хүү минь сонс чи!
Хүмэн бүхэн
Едтэй болдог [=байдаг]
Хүлэг бүгд л
Хурдтай болдог [=байдаг]
Хүний нутаг хүчтэй
Хүчигнээн[52] *нүхэн*
Түврээтэй[53] *болдог* [=гэдэг юм].
Эр л хүмэн идтэй
Эр л морин хурдтай
Дайны хөлийг
Далайн ёроолыг сайн
Ажиглаж яв л.
Хүүкэм минь [=хүү минь]
Үзэлгүй [=ажиглаж харалгүй]
Нүх л гишгүүзэй ч
Мэдэлгүй [=санамсаргүй]
Хор л уувуузай
Хүүкэм минь
Аранзаа *хааны*
Алтан шарга
Морин байсан газарт
Аггаан хишиг
Цугларч байдаг
Алтан солонго
Дагина байсан газарт
Хүмнээ хишиг
Цугларч байдаг
Учиртай юман гэвэл [=гэж хэлэв л]

[52] [illegible] оготны
[53] [illegible]тэй, бартаатай

Алтан солонго *дагина*
Үхснийг амьдруулдаг
Үгээгтэйг[54] *баяжуулдаг*
Үргэжнийг тогтоодог
Учиртай юман гэв.
Зуур замд чинь
Таван ерэн
Есөн эсийн
Газрын цаахан талд
Алтайн нураг
Хүрэн зандан
Улаан уул
Нутагтайхан байдаг
Шуугиатай олон
Мужл албаттай байдаг
Луу шар
Цоохор морьтой
Луузан тивийн хаан
Гэж байнаа:
Тэр л Луузан тивийн хаан*д*
Гурван хөвгүүн
Байнаа гэнэ.
Ууган хөвүүн нь
Чимхээд татдаг ноосгүй
Чилэн шар
Цоохор морьтой
Чимээ сураг муутай
Чинбүс *гэдгийг*
Хүмээр [=хүн чанар] *дүнтэй*
Баатай гэж л сонслоов.
Дунд л хөвүүн нь
Төвлөөтэйхэн
Бор халзан морьтой

54. Үгүй ядуу

Төморзүрхэн баатар *гэж*
Бас л хүнээр
Дунтэй баитай [=муу] *гэнэ.*
Луузан тив хааны
Отгон хөвүүн нь
Хүрзээн чинээн шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай *гэж*
Амтай хүмэн
Ам ангайхаар
Ам нь ардаан
Гардаг түүхтэй
Хэлтэй хүмэн
Хэлэхээр л гэнээ
Хэцүү болон
Хэдэр муухай догшин
Хатуу болон
Хажир дайсан
Байнаа гэж сонслоов.
Хүрэл-Арслан Магнайн
Замаас нь тун зайдуу
Хөлөөс нь хол хөндий
Яв л хүүкэм минь л гэгээд
Дахин дахин хэлээд
Дахин дахин захиад
Барагдашгүй их л
Ерөөлөө тавиад
Мартагдашгүй их л
Сургаалаа өгөв л.
Талын Харбодон
Тойг өвдөг
Газардуулаад
Төт хар толгой

Тонголзуулаад
Өвдөг тохой
Газардуулаад
Өнчин сүвээгээ
Махилзуулаад:
Хаан сайхан аав
Хатан сайхан ээж л
Хоёр минь ээ
Санаагаар амар
Заяагаар их л
Суугийт та нар минь ээ
Удалгүй яваад
Төдөлгүй алтан
Жолоо эргүүлээд
Дайныг дараад
Далайг л гатлаад
Дагина бэрийг залаад
Хүрээд эргээд
Яваад буцаад
Ирнээв гэв л.
Тас хар хээр морьтой
Талын Харбодон *гэж*
Миний алдар их
Нэрийг сонсоод
Ай чимээгий минь
Мэдсэн амьтан
Байдаг болохлоор
Алтайн минь л
Далан долоон
Хар л уулуур минь
Халиах ч үгүй гэгийт [=гэж бодно]
Долоон муэж л
Албат уруу минь
Өнгөлзөх ч үгүй билээ гэгийт [=гэж бодоорой].

Аранзаа хааны
Зам заяа л
Ангидаан байхад
Луузан тив хааны
Нураг хүрэн
Зандан улаан
Уул нутаг уруу
Би юугаан
Хайгаад шунаад
Тэнээд ордог
Билээв гэгээд
Алхаад эргээд гарав л
Баруун багс[55] л
Талдаан эргэлдээд
Сайн эрийг
Саадагтаагийн хамт
Шаагаад[56] явдаг
Муу эрийг болбол
Морьтой биетэйгийн хамт
Хатгаад авдаг
Гурван их л талтай
Гучин алд л хөх
Зэвтэй байдаг
Гурнайн хүзүүн
Сагалдаргатай байдаг
Гуншаа модон
Бариултайхан байдаг
Гунтын улаан жадаан
Аваад явнаа.
Гунжин үхрийн дүнтэй
Будмал улаан
Цацагтайг нь авч л

55 Гэрийн хаяа
56 Жанчих, зодох

Гурав сэгсэргээд явнаа
Гучин тохой газар
Тулаад түшээд
Алхаад эргээд явнаа.
Талын Харбодон
Тас хар
Хээр мориныхоо
Хажуу талд л
Эргэлдээд ирэв.
Тавин алд л
Тахийн хүзүүн цулбуурыг
Тай гув татаж
Тайлаад авнаа л
Тав зургаа хугасалж
Давшуур дороон
Дүрээд явнаа
Харгайн буурал хэрмэн хэвтээ
Хаян торолж мордоод
Хадаан цагаан
Ялман [=алаг даага] хэвтээ
Хий хаян торолж
Мордоод явнаа.
Зөөлөн амы нь татаж
Зөв амы нь эргүүлээд
Баруун өмнө
Зүгээн тэмцүүлэн
Гараад явнаа.
Тас хар
Хээр морины
Баруун зүүн
Урдаас нь байн байн
Баг л улаан хөөсөн
Баагиад явнаа.
Бахтай ёнхор

Торгон жолооны
Үзүүр талд нь
Хөм хөм л татаад явнаа.
Хүрэл мөнгөн уудаа
Махан болгон
Зажилаад явна
Мокан[57] болгон
Зуугаад явна
Тавлан цохиод
Наадаад явахад
Эрээн сайн
Ганцаараа төрөгсөн
Талын Харбодон
Хүрэл мөнгөн уудыг
Хүй ев язлаад
Татан тавин
Товчлоод явнаа
Тавин татан [=татан түлхэж] тэшүүлээд явнаа
Хонин жороо
Хөвөлзүүлээд явнаа
Морин жороо
Бөжүүлээд явнаа.
Нарийн жороо
Нахилзуулаад явнаа
Бүдүүн жороо
Бөжүүлээд явнаа
Бөжин төжин
Тэшүүлээд явнаа.
Алтай өргөн нутагаа
Шувтлаад явнаа.
Амхаан цагаан
Хөтөл өөдөөн гараад
Аван идэн [=бардам, баясгалантай]

---
57 [illegible]

Алдуулаад явнаа.
Гараад явав л
Талын Харбодонгийн
Харгай сайхан тэвэг нь
Хацраа даган
Халиураад явнаа.
Чиргаа сайхан тэвэг нь
Чихээн дахан
Чичрээд явнаа.
Дөчин дөрвөн салаатай
Дөрвөн мянган уялгатай
Дөлөөн хар боодог нь
Ар дагзын
Гэрэл даган
Цацарч цохилоод явнаа.
Орой дээр нь
Очиртой алтан
Дуулхаа малгай нь
Огторгуйн их
Нар сарны
Наахан талд нь
Гялавхээд явнаа.
Аттай хөө хуягны
Хормой нь чичрээд
Тас хар
Хээр морь нь
Тургиад явахад
Алтайн арван гурван нагал
Цагаан уулын
Наахан талд л
Найман өнгийн
Солонго живэрлээд [=жигүүрлээд] явнаа.
Талын Харбодонгийн
Дөрөөлөөд явсан

Дөрөөний сэнжнээс
Тав тав л гэсэн анирын
Арван өнгийн
Солонго живэрлээд [=татаад] явнаа
Түүний мангадар
Өрүүн шар
Гэрэл магнайлж явахад
Амхаан цагаан
Хөтөл өөд
Алаг хар нүдэнд минь
Ер л юун
Үзэгдэх болов уу
Арван зандан хуруунд
Ер л юун
Атгагдана билээ гээд
Улам улам
Өндөлзөөд явнаа.
Гараад ирэхэд
Арван таван
Хоногт гаталмаар
Арвин өргөн говь л
Дэлүүрээд байв л
Ардаан эргэж
Алтай нутгаан
Ажиглаад байхад
Далан долоон
Хар л уул нь
Ээм цаагаан
Өнгөлзөөд байнаа.
Сүүн цагаан уулс нь
Шунхийгээд байна.
Суунаг татан
Бууралтаад байна.
Суу дундуураас нь

Уруугаан тогтсон
Утаан гэдэг юман
Униар татан
Үүлэн болон цэнхэртээд
Агтаан туурай
Харгилдаад явна
Алдаан [=үе тэнгийн] залуус
Шуугилдаад явнаа.
Азаргаан дуун
Бөлбөөлөөд явна.
Албатын нь дуун
Шуугилдаад байв л
Азаргаар нь ялгашгүй
Адуутай баян юм шиг
Болж л мэдэгдээд
Ач нараа танишгүй
Баян өнөр юм шиг
Болж мэдэгдээд байв л
Талын Харбодон
Тас хар хээрийнхээ
Зөөлөн амы нь татаад
Зөв амы нь эргүүлээд
Баруун өмнө л
Зүгээн тэмцүүлээд
Явахдаан сайхан
Тургийн нь [=биеийн нь] султгаад явнаа.
Тунхан чоныи бөгтөргийг
Тэнийлгээд явнаа.
Айрастайхан хар л
Таварцагыг авч
Тас хар хээрийнхээ
Хангал цагаан гуяд
Гүн давын[58] гууцаг

58. Жалга

Зуураан гартал нь
Цохилоод явахад
Анир биш
Анир гараад явнаа.
Арван тивийн орон
Хүнхэнээд явнаа.
Хүнд хөлтэй
Хүлгийн анир
Хүнхэнээд явнаа.
Хүмэн сайн эрийн
Давилгаагаар л
Давигдаад явнаа.
Үерийн усаар
Цохиод явнаа.
Үерийн чулуугаар
Шуурга татаад
Бүр бүр л
Хур ороод
Сэр сэр
Салхи гараад явнаа.
Тэр зүгийн
Тэнгэрийн өнгө
Хаш л болж л
Улайгаад явна.
Газрын өнгө
Гасан[59] болж л
Эрэгтээд явнаа
Ар талд нь байсан
Довон Харбөхийн
Далан найман тэрэмтэй
Долоо найман
Зуухан уньтай
Далай цагаан өргөө нь

[59] [illegible]

Дайвалжин шижигнээд
Хотгор сайхан
Бараа нь хөдлөөд
Хотгор улаан гол [=судас] нь
Дэлсээд байв л.
Талын Харбодон
Амхаан цагаан хөтөл
Даваад явнаа.
Арвин шар
Говийн өрийг
Гатлаад явнаа.
Хоо цагаан хөтлийг
Даваад явнаа.
Хотгор шар говийг
Гатлаад явнаа.
Хол уужим газрыг
Авч л гүйлгээд явнаа.
Чилгэр шөнө гэж
Чилэлтгүй гүйлгээд явлаа.
Чилэн шар наран гэж
Сааталгүй гүйлгээд явнаа.
Харанхуй шөнө гэж
Харилтгүй гүйлгээд
Халуун шар л
Наран гэж л
Сааталгүй гүйлгээд
Гарав л, гэнээ хөө
Талын Харбодонгийн
Үүрээд явсан
Хөө хуяг нь
Хоороондоо хавиралдаад
Явахад л гэнээ
Арван настай
Балчируудын дуун шиг

Чашгилдаад явнаа.
Гунтын улаан жадны
Гунжин үхрийн дүнтэй
Будмал улаан
Цацагт нь [=гэнээ л]
Бүргэд шувуун
Зулзагалаад өндөглөөд
Зулзагаан бойжуулж
Хагшилдсан болоод явнаа.
Талын Харбодон
Луузан тив хааны
Гурван хөвүүтэй
Өрүүн [=өглөө] харгалдах болов уу?
Асган[60] харгалдах болов уу?
Өдөр харгалдах болов уу?
Сөө[61] харгалдах болов уу? гээд
Улам улам хүсэж бодол
Бодоood гарав л.
Тас хар
Хар Соёны хошуу нь
Богд хаант
Монгол улсын үеийн
Зоригт гүний
Хээр морины
Өмнө хөлд нь
Харгалдсан их л
Үхэр хар чулуун
Хойт л хөлдөөн
Хүрэлгүй элсэн
Тараг болоод явнаа.
Өтгөн хар
Тоосон болж л

[illegible]
[illegible]

Хаягдаад явнаа.
Хойт л хөлд л
Харгалдаад явсан
Хонин дүнтэй чулуун
Өмнө л хөлд л
Хүрэлгүй элсэн болон
Талхараад явнаа.
Өтгөн хар
Тоосон болж л
Хаягдаад явнаа.
Тас хар
Хээр морин
Усан ундтай
Өвсөн хийтэй
Малын хөвүүн
Билээв гэсэн төлөөдөөн
Дөчин дөрвөн
Уулын толгой
Дээгүүр ниссэн
Дөрвөн мэсэр
Хар туруугаараа
Дөмөн хүргээд явахад
Хонхон хоёр чихний
Хойхон талаас
Хорон шар хөлсөн
Хоёр гурав
Шинэхэн чийхэлж
Дусаад явнаа.
Талын Харбодон
Сайхан дөлөөн [=уужим]
Хол газрыг
Авч л гүйлгээд явнаа.
Нартай тэнгэрийн доогуур
Дуугиулаад явнаа.

Навчтай модны дээгүүр
Дэвүүлээд явнаа.
Үүлтэй тэнгэрийн доогуур
Дуугиулаад явнаа.
Үзүүртэй модны
Дээгүүр дэвүүлээд явнаа.
Дуутай тэнгэрийн
Доогуур дуугиулаад
Цастай арван гурван
Өндөр хайрхануудын
Оройгоор шуугиулаад ниснээ.
Таван ерэн есөн
Жилийн газрыг
Таван жилээр
Болзож булаалдаж
Гүйлгээд явнаа.
Таван жилийн газрыг
Таван сайн сараар
Болзож гүйлгээд явнаа.
Таван сарын газрыг
Амаргүй арван
Таван хоногийн
Газраар болзож
Булаалдаж гүйлдээд явахад
Урд л үзэгдээгүй
Нэг л өндөр болон
Заан цагаан хөтөл
Өнөөдөр
Шинэхэн үзэгдээд ирэв л
Түүн дээр [=дараа нь]
Алаг хар нүдэнд минь
Ер л юун үзэгдэнээ
Арван зандан хурганд минь
Ер л юун

Атгагдах болов гээд
Улам улам өндөлзөж
Улам улам өхөлзөөд
Гараад ирэхэд
Түүний цаахан талд
Найман сарын
Нарийхан шар
Говийн өр л дунд
Сайн эр л
Сар арван тав
Хоноод хүрмээр газарт
Баатар хар тоосон
Багтаж ядаад
Хүдэр хар тоосон
Гүйцэж ядаад явахыг
Алдалгүй үзэв л
Талын Харбодон:
Огторгуйн хий
Салхины тоосон болов уу?
Орон замба тивд
Нэг л сайн
Төрсөн баатрын
Тоосон болов уу ? гэж бодоод
Бараагийн багатгаад
Байсан биед нь
Лавлаад лавлаад
Тоосы нь тодоруулаад
Тун биед нь
Тодолж халиагаад үзэхэд
"Орон гүрнийг
Ор ганцаараа
Эзлээд төрлөөв
Гэхийн шинжтэй
Олон түмэн

Амьтныг би л
Ганцаараа ахалж
Ноёлоод төрлөөв
Гэхийн шинжтэй
Эрээн [=эрийн] дунд настай
Эгц л цагаан шүдтэй
Хүйтэн хар л
Царайтахан төрсөн
Хэрээ дүнгийн [=шиг]
Сахалтайхан төрсөн
Айшгүй зүрхтэй
Аваршгүй сэтгэлтэй
Амирлангуй их л
Ужим санаатай төрсөн
Чимхээд татаад авах
Ноос үсгүй төрсөн
Чилэн шар
Цоохор морьтой
Чин Алтанбүс л
Гэж хүмэн
Байдаг гэж л
Хаан сайхан аав минь
Захисан билээ л.
Тэр л хүмэн энэ
Мөн бололгүй
Яганаа" гэгээд
Талын Харбодон
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн алдуулаад
Аван шүүрүүлээд
Ороод явнаа.
Арвин шар говийн
Өр л дунд

Хоёр сайн эр л
Хас бас
Харгалдаад явнаа.
Бух цагаан өвдөг нь
Мөргөлдсөн болоод явнаа.
Булган хар л
Тэргүүн нь лээ
Зөрөлдсөн болоод явнаа.
Арслантай дөрөө нь
Хавиралдаад явнаа.
Араан час хар
Модон шиг
Саадаг нь харгалдаад явнаа.
Хоёр сайн эр л
Айрастай хар л
Таварцагаараа дамналцаж[62]
Хэн хэнийгээ
Үсний захаар
Хэдүү ядуу [=нэгэн үе]
Дамналцаад явахад
Хэн хэн нь
Эс л чирэм [=ядрав] гэв л
Хоёр сайн эр л
Хангал улаан
Бух хэвтээ
Хялайлцаад явнаа.
Хажир хар
Манхан буур л
Хэвтээ нүрэлцээд [=түшилцээд]
Эмнэг улаан
Бух л хэвтээ
Хөшилцөөд явнаа.
Эргүү хар л

62. Ташуураараа цохилцоод

Тайлаг хэвтээ
Нүрэлцээд [=түлхэлцээд] явнаа.
Өдий төдий
Цагийн үе л
Өнгөрөөд ирэхэд
Талын Харбодон
Хайхраад хэлэв л:
Эцсэн чилэн шар
Цоохор морьтой
Элээд хуучирсан
Хөө хуягийн
Танагтайхан чи!
Эргүү пэнэг
Элмэр чи!
Алтай өндөр
Нутаг чинь
Хаана билээ?
Алдар их
Нэр чинь
Хэн болдог билээ?
Хэт холын
Хэрэг зориг чинь
Хэнд л болдог билээ?
Хэлээд өг л!
Явдал минь
Яруу билээ л!
Газар минь
Хол л билээ гэв л
Чилэн шар
Цоохор морьтой
Хар Улаан залуу
Хайхирч дуудаад
Хэлдэг нь энэ билээ л:
Чиний дүнтэй [=чам шиг]

Тэшээд гүйсэн
Тэх л хуц бологсон
Тошоод гүйсэн
Бяруу бух шингээн [=шиг]
Эргүү тэнэг элмэрт[63]
Алтай өргөн нутагаа
Алдар их нэрээ
Хэт хол
Хэрэг зоригоон
Хэлээд өгмөөр дүнтэй [=шинжтэй]
Залуу би бишэв [=биш билээ]
Гэвч яахав
Харанхуй шөнийн чинь
Зүүдэн болоод явах хэцүү!
Халуун өдөрт чинь
Гомдол болоод явах хэцүү !
Хэлээд өгье одоо би чамд
"- Алтай өргөн
Нутгийн минь
Сураад сонсоод
Авдаг юм болохоор [=юм болбол]
Үүкэн[64] *энэ л*
Өмнө наран
Эргээд гардаг
Зүгт л байдаг
Нураг хүрэн зандан
Улаан уул нутагтай
Шуугиантай олон
Муэж л албаттайхан байдаг
Луу цоохор морьтой
Луузан тив хаан *гэдэг*
Хаан сайхан аавын минь

63. Муу амьтанд
64. Энүүхэн

Алдар их нэр нь
Тэр л болдог билээ.
Төвлөөтэй бор [=сартай бор]
Халзан морьтой
Төмөрзүрхэн баатар *гэж*
Дунд дүүгий минь
Алдар нэр нь
Тэр билээ л
Хүрзийн чинээ шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай
Гэдэг хүмэн
Отгон дүүгий минь
Алдар их нэр нь
Тэр л билээ.
Өөв (энэ) биений минь
Алдар их нэр болохлоор
Луузан тив хааны
Ууган хөвүүн
Чимхээд татдаг ноосгүй
Чилэн шар
Цоохор морьтой
Чин Алтанбүс
Гэдэг хүмэн
Би болдог билээв.
Хэт хол
Хэрэг зориг минь
Одоо болохоор
Үүхэн энэ
Хойт наран
Эргээд ордог
Зүгт л байдаг
Товчлоод хэлэхэд

Төсөр хол газар байдаг
Тоолоод дүгнээд хэлэхэд
Таван ерэн есөн
Жилийн газарт байдаг
Алтайн далан
Долоон хар
Уул нутагтай
Долоон муж л
Албаттайхан байдаг
Далан дөрөө
Дамжаад мордмоор
Долдоо догшин
Хар хээр морьтой
Довон Харбөх*ийн хөвүүн*
Тавин дөрөө
Дамжаад мордмоор
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон *гэдэг залуу болбол угтаа*
Довон Харбөх*ийн*
Баян тарганд нь
Зугуйдан ирж л
Төрсөн [=тэжээмэл хүү]
Эргүү тэнэг
Элмэр байнаа гэнээ.
Тас хар
Хээр морьтой нь
Чилэн шар
Цоохор морион
Уралдуулж шөвгөлүүлээд
Авсав гэж явнаав лээ би!
Талын Харбодон*той*
Гар зөрүүлж
Барилдаад дийлээд

Хангал цагаан
Ясы нь цайлгаад
Халуун бүлээн сэгий нь
Халуун шар наранд
Хатаагаад хаясав л
Гэж явнаа лээ би!
Тас л хар
Хээр мориор нь
Атаа дайчин
Таван тэнгэрээн
Тахиад авсав л
Гэж явнаав лээ би!
Далан долоон
Хар уулд нь
Долоон их л эхтэй
Түймэр тавьсав л
Гэж явнаав лээ би
Долоон муж л албатыг нь
Энэ л Алтай нутгийн
Арвин шар замаар
Олзондоо оруулэж
Гинжиндээн хатаагаад
Харьсав гэж явнаав лээ би гэхэд
Талын Харбодонгийн
Бух л сайхан
Магнай нь тэнийж
Янхийгээд явнаа.
Бүүмэн цагаан соёо нь
Буруу зөв л оочоор нь
Зөрөлцсөн болоод явнаа.
Ар л шил нь
Ангалзаад явнаа.
Арван хоёр
Хуниа нь буугдаад

Хойт/оо/ шил нь
Анхалзаад явнаа.
Хорин хоёр хуниа нь
Бүүгдсан болоод явнаа.
Алаг хоёр нүдээ
Аньж халиагаад
Арван зандан хуруугаа
Атгаж тавиад
Хажуу талдаан
Хамардаад [=үнэртээд] явнаа
Хайрын хар
Бараан үлдээн
Гал л бадартал нь сугалаад
Талын Харбодон
Хайхираад хэлэв л:
- Хүсээд явсан
Талын Харбодон *чинь би байнаа.*
Хүрээд ирнээ
Гэдэг энэ лээ.
Занаад явсан
Талын Харбодон *чинь би байнаа*
Залраад ирнээ
Гэдэг чинь энэ л ээ гээд
Тас л хар
Хээр мориныхоо
Хавцал болсон амыг
Хариу гэдэргээн эргүүлээд
Энэ л зүгийн
Энэ л уулын
Бэлийг ташуулдан яваад
Хариу эргүүлээд
Хар л хээр мориныхоо
Таван их л
Хурдын гаргаад явнаа.

Өвөр [=өөрийн] биеийнхээ
Таван их ед хүчээ
Хар хээрийнхээ хурдтай
Хааяд [=хаая, хүүе, уухай] гэж
Хайхираад [=уриадаад]
Хашин хясан
Давируулаад ороод одов л.
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон
Өндрөөс ойгоод
Одсон зулсагын [=бүргэдийн зулзага]
Цохилгон болоод явнаа.
Өлөнд ассан
Түймрийн заль л хэвтээ [=дөл шиг]
Дүрэвкээд ороод явнаа.
Салаад гарсан
Аргалийн [=гөрөөсний] тоосон хэвтээ
Салхинд ассан
Галын заль л хэвтээ [=дөл шиг]
Дайраад ороод явнаа.
Чилэн шар
Цоохор морьтой
Чин Алтан бүс
Ажиглаад харахад
Талын Харбодон
Тэсэлгүй шуу [=цуу, цуулах]
Чавчмаар хүчтэй болж
Мэдэгдээд явнаа.
Чилэн шар
Цоохор мориныхоо
Хавцал болсон амыг
Хариу гэдэргээн эргүүлээд:
Хайртай чилэн шар

Цоохор морь минь
Мөн л болохлоор
Талын Харбодон*гоос*
Утасны чинээн
Улаан амий минь
Уучлаад авраад гараарай!
Нураг хүрэн
Зандан улаан уулд минь
Хүргэ гээд
Оольэс[65] *зугатаагаад явахад*
Талын Харбодонгийн
Тас л хар
Хээр морин
Ийг[66] болон
Эвкрээд наадан хөөцөлдөнө л
Хуруувч болон
Хумигдаад [=наадан] хөөцөлдөнө л
Тэвнэ болж
Тэлэгдээд [=наадан] хөөцөлдөнө л
Тэр л зүгийн
Тэр уулын бэлийг
Дөшүүлж[67] яваад
Чилэн шар
Цоохор морины
Дөрвөлжин сайхан сайр дээр нь
Тас хар хээр морин
Тольт сайхан
Өргөөн тавин тавьж
Дөгнөн наадаад гүйцэх үед
Талын Харбодон
Чин Алтанбүсийн

65.Буруулан зугтааж
66. Утасны зэрүүл
67.Өгсүүлж

Орооны заадсаар
Оруулж чавчаад
Хангай хар эмээл
Чилэн шар
Цоохор морьтойг нь
Зургаан анги
Шуу чавчаад
Зуун алд
Зуух [=жалга, нүх] малтаад
Тэр зүгийн
Тэр л уулын бэлийг
Дөшүүлж л очоод
Талын Харбодон
Хайрын хар бараа үлдээн
Баруун сугандаан
Шувтарч гүйцээж домноод
Хариулж хуйлаад шившиж хэлэв:
Чип Алтанбүс чи
Чийргүй [=чадалгүй] ***байтлаа***
Чигтээн [=яасан] ***их санаатай юм ?***
Цаа үгүй [=ирээдүй үгүй] ***байтлаа***
Цамаан их л санаатай болдог чи !
Эр морины
Таван их хурдыг
Эр хүмүүний
Таван их ед
Хүчийг өнгөрүүлдэггүй
Эргүү тэнэг элмэр байж
Жигтэй [=санаанд багтамгүй] ***юм амлаж***
Хэлэж явдаг элмэр бэ? чи гэв.
Түүнээсээ цаашаан
Талын Харбодон
Бахийтал суугаад
Бадартал нь тавиад [=гүйлгээд]

Дуугитал нь цохиод
Шуугитал нь довтолгоод
Бас л нэг
Амхаан цагаан
Хөтөл дээр
Гараад ирэхэд
Түүний цаад талын
Найман сарын
Нарихан шар
Хөдөөн өр дунд
Баатар хар тоосон
Багтаж ядаад явнаа.
Хүдэр хар тоосон
Гүйцэж ядаад явнаа.
Тэр тоосон дотор нэг бараан юм
Нар зөв буруу босож
Эргэлдээд явахыг
Огторгуйн савсалганы
Орог шаргал үүлэнд
Тулаад босоод явахыг бас
Алдалгүй үзэв л
Талын Харбодон
Барааг нь бататгаад
Байсан биед нь лавлаад
Тоосы нь тодоруулаад
Тун биед нь
Тодолж халиагаад байхад:
- Орон гүрнийг ор ганцаараа
Эзлээд төрлөөв
Олон түмэн амьтаныг
Би ганцаараа
Ахлаад төрлөөв
Гэхийн шинжтэй
Нүүр талдаан галтай

Нүдэн талдаан цогтой
Уулын дүнтэй
Төөлөөтэй [=сартай] бор
Халзан морьтой
Хайрын хар
Улаан залуу
Бахийтал нь суугаад
Бадартал нь довтолгоод
Дуугтал нь цохиод
Шуугтал нь тавиад [=давхиад]
Аашихыг [=явахыг]
Алдалгүй үзэв.
Талын Харбодон
Луузан Тив хааны
Дунд хөвгүүн
Төлөөтэй бор
Халзан морьтой
Төмөрзүрхэн баатар гэдэг
Дайчин эр хүн
Байдаг гэдэг билээ л.
Тэр л баатар эр
Энэ бололгүй яаганаа [=яана] гээд
Төморзүрхэн баатартай
Чин Алтанбүсийн адил
Хэвээр хэвлээд [=шавж тулалдаж]
Хаядаг [=дийлдэг] болох гээд
Хайрын хар
Бараан үлдээн
Хангинатал нь сугалаад
Хангал цагаан
Ээм талдаан домнож шившээд
Тавиад явнаа
Амхаан цагаан
Хөтөл уруугаан

Аван идэн
Алдуулаад ороод явахад
Талын Харбодонгийн
Тас хар
Хээр морин хөлөг
Өндрөөс ойгоод орогсон
Зумгийн [=чулуу] цохилгон
Болоод явнаа.
Өлөнд ассан
Түймрийн заль л хэвтээ [=дөл шиг]
Дүрсхийн асаж
Ороод явнаа.
Салаад гарсан
Аргалийн тоосон хэвтээ
Салхинд ассан
Түймрийн заль л хэвтээ
Дүрсхийгээд асаж
Ороод явнаа.
Арвин шар говийн
Ар дундаас цойлон
Ирж явсан
Төөлөөтэй бор
Халзан морьтой
Томорзүрхэн баатарт
Талын Харбодон гэдэг чинь
Тас хар
Хээр морьтойгоон
Хамт нийлээд
Нэг арслан
Хар уул дээр л
Бас л нэг
Арслан хар уулыг
Ташир тавиадахсан
Шингээн сүрлэг үзэгдэв ээ.

Талын Харбодон
Тэсэлгүй шуу
Чавчмаар хүчтэй болж
Мэдэгдээд явнаа.
- Төлөөтэй бор
Галзан [=халзан] ***морь минь***
Талын Харбодон***гоос***
Утасны чинээн
Улаан амийг минь аварч
Ууччлаад намайг
Нураг хүрэн
Зандан улаан уул
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай
Дүүд минь
Хүргээд өг гээд
Төлөөтэй бор
Халзан мориныхоо
Хавцал болсон амыг
Хариу татаж эргүүлж
Ойлж зугатаагаад гарав л гэлээ.
Төлөөтэй бор
Халзан мориныхоо
Хавцал болсон амыг
Хариу гэдэргээн эргүүлээд, давтан хэлэв:
- Сайн төлөөтэй
Бор халзан морь минь
Чи үнэхээр мөн болбол
Утасны чинээн
Улаан амий минь
Талын Харбодон***гоос***
Хамгаалж гараад л
Нураг хүрэн их
Улаан уул өргөн

Сайхан нутагт минь
Хүргэ бушуухан намайг гээд
Нураг хүрэн их
Зандан улаан өргөн
Уулаан тэнцүүлээд
Ойлж зугатаагаад гарав л гэнэ.
Талын Харбодонгийн
Тас хар хээр морин
Ар мөрт нь [=дагаж хөөгөөд]
Ороод [=гүйцээд] явнаа.
Ийг болж л
Эвхрээд явнаа.
Хуруувч болж
Хумигдаад явнаа.
Тэвнэ болон
Тэлэгдээд явахдаа
Тэр зүгийн
Тэр л уулын өндөр
Бэлийг дөшүүлж л хөөгөөд
Төөлөөтэй бор Халзан морины
Дөрвөлжин сайхан
Сайр дээр нь
Хашиг [=халбаган] цагаан өргөөн
Тавин дөгнөн [=хүргэж]
Наадаад явахад
Талын Харбодон
Төмөрзүрхэн баатарыг
Хангай дөш л
Хар эмээлтэйг нь
Төөлөөтэй бор
Халзан морьтойг нь
Зургаан анги л болгож
Шуу чавчаад хаяв л гэнэ.
Зуун алд л

Нүх малтаад
Өнгөрөөд [=амийг тэвчив] одов л.
Эр моршны увидастай
Таван их хурдыг
Эр хүний шөрмөстэй
Таван их едийг
Даах л чадалгүй
Эргүү тэнэг
Элмэр чиг л байнаа чи!
Жигтэй их л юм бодож
Чалчиж явдаг юм бэ? гэж шившээд
Хайрын хар
Бараан үлдээн
Баруун суга талдаан
Шувтарч хариулж домноод
Эргүүлж хуйлаад явнаа.
Түүнээс цаашаан **Талын Харбодон**
Амхаан цагаан хөтөл
Даваад явнаа.
Арвин шар хөдөөн
Өрийг гатлаад
Хоо цагаан өргөн их
Хөтөл андууралгүй даваад явна
Хотгор шар сайхан
Говийн өрийг эндүүрэлгүй
Гатлаад явнаа.
Хол ууржим газрыг гатлан
Авч гүйлгээд явна
Нэг өндөр болон сайхан
Заан цагаан [=ууржим]
Хөтөл өөд гүйлгээд
Аван идэн даваад
Алдуулаад гараад явнаа.
Луузан Тив хааны

Нураг хүрэн
Зандан улаан уул
Үүний цаад талд
Байдаг болов уу гээд
Халиаж ажиглаад үзэхэд
Сайн морьтой
Сайхан залуу болжим
Сааталгүй явахаар
Сар арван тав хоноод
Хүрмээр газарт л
Сарвайж л үзэгдээд байв
Муу морьтой
Муухан эр болжим
Хоёр жилийн
Хорин дөрвөн сард
Хүрмээр газрын
Цаахан талд
Харалж л үзэгдээд байв л
Түүний наахан талаар нь
Эргэлдүүлээд халиахаар
Хорин тав
Хоноод гаталмаар
Хотгор шар өргөн
Говийн өр дунд
Баатар хар тоосон
Багтаж ядаад явнаа.
Хүдэр хар тоосон
Гүйцэж ядаад явнаа.
Түүний дотор
Нарийхан цагаан тоосон
Нар зөв эргэлдэж
Мушгираад босоод явнаа.
Огторгуйн өндөр
Орог шархал үүлийг

Цоо хадаад явав л
Талын Харбодон
Бараагий нь харж
Бадруулаад явнаа.
Байсан биеийг нь харж
Тодоруулаад явнаа.
Тоосы нь харж
Тодоруулаад үзнээ л
Тун биеийг нь лавлаж
Халиагаад үзэхэд
Хоёр нүдэн хооронд нь
Хоёр тэмээ хэвтүүлээд
Хомноод ачаад босгомоор
Өргөн уужим магнайтай
Цээж хооронд нь
Хоёр хотон хонийг
Хоёр хөвүүн
Хол хол хариулаад
Хоножөнжөөд ирмээр
Өргөн уужим
Чээжтэй төрсөн
Дал хооронд нь
Далан таван агт
Сойж уралдуулаад авмаар
Өргөн уужим
Далтай төрсөн
Орон гүрнийг
Ор л ганцаараа
Эзлээд төрлөөв
Гэхийн шинжтэй
Олон түмэн амьтаныг
Би ганцаараа
Ахлаад төрлөөв
Гэхийн шинжтэй

Хөө болсон махтай
Хөрөнгө [=хөлдүү] газар шиг
Цогцостой төрсөн
Хөөрхий гэх нинжин
Сэтгэлгүй төрсөн
Харгай сайхан тэвэг нь
Халхаан[68] даган
Халиурсан шинжтэй
Чиргай сайхан тэвэг нь
Чихээн даган
Чичирсэн, шинжтэй
Тэвэрч хүрэмгүй
Хүзүүтэй төрсөн
Тэнгийн [=үе насны]
Хар Улаан залуу
Самнааны сайхан
Үс нь гүйцээгүй
Тахимын нь
Шар шөрмөсөн
Тэнийгээгүй төрсөн
Хүрзээн чинээ нүдтэй
Хүрэн цоохор мориныхоо
Хавцал болсон амыг
Ангайтал нь татаад
Харгай зөөхөн соёог нь
Ярзайтал нь татаад
Бахийтал нь суугаад
Бадартал нь довтолоод
Дуугтал нь цохиод
Шуугитал нь тавиад [=хатируулаад]
Аашихий нь бас
Талын Харбодон
Алдалгүй үзэв л.

68. Хацраа

Талын Харбодон
Улам улам баярлаад
Улам улам бахдаад явнаа.
Энэ л их өргөн
Айгаан дүнтэй [=аягын чинээн]
Шар наран
Альханы дүнтэй (=алга шиг)
Хотгор шар
Дэлхийн өр дээр л
Тас хар хээр морьтой минь
Хайнцуулан байж
Уралдуулаад авмаар
Унааны нэг л сайн
Унаа хий хүлэг
Морин төрсөн нь энэ болов уу?
Өвөр [=энэ] биетэй минь
Ноолдож [69] барилдаад
Зоогийн шар
Шөрмөс тэнийлгэх
Зулааны шар хөлс
Гаргаад авмаар
Гар нь чанга
Ганзага нь чийлхаа [=бөх]
Ганц л сайн эр
Төрсөн нь энэ болов уу гээд
Улам улам баярлаад
Улам улам бахдаад
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн алдуулаад оров л.
Талын Харбодонгийн
Тас хар хээр морь нь
Түмэн агтын

[69] Ноолдож

Тоос татуулаад явнаа.
Мянган агтын
Чимэ гаргаад явнаа.
Талын Харбодонгийн
Түмэн хүний
Сүр дармаар
Түүхий улаан
Чирай[70] тодроод явнаа.
Мянган хүний сүлд
Сүр дармаар
Мяндасан улаан
Чирай тодроод
Ороод явнаа.
Эзэнгүй их
Эрмэн улаан
Говийн өр дунд
Хоёр сайхан баатар
Хас бас [=тэв тэнцүү]
Харгалдаад явнаа.
Бух л цагаан өвдөг нь
Мөргөлдөөд явнаа.
Булган хар тэргүүн нь
Зөрөлцөөд явнаа.
Арслантай дөрөө нь
Хавиралцаад явнаа.
Арын чис [=хав]
Хар модон шигээн
Саадаг нь бас бас
Харгалдаад явнаа.
Хоёр сайхан эр л
Айрстай хар малиа
Таварцагаа авцгааж
Хэн хэнийхээ магнай хооронд

70. Царай

Хээгүй, хийгүй
Хорь хорь дахин
Дамнаж цохиод явахад
Хэн хэн нь нэг ч удаа
Эс чирэм гэв л гэнээ
Дараа ар талд нь гэлээ
Хоёр сайн баатар эрийн
Унаа хий хөлөг
Морион хойшоон
Татаад зэрэгцүүлээд
Хоёр сайхан баатар
Хангал улаан бух
Хэвтээ хялайлцаад
Хажир хар манхан
Буур хэвтээ
Нүрэлцээд явнаа.
Эмнэг улаан
Бух хэвтээ
Хялайлцаад явнаа.
Эргүү хар
Тайлаг хэвтээ
Нүрэлцээд явнаа л
Өдий төдий
Цагийн үе
Өгөрөөд ирэхэд
Талын Харбодон
Хайхираад хэлэв л:
Хэтэм хол
Хэрэг зориг чинь
Хэнд болдог билээ?
Өтөр шулуун
Хэлээд өг
Явдал минь
Яруу билээ

Газар минь
Хол л билээ гээд
Аван идэн
Алдуулаад хэлэв л
Хүрэн цоохор морьтой
Харулаан залуугийн
Аа гэсэн амнаас
Арван таван эхтэй
Галын заль л
Дүрэвкээд явнаа.
Өө гэсэн амнаас нь
Өлөн хөх утаан
Суунаглаад явнаа.
Чиний дүнтэй
Хуртай өдөр
Хуйхлаад иддэг
5 Хурган хуц бологсон
Эргүү тэнэг элмэрт
Алтай өргөн нутгаан
Алдар богд нэрээн
Хэт хол
Хэрэг зоригоон
Хэлээд өгмөөр [=өгөх]
Дүнтэй эр л
Би биш л билээв лээ.
Тэгэвч би чамд одоо хэлье:
Харанхуй шөнөд чинь
Гомдол болоод
Явж л магадгүй
Алтай өргөн
Нутаг минь болохоор
Өмнө наран
Эргээд гардаг
Зүгт л байдаг

Сайн морьтой
Сайн сайхан залуу болбол
Сар арван тав
Хоноод хүрмээр
Газрын цаахан
Талд байдаг
Муу морьтой
Муухан эр болбол
Хоёр жилийн
Хорин дөрвөн
Сар болоод
Хүрмээр газрын
Цаахан талд байдаг
Нураг хүрэн зандан
Улаан уул нутагтай
Луу шар
Цоохор моьтой
Луузан Тив хаан *гэж*
Аавы минь
Алдар нэр нь
Тэр л болдог билээ
Чимхээд татдаг ноосгүй
Чилэн шар
Цоохор морьтой
Чиналтан бүс
Гэдэг хүн болбол
Ууган ахы минь
Алдар их нэр нь
Тэр л болдог билээ.
Төлөөтэй бор халзан морьтой
Төмөрзүрхэн баатар *гэж*
Дунд л ахы минь
Алдар их нэр нь
Тэр л билээ.

Өвөр биеийн минь
Алдар нэр нь болохоор
Хүрээн чинээ шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай
Гэдэг хүмэн
Би болдог билээв.
Хэт хол
Хэрэг зориг минь болохоор
Хойт наран
Эргээд ордог
Зүгт л байдаг
Товчлоод хэлэхлээр
Төсөл хол газар
Тоолоод дүгнээд
Хэлэхлээр тавтай [=бардам, ужуухан]
Таван ерөн есөн
Жилийн газрын
Цаахан талд л байдаг
Далан долоон
Хар уул нутагтай
Долоон муж
Албантайхан байдаг
Далан дөрөө
Дамжиж морддог
Долдоо догшин
Хар хээр морьтой
Догшин довон Харбөх*ийн*
Баян тарганд нь
Зулгуйдаж төрсөн
Тавин дөрөө
Дамжиж морддог
Тас хар

Хээр морьтой
Талын Харбодон *гэж*
Нэг л сайн эр л
Байнаа гэж сонсоод
Тас хар
Хээр морьтой нь
Хүрэн цоохор морио
Уралдуулж шөвөгдүүлээд
Авъя гэж явнаав.
Талын Харбодон*той*
Авалдаж ноолдож түрүүлээд
Хангал цагаан
Ясы нь цайлгаад
Халуун бүлээн сэгий нь
Халуун шар наранд
Хатаах л гэж явнаав.
Тас хар хээр мориор
Атаа дайчин
Таван тэнгэрээн
Тахъя гэж явнаав.
Ар талд нь
Далан долоон
Хар уулд нь
Долоон эхтэй
Их түймэр
Тавиад авъя
Гэж явнаав лэ би
Долоон муж албаты нь
Энэ л алтайн арван гурван
Арвин шар говийн
Өрөөр олзодоо оруулж
Гинжиндээ хатаагаад
Одъё гэж явнаав лээ би
Догшин довон Харбөх *эцгийг нь би*

Чадалтай сайн
Эр болохоор нь
Ардаан [=хажуудаа] *буулгаж*
Адуучаан хийлгээд
Авъя гэж явнаав лээ би
Хойноо буулгаад
Хоньчноо хийлгээд
Авъя гэж явнаав лээ би
Чадалгүй муу
Эр л болохоор түүнийг
Үнэгэн шинжих
Мэнгүй болгоод
Үхэр хэмлэх
Ясгүй хийгээд
Будаан шиг
Бутартал нь цохиод
Тариан шиг
Талхартал нь дараад
Довон Харбө*хийг олзолж*
Цохиод дараад хаяъя
Гэж явнаав лээ би
Харзандан *хатныг нь*
Хангал гүүний
Хаа тэврүүлээд
Эмнэг гүүний
Гуя л тэврүүлээд
Хаяъя гэж явнаав гэв лээ
Талын Харбодонгийн ар шил нь
Ангалзаад явнаа
Арван хоёр хуниа нь
Буугдаад явнаа.
Хойт шил ангалзаад
Хорин хоёр хуниа нь
Буугдаад явнаа, лэ
Алаг хоёр нүдээ

Аньж л халиагаад явна лээ
Арван зандан хуруугаан
Атгаж, тавиад явнаа, лэ
Хажуу талдаан
Хамардаад [=үнэртээд] явнаа
Хайрын хар шидэт
Бараан үлдээн
Гал бадартал нь
Сугалаад авнаа лээ
Хангал цагаан
Ээм талдаан тавиад
Хайхирч дуудаад хэлэв л:
- ***Хүсээд явсан***
Хүслэнтэй төрсөн
Талын Харбодон *чинь би байна*.
Хүрээд ирнэ гэдэг энэ л байна.
Занаад явсан
Талын Харбодон *чинь би байна.*
Залраад ирнэ
Гэдэг энэ л гэж хэлээд
Тас хар
Хээр мориныхоо
Хавцал болсон амыг
Хариу гэдэргээн эргүүлээд
Тэр л зүгийн
Тэр л уулын бэлийг
Дөшүүлж давхиад
Тас хар
Хээр мориныхоо
Арван их хурдыг өөрийн биедээ
Нийлүүлээд явнаа.
Өвөр [=өөрийн] биеийнхээ
Арван их ед хүчийг
Хар хээр мориндоо нийлүүлэв.

Хааяд гэж
Хайхиран [=уриадаад]
Хасан хясан давираад
Ороод ирж явнаа.
Тас л хар
Хээр морин нь
Өндрөөс буусан
Зумгийн [=жалгын] цохилгон чулуу
Болоод явнаа лээ
Өлөнд ассан
Түймрийн заль л шиг
Дүрэлзэн дүрэвхээд
Ороод хуймраад явнаа.
Салаад гарсан
Аргалийн тоосон хэвтээ
Салхинд ассан
Түймрийн заль л болон
Дүрэлзэн дүрэвхээд
Ороод эрчлээд явнаа.
Арвин шар
Хөдөөн өр дунд байсан
Хүрзээн чинээн шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай баатар
Харих л санаангүй
Халтирах зүрхгүй
Сайн л нэг санаангүй
Шаргиа алтан
Дуулхаагаа мөлтөлөөд
Баруун өвдөг талдаан
Өмсөөд явнаа.
Алттай хар

71. Ходоодоо

Илгэн хотоон[71]
Хоёр гурав дахин
Илээд явнаа лээ
Хангал хар элгээн
Хангай хар
Эмээлийнхээ бүүргэнд
Тааруулаад сахиад
Сайхан хэвтээд өгөв л
Талын Харбодон чинь
Хүрэл-Арслан Магнайн
Оройны нь заадсанд
Оруулж л чавчаад явахад
Ойж л буугаад буцаад байна
Баян далай өргөн
Цагаан альган нь
Өвдсөн шиг болоод байна.
Хад чавчисан шиг
Мөлтрөөд одов л.
Тэр зүгийн
Тэр л уулын
Бэлийг дөшүүлж л яваад
Тас хар
Хээр мориныхоо
Хавцал болсон
Амыг ариа
Чамай гэж татан тогтоогоод
Хайрын хар
Бараан үлдээн
Халиагаад үзэхэд
Гур болж
Гулжийгаад одсон байнаа л.
Дөр болж
Махийгаад одсон байнаа л.
Нимгэн цагаан

Ир нь мэлтэрээд
Мөнгөн цагаан
Тольт нь хөдлөөд
Одсон байхыг
Талын Харбодон
Алдалгүй үзээд
Баруун суга талдаан
Шувтарч л гүйцээн шившээд
Хариулаад хуйлаад авнаа л
Хариу гэдэргээн эргээд
Хүрэл-Арслан Магнайн
Хажуу талд л ирэв.
Хүрэл-Арслан Магнай хэлэв:
Чи бидэн хоёр
Даалттай дархан
Далан жил
Давтаад хийсэн
Хурц болтугай гээд
Хурдан морины
Туруугаар [=туурайгаар]
Хуривсалаад хийсэн
Нарийхан уян
Цагаан төмөр
Үлдээр үзэлцээд дийлэлдсэнгүй.
Уран аав ээжийн
Занагаар бүтсэн
Ээм далаар
Үзэлцээд [=барилдаад] ***авъя*** гэвэл
Тэр л газар дээрээн
Артаа хүрэн зодгоон
Авч өмсөөд явнаа.
Нарийхан цагаан өлкий[72] нь
Наян найм хүргэж

72. Тэлээ

Зангидаад явнаа.
Хоёр сайн баатар эр
Тэр л газар дээрээн
Ач тач авалдаад [=барилдаад]
Алс булс орхилцоод
Цэглэн босон
Барилдаад явнаа.
Бага уулыг
Балц л түлхэлцээд явнаа.
Их уул хадыг
Ивт л түлхэлцээд явнаа.
Хөдөө нь эвдэрч
Хөтөл болтол
Авалдаад [=барилдаад] явнаа.
Хөтөл нь эвдэрч
Хөдөө болтол
Авалдаад явнаа.
Голын ус нь
Тасартал нь барилцан
Цохилцоод явнаа.
Дүлий хар будан
Дунд замба тивийг
Бүрхээд явнаа.
Явган хар будан
Элкэдээд явнаа.
Есөн төө
Цасан ороод явнаа.
Ерэн хоногийн
Зуд эхлээд авав.
Хоёр сайн эр
Хүрээд одсон газраасаа
Хүрзээн чинээн
Мах тасалаад
Хаялцаад явнаа.

Бариад авсан газраасаа
Барим төө мах
Таслаад хаялцаад явнаа.
Алаг хоёр нүднийхээ
Хар бараан нь
Тасартал нь цохилцоод
Авдар зандан
Чээж чээжиндээ [=хоёр цээжиндээ]
Хар луугийн
Дуун донгодтол нь
Цохилцоод явнаа.
Бүргэд улаан хоёр
Хоншоороо шалбартал нь
Цохилцоод явнаа.
Хоёр сайн эр
Хальтирах нэг л зүрхэнгүй
Харих нэг л санаангүй
Далаараа илмэрч л [=түшилцэж]
Авалдаад, хүзүүгээрээ
Хөшилдөөд явнаа.
Хүрэн өргөн чээж, чээжээрээ
Дөгнөлцөөд явнаа.
Өвдөг тохойгоороо
Дөгнөн цохилцоод явнаа.
Өвдөг тохойн ясаа
Цайтал нь цохилцоод явнаа.
Ууц сээрийн махыг
Холби холби
Цохилцоод явнаа.
Хатуу хар мах махаан
Салбартал нь цохилцоод
Хангал цагаан яс ясаа
Хамхартал хэмхэртэл нь
Авалдаад явнаа.

Олон жилийн он
Олон сарын адаг
Болоод болоод явнаа.
Их л нуур
Лайдаа даргдаад
Бага л нуур
Ширгээд явнаа.
Доод л замба тивийн
Алтан мөнгөн ховоог
Ширгэтэл нь барилдаад явнаа.
Дээд хурмастад
Дүлий хар будан
Татаад явнаа.
Явган хар будан
Элхэдээд байв л
Дээд хаан хурмастын
Арш дээд лам энэ л
Есөн төө
Цасан оров
Ёрын хар
Зуд эхлэв
Дүлий хар
Будан бөглөв
Хүйтэн хар
Хүдэн элхэдэв
Ер л юун болоод
Байнаа гээд
Мэргэлээд үзээд орхисон чинь
Дунд замба тивийн
Далан долоон хар
Уул нутагтай
Долоон муж албаттай
Догшин довон Харбөх
Баатарын хөвүүн

Тавин дөрөө
Дамжаад мордмоор
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон
Луузан Тив хааны
Отгон хөвгүүн
Хүрзээн чинээн шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнайтай
Авалдаж барилдаад
Байнаа гэж
Мэдэгдээд байв.
Энэ л хоёр баатрын
Хэн нь дийлж
Хэн нь дийлэгддэг болов уу гээд
Мэргэлж үзээд байхад
Тас хар хээр морьтой
Талын Харбодон
Хүрзээн чинээ шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүрэл-Арслан Магнай хоёр
Энэ л яваа насандаа
Нэгэндээ дийлэгдэх байтугай
Эцэж дордоогүй
Сүнс, яс хоёр нь
Холбоо хэлхээтэй явдаг
Хоёр амьтан болж
Мэдэгдээд байв л
Энэ л хоёр баатрыг
Ах дүү, амин цөсөн болгож
Нартын гурван орны
Амьтныг төвхнүүлдэг

Байнаав гэгээд
Дээд замба тивийн
Арш дээд лам
Алтан мөнгөн бумбатай
Рашаан зангиагаа аваад
Алтан шатын амаар
Дунд замба тив рүү
Нисээд ороод ирэхэд
Дүлий хар
Будан бөглөөд
Явган хар
Будан элкэдээд байв.
Бараагий нь багатгаад
Байсан биед нь
Лавлаад халиагаад байхад
Тоосы нь тодлон
Тодруулаад тодруулаад
Тун биед нь хувилгаад, хувилгаад
Лавлаад халиагаад байхад
Тас хар
Хээр морин хөлөг
Хүрэн цоохор
Морин хөлөг
Уяатай байхыг
Алдалгүй үзэв
Хажуу талаар нь
Эргэлдүүлээд халиахаар
Талын Харбодон
Хүрэл-Арслан Магнай хоёр
Тэр их шар хөдөөд
Тэн сайхан таталцаад
Тэгш л сайхан
Түлхэлцээд явнаа.
Арш л дээд лам

Хайхирч дуудаад
Хэлэв л гэнээ.
Догшин Харбөхийн хөвгүүн
Талын Харбодон
Луузан Тив хааны хөвгүүн
Хүрэларслан Магнай
Та хоёр болбол
Энэ л яваа насандаа
Нэг нэгээн дийлэж ялж
Нэг чинь дийлэгдэх нь байтугай
Эцэж цуцах сүнс яс хоёр чинь
Хэлхээтэй хамт төрсөн
Хоёр амьтан байнаа.
Миний алтан
Мөнгөн бумбатай рашаанаас
Та хоёр хүртээж
Аюуш цагаан мэндийн
Хадаг зангиаг зүүлцээж
Ах дүү
Амин цөсөн бологтун гэж
Шившин хайхираад
Дуудаад хэлэв л.
Хүрзээн чинээн шүдтэй
Хүрэл цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэларслан Магнай
Халиагаад үзэхэд
Арш л дээд лам
Алтан мөнгөн бумбатай
Илбийн рашаан,
Аюуш цагаан мэндийн
Хадаг зангиагаа аваад
Эргээд хүрээд
Нисээд ирэхийг

Алдалгүй үзэв.
Хүрэл-Арслан Магнай
Хайхираад хэлдэг нь
Энэ билээ:
Өвгөн арш их
Дээд лам *минь*
Таны алтан бумбатай
Илбийн рашаанаас
Хүртээгүй болович
Хүртсэнтэй адил болтугай!
Аюуш цагаан мэндийн
Хадаг зангиаг тань
Зүүгээгүй болович
Зүүсэнтэй адил болтугай!
Талын Харбодон*гийн*
Голын нь булгилсан
Хүрэн цуснаас
Гурав
Балгаад авбал миний
Ундам харих*[73] *л гэж
Байна шүү дээ!
Гуяны чичивхийрсэн
Улаан махнаас
Гурав хэрчээд
Зажилж л залгиад авбал
Хотом*[74] *цадах гэж
Байнаа шүү дээ гээд
Талын Харбодонтой
Тэн сайхан таталцаад
Тэгш сайхан
Түлхэлцээд явав л
Талын Харбодон

---

[73] Амын цангаа гаргах
[74] Ходоод минь

Халиагаад үзэхэд
Арш дээд ламд
Хайхирч л дуудаад
Хэлдэг нь энэ билээ л:
Талын Харбодон *би*
Арш дээд лам *таны*
Алтан бумбатай илбийнтэн
Рашаанаас л ууж
Хүртээгүй болович
Хүртсэнтэй адил болтугай!
Аюуш цагаан мэндийн
Хадаг зангиаг тань барьж
Зүүгээгүй болович
Зүүсэнтэй адил болтугай!
Хүрэл-Арслан Магнай*тай*
Би ах дүү
Болъё гэсэн болович
Хүрэл-Арслан Магнай
Надтай ах дүү
Болохгүй гэхээр
Би л яах юм бэ? гээд
Тэн сайхан таталцаад явнаа.
Тэгш сайхан түлхэлцээд явнаа.
Өөдөөнөө харж
Өрөлцөж цохилцоод
Уруугаанаа харж
Уралцаж цохилцоод явав л
Арш дээд лам хэлэв:
Хүрэл-Арслан Магнай *чи*
Миний үгэнд эс
Ордог болохлоор би
Талын Харбодонг *увдслаж*
Тамир тэнхээ нэмүүлээд
Хүрэл-Арслан Магнайг

Ялж дийлүүлээд
Нарны гурван
Орон гүрнийг
Төвхнүүлээд явдаг нь
Зөв юм байна гэж хэлээд
Алд л аюуш
Цагаан хадаг
Зангиагаа авч
Зангидаж л байгаад
Талын Харбодонгийн
Хавцал болсон аманд
Хаяад өгдөг нь
Энэ л билээ.
Талын Харбодон
Бадартал нь шүүрэн авч
Ёлон хар ходоодондоо
Залгиад одоход
Талын Харбодонгийн
Алаг хар нүдэнд нь
Хар бараан
Ороод явнаа
Авдар зандан
Чээжинд нь уран
Ухаан санаан
Нэмэгдсэн болоод явнаа.
Дал ээм талаар нь
Далан таван барын
Тэнхээн нэмэгдээд явнаа.
Хар харцагаар нь
Хар барын тэнхээн
Нэмэгдээд явнаа л
Хүрэл-Арслан Магнайн
Тал өргөн цээж нь
Харанхуйтаад явнаа.

Тахь найман үе нь
Сулдаад явнаа.
Сар ирэх тусмаан
Саараад явнаа л
Талын Харбодон
Өдөр ирэх тусмаан
Имэрч л бариад авахдаа
Хангал цагаан яс нь
Халуу бүлээ өргөөд явнаа.
Хамаг эрээн
Сайн мах нь
Өврөөн [=өөрөө] зөндөөн
Гүйцээд явнаа л
Нягт хар мах нь
Нягтраад явнаа.
Нийлэг цагаан яс нь
Халуу бүлээ
Өгөөд [=оргиод] явахдаан
Хүрэл-Арслан Магнайг
Хангал сайхан ташаа талдаан
Хаман барин мушгиан
Бариад эргээд
Босдог газрыгаан
Халиагаад явнаа
Элбэг сайхан
Ташаа талдаан
Эвхэн барин мушгиад
Эргээд хаяад
Босдог газрыгаа
Талын Харбодон
Халиагаад явнаа
Зайрын шил
Замбуулингийн хөдөө болтол
Халбайтал нь өргөөд

Тором тэмээн тоглож
Тавагаан татаж чадашгүй
Торгон цагаан элсэн дунд
Тэрийтэл нь цохиод явнаа.
Хүрэл-Арслан Магнайн
Авдар зандан
Цээж дээр нь
Зайдагнаж амраад суув л.
Амаргүйхэн
Арван таван хоног
Амраад явнаа.
Арван зургаа дахь нь
Болж л явахад
Хайрын хар бараан
Илд минь
Хаана байдаг
Болов уу гээд
Талын Харбодон
Халиагаад үзэхэд
Тавтай таван
Хоногийн газарт
Мөн хэвэндээ [=байдгаараа]
Ир нь гялайгаад
Нимгэн цагаан
Тольт нь цайгаад
Үзэгдээд байхыг
Алдалгүй үзэв.
Талын Харбодон
Халуун уураан тавьж
Хар илдээ татаад авнаа л
Хүйтэн уураан тавихад
Хайрын хар бараан илд нь
Хий хамхуул хэвтээ

[illegible] хийсээд

Хийсээд[75] ирдэг нь
Энэ билээ.
Талын Харбодон
Хавалж аваад явнаа.
Хайрын хар
Бараан илдээн
Хангинатал нь шившин
Сугалаад явнаа.
Хүрэл-Арслан Магнайн
Хүрэл улаан хүзүүнд
Хар бараан үлдээ
Түшүүлж шившээд
Хүрэл-Арслан Магнайн
Хүзүү толгойг нь
Тас чавчиж хярган
Хаяад одов л гэнэ.
Тэр л газар дээрээсээ
Талын Харбодон босоод
Атан тэмээ хэвтээ
Алхаад явнаа.
Агт морин хэвтээ
Гишгэлээд явнаа.
Алхаад эргээд явнаа.
Хүрэл-Арслан Магнайн
Хүрэн цоохор морины
Хажуу талаар
Эргэлдэж ирээд
Урт сайхан цулбууры нь
Аваад явнаа.
Уужим сайхан
Хүзүүгээр нь тааруулаад
Тас чавчиж хяргаж
Унагаад явнаа
Ар дараа талд нь

Талын Харбодон
Алттайхан хөө
Хуягаан өмсөөд явнаа.
Араан чис
Хар модон шиг
Саадагаан авч л
Агсаад явнаа.
Тас хар
Хээр мориныхоо
Тавин талд
Тахийн хүзүүн цулбуурыг
Тэй гүв татан тайлж
Тав зургаа
Хугасалж давшуур
Дороон бөхлөн хийгээд
Хатуу харгайн
Очин хэвтээ [=адил]
Хаян торолж мордоод
Харгайн буурал
Хэрмэн хэвтээ [=шиг]
Хий торолж мордоод
Баруун өмнө л
Зүгийг тэмцүүлээд гарав л
Амхаан цагаан
Хөтөл даваад явнаа.
Арвин шар
Говийн өрийг
Гаталаад явнаа.
Хоо цагаан
Хөтөл даваад
Хотгор шар
Хөдөөн өрийг
Гатлаад явнаа.
Хол л ууж им

Газрыг авч л
Гүйлгээд явнаа
Нэг л амхаан
Цагаан хөтөл өөд
Аван идэн
Алдуулаад гараад ирэхэд
Нураг хүрэн зандан
Улаан уул нутаг
Тохомцаагаа[76] [=ил сайхан]
Торолзаад явнаа.
Торгон сайхан орой нь
Цэнхэртээд явнаа
Ээмцээгээ[77][=ил ойрхон] эргэн
Өнгөлзөөд явнаа
Шуу цаагаа [=гарын дор]
Шунхалзаад үзэгдэнэ
Суунаг татан
Дүмбийгээд үзэгдэнэ
Суу дундуураасай
Уруугааны тогтсон
Утаан гэдэг юман
Униар татан
Цэнхэртээд байнаа
Агтаан туруун [=туурай]
Харгилдаад байнаа
Алдаан [=үе тэнгийн] залуучууд нь
Шуугилдаад байнаа
Азарганы дуун
Бөлбөлөөд байнаа
Албатын нь дуун
Шуугилдаад байв л
Луузан Тив хааны

76. Тохмоороо
77. Ээмээрээ

Далан найман тэрэмтэй
Долоо найман
Зуун унытай
Далай цагаан өргөө нь
Далбайж л дүнхийгээд
Үзэгдээд байв л
Үүдэн талаар нь эргэлдүүлээд
Юун үзэгдэнэ билээ гэж
Халиагаад үзэхэд
Луузан Тив хааны
Луу шар идэрмэг
Цоохор морин
Уяхан зандан
Модон уяандаан
Сагалар зандан
Модон сүүдэртээн
Гур сайхан
Гуя нь гулжийгээд
Гулз сайхан
Цээж нь дэнхийгээд
Зогсож байхыг
Алдалгүй үзэв.
Түүний дараа талд нь
Эмээлийн хавтасны нь
Хар хөлс нь
Хатаж эвэрээдгүй
Хамраас нь гарсан уур нь
Саарч жилийгээдгүй[76]
Тэл хонгор саарал
Морин зогсож байхыг
Алдалгүй үзэв.
Талын Харбодон
Замба тив догдолтол

---

[76] [illegible]

Захын модон
Найгатал хайхираад явнаа.
Зах таван
Товч мөлтөртөл
Задгай их дуугаан
Гаргаад хайхираад хэлэв л.
***Энэ л* Луузан Тив хааны**
Ид шидтэй ирмэг
Луу шар цоохор
Морины хажуу доод
Талд л уяатай байдаг
Эцсэн муу
Тэлээ хонгор морьтой
Эргүү тэнэг
Элмэр наарашаан [=наашаа]
Өтөр шулуун гараад ир.
Нарны эртэд
Насныхаа багад чи
Надтай ирсэн
Харьснаа үзээд ав гээд
Хайхираад хэлэв.
Луузан Тив хааны
Гурван хөвүүн
Талын Харбодонгийнх уруу
Явсны араар нь
Тэл хонгор морьтой
Тэнгэрийн хөвүүн
Тэвэг Алтанзул л
Луузан Тив хааны
Цахилгааны зандан дагиныг
Залаад авдаг гэж ирээд
Луузан Тив хаанд
Амин гурван үгээн
Ёс болгож хэлээд

Аюуш цагаан
Аман хадгаан өгөөд
Сууж л байтал
Талын Харбодонгийн
Дуун гараад
Хайхираад одоход
Луузан Тив хаан
Хэлдэг нь энэ билээ:
Чимхээд татдаг ноосгүй
Чилэн шар цоохор морьтой
Чин-Алтан бислэг ***минь ч яахав***
Төвлөөтэй бор
Халзан морьтой
Төмөрзүрхэн баатар ***минь ч яахав***
Хүлэг төрж
Хүрээн чинээн шүдтэй
Хүрэн цоохор морин шиг
Хүлэг төрөөгүй билээ
Хүмэн төрж л
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай ***шиг***
Хөвүүн төрөөгүй билээ надад.
Талын Харбодон
Тас хар хээртэйгээн
Төрсөн сайн эр сайж
Хүрэл-Арслан Магнайг ***минь***
Хүчээрээ дийлсэн болохоор
Хүрэл-Арслан Магнай ***минь ч***
Юу үлдэх билээ.
Талын Харбодон
Миний гурван хөвүүний
Дон[79] дээр л суучихаад
Ирж яваа буйзаа!

---

[79] Ижилдийтээд, толгойг нь залгиад

Талын Харбодон*гийн*
Дуун гарч байнаа.
Тэвэг Алтанзул *л чи*
Амьд мэнд л явбал
Миний цахилгааны
Зандан дагина
Шиг юмыг [=дагина бэрийг]
Хар нохойн хаагаар
Даллаад авнаа гэгийч?
Замдаан орэж буцаад
Завгангааг (!) *тосолэж яв!*
Күкмэн минь [=хүү минь л])
Талын Харбодон*гоос*
Унасны чинээн өөрийн
Улаан амиан одоохон
Уучлаад гар гэж
Луузан Тив хаан хэлэв.
Тэвэг Алтанзул хариу хэлэв:
Хаан сайхан аав минь
Ухаантай болтолоо
Ухаан мунхаг шиг
Болдог тань юу билээ?
Санаан тань саруул болтолоон
Санаа мунхаг шиг
Болдог тань юун билээ?
Тас хар
Хээр морин болбол
Азарганы дусаалаас бүтэж
Дусаад гарсан унаган.
Сайн гүүний умайгаас л
Унаад боссон
Унаган морин
Миний унаа сайн хөлөг
Тэл хонгор

Мөн адил гэж бодийт та.
Талын Харбодон
Эр хүний
Дусаалаас дусаад бүтсэн
Эхийн умайгаас унаад боссон
Хүмний хөвүүн болохоор
Тэвэг Алтанзул
Мөн адилхан гэгийт гээд
Яаралгүйхэн босоод
Ялалгүй алхаад
Эргээд гарав л.
Амхаан цагаан
Хөтөл өөдөөн
Халиахаар бас л
Амхаан цагаан
Хөтөл дээр л
Талын Харбодон
Тас хар хээртэйгээн
Зогсож байх нь
Нэг л арслан
Хар уул дээр
Бас л нэг
Арслан хар уулыг
Ташир тависан юм шиг л
Тэнгэрийн хөвүүн
Тэвэг Алтанзулд л үзэгдэв л
Тэвэг Алтанзул
Тэлээ хонгор хөлөг
Сайн морин дээрээн
Хаян торолж мордоод
Баруун ам нь эргүүлээд
Хойт наран
Эргээд ордог
Зүг рүү тэмцүүлээд

Талын Харбодонгоос
Ойлж л зугтаагаад явав л
Талын Харбодон
Бас хайхираад хэлэв л:
Тэлээ хонгор морьтой
Эргүү тэнэг элмэр чи
Ойлож л зугатаагаад
Надаас ч хаараан [=хаашаа]
Гарнаа ч кукам [=хөөрхий минь]
Тэлээ хонгор морин чинь
Далд орлооч
Чи өөрөөн яагаад ч
Надаас далд л оршгүй юм байна.
Яганаач элмэр минь ээ?!
Бие чинь одоо
Далд орлооч надаас
Тэл хонгор морин чинь бас
Далд оршгүй юм байнаа
Яганаач элмэр минь [=золиг] ээ (?)
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон *би*
Чамайг одоохон
Тас болж халин нисээд
Тэнгэрт гарлаач
Гүйцнэ гэгийч /=шүү/
Тарваган болоод доошоо
Газарт орлооч
Би чамайг
Гүйцнэ гэгийч гэж шившээд
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн гишгэн
Алдуулаад оров л.

Тэвэг Алтанзулын
Тэлээ хонгор морин нь сульдаж
Дав дав давиулаад одов
Шив шив цохиулаад явнаа.
Тэвэг Алтанзул
Холби тусан буугаад
Ужим сайхан
Хормойгоо дэвсээд
Урт сайхан
Шовшиpолтоороо шовшироод
Морьтойгоо
Күүндээд[80] хэлэв:
Тэлээ хонгор морь минь чи
Хүлэг биш
Хүрэл эрдэнэ эс билүүч
Морин биш
Молор эрдэнэ
Эс билүүч
Эцээд тураад муучрах
Газар чинь энэ билүү? [=юм уу]
Эзэн хаан баатар намайгаа
Талын Харбодон*д*
Уядаж дандахыг
Мэдээд зогсов уу ч гэв л.
Тэлээ хонгор морины
Халиа мөнгөн уруул нь
Гүвэлзээд явнаа
Хаш морол шүд нь
Яралзаад явнаа.
Хүлэгчилж хэлээд
Хүүндээд [=ярилцаад] явнаа
Хүмэнчилж хэлээд
Хүүндээд [=ярилцаад] хэлэв л:

---

[80] [illegible]

Талын Харбодон
Тас хар
Хээр морьтойгоон хамт
Та бид хоёрыг
Тас болж
Тэнгэрт гарлаач
Бид хоёрыг
Гүйцнэ гэгийч
Тарваган болж л
Газарт орлооч
Бид хоёрыг
Гүйцнэ гэгийч
Та одоо хариу эргээд
Аавын аргаар
Аргалаж ярилцаад
Ээжийн эвээр
Эвлэж ярилцаад
Талын Харбодон*гоос*
Утасны чинээн
Улаан амиан
Уучилах арга
Эвээн хайх тань
Янаа гэж бодно би гэв.
Тэвэг Алтанзул
Тэлээ хонгор морион
Тэр л газраасаа эхлэн
Хөтөлж наминчлан мөргөөд
Талын Харбодонтой
Очиж уулзах газраа хүртэл
Дөхөж наминчлан очиход л
Талын Харбодон
Аван идэн алдуулаад
Хайхираад хэлэв:
Чи ямар гэм зэм л

Хийсэндээ одоо ингэж
Надад наминчлан мөргөөд
Ирдэг учиртай
Амьтан билээ?
Намайг хамаа нэг [=хаана]
Ямар газар [=хэзээ]
Ядарсан амьтныг өөртөө
Наминчлуулан мөргүүлж л явдаг
Хүмэн гэж л хэзээ
Хэнээс л сонсолоо чи?
Өтөр шулуун хэл л гээд
Аван идэн шамдуулаад хэлэв л
Тэнгэрийн хөвүүн
Тэвэг Алтанзул хэлэв л:
Нартын хүмүүнээс
Таныг муулж хэлж, гоочилж
Доорд үзэж байхыг
Сонсоо ч үгүй билээ би?
Талын Харбодон
Танд учир, түүх
Намтраан би одоо
Уг үзүүрээс нь наашлуулан
Тоолж товчилоод
Тун үнэнээр нь хэлье гэв л
Луу шар морьтой
Луузан Тив хааны
Гурван сайхан хөвүүнь
Талын Харбодонуур
Явж л гэж сонсоод би
Ар сугаар нь
Луузан Тив хааны
Цахилгааны зандан дагиныг *залаад*
Авъя гэж ирээд би
Луузан Тив хаанд

Амин гурван
Үгээн хэлээд, би
Алд цагаан мэндийн
Аюуш хадгаан бариад
Сууж л байтал
Талын Харбодон
Таны чимээн сураг гарахлаар би
Дуунаас тань оолж [=хулжин] *зугтаагаад*
Утасны чинээн нарийхан
Улаан гол амиан
Уучилгаад авч явсан
Учир цаг минь энэ билээ би.
Та, тас болоод
Тэнгэрт гарлаач
Чамайг гүйцнэ би!
Тарвага болоод
Газарт орлоо ч
Чамайг гүйцэн би гэж хэлэхээр тэнь би
Утасны чинээн нарийхан
Улаан гол амий минь
Уучлагтун гэж гуйхаар би
Хариу гэдэргээн эргээд
Амиан хамгаалан гуйхаар
Эргэн ирж л байгаа
Учир цаг минь энэ л гэв
Тас хар хээр морьтой
Талын Харбодон
Тэвэг Алтанзулд хэлэв л:
Дуртай дургүй ч гэсэн
Муу дүү минь болбол болоорой!
Эс болбол ч бас
Эс болоорой гэв л.
Тэвэг Алтанзул
Талын Харбодон хоёр

Тэндээ сууж хүүнэлдээд
Ах дүү хоёр баатар болоё
Амин цөсөн болоё гэж
Ам тангарагаан авалцаад
Хариутай төрсөн
Хаан сайхан ах нь
Хар хээр моьтой
Талын Харбодон
Болоод явнаа.
Үргээд одохоор [=холоод явахаар]
Тоосы нь хайдаг
Үхээд одохоор [=үхмэгц]
Сэгий нь хайдаг
Хариутай төрсөн дүү нь
Тэвэг Алтанзул
Болоод явнаа.
Хоёр сайн унаа
Хий салхин [=хийморь] **болсон**
Хөлөг морьдынхоо
Эмээл доогуур шургалцаад
Ах дүү хоёр бололцов.
Эр биеийнхээ
Эрхий хомхоогоо хагалж
Цусы нь солилцож амсалцаад
Ах дүү хоёр бололцов.
Сайн явснаа
Хэлж инээлдээд
Салангид муу
Явснаа хэлэлцэж уйлалдаад
Ах дүү хоёр бололцов.
Өдий төдий
Цагийн үе өнгөрөхөд
Талын Харбодон
Хэлэв л гэнээ.

Одоо хоёулаан
Луузан Тив
Хаанд очъё гэв л
Тэр л газраас
Хоёр сайн баатар
Босоод явнаа.
Тэвэг Алтанзул
Дүү баатар эр
Хаан сайхан ахынхаа
Тас хар
Хээр морины
Урт сайхан
Цулбууры нь аваад
Уужим сайхан сугаас нь
Сугадаж мордуулаад явнаа
Дараа талд нь
Тэлээ хонгор
Морин дээрээ
Хаян торолж мордоод
Ах дүү, амин цөсөн болсон
Хоёр баатар
Луузан Тив хааны
Далай цагаан
Өргөөг чиглүүлэн
Бахийтал суугаад явнаа.
Бадартал нь довтлуулаад явнаа.
Дуугтал нь цохиод
Шуугитал нь тавиад явнаа.
Ууд л төөдөг [=амгай зуузай]
Уралдуулаад явнаа.
Өвдөг тохой
Зөрөлдүүлээд явнаа.
Хүр хүр гэж
Хүүндээд явнаа

Хүрзээн чинээ шүдээ
Яралзуулаад явнаа
Луузан Тив хааны
Далай цагаан өргөөн
Үүдэн талд ирээд
Холби тусан буугаад явнаа.
Хоёр сайхан унаа
Хий хөлөг морион
Луу шар цоохор
Морины хажуу талд
Уяхан зандан
Модон сүүдэрт нь
Уян сүүдэрлүүлж хаяад
Талын Харбодон
Тэвэг Алтанзул
Хоёулаа цуваад
Луузан Тив хааны
Далай цагаан өргөөд
Алхаад эргээд
Орж ирээд
Луузан тив хаан
Хатан хоёулаа
Талын Харбодонд хэлэв л
Чимхээд татдаг ноосгүй
Чилэн шар
Цоохор мортой
Чин Алтанбүс ***минь нахав!***
Төлөөтэй бор
Цоохор морьтой
Төмөрзүрхэн баатар ***минь нахав!***
Хэлэх үгийг минь сонсогтун!
Хүлэг торж л
Хүрзэн чинээн шүдтэй
Хүрэн цоохор морин

Шиг л төрөөгүй байсан билээ.
Хүмэн төрөж л
Хүч их тэнхээтэй
Хүрэларслан Магнай *шиг л*
Хүмэн төрөөгүй байсан билээ.
Тас хар хээр
Морьтойгоон тал одоо
Төрсөн санж
Хүрэл-Арслан Магнай*гаар минь*
Дороон дөнтэй сайн
Дүүгээ хийж ах дүү бололцоод
Далай цагаан
Өргөөний минь үүдээр
Дахуулаад ороод
***Ирэх чинь ягав*"** гээд
Луузан тив хаан
Хатан хоёулаа
Хий харгаад [=ухаан балартаад]
Унаад байв л гэнээ
Талын Харбодонгийн
Хөдөлж үзээгүй байсан
Хүрэн улаан зүрх нь
Түүн дээр бас л нэмэж
Хөдлөөд явнаа.
Уярч үзээгүй
Улаан зүрх нь
Түүн дээр бас л нэмэж
Уяраад явнаа.
Талын Харбодон намайг л
Нэг л сайн эр алчихаад
Догшин довон Харбөх баатрынд
Эрээд сураад ирэхлээр л
Догшин Харбаатар [довон Харбөх]
Аав минь

Бас л ингэж хэлэлгүй яанаа гээд
Талын Харбодонд бодогдов л
Талын Харбодон
Хажуу талдаа эргэлдээд хэлэв л:
Тэлээ хонгор морьтой
Тэвэг Алтанзул ***баатар дүү минь явэж***
Хүрэл-Арслан Магнай
Төмөрзүрхэн баатар
Чин Алтанбүс
Энэ л гурван баатар эрсийг
Чи амьдаруулаад
Дагуулаад ирсэн цагт
Луузан Тив хааны
Цахилгааны зандан дагиныг
Би л мэдээд
Чамд л өгнөөв гээд л
Аюуш цагаан хадаг гаргаж
Энэ Аюуш цагаан хадгаар
Гурван их сэвүүлээд
Гурван их хайхирахаар [=уриадан дуудахад]
Тэр гурван баатар эр
Амьдараад босдог домтой
Учиртай юман гэв.
Тэвэг Алтанзул
Алтан хавтгынхаа аманд
Аюуш хадгаа хийж
Арай чамай багтаагаад
Алхаад эргээд гарав л
Ар талд нь
Талын Харбодон
Луузан Тив хаан
Хоёр хоцров л
Тэвэг Алтанзул
Тэр л газар дээрээс

Тэлээ хонгор
Морин дээрээ
Хаян торолж мордоод
Хойт наран
Эргээд ордог
Зүгийг чиглээд гарав.
Алтай өргөн нутгийг
Шувтлаад явнаа.
Амхаан цагаан
Хөтөл даваад явнаа.
Арвин шар
Говийн өрийг
Гаталаад явнаа.
Хоо цагаан
Хөтлийг даваад
Хотгор шар
Хөдөөн өрийг
Гаталаад явнаа.
Хол ууж им
Газрыг авч гүйлгээд
Нэг л амхаан
Цагаан хөтөл дээр
Гараад ирэхэд
Түүний цаахан талын
Нарийхан шар
Говийн өр дунд
Нэг л хар бараан
Үзэгдээд явнаа.
Түүн дээр л
Тавиад [=давхиад] ирэхээр
Хүрзэн чинээ шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнайг

Түүн дээр л оршоосон байв.
Түүний цаахан талын
Арвин шар хөдөөн
Өрийг гаталаад
Бас л нэг
Амхаан цагаан
Хөтөл дээр
Гараад ирэхээр
Бас л нэг
Нарийхан шар
Хөдөөн өр дунд
Хариу гэдэргээ
Эргээд ороод явнаа.
Төморзүрхэн баатар
Төөлөөтэй бор
Цоохор морин хоёрын
Хүүр хайж олоод
Холби тусан буугаад
Салбараад одсон махы нь
Хайж л цуглуулаад
Салаад одсон ясы нь
Түүж л аваад
Бас л хүмэн
Хүлэг хоёрын
Яс мах хоёрыг
Эгнүүлж л тавиад явав л
Тэнгэрийн хөвүүн **Тэвэг Алтанзул**
Тэл хонгор морин дээрээ
Хаян торолж мордоод
Хариу гэдэргээн
Эргээд гараад явнаа.
Арвин шар
Говийг гатлаад
Амхаан цагаан

Хөтөл даваад
Нарийхан шар
Говийн өр л
Дунд байсан
Хүрэл-Арслан Магнай
Хүрэн цоохор
Морин хоёр
Хүүр дээр буцаж ирээд
Тэгнээд явав.
Нэг л хар бараан
Алс бул [=энд тэнд] үзэгдээд явнаа.
Түүн дээр л
Тавиад ирэхээр
Төмөрзүрхэн баатар
Төөлөөтэй бор
Цоохор морин хоёрын
Сэгийг тэгнээд мордов л.
Түүнээс л өнгөрөөд
Нарийхан шар
Говийн өрийг гатлаад
Нэг л амхаан
Цагаан хөтөл дээр
Гараад ирэхэд
Бас л хар бараан
Алс бул үзэгдээд явнаа.
Түүн дээр л
Хүрээд ирэхлээр
Чин Алтанбүс
Чилэн шар
Цоохор морин
Хоёрын хүүр байв.
Хүмэн хүлэг хоёрын
Салаад одсон ясыг
Хайж л цуглуулаад

Салбараад одсон махыг
Түүж л аваад
Хоёр гурван тэгнээ махыг
Тэлээ хонгор
Дээрээ тэгнээд
Хаян торолж мордоод
Холби тусан буугаад
Хоёр тэгнээ махыг
Холбилж буулгаад
Хүрэн цоохор морин
Хүрэл-Арслан Магнай хоёрын
Хээр хэвтсэн
Хүзүү толгойг
Зүүж л тавиад явнаа.
Хүрэн цоохор морин
Хүрэл-Арслан Магнай хоёрын
Салаад одсон ясыг
Зүүж тавиад
Салбараад одсон мхыг
Эвлүүлж тавиад явнаа.
Төөлөөтэй бор
Цоохор морьтой
Төмөрзүрхэн баатарын
Салаад одсон ясыг
Салбараад одсон махыг
Зүүж эвлүүлж
Тавиад явнаа.
Алтан хавтгынхаа
Амыг [=домнож] эвшээлгээд явнаа.
Аюуш цагаан хадгийг
Гаргаад [=гаргаад] явнаа.
Чин Алтанбүс
Төмөрзүрхэн баатар
Чилэн шар

Цоохор морин
Төлөөтэй бор
Галзан морин дөрөвийг
Аюуш цагаан хадгаар
Гурав дахин адислаад
Гурав дахин
Ариулаад явахад
Хүмэн хүлэг амьдраад
Хийлээд хийлээд хээрэн
Босдог нь энэ билээ л.
Үд хүршгүй
Үетэй цагаан эм
Хоног хүршгүй
Хонин цагаан эм
Өгч бүтэн хэвд нь
Оруулж амьдруулаад явнаа.
Ар талд нь
Хүрэн цоохор морин
Хүрэл-Арслан Магнай
Хоёрын хүзүү толгой нийлээд
Аюуш цагаан хадаг
Зангиагаар адислаад
Үд хүршгүй
Үетэй цагаан эм
Хоног хүршгүй
Хонин цагаан эм
Өгөөд ирэхэд
Хүрэл-Арслан Магнай
Хүрэн цоохор морин хоёр
Амьдраад босоод ирэв
Хүрэл-Арслан Магнай хэлэв:
Талын Харбодон
Хамаа байнаа?
Гуяны чичив гэсэн

Хар махнаас нь
Гурав зажилаад
Авмаар байнаа би!
Голын булгилсан
Хүрэн цуснаас нь
Гурав балгаад
Авмаар байнаа би! гэзд
Босоод ирэв л
Тэвэг Алтанзул
Түүн дээр
Усан хэлээр
Урсгаад явнаа.
Тосон хэлээр
Тошуулаад явнаа.
Экий нь[81] эргүүлээд
Толгойг нь бас
Тойруулаад авав л
Ах дүү амин цөсөн
Дөрвөн сайхан баатар
Тэр л газраан
Сайн явсанаа
Хэлцэж инээлдээд
Салангид явсанаа
Хэлцэлдэж уйлалдаад
Өдий төдий цагийн үес
Өнгөрөөд ирэхэд
Яаралгүй босоод явнаа.
Могой болж л
Илэвкээд байнаа
Морин болж л
Жилэвкээд байнаа л
Тогос шувуун хэвтээ
Тонголзоод байнаа л

81 Гархийг нь

Тоть шувуун хэвтээ
Гялавхийд байхыг
Алдалгүй үзэв.
Дараа талд нь
Талын Харбодонгийн
Тас хар
Хээр морин
Самнаагаараа наадаад
Сар нар сэвээд
Сагаг дөрвөн туурайгаараа
Сайхан дэлхийн өрийг
Салбартал нь хүй
Ум дэлдээд
Уяхан зандан модон
Сагалгар зандан модон
Хоёрыгоо шөргөөгөөд
Хонх л болсон
Хоёр чихээн
Хомин цохин
Хайчилаад байхыг
Алдалгүй үзэв.
Ах дүү гурвуулаа
Тэвэг Алтанзул
Дөрвөн сайхан баатар
Ядаж төдөлгүй
Дөрвөн сайхан унаа
Хий хүлэг
Морин дээрээ
Хаян торолж
Мордоод явнаа.
Нураг хүрэн
Улаан уул нутагаан
Тэмцүүлээд явнаа.
Бахийтал нь суугаад

Бадартал нь довтлоод
Дууггал нь цохиод
Шуугитал нь тавиад явнаа.
Нураг хүрэн
Улаан уулынхаа
Наахан талын
Амхаан цагаан
Хөтөл дээр
Гараад ирэхэд
Луузан Тив хаан
Сайхан аавы нь
Далай цагаан өргөө
Далбайж дүнхийгээд
Үүдэн талд нь
Луу шар
Цоохор морин
Уяхан зандан
Модон уяандаа
Саглагар зандан
Модон сүүдэртээн уяатай Үзэгдэв.
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Хүр хүр хүүндээд
Хүрзээ чинээн шүдээ
Яралзуулаад ороод явнаа.
Алтай өргөн нутгаа
Шувтлаад явнаа
Далай цагаан өргөөнийхөө
Үүдэн талд ирээд
Холби холби тусан
Буугаад явнаа.
Унаа хий хүлэг
Морьдоо амрааж
Уян сүүдэрлүүлж

Хаяад явнаа.
Алхаад эргээд
Ороод ирэв л
Ах дүү дөрвөн
Сайхан баатар
Аав ээж
Тэвэг Алтанзултай
Зургуулаа уулзаад
Сайн явснаа хэлэлцэж
Инээлдээд, баясаад
Салангид явснаа хэлэлцэж
Уйлалдаад хүүндээд
Талын Харбодонтой
Луузан Тив хааны
Гурван хөвүүн
Ах дүү болж
Аман тангарагаан
Авалцаад байнаа л
Ар талд нь
Арван таван хоногийн
Найр хийгээд
Авдаг юман гээд
Далай болсон
Архи цуглуулаад
Даранх болсон
Мах идээгээ
Цуглуулаад байна л
Нарийхан шар
Бүрээгээ татаад
Найман түмээ цуглуулаад
Урт шар
Бүрээ татаад явнаа.
Олон түмнээ цуглуулаад
Нэг их л

Найр эхлээд явнаа.
Тэр өдрөөн
Тэсэн найрлаад
Тэр шөнө дөлөн найрлаад
Түүний мангаадарыг
Аван найрлаад
Амаргүй сууцгааж
Арван таван хоногийн
Адаг өнгөртөл нь
Найрлаад байхад
Талын Харбодон
Арван зургаадахь
Өдөр болж л явахад
Хайхираад хэлдэг нь энэ л:
Луузан Тив хаан
Сайхан аав минь би
Зах л хол
Нутагтай билээв
Заг л хэврэг
Түлээтэй билээв
Өвгөн болсон аавтай
Эмгэн болсон
Ээжтэй билээв.
Явдал минь
Яаруу билээв
Газар минь
Хол л билээв
Одоо миний
Явах цаг минь
Боллоо гэв л
Луузан Тив хаан
Хэлдэг нь энэ билээв:
Чиний хэлдэг ч зөв
Миний сонсдог ч зөв

Чамайг хэзээ
Ингэж хэлдэг болов уу гэж
Бодож байлаав.
Аранзаа хааны хүүхэн
Алтан Солонго дагиныг
Удалгүй аваад
Төдөлгүй алтан
Жолоо эргүүлээд
Дайныг дараад
Дагина бэрийг
Залаад ир хүүкэм минь
Эргээд ирэхэд чинь
Чамтай хамт л нүүж
Далан долоон
Хар уулд чинь нүүж
Хүрч нутагланаав
Дунд замба тивийн
Хорон шүү нь
Ихдээд байхад
Хортон дайсан
Олширч байхад
Миний гурван хөвгүүн
Талын Харбодон
Чамтай хамт
Нэг л газар
Нэг л орон орчинд
Нутагладаг ёстой юман байна.
Нураг хүрэн
Улаан уул нутаг минь багадаад
Шуугиантайхан олон муж
Албат минь ихдээд
Багтаж ядаад нутаг газар
Хайгаад нүүж л
Байгаа хэрэг биш л

Хорон шүү ихдээд
Хортон дайсан
Олдож байхад
Хэдэн хөвүүтэйгээ
Нэг л газар
Нэг л орон тивд
Далан долоон
Хар уулдаа
Бөөнөөр нутагланаав гэв.
Ар л талд нь
Мартагдашгүй их
Сургаалаа хэлээд
Барагдашгүй их
Ерөөлөөн тавиад
Талын Харбодон
Яаралгүй босоод
Ядалгүй хувцаслаад
Боол тулгын
Өмнө л талд
Босго тотгын
Ар талд
Төөнө өвдөг газардуулаад
Өнчин сүвээ мэхэлзүүлээд:
Хаан сайхан
Аав минь
Харцутай сайхан олон
Ах дүү нар минь
Хавтгай өргөн
Хошуу нутагтайгаа
Амар сайхан
Санаагаар их
Заяагаар өнөр
Сайн сууж байгтун
Удалгүй яваад

Төдөлгүй алтан
Жолоо эргүүлээд
Ирнээв гээд
Алхаад эргээд гарав л.
Тас хар
Хээр мориныхоо
Тахийн хүзүүн цулбуурыг
Тэй гүв татаад
Тав зургаа хугасалж
Талын Харбодон
Давшуур дороо хийгээд
Хатуу харгайн
Оч хэвтээ [=шиг]
Хаян торолж мордоод
Харгайн буурал
Хэрмэн хэвтээ
Хий торолж мордоод
Баруун ам эргүүлж
Баруун өмнө
Зүгээ тэмцүүлээд
Гараад явнаа.
Дараа талд нь
Луузан Тив хаан
Тэвэг Алтанзул
Цахилгааны зандан дагина
Хоёрын далай цагаан
Өргөөг нь дотортой
Гадартай нь бүрэн
Дэглээд явнаа л.
Сарын сайхныг
Саатаж хүлээгээд
Өдрийн сайхныг
Өнжиж хүлээгээд
Өлзийтэй сайн

Өдөр болоход
Зуун манхан тэмээний
Бөхнөөс нь уруугааны
Борвиноос нь өөдөөний
Далай цагаан өргөөг
Алт мөнгө хоёртой нь
Ачуулаад явнаа
Нүүлгээд явнаа.
Аранзаа хааны
Алтан Солонготой
Өдөр харгалдах болов уу
Шөнө харгалдах болов уу гээд
Талын Харбодон
Таван ерэн есөн
Жилийн газрыг
Таван жилээр
Болзож гүйлгээд
Гараад явахад
Нэг л өндөр болон
Заан цагаан
Хөтөл дээр
Гараад ирэхэд
Түүний цаахан талын
Хорин таван сар
Явж гаталмаар
Хотгор шар
Хөдөөн өр дунд
Баатар хар тоосон
Багтаж ядаад
Хүдэр хар тоосон
Гүйцэж ядаад
Дүлий хар
Будан татаад
Хүйтэн хар

Хүдэн элхэдээд
Одсон байхыг
Талын Харбодон
Алдалгүй үзэв.
Бараагий нь багатгаад
Байсан биед нь оруулаад
Тоосы нь тодоруулаад
Тун биед нь
Оруулаад байхад
Уулын дүнтэй
Зориг цагаан морин
Уяатай байхыг
Алдалгүй үзэв.
Түүний хажуу талд л
Шагай шаргал морин
Уяатайхан байхыг
Алдалгүй үзэв.
Түүний хажуу
Талаар эргэлдүүлээд
Халиагаад байхад
Хоёр сайн баатар эр
Шинэхэн [=дөнгөж саяа] нэг нэгээн
Унагаагаад, дийлээд
Амраад сууж байхыг
Талын Харбодон
Алдалгүй үзэв
Тас л хар
Хээр мориороо
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн
Алдуулаад ороод явнаа.
Арвин шар
Хөдөөн өр дунд

Нэг нэгээн унагаагаад /=ялаад/
Нэг нь унаад одсон байсан
Хоёр баатрын
Дээр нь байсан баатрыг
Тас хар хээр
Дээрээсээ аваад
Тавтай таван
Үдийн газарт
Талхартал нь цөөлдөж /=шидэж/
Таягдаад одов л
Тэр л уулын
Бэлийг өгсүүлж л яваад
Тас хар
Хээр мориныхоо
Хавцал болсон амыг
Арай чамай
Тогтоож эргүүлээд явнаа.
Дор нь байсан
Хар л улаан залуугийн
Хажуу талд л ирээд
Морин дээрээсээ
Хайхираад хэлэв л
Чи л ямар
Гэм хийсэндээ
Хүний сандалаа
Болж л байдаг чинь
Энэ билээ.
Миний тэр л
Аваад хаядаг хүмэн
Ямар их л
Гавъяа шагнал
Хийсэндээ
Хүнээр сандалаа
Хийж л байдаг

Билээ гэв л
Дор нь байсан
Хар л Улаан залуу
Хайхираад хэлэв л:
Өндөр шаргал уул
Нутагтай байдаг
Өндөр шаргал морьтой
Шар л хаан ***гэж***
Хаан сайхан аавын минь
Алдар нэр нь
Тэр л билээ.
Шар л хааны хөвүүн
Шагай шархал морьтой
Шаралдаймэргэн баатар
Гэдэг хүмэн би
Болдог билээв.
Шар л хаан
Аав минь
Эрт л урд эхэн
Анхан түрүүн цагт
Далан долоон
Хар уул нутагтай
Долоон муэж албатай
Далан дөрөө
Дамжиж морддог
Долдоо догшин
Хар хээр морьтой
Догшин Харбөх баатар
Гэдэг күнтэй
Ах дүү
Амин цөсөн
Болсон билээв л.
Одоо тавин дөрөө
Дөрөөлөөд мордмоор

Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон *гэдэг*
Хөвүүтэй болсон гэлээ.
Догшин Харбох баатар
Аавындаа очоод
Амар мэндийг мэдээд
Тас хар хээр морьтой
Талын Харбодон *ахтайгаа*
Танилцаад ир гэж
Намайг явуулсан билээ.
Далан долоон хар л
Уулд нь ирэхээр
Өвс нь сэргээд
Ус нь тунаад
Байр нь харлаад
Баас нь эврээд
Одсон байлаа л.
Шулмаан хаан
Бирдээн хаан
Бирэнзээн хаан
Шарай голын хаан
Шарзын хаан *гэж*
Шулмаан *таван*
Их хаан толгойлоод
Тавин долоо
Гучин таван
Моршны үс тоолмоор
Догшин шар цэрэг*тэйгээ*
Ирээд Догшин довон Харбох
Баатар *аавыг*
Долоон муж
Албат*тайг нь олзолоод*
Одсон байлаа.

Араас нь хөөцөлдөөд
Шулмаан *таван*
Их хааныг дараад
Тавин долоо
Гучин таван
Морины үс тоолмоор
Догшин шар цэрг*ий нь*
Үрийг таслаад
Үндэсий нь хийсгээд
Эрийн ясаар
Эрэг тогтоогоод
Хүлгийн ясаар
Хөсөг тогтоогоод
Долоон муж албат*ыг*
Далан долоон
Хар уулд нь
Хүргэж төвхнүүлэв.
Догшин довон Харбөх
Баатар *ааваас*
Талын Харбодон *ах*
Ягалаа (хаана бэ?) гэхлээр л
Аранзаа хааны
Алтан Солонго дагин*ыг*
Авдаг (=залах) гээд
Эртээ урт
Эхэн анхан
Түрүүн цагт л
Явсан билээ гэхээр
Аранзаа хаан*уур*
Очиж л явтал
Уулаан дүнтэй
Зөн цагаан морьтой
Түүхий мах идэвч
Түй гэж үзээгүй

3Түмэн бугын
Мунаар цохивч
Ёо гэдэггүй
Шулаг улаан
Мангас ***гэдэг***
Хүмэн харгалдаад
Гурав саадс [=дахин] ***унагаагаад***
Гурав саадс [=дараа дараагаар]
Алахаар минь [=алахад минь]
Гурав саадс л **Шулаг улаан мангас**
Амьдарч босоод
Дөрөв дэх дээрээ
Хүлэг дандав [=доройтов]
Хүмэн үндав [=ганцаардав]
Шулаг улаан
Мангасын ***дор***
Би унаад [=ялагдаад]
Шулаг Улаан мангас
Намайг унагаагаад[=ялаад, дийлээд]
Байсан цаг минь
Энэ билээ гэв л.
Талын Харбодон
Шаралдаймэргэн
Баатар хоёул
Тэнд, тэгэж танилцаад
Шаралдай мэргэн баатарын
Нүдний шороог нь
Хэлээрээ арчаад явнаа.
Нүүрний шороог нь
Алгаараа арчаад явнаа.
Нурууны шороог
Кийлэнгээрээ арчаад явнаа л.
Талын Харбодон
Шаралдаймэргэн баатар

Хоёулаа тэгж уулзаж
Ах дүү хоёр танилцаад
Сайн явснаа хэлэлцэж
Инээлдээд явнаа
Салангид явснаа хэлэлцэж
Уйлалдаад явнаа.
Өдий төдий
Цагийн үе
Өнгөрөөд ирэхэд
Тэр л газар дээрээсээ
Босоод явнаа.
Шаралдаймэргэн баатар
Алттай хөө
Хуягаа өмсөөд явнаа.
Араан чис (час)
Хар модон шингээний
Саадгаан өмсөөд явнаа.
Шагай шархал морины
Хажуу талд л уяатай байсан
Шулаг улаан мангасын
Уулын дунтэй
Зөн цагаан морины
Урт сайхан цулбуурыг
Аваад явнаа
Уужим сайхан хүзүүгээр нь
Тас цавчиж тасдан
Хаяад явнаа л
Уулаан дунтэй
Гал түлээд явнаа.
Улхан[82] болсон
Цогоон нураагаад явнаа.
Атаа дайчин
Лха таван тэнгэрээн

82. Голомт. цог. нурам

Зөн цагаан мориор
Тах иад явнаа л
Хоёр сайн эр
Сарбайж мөргөөд
Санаж л залибраад шившив л.
Сайн эрийн
Сайн санаа зориг [=зөн]
Цагаан морин болбол чи!
Сардаан нэг л ийм
Их л дайтай
Харгалдуулэж яв биднийг.
Муу эрийн
Муу, зориг цагаан
Морин болбол чи!
Жилд нэг л
Их дайгаар
Харгалдуулэж яв гээд
Сарвайж л мөргөөд
Санж л залбираад
Дараа талд нь
Шаралдаймэргэн баатар
Талын Харбодон
Хаан сайхан ахынхаа
Тас хар
Хээр морины
Урт сайхан
Цулбуурыг аваад явнаа.
Ужим сайхан сугаас нь
Сугадаж мордуулаад
Ар л талд нь
Шагай шархал
Морин дээрээн
Хаян торолж
Мордоод явнаа.

Баруун ам эргүүлээд
Баруун өмнө л
Зүгрүү тэмцүүлээд
Аранзаа хааны
Арслан хар
Уул тэмцээд
Гараад явнаа
Амхаан цагаан
Хөтөл даваад явнаа.
Арвин шар
Говийн өрийг
Гаталаад явнаа.
Хоо цагаан
Хөтөл даваад явнаа.
Хотгор шар
Хөдөөн өрийг
Гаталаад явнаа.
Хол ууж им газрыг
Авч л гүйлгээд
Тавтай таван
Жилийн газрыг
Таван сараар
Болзож гүйлгээд явнаа.
Таван сарын газрыг
Арван таван хоногоор
Болзож гүйлгээд
Арван таван хоногийг
Асганаан улаан нарнаар
Болзож гүйлгээд
Нэг л өндөр болон
Заан цагаан
Хөтөл дээр
Аван идэн
Алдуулаад гараад ирэв

Аранзаан хааны
Арслан хар уул
Тохом цаагаан
Торолзоод явнаа.
Торгон сайхан орой нь
Цэнхэртээд явнаа.
Ээм цээгээн [=эгэм цацуу]
Өнгөлзөөд явнаа
Шуу цаагаа [=шуу чацуу]
Шунхалцаад явнаа
Суунаг татан
Дүмбийгээд явнаа.
Суу дундуураасаа
Урууганы тогтсон
Утаан гэдэг юман
Униар татан
Цэнхэртээд явнаа.
Агтаан туруун [=туурай]
Харгилдаад явнаа.
Алдаан [=үе тэнгийн] залуучууд нь
Шуугилдаад явнаа
Азарганы дуу нь
Бөлбөөлөөд явнаа.
Албатын нь дуу
Шуугилдаад явнаа.
Хүлгээн анир
Хүнхэнээд явнаа
Хүний дуу нь
Шуугилдаад байв л.
Олон цагаан гэрүүд нь
Одон мичин болон
Ярийгаад явнаа
Хар бараан мал нь
Хаpалж хүрийгээд явнаа.

Хавтгай өргөн
Ужим нутгийн нь
Утаан гэдэг юман
Униар татан цэнхэртээд
Аранзаа хааны
Далан найман тэрэмтэй
Долоо найман
Зуун уньтай
Далай цагаан өргөө нь
Далбайж л дүнхийгээд
Үзэгдээд байв л
Үүдэн талд нь
Аранзаан хааны
Алтан шарга морин
Могой болж л гилэвкээд
Морин болж жилэвкээд
Тоодог шувуун болон
Тонголзоод явнаа
Тогос гургуул хэвтээ
Гялавкаад байхыг
Талын Харбодон
Шаргалдаймэргэн
Баатар хоёр
Алдалгүй үзээд явнаа
Амхаан цагаан хөтөл уруу
Аван идэн
Алдуулаад ороод явнаа
Алтай өргөн
Нутгийн дундуур
Дуугитал нь цохиод
Шуугитал нь тавиад явнаа.
Бахийтал нь суугаад
Бадартал нь довтуулаад явнаа.
Далай цагаан өргөөн

Үүдэн талд нь ирээд
Алтан шаргал морины
Хажуу талд
Холби холби тусан
Буугаад явнаа.
Тас хар
Хээр морин
Шагай шархал
Морин хоёрыгоо
Уяхан зандан модон
Уянд нь амраан
Уян сүүдэрлүүлж
Хаяад явнаа.
Ах дүү, амин зөсөн
Хоёр сайхан баатар
Далай цагаан өргөөнд нь
Цуван алхаад
Эргээд ороод ирэв л
Гэрийн баруун гол
Сууриан эхэн талд
Аранзаа хаан
Эрүүнийхээ сахлыг
Өвчүүн талдаан шувтараад
Оочийхоо сахлыг
Чихэн талдаан имэрээд
Хялам хялам гээд суухыг
Алдалгүй үзэв л
Гэрийн зүүн гол
Сууриан эхэнд
Аранзаа хааны хатан
Халиагаад суухыг
Алдалгүй үзэв.
Аранзаа хааны
Дараа талд нь [=дараа нь]

Атан тэмээн хэвтээ
Алхлаад одов [=очив]
Агт морин хэвтээ
Гишгэлээд хүрэв
Ах дүү, амин зөсөн
Хоёр баатар
Хорин тохой газар
Хотгойтол нь суув л
Аранзаа хаан
Таван согтуу улаан
Түшмэд талдаан (тийшээ)
Халиагаад хэлэв л:
Хол л газраас
Явсан өнгөтэй [=шинжтэй]
Хортон дайсантай
Харгалдсан өнгөтэй
Орон гүрнийг
Эзлээд төрсөн
Баатар шинжтэй [=зүстэй]
Олон түмэн хүнийг
Ор л ганцаараан
Ахалж захлаад
Төрлөөв гэхийн шинжтэй [=байдалтай]
Энэ л хоёр
Хар улаан залууд
Өдөр шулуун
Аманд нь одоо
Аяга унд өгтүн
Алтай өргөн нутаг
Алдар богд нэрэн
Хэтэм хол
Хэрэг зоригий нь
Сураад сонсоод
Авнаав гэв л

Таван согтуу улаан түшмэд
Яаралгүй босоод явнаа.
Ядалгүй босоод гарнаа.
Далан хүмэн
Дамжилаад уумаар
Дангын ногоон шаазанд
Шихэр бурмын амтаар
Шинэхэн бүрээд хийсэн
Шингэн цагаан
Чигээнээс л хийж л
Бариад явнаа.
Ах дүү хоёр баатар аваад
Дав дээрээн
Дал хүргэж донгодоод [=уугаад]
Хатуу алттай
Хар архинаас нь
Нав дээрээн
Ная хүргэж донгодоод
Уугаад суув л
Аранзаа хаан
Хайхираад асуув:
Хол л газраас
Явсан өнгөтэй [=бололтой]
Нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Хоёр хар улаан залуу*гийн*
Алтай өргөн нутаг
Хаана билээ?
Хэтэм хол
Хэрэг зориг чинь
Хэнд болдог билээ?
Өдөр шулуун
Хэлээд өгийт гэв л
Талын Харбодон

Хайхираад хэлэв:
Алтай өргөн
Нутаг минь болохоор
Хойт наран эргээд
Ордог зүгт л байдаг
Эр морин явахаар
Эцээд тураад
Туруун нь [=туурай нь] *эргээд*
Хүрмээр газарт байдаг
Эр хүмэн явахаар
Өвгөрч хөгшироод хүрмээр
Элээ шувуун явахаар
Зуур гурав зулзагалаад
Живэр нь гуужаад хүрмээр
Эдгээдийн хол газрын
Цаахан талд л байдаг
Товчилэж хэлэхээр
Төсөр хол газар
Тоолоод дүгнээд хэлэхээр
Арван ерэн есөн
Жилийн газарт байдаг
Алтайн далан долоон хар уул
Нутагтай байдаг
Долоон олон мөс хүрээд үлсэн
Албаттайхан байдаг
Далан дөрөө
Дамжиж морддог
Долдоо догшин
Хар хээр морьтой
Догшин довон Харбөх баатар
Гэдэг хүмэн
Хаан сайхан
Аавын минь
Алдар нэр нь

Тэр болдог билээ.
Шагай шархал морьтой
Шаралдаймэргэн баатар *гээж энэ*
Дүүгий минь
Алдар их богд нэр
Тэр л билээ.
Өвөр биеийн минь
Алдар нэрэн болохоор
Догшин довон Харбөх
Баатрын хөвүүн
Тавин дөрөө
Дамжиж мордмоор
Тас хар хээр морьтой
Талын Харбодон *гэдэг хүмэн*
Би болдог билээ.
Хэтэм хол
Хэрэг зориг минь болохоор
Хаан сайхан аав таны
Алдарт тань гарч
Харуусы тань
Харсал гээд ирлээв
Өргөн тань гарч
Мөр л хэрчээжий тань
Огтолъё гээд ирлээ би
Хатуу хажир
Дайсанг дарахад тань
Дэм болъё гээд ирлээ би
Хатуу алттай
Хар архинд тань
Сөн ч бараан
Болъё гээд ирлээв би.
Алтансолонго дагин*ыг*
Тань залаад
Авсал [=авъя] *гээд ирлээ би* гээд

Яаралгүй босоод
Ядалгүй алтан хавтганыхаа
Амыг эвшээлгээд
Алд л дүнтэй
Аюуш цагаан хадаг
Аягын амны дүнтэй
Шар л зүстэйг нь
Алд л дүнгийн
Татаастайг нь
Аван гаргаад барив л
Аранзаа хаан аваад
Хоймор талын
Бараан өөдөөн
Хаяад суув л
Талын Харбодон
Үүдэн тал руу
Алхалж одоод
Босго тотгын
Ар талд
Боол тулгын
Өмнө талд
Төөнө өвдөг
Газардуулаад суув
Төт хар
Толгойгоо тонголзуулаад ёслов
Өвдөг тохой газардуулаад суув
Өнчин сүвээ мэхэлзүүлээд ёслов
Өөдөө дөхөж ирээд суув.
Аранзаа хаан хэлэв л:
Хүмүн бүхэн
Авнаан [авна би] ***гээд байдаг***
Хүсэлтэй ганц л
Хүүхэн манайд байдаг юмаа.
Боломжтой нэг

Занатай эрд
Өгсөл [=өгнө би] ***гэлээ*** гэв л.
Талын Харбодон
Шаралдаймэргэн баатар хоёр
Ахлаад эргээд
Гараад явнаа
Үүдэн талд л байсан
Тас хар
Хээр морин хөлөг
Шагай шаргал хөлөг
Морин хоёр дээрээ
Хаян торолж мордоод
Аранзаа хааны Алтансолонго
Дагиных байдаг
Алтан луу шил л
Цонж байшин тийшээ
Тэмүүлээд гараад явнаа.
Алтан луу шил
Байшингийн үүдэн
Талд ирээд
Холби холби тусан
Буугаад явнаа.
Тас хар
Хээр морин
Шагай шаргал хөлөг
Морин хоёрыг
Хад чулуу дамжуулаад
Хайр чулуу гишгүүлээд
Хад мэт хантраад
Тулга мэт
Тушаад явнаа.
Ар талд нь
Алтан шил луу
Цонж байшингуур

Алхаад эргээд
Ороод ирэв л
Алтансолонго дагина
Тавин хүүхэн дагуултай
Тамсаг улаан хүүхэн
Алтан мөнгөн домбодоон
Аршаан болсон усаа
Аваад явнаа
Аагтай улаан цайгаа
Чанаад явнаа.
Алтан мөнгөн домбодоон
Хийж юугээд[83] явнаа.
Далан хүмэн дамжилмаар
Дангын ногоон шаазанд
Чих (зөв) баривал
Чигчээ дундуур
Эвтэй баривал
Эрхий дундуур хийгээд
Талын Харбодон
Шаралдаймэргэн
Баатар хоёрт
Хийгээд барив л.
Алтан юү тавганд
Алим идээг
Асгартал нь хийгээд
Хорин найман хөлтэй
Хойморын ширээн дээр
Хотойтол тавиад
Дараа талд нь
Тавин хүүкэн дахуултайгаа
Атлансолонго дагина
Талын Харбодон
Шаралдаймэргэнтэй

83. Уудлаад юүгээд

Тавин гурвуулаа
Шагай шатар даамаар
Алтан шил цонж байшиндаа
Наадмын ихээр наадан
Жаргалын ихээр жаргаад
Наадмын ихээр наадаад
Жаргал цэнгэл үүсгээд
Хийгээд байв л
Арван таван хоногийн
Адаг өнгөртөл нь
Жаргал цэнгэл хийгээд
Арван зургаа дахь нь
Болж л явтал
Арапзаа хааны
Ховч шандан
Шар хүүхэн
Нэг л өглөө эрт
Хагь л цагь татаад
Ороод ирэв л
Хаан сайхан аавын
Өлөг хууч өвчин хөдлөөд
Талын Харбодон
Таныг өтөр шулуун
Хүрээд ир гэнээ гээд
Гараад одов л
Талын Харбодон
Яаралгүй босоод
Ядалгүй хувцаслаад
Алттай хөө
Хуягаан өмсөөд явнаа.
Арын чис [=час]
Хар модон шиг
Саадгаан агсаад
Алхаад эргээд

Гараад явнаа.
Тас хар
Хээр мориныхоо
Тавин алд цулбуурыг
Тай гүв татаад
Тав зургаа хугасалж
Давшуур дороо хийгээд
Тас хар
Хээр морин дээрээ
Хаян торолж мордоод
Аранзаа хааны
Далай цагаан
Өргөөг тэмцүүлээд
Бахийтал нь суугаад
Бадартал нь довтолуулаад
Дууттал нь цохиод
Шуугитал нь тавиад явнаа.
Далай цагаан өргөөн
Үүдэн талд л ирээд
Холби холби тусан буугаад
Тас хар
Хээр морион
Уяхан зандан
Модонд уяанд нь
Саглагар зандан
Модон сүүдэрт нь
Уян сүүдэрлүүлж хаяад
Алхаад эргээд
Ороод ирэв.
Аранзаа хаан
Нарийхан зандан
Ширээ орон дээрээ
Нимгэн булган
Хөнжил дотроон

Ёо гэсэн дуу нь
Хоёр чихэнд
Хахир хадаад байв.
Талын Харбодон
Хайхираад л суув:
Хаан сайхан аав минь
Та яавт?
Таны энэ
Өлөг хууч өвчинд
Эм л дом болдог юман
Байдаг болохоор
Талын Харбодон*гоо* [=намайгаа]
Өтөр шулуун явуулагтун!
Тас хар
Хээр морь минь
Тав их махтай
Таван их хурдтай байна.
Талын Харбодон *тань*
Тавтай таван их
Едтэй байнаав гэв л
Аранзаа хаан
Түүн дээр бас нэмж
Хайхираад хэлэв:
Энэ л нэг хөдөлдөг хууч
Намайг авах [=үхүүлэх] *гэсэн*
Иймл сүрхий
Өлөг хууч
Өвчин байдаг юман хүүхэм минь
Залахад яргай мод сайхан
Зарахад хүргэн хүн сайхан
Гэж л байдаг юмсан
Үүнд л эм л
Дом болохоор юман гэвэл
Өмнө л нарин

Эргээд гардаг
Зүгт л байдаг
Оронгоон хөх
Бух л гэж байнаа
Түүний баруун
Бөөрийг халуунаар
Идэхээр эдгэрдэг
Нэг л эм дом
Тэр л билээ
Оронгоон хөх бухын
Баруун бөөрийг
Халуунаар надад
Авч л ирэх өг
Хүкэм минь л гэв.
Тавин дөрөө
Дамжиж мордмоор
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон
Атан тэмээн
Хэвтээ алхалаад
Арван тавны
Сар хэвтээ
Малмаагаад гараад явнаа.
Үүдэн талд нь
Уяхан зандан модон уяандаан
Сагалар зандан модон
Сүүдэрт нь сүүдэрлүүлж
Уяатай байсан
Тас хар
Хээр мориныхоо
Хажуу талд нь эргэлдээд
Тавин алд
Тахийн хүзүүн цулбуураа

Тай гүв татаад тайлаад
Тав зургаа хугаслаад
Давшуур дороо
Хийгээд явнаа.
Хатуу харгайн очин
Харгайн буурал
Хэрмэн хэвтээ
Хий холоос
Мордоод явнаа.
Зөв амыг нь татаад
Зөөлөн амыг нь
Эргүүлээд явнаа.
Зүүн өмнө л
Зүгийг тэмцүүлээд
Гараад явнаа.
Аранзаа хааны
Алтай өргөн нутгийг
Шувталаад явнаа.
Амхаан цагаан хөтлийг
Даваад явнаа.
Арвин шар
Говийн өрийг
Гаталаад явнаа.
Хоо цагаан
Хөтлийг даваад явнаа.
Хотгор шар
Хөдөөн өрийг
Гаталаад явнаа.
Хол ууҗим газрыг
Авч гүйлгээд явнаа.
Чилгэр сөө [=шөнө] гэж
Чилэлтгүй гүйлгээд
Чилэн шар
Наран гэж

Сааталгүй гүйлгээд
Харанхуй сөө гэж
Харилтгүй гүйлгээд
Халуун шар
Наран гэж
Сааталгүй гүйлгээд
Харь хол газрын
Хажир хар дайнуур
Хар ганцаараан
Очиж л явнаав гэж
Харих нэгэн санаангүй
Хальтирах нэгэн зүрхэнгүй
Имэрч гүйлгээд явахад
Нэг л өндөр
Болон сайхан
Заан цагаан
Хөтөл дээр
Гараад ирэв л
Цаахан талд нь
Оронгоон хөх бух
Арван таван
Хоногийн газарт
Уул шиг үзэгдээд
Үүлэн болон
Цэнхэртээд байхыг
Алдалгүй үзэв
Тасхар
Хээр морин
Хүлэг төрлөөрөө
Хүхэрдээд хэлэв л
Хүмэн төрлөөрөө
Хүүндээд хэлэв л:
Тэр л уул
Болон үзэгдээд

Үүлэн болон
Цэнхэртээд байдаг
Оронгаан хөх бух *тэр л байна.*
Тэр л хөх бух*тай*
Ирсэн харьсан
Хоёроо үзэлцээд
Автан [=барилдаараа та] гэв л
Тас хар
Хээр морион
Тэр л газар дээрээн
Хад л хэвтээ хантарч
Тулга хэвтээ
Тушиж хаяад явнаа.
Араан чис модон шиг
Саадгаа агсаж хаяад
Алттай хөө
Хуягийг тайчиж овоолоод
Артай хүрэн
Зодгийг агсаад явнаа.
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Алхаад эргээд
Ороод явахад
Оронгаан хөх бух
Алдалгүй үзээд
Талын Харбодон руу
Хагшаад алхаад
Эргээд аашихийг
Алдалгүй үзэв л
Талын Харбодон
Атар газарт тошсон
Отор тарган бух
Омог тарган болдог
Хүмэн малын бараа

Үзээгүйдээ ингэж
Ирж л явнаа бухан [=буйзаа] гээд
Оронгаан хөх бухыг
Тулаад ирэхийг
Тосон хүлээгээд
Оронгаан хөх бухын
Хоёр эврийн нь унгид
Таван зандан хуруугаан
Тааргүй шигтгээд
Өргөн ууж им магнайг нь
Тал л өргөн
Цээжээрээ тулаад
Тэр л өдрийг өнгөртөл
Оронгаан хөх бухтай
Барилдаад явнаа.
Тэр шөнийг
Дөлөн барилдаад явнаа.
Түүний мангадар
Болж л явахад
Оронгаан хөх бухын
Хоёр эврийн нь унгид
Таван зандан хургаан [=хуруугаа]
Тааргүй шигтгээд
Өргөн ууж им магнайг нь
Тал л өргөн
Цээжээрээн тулаад
Тэр л өдрийг
Оронгаан хөх бухтай
Барилдаад явнаа.
Тэр шөнийг
Дөлөн барилдаад
Түүний мангадар [=маргааш]
Болж л явахад
Оронгаан хөх бухыг

Унагаагаад дарав л.
Нэг л эврий нь газрын ан руу
Гадас болтол шааж
Унагаагаад дарав л.
Хавиргын нь хавсыг нь
Шинжигнэтэл өвдөглөөд
Амраад суув л
Оронгаан хох
Бух л хэлэв:
Алдаг болохоор
Өтөр шулуун ал
Авардаг болохлоор
Өтөр шулуун
Амий минь авар
Амь минь гарах л
Гэж байнаа
Арьсан минь
Хуурах гэж байнаа гэв
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон:
Би чамтай барилдахдаа
Алах л гэсэндээ
Чамтай барилдсангүй
Аврах гэсэндээ
Чамтай ирэж
Барилдсангүй билээв.
Аранзаа хааны
Өлөг хууч
Өвчин нь хөдөлөөд
Оронгаан хох бух***ын***
Баруун бөөрийг
Халуунаар идэхээр
Эдэгдэг билээ би гэсэн юм.

Чамтай ирэж л
Харгалдаад барилдсан минь
Ийм учиртай билээ гэв л
Оронгаан хөх
Бух л хэлэв:
Аранзаа хааны
Алтансолонго *дагиныг*
Арван зүгийн
Арван сайн эр
Авах л гээд ирэхээр
Охиноо өгөлгүй над руу
Явуулдаг болсон юм.
Хорин зүгийн
Хорин сайн эр
Алтансолонгыг
Авдаг гэхээр
Над руу явуулдаг болсон юм
Арван зүгийн
Арван сайн баатарт
Өгч ер болдоггүй
Адтай хүүхэнтэй
Аранзаа хаан
Хорин зүгийн
Хорин сайн баатарт
Өгч ер болдоггүй
Хорхойтой хүүхэнтэй
Аранзаа хаанд
Би биеэрээ хүрч очоод
Баруун бөөрөөн өгнөөв.
Надад дөр хамрыг
Шургуулэж өгөөд намайг
Хөтлөөд яв гэв л
Оронгаан хөх бухад
Дөр хамар зүүлгээд

Босгоод явнаа.
Талын Харбодон
Тас хар
Хээр морин дээрээ
Оронгаан хөх бухыг хөтөлж ирээд
Алттай хөх хуягаан
Авч л өмсөөд
Араан час хар
Модон шиг
Саадгаа агсаад
Ар л далдаан
Авч л агсаад
Дараа талд нь
Хаян торолж мордоод
Оронгаан хөх бухыг хөтлөөд
Арслан хар
Уул нутагтай
Аранзаа хааны
Алтай өргөн
Нутгийг тэмцээд
Гараад явнаа.
Хол уужим газрыг
Аваад явнаа.
Хотгор уужим
Говийг гатлаад явнаа.
Амхаан цагаан хөтөл
Даваад явнаа.
Арвин шар
Говийг гатлаад явнаа.
Нарийн шар
Говийг гаталаад
Нахиу цагаан
Хөтөл даваад явахдаа
Арслан хар уулын

Өмнө л талын
Амхаан цагаан
Хөтөл өөд
Гараад ирэв.
Алтай өргөн
Нутгийн дундуур
Орчлонгийн **Оронгаан**
Хөх бухыг
Хөтөлж ирээд
Аранзаа хааны
Далай цагаан
Өргөөний үүдэн талд уяад:
Хаан сайхан аав минь
Оронгаан хөх бух*ыг гаргаж* [=алж]
Баруун бөөрийг
Өөрийн биеэр авч
Халуунаар нь идэгтүн гэж хэлээд
Талын Харбодон
Байшинд нь ороод
Алтан шил луу
Алтансолонго дагинатайгаа
Жаргал сэргэл хийж
Найр наадмын юмаан бэлтгэв л
Жаргалын дээдээр жаргаад
Найрын ихээр найрлаад
Ард л [=дуусаж] ороод
Арван таван хоногийн
Адаг өнгөрч байтал
Аранзаа хааны
Ховч шандан
Шар хүүхэн
Нэг л өглөө дахин
Ирж л хэлэв:
Хаан сайхан аав

Оронгаан хөх бух*ыг*
Орон байранд нь
Өтөр шулуун хүргэж
Тавигтун.
Өлөг хуучин
Эдгээлээ одоо
Хаан сайхан аавын
Далай цагаан өргөөнд
Хүн л цухалзуулалгүй
Давирч хагшиж
Мөргөөд, дайраад
Оронгаан хох бух
Хүнийг оруулж
Гаргахгүй байнаа гэв л
Талын Харбодон
Яралгүй босоод
Ядалгүй гараад явнаа.
Тас хар
Хээр морин дээрээ
Хаян торолж мордоод
Аранзаа хааны
Далай цагаан өргөөний
Үүдэн талд уятай байсан
Оронгаан хөх бухын
Хамар дөрийн нь сугалж
Таван өнгийн
Хив зүүж сэтэрлээд
Аранзаа хааны
Арван олон муж
Албат иргэдийг
Гурав хувилаад [=хуваагаад]
Нэг хувийг [=хэсэг]
Аранзаа хааны хувь болтугай
Бас нэг хувь нь

Алтансолонго дагины
Хувь болтугай гээд
Оронгаан хөх бухад бас
Хувь өмчлүүлж өгөөд:
Хэрээ шувуун хэлмэрчтэй явъя
Хээзээ мөнх л мэндтэй явъя
Элээ шувуун
Элчтэй явъя
Энд л тэнд
Мэндүүтэй явъя гээд
Оронгаан хох бухыг
Орон байранд нь тууж хүргэв.
Талын Харбодон
Алтан шил
Байшинд ирээд
Алтансолонго дагинатайгаа
Шаргалдаймэргэн баатар
Тавин хүүхэн дахуултайгаа
Шагай, шатар, даам
Жаргал сэргэлийн
Ард л ороод
Арван таван хонгийн
Адаг болж л байтал
Ховч шаадан шар
Хүүхэн нэг л
Өглөө эрт ирээд
Хаан сайхан аавын
Өлөг өвчин дахиж
Хөдлөөд болдоггүй гэв.
Талын Харбодон
Яаралгүй босоод
Ядалгүй хувцаслаад
Алттай хөө хуягаан
Өмсөөд явнаа.

Араан час модон
Шиг саадгаан
Ар (нуруундаа) далдаан
Агсаад авав.
Ардараа талд нь
Алхаад эргээд
Гараад явнаа.
Тасхар
Хээр морин дээрээ
Хаян торлож мордоод
Алтай өргөн
Нутаг дундуур нь
Бахийтал нь суугаад
Бадартал нь довтолоод
Дуугтал нь цохиод
Шуугитал нь тавиад явахад
Аранзаа хааны
Далай цагаан өргөөний
Үүдэн талд л ирээд
Холби тусан буугаад
Тасхар
Хээр морион
Уяхан зандан
Модон уяанд
Сагалар зандан
Модон сүүдэрт нь
Уян сүүдэрлүүлж
Хаяад алхаад
Эргээд ороод ирэхэд
Аранзаа хаан
Орноос босолгүй
Ёо гэсэн дуу
Хоёр чихэнд
Цоо хадаад байв л

Аранзаа хаан
Сариг цагаан ингэний сүүнээс өөр
Эм л дом болох аятай тустай эм
Түн надад
Байхгүй юм гэнэ гэхэд
Талын Харбодон
Сариг цагаан ингэний
Баруун мээмийн сүү
Авч л ирэж л хаан аавдаа
Өгнөөв гэгээд
Атан тэмээн
Хэвтээ таварч алхалаад
Арван тавны
Сар хэвтээ
Асар дүүрэн
Малмааж л амарлингүй
Улаагаад гарав л
Тас хар
Хээр мориныхоо
Хажуу талд л
Ирж эргэлдээд
Тавин алд л
Тахийн хүзүүн
Суран цулбуурыг
Тай гүв татаад
Тайлаад сугалаад
Тав зургаа хугасалж
Давшуур дороо
Дүрээд [=хийгээд] явнаа.
Харгайн буурал
Хэрмэн хэвтээ
Хаян торолж эвхрэн мордоод
Алс хол явахад бэлтгэв.
Тас хар

Хээр морь минь
Таван их
Хурдтай байна
Талын Харбодон *би*
Эр дунд настай
Эгц цагаан шудтэй
Таван их
Едтэй байнаа
Эм домтой сайн юм бол
Сариг цагаан ингэний сүүг
Хаан аавдаа
Өтөр түргэн явж
Би авч л ирнээв гэхэд л
Аранзаа хаан дахин дахин
Хэлдэг нь энэ билээ.
Энэ л өвчин
Эцэстээн намайг
Нэг л авах [=үхүүлэх]
Юман байнаа
Одоо эм л
Дом болох рашаан бол
Сариг цагаан ингэний
Баруун мээмийн
Үсийг[84] ***уувал л***
Намайг эдгэрээх нэгэн
Эм дом гэнэ гэв.
Эртэй төрсөн
Эрийн сайн **талын Харбодон**гийн
Эрмэг сайн хөлөг морь нь
Шив шив цохиулаад шогшив.
Уядаад дандаан одсон
Хар хээр мориноосоо
Талын Харбодон

Холби тусан буугаад
Ужим сайхан
Хормойгоо дэвсээд
Урт сайхан
Шогшролтоороо шогшроод:
Тавин дөрөө
Дөрвөлж морддог
Тас хар хээр
Хөлөг морин минь чи
Хүлэг биш
Хүрэл эрдэнээр бүтсэн
Морин билээл?
Морол эрдэнээр бүтээлдээд
Төрсөн эс билүү?
Халуун хол
Газар яваад
Эцэж тураад
Зогсдог газар чинь
Энэ болдог нь билүү?!
Эзэн хаан баатар чинь
Сариг цагаан ингэнд дарагдаж
Уядаж дандахыг
Мэдээд зогсож
Байна уу чи гэж асуугаад
Тас хар хээр хөлөгдөө
Ариун сан*гаа уншин шившив л*
Могой улаан хэл нь
Жилэвкээд одов л
Мокин цахиур
Шүд нь яралзаад одов л.
Халиа мөнгөн уруул нь
Өмөлзөөд одов л.
Хаш морол шүд нь
Яралзаад ирэхэд

Хүлэг төрлөө олж
Хүхэрдээд явнаа.
Хүмэн төрлөөрөө
Хүүндээд хэлэв л
Сариг цагаан ингэний
Байрлаж байдаг
Орон байр нь
Үүний цаад талд байнаа!
Сариг цагаан ингэн
Арван таван хоног
Ан гөрөө хийгээд
Явдаг юм байнаа.
Арван таван хоног
Ботгоо хөхүүлдэг юм байнаа.
Одоо арван таван хоног
Ан хийгээд явсан байнаа.
Ар талд одоо
Ботго нь ганцаараа байнаа.
Ботготой нь эхлээд
Ах дүү анд нөхөр
Амин цөсөн
Болоод авах л
Арга л эвээн хайгтун! одоо гэв л.
Талын Харбодон
Хөлөг мориндоо
Хаян торолж мордоод
Хадаан цагаан ялман шиг
Хий торолж мордоод
Зөв амы нь эргүүлээд
Зөөлөн амы нь татаад
Чанх өмнө л
Наран эргээд
Гардаг зүгийг тэмцүүлээд
Алтай өргөн

Нутгийн дундуур
Аван идэн алдуулаад
Арай чамай
Шувталаад өнгөрөв л
Амхаан цагаан хөтөл
Даваад явнаа.
Арвин шар
Говийн өрийг
Гатлаад явнаа.
Хоо цагаан
Хөтлийг даваад
Хол ууҗим
Газрыг авч гүйлгээд
Явахад нэг л
Өндөр болон сайхан
Заан цагаан
Хөтөл өөд өгсөн
Өгсүүлээд гараад ирэх үед
Тас хар
Хээр морин
Хий [=салхин] сайхан хөлөг нь
Дав дав давиулаад зогсов л.
Увидастай төрсөн
Талын Харбодон чинь
Тас хар хээр морин
Хий сайхан хөлөгөө
Морины хувхай
Тал л хомоолд *хувилгаад*
Алтан хавтагадаа хийгээд явнаа.
Араан час
Хар модон шиг
Саадгаан авч л
Хаяад *ишвишээд* явнаа.
Алттай хөө хуягаан

Тайчиж овоолон *шивиэд* явнаа.
Артай хүрэн зодогоо
Өөрийн биедээ өмсөөд шившинээ.
Ар дараа талд нь
Амхаан цагаан
Хөтөл дээр
Шулмын гэтэлгээр
Гэтээд гарнаа
Шулмаан цэмцэлгээр
Цэмцэж гэтээд
Гараад ирэхэд
Түүний цаахан талын
Өргөн шар говийн
Өр дунд
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан ботгон
Урагшаа халиагаад [=хараад]
Сариг цагаан эхээ харууслаад
Буйлин дуулаад
Хэвтэж байхыг
Алдалгүй нэг л үзэв.
Талын Харбодон
Араас нь шулмын
Мэрээлгээр мэрээгээд одноо.
Шуламын цэмцэлгээр цэмцээд
Гэтэн гэтэж
Очиж хүрээд
Арвин шар говийн
Өр дунд байсан
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан
Ботгоны ар л
Бөгс талд ирээд
Таван зандан

Хургаа хоёр бөхөнд нь
Тааруулж шигтгээд
Бариад авав л
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан ботгон
Замба тивийн өрийг
Зад тоглоод явнаа
Захын модыг
Хуй булга тоглоод
Задгай их дуугаараа
Буйлан тоглоод явах үед л
Талын Харбодон
Автай их хүчээрээн
Арвин шар өргөн их
Хөдөөн өр дунд
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан ботгыг
Хавиргаар нь унагаад
Хавсануур нь дахин, дахин
Өвдөглөөд суухад
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан ботгон
Хэлдэг нь энэ билээ
Амин гарах л гэж байнаа
Арьсан минь хуурах
Гэж байнаа
Ах минь ээ!
Алдаг болохлоор
Өтөр шулуун
Намайг зовоолгүй ал!
Авардаг болохлоор
Өтөр шулуун
Амий минь авар гэв
Талын Харбодон

Хариу гэдэргээн хэлэв л.
Алах л гэсэндээ
Чамтай барилдсан үгүй би
Аврах гэсэндээ
Чиний ээжийн
Баруун мөөмний ачлалт
Сүүг авъяа гээд
Чамтай ах дүү
Амин зөсөн болъё гээд
Хол газраас ирлээ би гэв лээ.
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан ботгон
Талын Харбодон хоёр
Ана мана үзэлцээд байнаа л.
Талын Харбодон өөрөө
Алтан хачигт хувилаад
Сариг цагаан ингэний
*Сайхан цагаан ботгон*ы
Ар бөхөнд нь шигдэн
Хэвтээд авав л
Түүний мангадар
Болж явахад
Бүр бүр
Хур ороод байнаа.
Сэр сэр
Салхин гараад явнаа.
Талын Харбодонд
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан ботгон
Хариу хэлсэн нь:
Манай ээж
Чимээ анир авчихаад
Одоо үтэр түргэн эргээд
Ирэх л явнаа

Мангадар өглөөний
Шар нараар магад
Над дээр ирнээ гэв
Сариг цагаан ингэн
Түүний маргадарын
Өглөө шар гэрлээр
Өмнө амхаан
Цагаан хөтлөөр
Эрүү нь газарт
Төө дүнтэй
Зурагдаад одсон [=хүрсэн]
Бөх нь огторгуйн
Орог шархал үүлэнд
Баганадаж хүрээд одсон
Өмнө л амхаан
Цагаан хөтөлөөр
Харгай зөөхөн
Шигтгээний соёо нь арзайгаад
Хавцал болсон
Ам нь ангайгаад
Ороод аашихийг
Алдалгүй үзэв л
Сариг цагаан ингэн ирээд
*Сайхан цагаан ботгон*доо
Арван таван хоног
Хоёр мөөмнийхээ сүүг
Сэлж л хөхүүлээд байхад
Арван таван
Хоногийн адаг
Өнгөрч л явахад
Сариг цагаан ингэний
Сайхан цагаан ботгон
Сүүлээ хөдөлгөөд орхив л
Талын Харбодон

Мөн хэвэндээ *хувилаад*
Сариг цагаан ингэний
Сэрээ хоёр бөхний үгт нь
Таван зандан хуруугаа
Тааруулж ширгээд явнаа
Таван үе гэж
Таталцаад явнаа
Гурван үе гэж
Сэгсэрэлцээд явнаа
Сариг цагаан ингэн
Хошуу талдаан
Өрөвкөөд[85] ***авнаав*** гэж хэлээд
Гацас, гацасын[86]
Хад чулуу
Харгай модыг
Хий өрөвкөөд явнаа
Арван таван хоногийн
Адаг өнгөрч явахад
Сариг цагаан ингийг
Арвин шар хөдөөн
Өр л дунд
Хажуу талаар нь
Унагаад явнаа
Хавирганы хавсануур
Шижигнэтэл өвдөглөөд суув л
Сариг цагаан ингэн:
Амин минь гарлаа
Арьсан минь хуурлаа
Алдаг болохлоор намайг
Зовоолгүй өтөр түргэн
Шулуун ал одоо! гэв л
Талын Харбодоп
Сариг цагаан ингийг хөтлөж

85 [illegible] сорох, сороод
86 [illegible]

Аранзаа хааны
Далай цагаан өргөөн үүдэнд уяв.
*Шагай шархал морин*ы хажууд
Тасхар
Хээр морион
Уяад алхаад
Эргээд ороод явнаа.
Алтансолонго дагина
Талын Харбодон
Шаралдаймэргэн баатар
Тавин хүүхэн дагуултайгаа
Тавин гурвуулаа
Шагай шатар даам
Жаргал цэнгэлийн
Ард ороод байв л
Арван таван хоногийн
Адаг өнгөрч л явахад
Аранзаа хааны
Ховч шандан
Шар хүүхэн бас дахин
Нэг л өглөө
Хагъ цагий татан уйлаад
Ороод ирэв л:
Хаан сайхан аавын
Өлөг хууч өвчин
Эдгэрээд хуучин
Хэвэндээ орлоо.
Талын Харбодон *таныг*
Сариг цагаан
Ингийг тавьэж
Орон байранд нь
Явуултан гэнээ.
Хаан сайхан аавын
Үүдээр сариг цагаан ингэн

Түн нэг ч хүн л
Цухалзуулалгүй байнаа гэв л
Талын Харбодон
Яаралгүй босоод
Ядалгүй алхаад
Эргээд гараад явнаа.
Тасхар
Хээр морин дээрээ
Хаян торолж мордоод
Аранзаа хааны
Далай цагаан өргөөн
Үүдэн талд л ирээд
Холби тусан буугаад
Сариг цагаан ингэн
Таван өнгө хивээр
Сэтэрлээд явнаа.
Аранзаа хааны
Албат нутгийг
Гурав хувилаад[87] [=хуваагаад]
Нэг л хувий нь [=хэсгийг]
Аранзаа хааны хувь
Бас нэг хувь нь
Алтансолонго дагинын
Хөрөнгө хувь болог гэгээд
Бас нэг хувий нь
*Сариг цагаан ингэн*д
Өрөвкүүлж л өгөөд
*Сариг цагаан ингэн*ий
Буйл товхы нь сугалаад
Бурантгий нь авч
Тайлаад явнаа
Сариг цагаан ингэнд:
Хэрээ шувуун

[87] [illegible]

Хэлмэрчтэй авъя
Хээээ мөнхөд
Мэндтэй явъяа
Элээ шувуун
Элчтэй явъя
Эгүүрт мэндтэй
Явъя гэгээд
Орон байранд нь
Тавиад явуулав.
Талын Харбодон
Алтан луу шил
Байшинд эргэж ирээд
Үүдэн талд
Холби тусан
Буугаад явнаа.
*Шагай шаргал морин*ы
Хажуу талд
Тасхар
*Хээр мори*йг
Хад чулуу долигуулж
Хайрга чулуу гишгүүлж
Уяад тушаад
Хаяад явнаа.
Алтан луу шил байшиндаа
Алхаад эргээд
Ороод явнаа.
Аагтай сайхан
Цайгаа уугаад
Амттай сайхан
Алиман өргөнөөс идээд
Дараа талд нь
Шагай шатар
Даамаар наадаад
Жаргал цэнгэлийн

Ард л ороод
Арван таван хоногийн
Адаг өнгөрч л явахад
Нэг л өглөө
Ховч шандан
Шар хүүхэн дахин
Агь л цагь л татан
Ороод ирэв
Талын Харбодон ***таныг***
Хаан сайхан аав л
Өтөр шулуун
Хүрээд ирэгтүн
Гээд сураг хэлээд ирэв
Талын Харбодон
Яаралгүй босоод
Ядалгүй хувцаслаад явнаа.
Арын час
Хар модон
Шиг саадгаан
Авч л ар далдаа
Агсаад явнаа.
Алхаад эргээд
Гараад явнаа.
Тас хар
Хээр морин дээрээ
Хаян торолж модоод явнаа.
Аранзаа хааны
Далай цагаан
Өргөөг тэмцүүлээд
Бахийтал нь суугаад
Бадартал нь довтолоод
Шуугтал нь тавиад
Далай цагаан өргөөн
Үүдэн тал ирээд

Холби тусан буугаад явнаа.
Тасхар
Хээр морийг
Уяхан зандан модон
Уянд нь уян
Сүүдэрлүүлж хаяаад
Алхаад эргээд
Ороод явнаа.
Аранзаа хааны
Доод талд ирээд
Үй түмэн нүдтэй
Үхэр хөх түшлэгтэй
Олон давхар
Олбог суурь дээр ирээд
Хорин тохой газарт
Хотийтол нь суугаад
Наян тохой газарт
Нагцаатал нь суугаад ирэхэд
Аранзаа хаан
Аагтай улаан
Цайгаа хийгээд
Амттай сайхан
Алиман өргүүдийг
Тавиад явнаа.
Дараа талд нь
Ам сэхэн
Зарлиг нээгээд хэлэв л:
Хүлэг төрөөд
Миний* талын Харбодон*гийн
Тас хар
Хээр морин шиг
Төрдөг болох л яанаа
Хүмүүн төрөж
Талын Харбодон

Миний хүргэн шиг л
Төрдөг болох нь яанаа
Миний Алтансолонго дагина
Талын Харбодон
Та хоёрын
Далай цагаан өргөөг
Дотортой гадартай нь
Бүрэн гүйцэд
Тааруулж дэглэж дүүрлээв [=бэлтгэв]
Одоо сарын сайхныг
Сахиж хүлээгээд
Өдрийн сайныг
Өнжсөн хоног хүлээгээд
Өлзийтэй сайн өдөр чинь
Алтайн их далан
Далан долоон уулаа
Тэмцээд нүүгээд
Явах цаг чинь
Ойртож явнаа.
Халиахаар хар
Нүдний минь
Цөцгий бологсон
Хайртай ганц хүүхэн [=охиноо]
Хайрлалгүй чамд
Өгч л байнаав.
Хажсир дайсанд
Нөхөд дэм хийж
Арслан хар уулдаан хүрч л
Ан авын тарганаас нь
Үнэгний улаанаас нь
Булганы хараас нь
Бариулж байгаараа! чи
Энэ баруун өмнө л
Наран эргээд

Гардаг зүгт байдаг
Гурван гал бургасанд
Хан гарьдын
Гурван хар
Зулзаган *байгаа.*
Тэр гурван зулзаганы
Отгон хар зулзагыг
Надад авч
Ирэх л өгчихөөд
Алтансолонго *дагинаа залаад*
Алтайн арван гурван
Өргөн нутаг усандаа
Аав ээжсдээн эргээд нүүгээд
Харих л цаг чинь
Тэр боллоо гэв л.
Талын Харбодон
Яаралгүй босоод явнаа.
Ядалгүй алхаад эргээд
Гараад явнаа.
Тас хар хээр морины
Хажуу талд нь ирж
Эргэлдээд явнаа.
Тавин алд
Тахийн хүзүүн цулбуураа
Тай гув татаад
Тайлаад явнаа.
Тав зургаа хугасалж
Давуур дороо
Дүрээд явнаа.
Харгайн буурал
Хэрмэн хэвтээ
Хаян торолж мордоод
Хадаан цагаан
Ялам [=алаг даага] хэвтээ

Хий торолж мордоод
Зөв амы нь татаж
Зөөлөн амы нь эргүүлээд
Баруун өмнө л
Наран эргээд
Гардаг зүгийг
Тэмцүүлээд гараад явнаа.
Алтай өргөн уудам
Нутгийг шувталаад
Амхаан цагаан
Хөтлийг даваад явнаа.
Арвин шар говийг
Гатлаад явнаа
Хоо цагаан хөтлийг
Даваад явнаа
Хотгор шар хөдөөг
Гатлаад явнаа
Хол уужим
Газрыг авч
Гүйлгээд явнаа
Нахиу цагаан хөтлийг
Даваад явнаа
Нарийн шар
Говийн өрийг
Гатлаад явахад
Урд үзэгдээгүй нэг
Өндөр болон сайхан
Заан цагаан хөтөл
Өмнө нь шинэхэн
Үзэгдээд ирэв л
Тэр өндөр
Болон сайхан
Заан цагаан хөтөл өөд
Өгсүүлээд явнаа

Түүний мангадарын
Өглөөний шар гэрлээр
Тэр өндөр болон
Сайхан заан цагаан
Хөтөл дээр
Тас хар
Хээр мориныхоо
Хавцал болсон амыг
Ангайтал нь татаад
Харгай зөөхөн
Идэрмэг соёог нь
Арзайтал нь татаад
Алаг хар нүдэнд минь
Ер юун
Үзэгдэх болов уу гээд
Өмнө талдаан
Өнгийж ажиглаад
Гараад ирэхлээр
Түүний цаахан талд
Гурван гал бургасан
Үзэгдээд байвал
Гурван гал бургасны
Адгийн гал бургасан өөд
Аргаль гулзаан[88]
Чинээн биетэй
Хортон шулмас болох
Шар цоохор могой
Авираад гарч
Явахыг алдалгүй үзэв л.
Хан гарьдын
Гурван хар зулзаган
Үүр дээрээсээ ургэж
Өөдөө босон дэвэж л

88. Угалз

Эргэж бүүгаад байх ыг бас
Алдалгүй үзэв л
Талын Харбодон
Хангай хар нумаан
Мөлт татаад авав л
Аянгын хий
Тавин түргэн
Цагаан сумнааныхаа
Нэг гоо шулуун
Мөсгөө сайныг
Шилж шүүж
Байгаад сугалж авав л
Хөтлийн дүнтэй онийг
Ханцуйтай хүний
Гуурын [=бугуйн] чинээн
Хар мяндасан хөвчид нь
Үмхүүлээд явнаа
Сөөм цагаан эрхийгээ
Чичиртэл нь татаад явнаа
Хоёр далны мөгөөрсөө
Ховхойж л нийлтэл нь
Татаад явнаа
Хонин цагаан эрхийгээс нь
Хорон шар шүүсэн
Хоёр гурав дуслал нь
Татаад явнаа
Хангай хар нум нь
Туйлын сүүдэр хэвтээ [=шиг]
Матилдаад явнаа.
Туулайн чихэн хэвтээ
Тэвкэлцээд явнаа.
Хангай цагаан сум нь
Хамаа хамаа[89]

---

[88] [illegible]?
[89] [illegible]?

Алив алив[90] гээд
Аливхийж жилэвхийсэн
Болоод явнаа.
Талын Харбодон
Хангай цагаан сумыг
Бүргэд улаан
Хоншоор талдаан
Татаж шившээд хэлэв:
Миний үүрээд явдаг
Араан час
Хар модон шиг саадаг
Гэгээн аянганы
Хий тавин түргэн
Цагаан сумны нэг л
Гоо мөсгөө сайн нь
Энэ мөн болохоор
Тэр гурван гал бургасны
Адгийн гал бургасан
Өөдөө гарч яваа
Гулзаан чинээ биетэй
Хортой шар цоохор
Шулам могойг
Хоёр анги
Тас харваад од гэж шившээд
Хонин цагаан
Эрхийгээ мөлтлөөд хэлэв л.
Хангай хар нумны
Хануутай хүний
Гуурын дүнтэй
Хар мяндсан хөвч л
Элхээн цохиод
Дингинаад явнаа
Хангай цагаан сум нь
Хамаа хамаа

Алив алив гэсэн болоод
Аливкэш жилэвкэд
Альхан жингэс /?/
Босоод гарав л
Адгийн гал бургасан
Өөдөөн авираад
Гарч явсан
Ховдоон чинээн биетэй
Хортон шар цоохор шулмас могойг
Хоёр анги л
Тас харваад одов
Хортон шар цоохор могойг
Хоёр анги л болохлоор
Орон дундаас нь
Нэг гүзээн
Хар цусан
Талын Харбодон
Хаанав гээд
Ирж л явахыг
Алдалгүй үзэв.
Талын Харбодон
Хортон шар цоохор
Шулмас могойны
Хорон хар цуснаас сэжиглэж
Ойлиод зугатаагаад гарав л
Нэг гүзээн
Хар цусан
Талын Харбодонг
Хөөгөөд явахдаа
Багадаж багадаад явсаар
Шалзын чинээн өчүүхэн
Жижиг болж л
Талын Харбодонгийн
Дал л дунд тусаад

Тас хар
*Хээр морин*ы
Сайр л дээр бас
Дусаад одоход
Талын Харбодон
Тас хар
Хээр морин хоёр
Хортон шар цоохор
*Шулмас могой*н
Хорон хар цусанд
Хордоод үхээд
Арвин тариаландаа гарав л.
Хан гарьдын гурван
Хар зулзаган нисэн ирээд
Хортон шар цоохор
*Шулмас могой*г л
Хаж л харваад
Хорт хар цусанд
Хордоод үхсэн
Талын Харбодонгийн
Араас нь ирээд
Ачтайд аминд орсон
Амьтан билээ та
Тустайд тустай болсон
Аминд орсон
Амьтан билээ л гээд
Наранд нь сүүдэр
Болж зогсоод
Салхинд нь нөмөр
Болж зогсоод
Өдий төдий
Цаг үе
Өнгөрөөд ирэхэд
Өвгөн хан гарьд

Эргээд нисээд
Ирдэг нь энэ билээ
Гурван хар зулзаган
Хэлдэг нь энэ билээ:
Ховдоон чинээн биетэй
Хортон шар цоохор
Шулман могой
Гурван хар зулзаган
Бид гурвыг
Идэх гээд
Адгийн гал бургасан
Өөл авираад
Ирэж л явтал
Энэ уулын дунтэй
Тас хар
Хээр морьтой
Хар улаан залуу
Хортон шар цоохор
Шулмас могойг
Хоёр анги
Тас харваад хаяхлаар
Хорон дундаас нь
Нэг л гүзээн
Хорон хар цусан
Хөөж л яваад
Шалзын чинээн
Болж л явахдаа
Тас хар
Хээр морьтой
Хар улаан залуугийн
Дал дээр дусав
Хар хээр
Морины сайр дээр
Тусаад одоход энэ хоёр

Үхээд арвин
Тариаланд гарахаар
Ачтайд ачтай
Тустайд тустай болсон
Хар хээр морьтой
Хар улаан залуугийн
Хүүр сахиж
Халуун наранд нь
Сүүдэр болоод
Хүйтэн хар салхинд нь
Хөлдөөд одож
Магадгүй гээд
Нөмөр болоод
Байж л байнаа гэв л
Өвгөн хан гарьд хэлэв л
Дээд хан хурмастын
Өвгөн Арш-дээд лам
Гунан настай банди байхдаа
Гунжин хан гарьдын
Үүр байх газрыг зааж
Энэ дунд замбуу тивийн
Гурван гал бургасанд
Үүрээ барихлаар
Жар зулзагалаад
Жаран нэгдэх дээрээ чи,
Муугаан үзнээ ч
Хөрөнгөө барнаа ч гэж
Тэр үед гунан
Настай байсан
Дээд хан хурмастын
Арш дээд лам та
Аврал буулгасан билээ л
Одоо жаран нэг зулзгалаад
Жаран нэгдэх

Зулзагаан үзэж
Байгаа минь энэ л
Тэр дээд л
Хан хурмастын
Өвгөн арш-дээд
Ламд хүрч
Энэ хар
Хээр морьтой
Хар улаан залууг
Хар хээр морьтой нь
Эдгээгээд амьдруулаад босгодог
Ид шидтэй эм тан
Рашаан зангиа
Авч л ирнээв би!
Гурван зулзаган минь
Сахиж байгтун гээд
Өвгөн хан гарьд
Өөдөөн нисээд гарав
Дээд хан хурмастын
Өвгөн арш дээд
Ламд хүрч очоод
Аврал гуйж
Өвгөн арш дээд ламд
Хэлдэг нь энэ билээ:
Гурван хар зулзаганы минь
Амий нь аварсан
Хар хээр морьтой
Хар улаан залуу
Ховдоон чинээн биетэй
Хортон шар цоохор
Шулам могойд хорлогдов гэлээ.
Өвгөн арш дээд лам:
Та яагаад эс л

91 Та яагаад эс цохив? Яагаад эс хороов?

Цохижсиквуут[91] гэв л
Ховдог шар
Хоо шар туулай
Хонодог газар
Хаа нэг л хортон шулам
Үзэгддэг юм надад.
Хангайн чинээ
Бие минь
Багтдаггүй өөгөөд[92] *явнаа.*
Хадтай модтой газар
Хаа нэг л хортон шулам
Үзэгддэг юм надад
Агуу их хүчинд минь
Хамхраад одож
Магадгүй гээд өршөөж
Өнгөрүүлж явлаа би.
Жаран нэгдэх зулзагаа
Үзэж байгаа минь энэ гэж
Өвгөн хан гарьд хэлэв
Арш дээд лам
Аюуш цагаан
Хадаг өгөөд
Алтан бумбатай
Аршаанаар аршаалаад
Хан гарьдын
Аман талд нь
Хийж өгөөд нисгэв
Өвгөн хан гарьд
Дунд замбуу тивд
Орж ирээд
Амандаа хийгээд ирсэн
Аршаанаар арилаалуулахаар
Талын Харбодон

92. юм шиг болоод

Тасхархээр
Морь хоёрт өгөв
Илбийн аюуш
Цагаан хадгаар
Тасхархээр морьтой
Талын хар бодонг
Адислаад одохлоор
Тасхар
Хээр морин
Талын хар
Бодон хоёулаа
Урдахаас өнгөтэй
Хэзээнээ хэвдээ [=яг хэвээрээ]
Амьдраад босоод
Ирдэг нь энэ билээ
Өвгөн хан гарьд
Гурван хар зүлзаган
Талын хар бодон
Тавуулаа сайн явснаа
Хэлцэж инээлдээд
Салангид явснаа
Хэлцэж уйлалдаад
Өдий төдий
Цагийн үе
Өнгөрөөд ирэхээр
Хархээр морьтой
Талын Харбодон
Хан гарьдын
*Гурван хар зүлзага*ны
*Отгон хар зүлзаг*ыг аваад
Аранзаа хааны
Алтай өргөн нутгийг тэнцүүлээд
Амхаан цагаан хөтөл
Даваад явнаа

Арвин шар
Хөдөөн өрийг
Гатлаад явнаа
Хол уужим газрыг
Авч гүйлгээд явахдаа
Алтай өргөн нутгийн
Өмнө л талын
Амхаан цагаан
Хөтөл дээр гарахдаа
*Отгон хар зулзага*ны
Өд шиврийг
Илж эрхлүүлээд
Ээм дал дээрээн
Таалж суулгаад
Аранзаа хааны
Алтай өргөн нутгийг
Шувтлаад[93] явнаа
Аранзаа хааны
Далай цагаан өргөөний
Үүдэн талд л ирээд
*Тас хар хээр морин*оосоо
Холби тусан буугаад
Отгон хар зулзагыг
Аранзаа хааны
Үүдэн дээр
Архлаад уячихаад
Тас хар
Хээр морин дээрээ
Хаян торолж мордоод
Алтан луу шил
Байшингүүр чиглээд явнаа
Алтан луу шил л
Байшингийн үүдэн талд

93. Өнгөрөөд, гатлаад

Холби тусан буугаад
Хээр морин
Хад мэт
Хантраад явнаа
Тулга мэт
Тушаад хаяад явнаа
Ар талд нь
Алтан луу шил байшингийн
Хүрэн зандан
Хаалгыг татаад
Алхаад эргээд
Ороод ирэв л
Алтансолонго дагина
Талын Харбодон
Шаралдаймэргэн баатар
Тавин хүүхэн дахуултайгаа
Тавин гурвуулаа
Аагтай улаан
Цайгаа уугаад
Амттай сайхан
Алим өргөнөөс идээд
Дараа талд нь
Шагай шатар
Даамаар нь наадаад
Жаргал цэнгэлийн ард ороод
Арван таван хоног
Болж л явахад
Нэг л өглөө
Ховч шандан
Шар хүүхэн
Агъ л цагил татаад уурсан
Ороод ирээд хэлсэн нь:
Хаан сайхан аавын
Далай цагаан өргөөгөөр л

Отгон хар зулзаган
Хүн л цухалзуулалгүй байнаа
Гадаанаас л хүн
Оруулалгүй байнаа
Гэртээс л хүн
Гаргалгүй байнаа
Отгон хар зулзагыг
Өдөр шулуун таныг
Тавьж явуулагтун
Гэнээ гэв л
Талын Хар бодон
Алхаад эргээд
Гараад явнаа.
Тас хар
Хээр морин дээрээн
Хаян торолж
Мордоод явнаа
Аранзаа хааны
Үүдэн талд байсан
Отгон хар зулзагыг
Таван өнгө хивээр
Цэцэглэж галаад
Аранзаа хааны
Албат нутгийг
Гурав хувилаад [=хуваагаад]
Нэг хувийг *отгон хар зулзага*нд
Хэрээ шувуун
Хэлмэрчтэй явъя
Хэзээ мөнхөд
Мэндтэй явъя
Элээ шувуун
Элчтэй явъя
Эгүүрд л мэндтэй явъя гээд
Отгон хар зулзагыг

Орон байрт нь
Тавин явуулаад
Дараа талд нь
Алтан луу шил л
Байшиндаа ирээд
Арван таван хоног
Болж явахад
Аранзаа хаан
Талын Харбодон
Шаралдаймэргэн баатар
Хоёрыг дуудуулж
Цай өгч
Цайлуулаад явнаа
Дараа талд нь хэлэв:
Сарын сайныг
Саатан хүлээсээр байтал
Сайн сар л
Өнгөрөх гэж л байнаа
Өдрийн сайныг
Өнжин хүлээгээд байтал
Өлзийтэй сайн өдөр
Өглөө болоод
Өнгөрөх гэж байнаа
Одоо өглөө босоод
Алтансолонго дагина
Талын Харбодон
Та хоёр ачаалаад
Алтайн далан долоон хар
Уул нутагтаа
Нүүгээд явах
Цаг тань боллоо
Адуу мал
Алт мөнгө
Ямаарыг авна ч

Албат нутаг
Ямаарыг авнаач [=авна чи] гэхэд
Талын Харбодон хэлэв:
Адуу мал
Албат нутгийг
Тасалж аваагүй болович
Тасалж авсантай
Адил болтугай
Алт мөнгийг
Ачиж аваагүй болович
Ачаалаад, ачаалаад
Аваад явсантай
Адил болтугай
Зах хол нутагтай билээв
Заг хэврэг
Түлээтэй билээв
Өвгөн болсон
Аавтай билээв
Эмгэн болсон
Ээжтэй билээв
Ууджим хол газар
Унаа хөлөг минь
Сулдаад явж магадгүй
Унаж сольж явахад
Унаартай [=унахад] *бат бүдүүн*
Хар хээр
Азаргы тань авнаав би.
Алс хол газарт
Ачлага минь
Дандаад явж л магадгүй
Ачаа бараа хөнгөлж
Явахад арьтай [=аривтай]
Бат бүдүүн
Асар хар бууры тань авнаав[=авна би]

Цөл говь нутагт
Ус ундаа тасраад
Явж магадгүй
Ус унд л зөөж
Тээвэрлэж явнаав.
Уужим их л арьстай
Чигээний тань[=цэгээний тэнь]
Хуучин хашин хар
Архады тань авнаав гэв
Аранзаа хаан хэлэв л:
Чамаас л харамлах
Юмгүй л билээ л
Халиахаар [=харахад]
Хар нүдний
Цөцгий болсон
Хатгахаар
Халуун бүлээн
Хар цус минь бологсон
Хайртай ганц л
Хүүхээн чамд л
Өгсөнөөс л цаараан [=цааш]
Хар хээр азарга
Хар манхан буур
Хашин хар архад
Гурвыг авахлаар /авбал/
Ав л гэв л
Талын Харбодон
Шаралдаймэргэн хоёр
Алхаад эргээд гарахдаа
Баруун талын
Бараан дээр
Эвхэйтэй байсан
Хашин хар архдыг

[94] Сүүлээ сугандаа хавчуулаад

Шаралдай мэргэн баатар
Сүүвдээд[94] гараад явнаа
Адуучныг нь
Адуунд мордуулж
Хураалгаад явнаа
Уналгын сайн
Унаа хий хүлэг
Морьдыг барьж
Уяад явнаа
Хар хээр азаргыг барьж л
Чөдөр ногт уяад
Шилээс нь уяж сойгоод
Шилбээс нь тавгалж
Батлаад авав
Тэмээчнийг мордуулаад
Тэмээг нь хураалгаад
Ачилгын сайн
Атан сайхан тэмээнд
Буйл товх хийгээд
Бурантаг зүүж
Уяад явнаа.
Хажир хар
*Манхан буур*т
Буйл товх шургуулаад
Бурантаг зүүгээд
Бөхнөөс нь уяж
Сойгоод явнаа
Борви шилбээр нь
Таваглаж батлаад авав.
Ачаа бараа дэслээд
Түүний мангадарын
Өрүүн шар гэрлээр
Зуун манхан тэмээний
Борвиноос нь өөдөө

Бөхнөөс нь уруугаа
Ачиж чөрхөлөөд
Эвэртэй жороо
Хөх бор морийг
Алтансолонго дагина унаад
Зүүн хар
*Манхан тэмээ*ний
Бурантгийг сунгаад
Зогдорыг хөдөлгөөд
Хойт наран эргээд
Ордог зүгийг [=баруун]
Тэмцүүлээд гараад явнаа.
Тавин хүүхэн
Дахуулан дахуулаад явнаа
Зуун манхан тэмээний
Араас нь хажир
*Хар манхан бүүр*ыг
Дахуулж чөрхөлөөд явнаа.
Талын Харбодон
Хар хээр азаргыг
Хөтлөөд ирж
Аранзаа хааны
Далай цагаан өргөөний
Үүдэн талд нь
Холби тусан буугаад
Хар хээр морин
Хар хээр азарга хоёрыг
Уяхан зандан
Модон уянд
Уян сүүдэрлүүлж
Сойгоод явнаа.
Алхаад эргээд
Ороод ирэв л
Босго тотгын

Ар л талд
Боол тулгын
Өмнө л талд
Тойг өвдөг
Газардуулаад ёслов!
Өнчин сүвээ
Мэхэлзүүлээд ёслов:
Хаан сайхан аав
Хатан сайхан ээж
Хоёр минь та
Санаагаар амар
Заяагаар их л
Суугийт.
Удалгүй яваад
Төдөлгүй Алтайн
Далан долоон
Хар уулдаан
Нүүгээд хүрнээ.
Холын амьтан
Сонсож гэхэд
Ойрын амьтан үзэж гэхэд
Тавин дөрөө
Дамжиж морддог
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон *гэж*
Миний авай их
Алдар нэрийг сонсож
Ай чимээг минь
Мэдсэн амьтан бүхэн
Танай арслан
Хар уулууд уруу
Халшахгүй [=довтлохгүй] *билээ.*
Арван муж

Албатууд уруу
Өнгөлзөх ч үгүй билээ.
Хэрээ шувуун
Хэлмэрчтэй явнаав.
Хээээ мөнхөд
Мэндтэй явнаав.
Элээ шувуун
Элчтэй явнаав.
Эгүүрт л мэндтэй явнаав.
Чадахаар болбол
Жилийн гурав ирэж
Мэндий тань
Мэдээж байнаав
Ядахаар болбол
Жилийн нэг
Мэндий тань
Мэдээж явнаав гээд
Би мэнд л
Та мэнд л гээд
Хариу алхаад
Эргээд гараад явнаа
Хар хээр
Морин дээрээ
Хаян торолж мордоод
Хар хээр
*Азарга*ан хөтөлөөд
Ачааны араас
Хөөж л гүйцээд ирэв л
Шаралдаймэргэн баатар
Алтансолонго дагина
Талын Харбодон гурвуулаа
Хүр хүр
Хүүндэж инээлдээд
Хүрзээн чинээ

Шүд нь яралзаад явнаа.
Алтай өргөн
Нутгийг шувтлаад
Амхаан цагаан
Хөтөл даваад
Арвин шар
Говийн өрийг
Гаталаад нүүнээ
Хөө цагаан
Хөтөл даваад
Хол ууҗим
Газрыг авч
Гүйлгээд нүүхдээ
Будтай өдөр
Бууҗаад явнаа
Бургастай газар
Суудэрлэж удлэн
Нүүгээд явнаа
Харзтай газарт
Өнжиж нүүгээд
Харгайтай газарт
Суудэрлэж нүүгээд явнаа.
Өвстэйд нь үдлэн
Өнжиж нүүгээд
Устайд нь *удлэн*
Бууж нүүгээд явнаа
Олон ерэн
Есөн жилийн
Газрыг авч
Нүүгээд явахдаа
Нэг л өндөр сайхан
Заан цагаан
Хөтөл дээр
Гараад ирэхэд

Луузан Тив
Хаан сайхан аавын нь
Нураг хүрэн зандан
Улаан уул
Ээм цээгээ
Өнгөлзөөд явнаа
Шуу цаагаан
Шунхалзаад байна л
Суу дундуураас
Уруугаан [=доошоо]
Утаан гэдэг юман
Униар татан
Үүл болон цэнхэртээд байв л
Хүрзээн чинээн шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай
Талын Харбодонгийн
Ар л талд яваад
Бас л хатан залаад
Шинэ гэрийн найр
Шинэ бэрийн мөргүүлэг
Болж л байв.
Талын Харбодон
Түүн дээр ирээд
Хүрэл-Арслан Магнайн
Далай цагаан өргөөний
Дараах талд
Данхан хөх л
Ширгийн өр дунд
Хангайн цагаан сумаан татаж
Харваад одоход
Хатгагдаад очсон газарт
Зуун манхан тэмээн ачаагаа

Зэрэгцүүлж хэвтүүлээд явнаа.
Ачаа бараа тайлаад
Ачилгын атан
Сайхан тэмээг
Солбиулж л сойгоод
Далай цагаан өргөөг
Далбайтал нь байгуулж
Бариад явнаа.
Шинэ гэрийн найр
Шинэ бэрийн мөргүүлэг хийгээд
Ахар богино
Арван таван хоногийн
Найр хийгээд байхад
Шаралдаймэргэн баатар
Хэлдэг нь энэ билээ:
Зах л хол нутагтай
Заг хэврэг
Түлээтэй билээв
Эмгэн болсон ээжтэй
Өвгөн болсон аавтай билээв.
Одоо миний
Харих цаг
Боллоо гэв л
Талын Харбодон
- Шаралдаймэргэн баатар
Дүү минь
Чамайг тэгэж
Хэлнэ гэж бодоод
Үүнээс л түргэн
Явах гэхээр энээ
Чилэн шар
Цоохор морьтой
Чин-Алтан бүс
Төвлөөтэй бор

Цоохор морьтой
Төмөрзүрхэн баатар
Хүрэн цоохор морьтой
Хүрэл-Арслан Магнай
Гурван ахтай чинь чамайг
Танилцуулаад явуулс гээд
Бодож л байлаав [= байлаа би]
Одоо чиний
Хэлдэг зөв л гээд
Би мэнд л
Чи мэнд л гээд
Ах дүү
Таван сайхан баатар
Аав хүү зургуулаа
Хүүндэж жаргалаад
Шагай шархал морьтой
Шаралдаймэргэн баатар аа
Унаган нутагт нь
Явуулаад орхив л
Ар талд л
Луузан Тив хаан
Нураг хүрэн зандан
Улаан уулынхаа
Орой дээр
Хавтгай өргөн
Хошуу нутгаа
Дахуулаад гарав
Талын Харбодон
Чин-Алтан бүс
Төмөрзүрхэн баатар
Хүрэларслан Магнай тавуулаа
Есөн үетэй
Ендэр бариад явнаа
Таван зүсэм

Малынхаа ясыг түлж
Таван тамсаг
Идээнийхээ дээжийг өргөж
Таван зүсэн малыг
Сэтэрлэж онголоод
Нураг хүрэн зандан
Улаан уулдаан
Тавьж туугаад
Дээшээ мөргөж
Дэлхийг тахиж явнаа
Өө их дуугаан
Гаргаж хайхираад
Нураг хүрэн зандан
Улаан уульнхаа
Орой дээр гарч
Сангаа тавиад
Сарвайж мөргөөд
Санаж залбираад:
Энэ дунд
Замба тивийн
Хорон шүү ихдэж
Хортон дайсан
Олдож байхад
Талын Харбодон*той*
Хамтарч нөхөрлөөд
Нийлж нүүгээд
Нэг л газар
Нутагласав л гэж байнаав.
Адуу мал
Албат нутаг ихдээд
Нураг хүрэн зандан
Улаан уул
Нутаг минь багадаад
Нүүж байгаа хэрэг биш

Нүгээд гарч байгаа
Нураг хүрэн зандан
Улаан уулын минь
Савдаг шивдэг
Ардаас л аварч
Өршөөж байтан [=байгтун]
Нүгээд очих л
Гэж байгаа [=нутаг минь]
Талын Харбодон*гийн*
Далан долоон
Хар уулын минь
Савдаг шивдэг *өмнөөс л*
Өршөөж л хайрлатан!
Өвлөж автан гээд [=авагтун гээд]
Өө их дуугаан
Гаргаж хайхираад
Дээрээн мөргөж
Дэлхийгээн тахиад
Хариу эргэж
Ороод явнаа
Ачаа бараагаа дэглэж
Адал малаан цуглуулаад
Ачилгын сайн
Атан тэмээг барьж
Сөөгөөд явнаа
Түүний мангадар [=маргааш]
Болж явахад
Дэлэм дээс
Дэлтэрийн эсгий
Хаяулалгүй ачуулаад
Согсоотой [=санмаатай] даага
Сахалтай ишиг
Хаяулалгүй туулгаад явнаа.
Хойт наран эргээд

Ордог зүг рүү тэмцүүлээд
Луузан Тив хааны
Шуугиантай олон
Муж албат иргэн
Нүүгээд гарахад
Арван хар гол болон
Аргамжилаад явнаа.
Таван хар гол болон
Тасарч нүүгээд явнаа.
Амхаан цагаан хөтөл
Даваад явнаа.
Арвин шар
Говийн өрийг
Гатлаад нүүгээд явнаа
Хоо цагаан
Хөтөл даваад
Хоттор шар
Говийг гаталж
Нүүгээд явахад
Өвсний сэрүүн [=сэрвүүн сайн]
Усны тунгалагыг
Дагуулж нүүлгээд явнаа.
Будантай өдөр
Бууగаад үдэлж
Бургастай газар
Сүүдэрлэж нүүгээд явнаа.
Харгайтайд нь үдэлж
Сүүдэрлэж нүүгээд
Харзтайд эь үдэлж
Бууగаад явнаа.
Өвстэй газар
Өнжөөд хоноод
Устай газарт
Бууగаад явнаа

Олон жилийн он
Олон сарын өдөр
Өнгөртөл нь нүүгээд
Олон жилийн адаг
Болоод ирэхэд
Алтайн далан
Долоон хар
Уулын өмнө талын
Нэг өндөр болон сайхан
Заан цагаан хөтөл дээр
Нүүгээд гараад ирэхэд
Далан долоон
Хар уул, нутаг нь
Ээм цээгээн
Өнгөлзөөд байв л
Суу цаагаа
Шунхалзаад байв л
Суунаг татан дүнхийгээд
Байр нь харлаад
Баас нь эврээд
Ус нь тунаад
Өвс нь сэргээд
Одсон байхы нь
Алдалгүй үзэв
Талын Харбодонгийн
Ар шил нь ангалзаад
Арван хоёр хуниа нь
Буугдаад явнаа:
Мянган хонины захаас
Ганц л хурга
Аваад зугатаадаг
Гурай хөх чоно хэвтээ
Талын Харбодон *би*
Аранзаа хааны

Алтансолонго ***дагиныг***
Авах гээд явахлаар
Араар минь ирж
Алтай өргөн, баян
Нутгийн минь тоноож
Олзлоод явдаг
Ямар арчаа муутай
Эргүү тэнэг
Элмэр байдаг
Болов уу гээд
Далай цагаан
Өргөө байсан
Данхан хөх ширгүүр [=ширэг үрүү]
Ороод ирэхлээр
Довон Харбөх
Аавы нь
Далай цагаан өргөөний
Ор гурван хүрэл
Чулуун тулга л
Тулаатайхан байв л
Дайнд орж
Дайсанд олзлогдсон амьтан
Тулсан тулгаан
Тулаатай хаядаггүй
Юман гэлээ л
Энэ тулсан тулгыг
Тулаатай нь хаюулаад
Албат ард
Иргэдий минь
Олзлоод явсан
Айлтай хажир дайсан
Ирээд явж л гээд
Холби тусан буугаад
Боол тулгаан

Холби татан хаяхаар
Болсон иргэн ууц
Болгоод дүрээд
Хаясан байв л
Хатан тулгыг
Ховхолоод хаяхаар
Хавчиг хар ташуурт
Хатуу амттай
Хар архи
Хийгээд дүрээд
Хаясан байв л
Ноён тулгыг
Ховхлоод хаяхаар
Номтой шар бичиг
Дэрэвкээд гараад ирэв
А. К.-аар нь
Ахлуулаад явнаа
Дараа дараагаар нь
Адаглуулаад үсэгчилэн
Аван уншин уншин
Дуудаар үзэхлээр
Адаг дээр нь
Хойт наран эргээд ордог
Зүгт байдаг
Тавтай хол
Таван ерэн
Есөн эсийн газрын
Цаахан талд байдаг
Дөрвөлжин хар
Уул нутагтай
Долоон олон муж
Албаттай байдаг
Дөрвөлжин шар
Хээр морьтой

Дөнөн шаргарьд гэж
Амтай хүн
Ан ангаахаар л
Ам нь ардаан
Гардаг түүхтэй
Хэлтэй хүмэн хэлэхээр
Хэцүү болон
Хэдэр аюултай
Хатуу болон
Хажсир дайсан ирээд
Хаан төрийг
Хамхалаад дагуулав
Хамаг түмнийг
Нүүлгээд дагуулав
Эзэн төрийг
Эвдээд дагуулав
Энх сайхан төр
Нутгий минь
Олзлоод явлаа
Талын Харбодон хүү минь ээ
Амьд мэнд яваад
Эргээд нэг
Ирдэг болохлоор
Албат иргэн
Аав ээж гэж
Бидний араас
Тун явж л болохгүй
Дөрвөлжин шар
Хээр морьтой
Дөнөн шаргарьд гэдэг
Амтай хүмэн
Ам л ангайхаар
Ам нь ардаан
Гардаг түүхтэй

Хэлтэй хүмэн
Хэлэхлээр хэдэр
Хэцүү болон
Хэдэр хүчир
Хатуу болон
Хаэкир дайсан гэж
Дахин дахин бичээд
Ахин ахин захиад хаясан байв.
Талын Харбодон хэлэв л:
Чилэн шар
Цоохор морьтой
Чин-Алтан бүс
Төвлөөтэй бор
Халзан морьтой
Төмөрзүрхэн баатар
Хүрзээн чишээн шүдтэй
Хүрэл цоохор морьтой
Хүрэл-Арслан Магнай *ах дүү*
Луузан Тив *хаан аав*
Дөрөв минь ээ!
Тас хар
Хээр морин минь
Тав их махтай
Таван их
Хурдтай байнаа
Талын Харбодон *би*
Тавтай [=идэрмэг] *эрийн*
Дунд настай
Эгц цагаан шүдтэй
Тавтай таван
Их едтэй байнаав.
Энэ дөрвөлжин
Шар цоохор морьтой
Дөнөн шаргарьдын

Араас хүцэж одоод
Ядахлаар [=чадвал] *дөрвөлжин*
Хар уулд нь хүрээд
Дөнөн шар гарьдын
Айга хар
Цусы нь асгаад
Араг цагаан
Ясы нь цайлгаад
Дөрвөлжин хар уулд нь
Дөрвөн их эхтэй
Түймэр тавиад
Дөлөөн олон
Муэж албаты нь олзлоод
Долоон муэж
Албаттайгаан хамт
Чөлөөлөө ирнэ би.
Аав, ах дүү та дөрөв минь
Би эргээд
Ирэх цагт
Жаран жилийн
Жаргал хийж
Наян жилийн
Найр хийдэг юман
Найр наадмын
Юмыг дэгэлээд
Шинэ малын
Бэлчээрийг тааруулаад
Шинэ нутгийн
Буйрийг тавиулаад
Байж л бай гэв л.
Талын Харбодон
Тас хар
Хээр морин дээрээ
Хаян торолж мордоод

Хойт наран эргээд
Гардаг зүгийг тэмцүүлээд
Амхаан цагаан
Хөтөл даваад
Арвин шар
Говийн өрийг
Гатлаад явнаа.
Хоо цагаан
Хөтөл даваад
Хотгор шар
Хөдөөн өрийг
Гатлаад явнаа.
Нарыг барин
Архалаад явнаа
Сарыг барин
Саатаагаад явнаа.
Салхи өрөн [сөрөн}
Дөлүүлээд явнаа.
Сайхан дөлөөн
Хол газрыг
Авч гүйлгээд явнаа.
Чилгэр сөө гэж [=сартай шөнө гэж]
Чилэлтгүй гүйлгээд
Чилэн шар
Наран гэж
Сааталгүй, гүйлгээд
Харанхуй сөө гэж
Хариултгүй гүйлгээд
Халуун шар наран гэж
Гажилтгүй гүйлгээд
Харь хол газарт
Хажир дөнөн
Шаргарьдаас
Ганцаараа билээв би гэж

Харих санаа үгүй
Халтирах зүрх үгүй
Улам имэрч [=хүчлэн] гүйлгээд
Таван ерэн, есөн
Жилийн газрыг
Таван жилээр
Болзож *гүйлгээд,*
Гүйлгээд явнаа
Арван таван хоногийн
Асганаа улаан нараар
Болзож булаалдаж
Гүйлгээд явнаа.
Нэг л өндөр болон
Сайхан заах
Цагаан хөтөл дээр
Аван идэн
Алдуулаад гараад ирэв л
Дөнөн Шаргарьдын
Дөрвөлжин хар уул
Ээм цаагаа өнгөлзөөд
Шуу цаагаа шунхалзаад
Суунаг татан дүнхийгээд
Суу дундуураас нь
Уруугаан [=доошоо]
Утаан гэдэг юман
Униар татан
Үүлэн болж цэнхэртээд
Хар бараан мал нь
Харалж хүрийгээд
Хавтгай өргөн
Хушууны нь албатууд
Олон цагаан гэрмүүд
Одон мичин хэвтээ жирийгээд
Агтны туруун

Харилдаад [=харгилдаад]
Алдаан залуучууд
Шуугилдаад байв
Азаргын дуу нь
Бөлбөөлөөд [=хослоод]
Албатын дуу нь
Шуугилдаад байв л
Дөнөн Шаргарьдын
Далай цагаан өргөө
Данхан хөх
Ширгийн өр дунд
Далбааж л дүнхийгээд
Үүдэн талд нь
Дөнөн шар
Цоохор морины
Товчлуур талд нь
Тоогүй олон
Жадын үзүүр
Хугараад эдгэрсэн
Сайр талд нь
Сайн нэг төө
Хүн хүлгийн цусан
Зузаан хуяглаж
Хатаад одсон
Дөнөн шар
Цоохор морины
Хамрын үүр
Арилаадгүй байхыг
Хавтасны хөлс нь
Хагсаадгүй[95] *байхыг*
Алдалгүй үзэв
Довон Харбөх [=аавын нь]
Далай цагаан өргөөг

95 Хлпашгүй

Адууны зэлийн
Адаг дээр
Буруу сөөрөг[96]
Харуулаад хээв нэг
Хойш яйш
Хазгай баригсан байв.
Талын Харбодон
Замба тивийг
Догдолтол нь хайхираад
Захын модыг
Найгатал нь хайхираад
Зах таван товч
Мөлтөртөл нь хахираад
Задгай их дуугаан
Гаргаад хайхираад хэлэв:
Хүмэн хүлгийн
Цус ууэж
Үндан чинь харьдаггүй
Хүмэн хүлгийн
Яс хэмэлэж
Араан чинь
Цоордог түүх үгүй
Дөрвөлжин шар
Хээр морьтой
Дөнөн Шаргарьд *гэдэг*
Эргүү тэнэг элмэр чи
Мянган хонины захаас
Ганц л хурга
Авч л зугатаадаг
Гурай хөх
Чоно хэвтээ [=шиг]
Талын Харбодон ***намайг***
Аранзаа хааны

96. Буруу зөв/сөрөг

Алтансолонго *дагиныг*
Авч л ирэхлээр явах цагт
Араар минь л
Алтай өргөн нутгийн минь
Эз л үгүй хаяад
Албат олон иргэдий минь
Олзлоод ирдэг чинь
Юун билээ
Одоо нүгэл чинь хүцэж [=гүйцэж]
Нүхэн чинь шороологдож
Байгаа бий
Өтөр шулуун
Наашаан гараад ир
Нарны эртэд
Насны багад
Талын Харбодон
Надтай ирсэн,
Харьсан хоёроо
Үзэлцээд ав гэзд
Хайхираад дуудаад хэлэв.
Хариу эргээд ороод
Эзгүй арвин
Улаан говийн
Өр дунд
Болзоотын бор
Улхан толгой дээр ирээд
Талын Харбодон
Тас хар
Хээр морион
Хад чулуу дамжуулаад
Хайр чулуу гишгүүлээд
Хад мэт сойж
Хантраад явнаа
Тулга мэт сойж

Тушиж хаяад
Арын час
Модон шингээний шиг
Саадгаа авч л хаяад
Алттайхан хөө хуягаа
Тайчиж овоолоод
Артай хүрэн
Зодгоо өмсөөд
Арвин шар
Говийн өр дунд
Үхэр хар чулуугаар
Тэвэг өшиглөөд
Наадаад явахад
Дөрвөлжин шар
Хээр морьтой
Дөнөн Шаргарьд хэлэв:
Орон замбу тивийг
Эргүүлээд явахад
Орчлонг төгөөлөөд тойроод
Олж ядаад байсан
Талын Харбодон ***чи***
Хэвтээ тэмээний аманд
Хий хамхуул шиг
Хийсээд ирнэ гэдэг
Энэ л байх" гэж хэлээд
Баш баш инээгээд
Яаралгүй босоод
Ядалгүй хувцаслаад
Арын час
Хар модон шингээн
Саадгаан өмсөөд
Алхаад эргээд
Гараад явахадаа
Дөрвөлжин шар

*Хээр морин*ыхоо
Тавин алд л
Тахийн хүзүүн цулбуурыг
Тайлж аваад
Хаян торолж мордоод
Өмнө л амаан
Цагаан хөтөл дээр л
Гараад ирэхэд
Талын Харбодон
Бас *хар*
*Хээр мори*он уяад
Газар өөд
Үхэр хар чулуугаар
Тэнгэр өөдөөн
Тэвэг өшиглөөд
Наадаад очихыг
Дөнөн Шаргарьд
Алдалгүй үзээд
Адаг араан зуугдаад
Арван зандан
Хурга нь [=хуруу нь]
Атгагдсан болоод байнаа.
Дөрвөлжин шар
Хээр морьтойгоон
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн
Алдуулаад ороод явнаа
Арвин шар говийн
Өр л дунд
Болзоотой [=болзоотын/
Бор толгой
Дээр ирээд
Тас хар

*Хээр морин*ы
Хажуу талд хүрч
Холби тусан буугаад
Дөрвөлжин шар
*Хээр мори*он
Хад чулуу дамжуулаад
Хайр чулуу гишгүүлээд
Хад мэт сойж
Хантараад уяв
Тулга мэт сойж
Тушаад уяв.
Алттай хөө хуягаа
Тайчиж овоолоод
Арын час хар
Модон шингээн
Саадгаан авч л
Хаяад явнаа
Артаа хүрэн зодгоон
Авч л өмсөөд
Нарийн цагаан
Төлгөөн [=тэлээгээ/
Давсгынхаа эхэн дээр
Далан тав зангидаад
Дараа талд нь
Талын Харбодонтой
Ач тач барилдаад
Алс булс орхилцоод
Цэглэн босон барилдаад
Цэрвэн татан
Чирэлцээд явахад
Өдий төдий
Цагийн үе
Өнгөрөөд явахад
Хоёр сайн эр

Хэн хэнээ ядалцаад
Хэсэг олон цагийн
Үе өнгөрөөд явахад
Хүрэн улаан
Хүзүү сээрээрээ
Хөшилцөөд явнаа
Хүрэл мөнгөн
Чээжээрээ нэгэн
Дөгнөлцөөд явнаа л
Арван таван хоногийн
Адаг өнгөрч л явахад
Дөнөн Шаргарьд
Сар ирэх тусмаан
Сааж л бариад
Өдөр ирэх тусмаан
Имэрч л бариад явнаа
Талын Харбодон
Хүмэн болж төрөөд
Хүнтэй барилдаж
Гар зөрүүлж явахдаа
*Дөрвөлж цоох ор морь*той
Дөнөн Шаргарьд шиг
Баатар эртэй
Авалдаж барилдаж
Учирч явсангүй билээ л.
Өдий төдий
Цагийн үе
Өнгөрч л байхад
Хүрзээн чинээ шүдтэй
*Хүрэн цоох ор морь*той
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай
Өмнө л амхаан
Цагаан хөтөл дээр нэхэн

Гараад ирэхлээр
Дөрвөлжин шар
Хээр морин
Тасхар
Хээр морин хоёр
Уяатай байхыг
Алдалгүй үзэв л
Хажуу талаар нь
Эргэлдүүлээд халиагаад байхад
Дөнөн Шаргарьд
Талын Харбодонг
Шинэхэн унагаагаад
Талын Харбодонгийн
Авдар зандан
Чээж дээр л
Амарч зайдагнаад суухыг
Алдалгүй үзэв л.
Гар нь чанга
Ганзага нь чийлхаа
Ганц ч хөвгүүн **талын Харбодон**той
Харгалдаж явж л
Үзээгүй болж
Мэдэгдээд ирэхэд
Тал өргөн чээж
Харанхуйтаад явнаа
Тахь найман үе нь
Сулдаад явахад
Дөнөн Шаргарьд
Талын Харбодонг
Элбэг сайхан
Ташаа талдаан
Эвхэн барин мушгиад
Эргээд хаяад
Босдог газрыг халиагаад

Хангал сайхан
Ташаандаан аваад
Хаман барин мушгиад
Хаяад босдог газрыг
Халиагаад
Дөнөн Шаргарьд баатар
Тором тэмээн
Тоглоод, наадаад
Тавгаан таслалгүй
Торгон сайхан
Элсний өр дунд
Торийтол нь цацаад
Талын Харбодонг
Унагаагаад байхыг
Хүрэл-Арслан Магнай
Алдалгүй үзээд явнаа.
Хүрэларслан Магнайн
Адаг таван араа нь
Зуугдаад явнаа.
Арван зандан
Хурга нь [=хуруу нь]
Атгагдаад явнаа.
Хурзээн чинээ шүдтэй
*Хүрэн цоохор морин*ыхоо
Хүч хурдаар нь
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Гүйлгэж ороод
Арвин шар
Хөдөөн өр
Дунд ялагдаад
Дөнөн Шаргарьдын
Доор байсан
Талын Харбодонг

Хурэн цоохор
Морин дээрээсээ
Суга татаж аваад
Долоон довонгийн
Цаад талд чулуудчихаад
Өнгөрч гараад
Тэр зүгийн
Тэр уулын бэлийг
Дөшүүлж яваад
Хурээн чинээ шудтэй
*Хурэн цоохор морин*ыхоо
Хавцал болсон амыг
Хариу татаж
Эргүүлээд ирхэдээн
Дөрвөлжин шар
Хээр морин
Тас хар хээр
Морин хоёрын
Хажуу талд ирээд
Холби тусан буугаад
*Хурэн цоохор мори*он
Хад чулуу дамжуулаад
Хайр чулуу гишгүүлээд
Хад мэт хантарч
Тулга мэт тушаад
Хаяад явнаа.
Дараа талд нь
Хүрэл-Арслан Магнай
Араан чис хар
Модон шингээний [=шиг]
Саадгаан авч
Хаяад явнаа
Алтай хөө хуягаан
Тайчиж овоолоод явнаа

Артай хүрэн зодгоон
Өмсөөд явнаа
Дөнөн Шаргарьдын
Агир зандан гуураас нь
Атгалцаж бариад
Суга суга л
Таталцаад явнаа
Ач тач авалцаад
Алс хулс орхилцоод
Цэглэн босон
Барилцаад явнаа
Хоёр сайн эр
Бага уул хадыг
Багцартал түлхэлцээд
Их уул хадыг
Ивт шувт түлхэлцээд
Хөдөө эвдэрч л
Хөтөл болтол
Барилдаад явнаа
Хөтөл нь эвдэрч
Хөдөө болтол
Барилдаад явнаа
Эмнэг газар нь
Эвдрээд нэгэн
Элсэн бөөрөг болтол
Барилдаад явнаа
Орон замба тивийн
Өрийг эвдэртэл нь
Барилдаад одоход
Олон шар нарийхан
Гууцагууд нь [=гуу жалга]
Ихдээд уужимдаад явнаа.
Дөнөн Шаргарьд
Сар ирэх тусмаан

Сааж л бариад явнаа
Өдөр ирэх тусмаан
Имэрч л бариад явнаа
Арван таван хоногийн
Адаг өнгөрч л явахад
Хүрзээн чинээ шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай
Элбэг сайхан
Ташаа талдаан
Эвхэн барин
Мушгиад явнаа
Эргээд хаяад босдог
Газрыг халиагаад явнаа.
Хангал сайхан
Ташаа талдаан
Хаман барин мушгиад
Хүрэл-Арслан Магнайг дийлээд
Босдог газраа
Халиагаад явахдаа
Тором тэмээн
Тоглоод явахад
Тавагаан татаж л
Чадашгүй болгов.
Торгон цагаан
Элсэн дунд
Зайрын шил
Замбуулингийн толгойг
Хөдөө болтол
Халбайтал нь цохиж [=дийлээд/
Хүрэл-Арслан Магнайн
Авдар зандан
Чээж л дээр нь

Амарч л зайдагнаад
Суув л гэнээ.

Талын Харбодонгийн хүү гунан Харбодонгийн бүлэг

Өдий төдий
Цагийн үе
Өнгөрч л байтал
Талын Харбодонгийн
Хөвүүн болсон
Хоёрхон сүүн цахиур шүдтэй
Хоймсон[97] настай
Баал улаан хөвүүн
Гунан хар
Хээр үрээтэйгээ
Гараад ирэхэд нь
Эрбэн[98] улаан
Хөдөөн өр дунд
Тас хар
Хээр морин
Хүрэн цоохор морин
Дөрвөлжин шар
Хээр морин
Гурав уятай байхыг
Алдалгүй үзэв.
Хажуу талаар нь
Эргэлдүүлээд үзэхэд
Хүрэл-Арслан Магнайг
Дөнөн Шаргарьд
Шинэхэн унагаагаад
Авдар зандан
Чээж дээр нь
Амарч л зайдагнаад

97. Хоёр настай
98. Арвин. өргөн

Суухыг алдалгүй үзэв
Талын Харбодонгийн хүү
Хоёрхон цахиур шүдтэй
Хоймсон настай
Баал улаан хөвгүүний
Адаг араан
Зуугдаад явнаа
Арван хурга нь [=хуруу нь]
Атгагдаад явнаа
Гунан хар
*Хээр үрээ*нийхээ
Хурд хүчийг нийлүүлээд
Өмнө л нэгэн их
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Ороод явнаа
Дөнөн Шаргарьд
Хүрэл-Арслан Магнай
Хоёрт тулж ирээд
Гунан хар
Хээр үрээ дээрээсээ
Хүрэл-Арслан Магнайг
Суга татаад
Долоон довын
Цаад тал руу
Давуулж хаяад явнаа.
Тэр зүгийн
Тэр уулын
Бэл руу дөшүүлж яваад
Гунан хар
*Хээр үрээ*нийхээ
Хавцал болсон амыг
Хариу эргүүлж ирээд
Тас хар хээр морин

Хүрэн цоохор морин
Шар хээр морин гурвын
Хажуу талд л ирээд
Холби тусан буугаад
Гүнан хар
*Хээр үрээ*г
Хад мэт нэгэн
Хантраад авав
Тулга мэт
Тушиж хаяад явнаа.
Ишигний арьсан
Дээлээн тайлж
Хаяад явнаа
Исгээн хязаар[99] госоон [=гутлаа]
Тайлж хаяад явахдаан
Хаан сайхан аавынхаа [=Талын Харбодон]
Тавин дөрөө
Дөрөөлөөд морддог
Тас хар
Хээр морины
Тахийн хүзүүн
Цулбуурыг нэгэн
Тайлж аваад явнаа.
Нарийн хар харцага
Хоёр гуяынхаа эхээр нь
Сайн эрийн барьц
Гаргаж аваад
Дөнөн Шаргарьтай
Ач тач барилдаад
Алс хулс орхилцоод
Цэглэн босон барилдаад
Цэрвэн татан
Ширвэлцээд барилдахад

[99] [illegible]

Баал улаан хөвгүүний
Алтан хонголцог нь
Артай хүрэн зодогны
Захд л арай
Шүүрч хүрч
Ядаад явнаа.
Арван таван хоногийн
Адаг өнгөрч л барилдахад
Талын Харбодон*гийн*
Шуд нь хуцэзгүй [=гүйцээгүй]
Шөрмөс сунаагүй
Хоёр шудтэй
Хоймсон настай
Баал улаан хөвгүүнийг хараад
Дөнөн Шаргарьдын
Хүч нь улам нэмэгдэв.
Омог нь улам догшров.
Талын Харбодонгийн
Баал улаан хөвүүнийг
Эмнэг сайхан ташаа талдаан
Дөнөн Шаргарьдыг
Эвхэн барин мушгив.
Эргээд хаяад босдог
Газрыгаа халиагаад явнаа
Хангал сайхан
Ташаа талдаан
Хаман барин мушгив.
Хаяад орхиод
Босдог газрыгаа
Халиагаад явав.
Бас л цаанаа бодож
Тором тэмээн
Тоглож наадаад
Тавагаа татаж чадашгүй

Торгон цагаан элсэн дунд
Торийтол нь цохиж унагаагаад
Авдар зандан чээжэн дээр нь
Амарч л зайдагнаад суув л.
Араас нь бас тэгээд
Амхаан цагаан хөтлөөд
Хурзээн чинээн шүдтэй
*Хүрэн цоохор морь*той
Хүч л их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнайн
Хөвүүн болж төрсөн
Сэгсгэр толгойтой [=сэвлэгтэй]
Сэмэрхий шүдтэй
Гунан настай
Баатар баал
Улаан хөвүүн
Гунан бор
*Цоохор морин*ыхоо
Хавцал болсон амы нь
Ангайтал татаад
Харгай зөөлөн соёог нь
Арзайтал нь татаад
Өмнө л талдаан
Өнгийгөөд гараад ирэхэд
Арвин шар
Хөдөөн өр дунд
Тасхар
Хээр морин
Хүрэн цоохор морин
Гунан хар
Хээр үрээ
Дөрвөлжин шар
Хээр морин дөрөв
Уяатай байхыг

Алдалгүй үзэв
Хажуу талаар нь
Зэрэглүүлээд халиагаад үзэхээр
Бас цаад талд нь
Дөнөн Шаргарьд
Хоёр шүдтэй
Хоймсон настай
Баал улаан хөвүүг
Шинэхэн унагаад
Дөнөн Шаргарьд
Амраад сууж байхыг
Алдалгүй үзэв л.
Хүрэл-Арслан Магнайн
Сэгсгэр толгойтой
Гунан настай
Баатар баал
Улаан хөвүүний
Ар шил нь ангалзаад
Арван хоёр хуниа нь бууглаад
Адаг таван
Араа нь зуугдаад
Арван зандан
Хурга нь аттагдаад явнаа.
Гунан бор
*Цоохор морин*ыхоо
Хурд хүчийг нийлүүлээд
Гунан настай
Баал улаан хөвүүн
Ед хүчээн нийлүүлээд
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн
Алдуулаад ороод явнаа.
Дөнөн Шаргарьдын

Доор байсан
Талын Харбодонгийн
Хоёрхон шүдтэй
Хоймсон настай
Баал улаан хөвүүг
Суга татаж аваад
Долоон довыг
Давуулж хаяад
Тэр зүгийн
Тэр уулын
Бэл л дөшүүлж даваад
Гунан бор
*Цоохор морин*ыхоо
Хавцал болсон амыг
Хариу эргүүлж ирээд
Холби тусан
Буугаад явнаа
Тас хар
Хээр морин
Хүрэн цоохор морин
Гунан хар, шар хээр
Үрээ дөрвийн хажууд
Гунан бор
*Цоохор мори*о
Хад чулуу дамжуулаад
Хайр чулуу гишгүүлээд
Хад мэт хантраад
Тулга мэт тушиж
Хаяад явнаа
Ишгэний хязаар дээл
Эсгийн хязаар
Гутлаа тайлж л
Хаяад явнаа
*Хүрэн цоохор морин*ы

Тавин алд
Тахийн хүзүүн цулбуурыг
Тайлж аваад
Хоёр гуядаан
Сайн эрийн
Барьц гаргаад явнаа
Дөнөн Шаргарьдтай
Ач тач барилдаад
Алс хулс орхилцоод
Цэглэн босон барилдаад
Цэрвэн татан
Ширвэлцээд явахдаа
Дөнөн Шаргарьдад
Хүрэл-Арслан Магнайн
Нялх балчир хөвүүн
Гунан настай
Баатар баал
Улаан хөвүүн шингээний
Гар нь чанга
Ганзага нь чийлхаа
Хөвүүн харгалдаж
Явж үзээгүй болж
Мэдэгдээд байв
Хүрэл-Арслан Магнайн
Баал улаан хөвүүн
Сар ирэх тусмаан
Саажл барилдаад явнаа
Өдөр ирэх тусмаан
Имэрч л барилдаад явнаа
Дөнөн Шаргарьдын
Тал өргөн чээж нь
Харанхуйтаад явнаа
Тахь найман үе нь
Сулдаад явнаа

Баатар баал улаан хөвүүний
Хангал цагаас яс нь
Халуу бүлээ өөгөөд [=болоод]
Хамаг эрээн хар мах нь
Эврээн зөндөө [=өөрөө аяндаа]
Гүйцэд явнаа
Нягт хар мах нь
Нягтраад явнаа
Нийлэг цагаан яс нь
Халуу бүлээ өөгөөд [=болоод]
Дал ээмээр нь
Далан таван хүчтний
Тэнхээн нэмэгдээд явнаа
Хар харцагаар
Хар барын тэнхээн
Нэмэгдээд явнаа л
Ховдол болсон зоонд нь
Хорин барын
Тэнхээн нэмэгдээд явахад
Гунан настай
Баал улаан хөвүүний
Алаг хар нүдэнд
Хар бараан ороод
Авдар зандан чээжинд нь
Ухаан санаан
Нэмэгдээд одов.
Эврээн зөндөөн [=өөрөө аяндаа]
Гүйцэд явнаа
Нягт хар мах нь
Нягтраад явнаа
Алаг хоёр нүдэнд нь
Хар бараан улам тодрон
Ороод явнаа
Авдар зандан чээжинд нь

Ухаан санаан улам
Нэмэгдээд явнаа
Дал л ээм талаар нь
Далан таван хүчтний
Тэнхээн нэмэгдээд явахад
Хар харцагаар нь
Хар барын тэнхээн
Нэмэгдээд явахад л
Баал улаан хөвүүн
Дөнөн Шаргарьдыг
Элбэг сайхан
Ташаа талдаан
Эвхэн барьж л
Мушгиад авнаа
Эргээд хаяад
Босдог газрыгаа
Халиагаад явахдаа
Тором тэмээн тоглож
Тавагаа таслашгүй
Торгон цагаан элсний
Өр л дундахыг
Тэмдэглэж жилэвкээд явнаа
Дөнөн Шаргарьдыг
Талын шар хөдөө
Хотойтол нь өргөөд явахад л
Баал улаан хөвүүний
Найман цагаан үе нь
Хугарахдаа хүрээд явнаа
Нарийхан улаан гол нь
Тасрахдаа хүрч л ядсаар
Дөнөн Шаргарьд*ыг унагаж*
Авдар зандан
Цээж л дээр нь
Зайдагнаад суухад л

Айрастай хоёр
Хар л таваг нь
Газраас л өөдөөн
Таван тохой
Дүнтэй зайтай байв л
Амаргүй арван
Таван хоногийн
Адаг өнгөртөл
Амраад [=суугаад]
Арван зургаадахь нь
Болж явахад
Дөнөн Шаргарьдыг
Алдаг аргаан
Эс л олж ядаад
Хажуу талдаан
Холби тусан буугаад
Дөнөн Шаргарьдын
Айрастай хоёр
Хар тавгийг
Цацуулж л бариад явахдаа
Дөнөн Шаргарьдыг
Хадтай газрын
Ирмэг дамжуулж
Цохиод явнаа
Харгайтай газрын
Харгайг дамжуулж
Цохиод явнаа
Тэр л өдрийг
Тэсэн цохиод явнаа
Тэр л шөнийгөөн
Дөлөн цохиод явнаа
Түүний мангадарын
Өрүүн шар гэрэл
Болж л явахад

Дөнөн Шаргарьдын
Айрастай хоёр хйлий нь
Хар л таваг
Баал улаан хөвүүний
Хоёр гарт л
Үлдээд ирэхэд
Таван үдийн газарт
Таягдаж чулуудаад
Дараа талд нь
Гунан бор цоохор
*Үрэ*эний хажуу талд л ирээд
Ишэгнйй арьсан дэвэлээн
Өмсөөд явнаа
Ишгээн хязаар госоон [=гутлаа]
Өмсөөд явнаа
Гунан бор цоохор
Үрээ дээрээ
Хаян торолж
Мордоод явнаа
Өмнө л амхаан
Цагаан хөтөл өөд
Халайгаад явахад
Талын Харбодон ах
Хүрэл-Арслан Магнай аавтай нь
Хоёулаан
Баал улаан хөвүүн өөд
Өмнө л амхаан
Цагаан уужим хөтөл
Уруугаан уруудан ороод
Ирж л явахыг
Алдалгүй үзэв
Талын цагаан
Хөдөө дунд
Аав, ах,

Хүү гурвуулаан
Уулзаад явнаа
Баатар, балчир
Баал улаан хөвүүн
Хаан сайхан
Аав л, ахынхаа
Амар, мэндийг
Асуугаад явнаа
Дараа талд нь
Баал улаан хөвүүгээ
Хүрэл-Арслан Магнай
Талын хар
Бодон хоёулаан
Хоёр халхаас нь [=хацраас нь]
Өдий төдий
Хүргэж үнсээд явнаа
Хүлэг төрж л
Гунан бор цоохор
Үрээ шиг төрдөг
Болох л яанаа
Хүмэн төрж л
Баатар баал
Улаан хөвүүн шиг л
Төрдөг болох л
Яанаа гэж л
Өдий төдий
Цагийн үеийг л
Өнгөрөөд явнаа
Дараа талд нь
Дөнөн Шаргарьдын
Долоон олон муж л албаты нь
Өврөөн нутаг өөдөөн
Нүүлгээд дахуулаад явнаа
Самнаатай даага,

Сахалтай ишиг
Хаялгүй туулгаад явнаа
Дэлэм дэяс,
Дэлтрийн эсгий
Хаялгүй ачуулаад явнаа
Дөнөн Шаргарьдын
*Дөнөн Шар хээр мори*йг
Далай цагаан өргөөний
Үүдэн дээр л авч ирээд
Баатар баал балчир
Улаан хөвүүн
Хүрэн улаан хүзүүгий нь
Тас цавчиж унагаагаад
Тавин тэмээн
Түлээ овоолж
Түймэр өгөөд [=тавиад]
Улаан дүнтэй [=уул шиг их]
Гал л түлж
Улхан болтол
Цогий нь нураагаад
Атаа таван тэнгэрээн
Тахиад явнаа
Дараа талд нь
Далай цагаан өргөөгий нь
Зуун манхан тэмээний
Борвиноос өөдөө
Бөхнөөсий уруугаан
Ачуулаад явнаа
Дөнөн Шаргарьдын
Шулам улаан хатныг
Хажир хар манхан
Буурын ар л бөхнөөсий
Дүүжлээд гарав л
Арван хар

Гол болон
Аргамжтал нүүлгээд
Таван хар гол болон
Тасартал нүүлгээд
Өмнө амхаан
Цагаан хөтөл
Давуулж нүүлгээд явнаа
Буруу халайж
Уйлаад явсаныг
Шулмын ур гэж
Дор нь нам цохиж
Унагаад явнаа
Зөв л халайж
Инээгээд явсныг
Бурхны ур гэж
Дэмжлээд өргөөд явнаа
Буттай газарт нь өнжөөд
Будантай газарт нь
Сүүдэрлээд үдэлж
Хадтайд нь өнжөөд
Харгайтад нь сүүдэрлээд
Хужиртайд нь буулгаж
Хустайд нь сүүдэрлүүлж
Нүүлгээд явнаа
Олон жилийн он болтол
Олон сарын адаг
Өнгөртөл нүүлгээд явнаа
Далан долоон
Хар уулынхаа
Хойт амхаан
Цагаан хөтлөөр
Арван хар
Гол болтол
Аргамжтал нүүлгээд

Таван хар
Гол болтол
Тасартал нүүлгээд
Ороод явнаа
Албат өргөн нутгийг
Бүүр бүүртий [=буурь буурьт нь]
Буулгаад явнаа
Адал сүрэг малыг
Бэлчээр бэлчээрт нь
Хариулаад явнаа
Довон Харбөх баатрын
Далай цагаан өргөөгийг нь
Хуучин далай
Цагаан өргөөнийн нь
Ором дээр нь
Далбаажий дүнхийтэл
Байгуулж бариад явнаа
Дараа талд нь
Луузан Тив хааны
Далай цагаан өргөө
Бариастайхан байдаг
Түүний дараа талд нь
Тэвэг Алтанбүс
Төмөрзүрхэн баатар
Хүрэл-Арслан Магнай
Талын Харбодонгийн
Далай цагаан өргөөг
Зэрэгцүүлэн бариад явнаа
Дараа талд нь
Далай болсон
Архи чигээгаан [=цэгээгээ]
Цуглуулаад [=сөгнөж]
Даранх болсон
Мах идээгээн

Бэлтгээд явнаа
Олон түмэн
Албатыг цуглуулаад
Талын Харбодонгийн
Багахан баатар
Баал улаан ховгүүний
Алдар богд л нэрий нь
Дууддаг юман
Алтан хонголцогий
Хайчилдаг юман гэгээд
Өдрийн сайхныг
Өнжиж хүлээгээд
Сарын сайныг
Сахиж хүлээгээд
Сайн өдөр нь болохоор
Урт сайхан шар
Бүрээгээн татаад
Олон түмнээн цуглуулаад
Нарийн шар
Бүрээгээн татаад
Найман түмээн
Цуглуулаад явнаа
Далай цагаан өргөөний
Үүдэн талд
Хүлэг гэдэг юман
Хөсөг тогтоод явнаа
Агт гэдэг юман
Асга тогтоод явнаа
Далай цагаан
Өргөө дотор
Амьтан багтаж
Ядаж цуглараад явнаа
Талын Харбодонгийн
Багахан баатар

Баал улаан хөвүүн*ий*
Алдар богд нэрий нь
Дуудаад цоллоод
Алтан хонголцогий нь хайчлаад
Талын Харбодонгийн хөвүүн
Гунан хар хээр морьтой
Гунан Харбодон гэж
Алдар их нэрий нь
Довон Харбөх баатар
Аав нь хайрлаад
Ар талд нь
Урт сайхан
Дуугаан дуулаад
Ут сайхан [=урт сайхан]
Найраан эхлээд
Найрын ихээр найрлаад
Жаргалын ихээр жаргааж
Жаргал цэнгэл
Хийгээд байхад
Их найрын дундаагуур
Хүрэл-Арслан Магнайн хатан
Уйлаад суудаг нь
Энэ билээ л
Хүрэл-Арслан Магнай хэлэв л:
Жаран жилийн жаргал
Наян жилийн найр
Ай бахаа хангаад
Жиргал цэнгэл
Хийэж л байхад
Чи ганцаараа
Энэ л найрын дундаагуур
Уй гашуу хийгээд
Суудаг чинь
Юун билээ гэв.

Хүрэл-Арслан Магнайн
Хатан хэлэв:
Ямар ачтай амьтны
Үр садан
Алдар богд
Нэрээн дуудуулаад
Алтан хонголцогоон хайчлуулаад
Найр жаргал
Хийгээд байдаг юм бэ?
Ямар хүний
Үр садан
Эргээд буцахаар нь тоолгүй
Үхээд очихлоор тоолгүй
Сэг ч гүй болдог юм?
Бор цоохор морьтой
Баатар баал
Улаан хөвүүн *минь*
Олон мал, хүмний
Тоосон дотроос
Хоороонаа эргээд
Буцаад явахыг
Алдалгүй үзлээв гэв л
Хүрэл-Арслан Магнай хэлэв:
Халайхаар [=харахаар]
Хар нүдний минь
Цэцгий болсон
Хазахаар [=энхийрэлэхээр]
Халуун бүлээн
Хар цусан болсон
Хайртай гаищ
Хөвүүгээн одоо
Хайж л яваад
Үхнээв одоо гэгээд
Яаралгүй хувцаслаад явнаа.

Алттай хөө хуягийг
Авч л өмсөөд явнаа
Араан чис
Хар модон саадгийг
Авч агсаад явнаа
Дараа талд нь
Довон Харбөх баатар:
Гунан улаанбодон ягалаа?
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Түүн дээр л
Довон Харбөх баатар
Луузан Тив хаан
Талын Харбодон
Хүрэл-Арслан Магнай дөрөв
Нэг нэгнээ хараад
Алан түлэн болоод[100]
Нэг нэгнээсээ сурахлаар
Хүрэл-Арслан Магнайн
Баал улаан хөвүүн
Хэзээ байсан
Хэзээ алга болсныг
Мэдэх л амьтан
Нэг ч гүй болоод явнаа.
Тас хар хээр морьтой
Талын Харбодонгийн хөвүүн
Гунан Хар бодон
Хайхираад хэлэв:
Эрт урьд цагт
Дөрвөлжин хар
Уул нутагтай
Дөнөн шар хээр морьтой

100. Гайхаад, гайхшраад

Дөнөн Шаргарьд***ын нутгийг***
Дөрвөлжин хар уулаас нь
Наашаа нүүлгээд
Гарч л явахад
Гунан баал улаан хөвүүн
Гунан Харбодон ***намайг***
Дахуулаад явж л билээ л гэж хэлээд
Талын Хар бодонгийн хөвүүн
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Хүрэн цоохор морьтой
Хүрэл-Арслан Магнай
Хоёулаан цуваад
Алхаад эргээд гараад
Баал улаан хөвүүнийг олохоор
Гунан хар
Хээр морин
Хүрэн цоохор морин
Хоёр дээрээн
Хаян торолж л
Мордоод явнаа
Баруун ам эргүүлээд
Баруун хойт л зүгээн
Тэмцүүлээд гараад явнаа
Алтай өргөн нутгийг
Шувталаад явнаа
Амхаан цагаан
Хөтлийг даваад явнаа
Арвин шар
Говийн өрийг
Гатлаад явнаа
Хоо цагаан
Хөтлийг даваад

Хол л уужим
Газрыг авч л гүйлгээд явахад
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Хэлдэг нь энэ билээ:
Гурван ерэн есөн
Жилийн газарт
Хүмэн мальн
Тоосон гараад
Байдаг нь юу билээ гэв.
Хүрэл-Арслан Магнай хэлэв л
Хүрэн цоохор морим
Тав их л махтай
Таван их л хурдтай явахдаа
Чиний гунан хар
Хээр морин шиг л
Гэжирмэг байсан юман.
Хүрэларслан Магнай би
Эрийн дунд настай
Эгц л цагаан шүдтэй
Таван их едтэй байхдаа
Гунан Харбодон
Чам шиг ээний би
Гурван ерэн есөн
Жилийн хол газрыг далдаас
Үзэж байгаа үгүй билээ.
Чи битгий худлаа хэл гэв л
Гурван ерэн есөн
Жилийн газрыг
Авч гүйлгээд ирэхэд
Нэг л амхаан цагаан
Хөтөл дээр
Гараад ирэхэд

Түүнээ цаахан талд
Нарийхан шаргал морьтой
Нэг л хар улаан залуу
Арвин шар хөдөөн
Өр л дунд
Олон албатыг
Арван хар
Гол болон аргамжлаад
Таван хар
Гол болон
Тасарталы нүүлгээд
Аашихыг алдалгүй үзэв
Хүрэл-Арслан Магнай
Гунан Харбодон хоёулаа
Амхаан цагаан
Хөтөл уруугуун
Аван идэн
Алдуулаад ороод явнаа
Арвин улаан
Говийн өр л дунд
Тэр их нүүдэлтэй
Тас бас л харгалдаад ирэв л
Нарийхан шарга морьтой
Хар улаан залуу
Холби тусан буугаад
Хүрэл-Арслан Магнайн
Амар мэндийг
Мэдээд явахдаа
Би мэнд л
Та мэнд
Мэндийн хариу
Мэнд л өгөлцөөд
Ар л талд нь
Хүрэл-Арслан Магнай

Хэлдэг нь энэ билээв:
Нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Хар улаан залуу
Хамаагаас л хамаа
Хүрч л яваа чинь
Энэ билээ л
Хэт хол л
Хэрэг зориг чинь
Хэнд л билээ
Хэлээд өгийч" гэв л.
Хар л улаан залуу
Хайхираад хариу хэлэв:
Хойт наран эргээд ордог
Зүгт л байдаг
Нарийхан улаан
Уул нутагтай байдаг.
Найм л хүрээд үлсэн
Олон муж
Албаттайхан байдаг.
Нарийхан шарга морьтой
Нарийхан Алтансүмбэ *л*
Гэдэг хүмүүн
Би болдог билээв л.
Эрт урьд
Нарийхан улаан
Уул нутагтайхан байхад минь
Алтайн далан долоон
Хар уул нутагтай
Долоон муж л албаттай
Хүрзээн чинээн шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнайн хөвүүн

Гунан бор цоохор морьтой
Баал улаан
Хөвүүн *ирэхлээр л*
Алдар их
Нэрий нь дуудаад
Алтан хонголцогийн нь хайчлаад
Хүрэн цоохор морьтой
Хүрэл-Арслан Магнайн хөвүүн
Гунан бор
Цоохор морьтой
Хүчтэй Улаанбодон *гэж л*
Алдар богд л
Нэрий нь дуудаад өглөөв.
Ар дараа талд нь
Зах таван
Товч шилбий нь
Шигтгээд өгдөг
Заяаны заяач болсон
Зандан дагиныг *л зааж*
Хойт наран
Эргээд ордог
Зүгт л байдаг
Гурван ерэн
Есөн жилийн
Газрын цаахан
Талд л байдаг
Хүрэн улаан
Уул нутагтай байдаг
Хүнхээ их хааны
Хүрэл алтан дагина
Гэж л байнаа
Залаад авахаар чинь
Заяаны чинь заяач болох
Зандан дагина *чинь*

Тэр л гэгээд
Заажг өгөөд явуулсан билээ
Ар дараа талд нь
Далан долоон
Хар уулаид нь хүрч
Долоон мужс л
Албаттай нийлж
Нутагтласав гэгээд [=нутаглъя гээд]
Далан долоон
Хар л уулууры
Нүүгээд очиж яваа
Цаг минь
Энэ билээ гэв л
Түүн дээрий [=түүний дараа]
Хүрэл-Арслан магнай
Нарийхан Алтансүмбэ
Гунан Харбодон гурвуулаа
Сайн явсаныгаа
Хэлж л инээлдээд
Саланги явсаныгаа
Хэлж л уйлалдаад
Тэр газар дээрээ
Ачаа бараа тайлаад
Адал олон малыг
Бэлчээр бэлчээрт нь гаргаад
Далай цагаан өргөөгөө
Далбайтал нь байгуулж бариад
Далай болсон
Архи чигээг бэлтгээд
Даранх болсон
Мах идээгээ тавиад
Амаргүй сайхан
Арван таван хоногийн
Найр хийгээд

Ар л талды [=дараа нь]
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон*доон*
Залаад авдаг
Заяаны чинь заяач болох
Зандан дагиныг бас л
Зааж өгнөөв
Залаад ав гэв.
Нарийхан Алтансүмбэ
Бас нэмж хэлсэн нь:
Бас л хойт наран
Эргээд ордог
Зүгт л байдаг
Гурван ерөн
Есөн жилийн хол
Газрын цаахан
Талд л байдаг
Хүрэн улаан
Уул нутагтай
Хүрэн алтан морьтой
Хүнхрээ хааны
Нутагтай хамт
Зэрэгцээ байдаг
Алтайн алаг
Балбуулжин улаан
Уул нутагтай
Арван муж хүрсэн
Албаттай байдаг
Алтан шарга морьтой
Алтуулж мэргэн хааны
Алтанхөвч л дагина
Гэж байнаа.
Залаад авахлаар чинь

Заяаны заяач дагина
Тэр л билээ гэв.
Ширтийн улаан авдраа
Шижигнэтэлий уудлаад явнаа
Алд дүнтэй
Аюуш цагаан хадгийг
Авч бариад
Гунан Харбодон *дүүдээн*
Мартагдашгүй их л
Сургаалаа хэлээд
Барагдашгүй их
Ерөөлөө тавиад явнаа гэв.
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон хэлэв л:
Хүрэл-Арслан Магнай
Нарийхан Алтансүмбэ
Ах нар минь
Заягаар их л заяатай
Санаагаар амар явж
Далан долоон
Хар л уулдаан хүрээд
Нутаглаж л байгыт.
Удалгүй яваад
Төдөлгүй алтан
Жолоо эргүүлээд би
Хүчтэй Улаан бодон*той хамтарч нийлээд л*
Дайныг л дараад
Дагина бэрийг
Залаад ирнээв гэзд
Алхаад эргээд гарав л
Гунан хар
Хээр морин дээрээ
Хаян торолж мордоод

Гунан Харбодон
Хойт наран
Эргээд ордог
Зүгийг тэмцээд гарав л
Ар л талд нь [=дараа нь]
Нарийхан Алтансүмбэ
Хүрэл-Арслан Магнай
Хоёулаа дараа дараагаараа
Цувж л гараад
Хавтгай өргөн
Нутгаа нүүлгээд
Далан долоон
Хар л уулыг
Тэмцэж нүүлгээд гарав л.
Гунан Харбодон
Амхаан цагаан хөтөл
Даваад явнаа
Арвин шар говийг
Гатлаад явнаа
Хоо цагаан хөтлийг
Даваад явнаа
Хотгор шар
Говийн өрийг
Гатлаад явнаа
Хол уужим газрыг
Авч л гүйлгээд
Гурван ерэн
Есөн жилийн газрыг
Гурван жилээр
Товчлоод гүйлгээд
Гурван жилийн газрыг
Гурван сараар
Товчилж гүйлгээд
Гурван сарыг

Амаргүй арван таван
Хоногийн газраар
Товчилж гүйлгээд
Арван таван хоногийн газрыг
Асганы улаан [оройн улаан]
Нараар болзож
Гүйлгээд явсаар
Нэг л амхаан
Цагаан хөтөл дээр л
Аван идэн
Алдуулаад гарч л ирэв л
Хүнхээн их хааны
Хүрэл улаан уул
Ээм цаагаан [=эгэм цээгээ]
Өнгөлзөж үзэгдээд
Шуу цагаан
Шунхалзаад байв л.
Суунаг татан
Дүнхэлзээд байв л.
Суу дундуураасаа уруугаан
Утаан гэдэг юман
Униар татан цэнхэртээд
Агтаан туруун харгилдаад
Азаргааны дуу нь бөлбөөлөөд
Олон түмэн нь
Шуугилдаад байв л
Хүнхээн их хааны
Далай цагаан өргөө нь
Далбайж л дүнхийгээд үзэгдэв л
Үүдэн талд нь
Хүрэн улаан
Морин уяатай
Байхыг алдалгүй үзэв л
Түүний дараа талд нь

Хүчтэй Улаанбодонгийн
Гунан бор цоохор морин
Уяатай байхыг
Алдалгүй үзэв л
Хариутай төрсөн
Гунан Харбодон
Улам улам баярлаад
Улам улам бахдаад явнаа
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн алдуулаад
Алтай өргөн
Нутгийн нь шувтлуулаад
Далай цагаан
Өргөөн үүдэн талд
Хүрэн халзан морин
Гунан бор цоохор
Морин хоёрын
Хажуу талд
Холби тусан
Буугаад явнаа.
Гунан хар
Хээр морио
Уян сүүдэрлүүлж хаяад
Алхаад эргээд
Ороод ирэв л
Хүнхээн ихээ хааны
Баруун гол
Суурин эхэн
Талд суугаад
Хаан сайхан аав
Амар сайн гэж л
Амар мэндий нь
Мэдээд явнаа.

Дараа талд нь суусан
Хүчтэй улаан
Бодонтой танилцаад
Хажуу талдаан
Эргэж алхаад
Хорин тохой газар
Хотойтол нь суув л
Хүнхээн их хаан
Таван согтуу
Улаан түшмэддээн
Хол газраас
Явсан өнгөтэй
Нүүр талдаан цогтой
Нүдэн талдаан галтай
Энэ л хар
Улаан залуугийн
Аманд нь одоо
Айгаан ам л зуулгыт
Алтай өргөн нутаг
Алдар богд л нэр
Хэтэм хол
Хэрэг зориг
Хэнд болохыг
Асуугаад авнаав гэв л.
Таван согтуу
Улаан түшмэд
Далан хүмэн дамжилдмаар
Дангын ногоон шаазанд
Чих л барьбал
Чигчий дундуур
Чимчигнүүлээд хийсэн
Чилэн цагаан
Чигээний дээжээс
Хийж бариад явнаа.

Хашир хар архадын
Амыг л өөдөөн
Татуулалгүй сөгнөөд
Дав дээрээн
Далан хоёр донгодоод
Хатуу амттай
Хар архинны дээжээс
Хийгээд ирэхэд
Хашин хар
Архадын амыг
Өөдөөн татуулалгүй
Нав дээрээн
Наян тав
Хүргэж донгодоод суув л
Ар талд нь
Хүрэн халзан морьтой
Хүнхээн их хаан
Хэлдэг нь энэ билээ л
Хол газраас
Явсан шишэстэй
Хортон дайсантай
Харгалдаад ялэж
Дарсан өнгөтэй.
Нүүр талдаан цогтой
Хар улаан залуу
Алтай өргөн нутаг
Алдар богд нэр
Хэтэм хол
Хэрэг зориг чинь
Хэнд л болдог билээ
Хэлээд өгийч гэв л.
Гунан Харбодон
Хэлдэг нь энэ билээ л:
Алтай өргөн

Нутаг минь болохоор
Өмнө наран
Эргээд тардаг
Зүгт л байдаг
Олон ерэн
Есөн жилийн
Газрын цаахан
Талд л байдаг
Алтайн далан долоон
Хар уул нутагтай
Долоон муж л албаттай
Тавин дөрөө
Дөрөөлөж мордмоор
Тас хар
Хээр морьтой
Талын Харбодон
Гэдэг хаан
Сайхан аавы минь
Алдар богд нэр нь
Тэр л билээ л.
Хүрээн чиээн шүдтэй
Хүрэн цоохор морьтой
Хүч их тэнхээтэй
Хүрэл-Арслан Магнай *гэж*
Хаан сайхан
Ахы минь
Алдар богд нэр нь
Тэр л билээ.
Өвөр биеэнэм [=өөрийн биений минь]
Алдар богд л
Нэр болохоор
Талын Харбодон*гийн*
Ганц хөвүүн
Гунан хар

Хээр морьтой
Гунан Харбодон
Гэдэг хүмэн
Би болдог билээв л.
Хэтэм хол
Хэрэг зориг
Минь болохоор
Гунан бор
Цоохор морьтой
Баал улаан
Хөвгүүн*ийг сураглаад*
Хүрэл-Арслан Магнай*тай*
Хамт л гарч яваад
Хойт паран
Эргээд ордог
Зүгт л байдаг
Нарийхан улаан
Уул нутагтай
Найман муэс албаттай
Нарийхан шарга морьтой
Нарийхан Алтансүмбэ л
Гэдэг хүмтэй хамт
Гунан бор морьтой
Цоохор морио
Уралдуулэс шөвгөлүүлээд
Өвөр биеэн
Нарийхан Алтансүмбэ*тэй*
Барилдаэс л дийлээд
Алтай өргөн
Нутгий нь олзлоод
Ирнээв гэгээд
Явсан билээв.
Энэ л гунан бор
Цоохор морьтой

Баал улаан
Хөвгүүн*ий араас*
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Би хайгаад
Ирэж л байгаа
Цаг минь энэ билээ гэв л.
Түүн дээр л бас
Хүрэл-Арслан Магнайн
Гунан Улаанбодон хөвүүн
Хүнхээн их хаан
Гунан Харбодон бид
Гурвуулаан
Сайн явснаа хэлэлцэж
Инээлдээд инээлдээд
Салангид явсанаа
Хэлж л уйлалдаад
Өдий төдий
Цагийн үе л өнгөрөөв бид.
Ар талд нь
Арван таван
Хоногийн найр хийгээд
Найрын ихээр найрлав.
Жаргалын дээдээр жаргав.
Дараа талд нь
Алтайн алаг балбуулжин
Улаан уул нутагтай
Арван муж л албаттайхан байдаг
Алтан шарга морьтой
Алтууж мэргэн хааны
Алтанхөвч дагиныг
Залаад явсал гээд явлаав.
Одоо **Алтууж**

Мэргэн хааныд хүрээд
Алтанхөвч л
Дагиныг залаад
Ирнэ гээд
Гунан Харбодон
Яаралгүй босоод
Ядалгүй алхаад
Эргээд гараад.
Гунан хар
Хээр морин дээрээн
Хаян торолж мордоод
Алтайн балбуужин
Улаан уул нутагтай
Алтан шарга морьтой
Алтууж мэргэн хааны
Алтай өргөн нутгийг тэмцээд
Амхаан цагаан
Хөтөл даваад явнаа
Арвин уужим газрыг
Авч л гүйлгээд
Нэг л амхаан
Цагаан хөтөл дээр
Гараад ирэхэд
Алтууж мэргэн хааны
Алтайн алаг балбуужин
Улаан уул тохомцогоон
Торолзоод үзэгдэв л
Торгон орой нь цухалзаад
Ээмцээгээн өнгөлзөөд
Шуу цагаан шунхалзаад
Суунаг татан дүнхэлзээд
Суу дундуураасаа уруугааны
Утаан гэдэг юман
Униар татан

Цэнхэртээд байв л
Алтууж мэргэн хааны
Далай цагаан өргөө нь
Далбааж дүнхийгээд
Үүдэн талд нь
Алтан шаргал морь нь
Уяхан зандан
Модон уяандаа
Сагалар зандан
Модон сүүдэртээн
Могой болж л жилэвкээд
Морин болж л гилэвкээд
Тоть шувуу
Хэвтээ гялалзаад
Тогос шувуун
Хэвтээ тонголзоод байв л
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Амхаан цагаан
Хөтөл уруугаан
Аван идэн
Алдуулаад идээд явнаа
Алтай өргөн
Нутгийн дундаагуур
Бахийтал нь суугаад
Бадартал нь тавиад
Дуугтал нь цохиод
Шуугтал нь тавиад явнаа
Далай цагаан өргөөний
Үүдэн талд л ирээд
Холби тусан
Буугаад явнаа
Гунан хар

*Хээр мори*он
Уяхан зандан
Модон уяанд нь
Сагалар зандан
Модон сүүдэрт нь
Уян сүүдэрлүүлж
Хаяад явнаа
Баруун талд нь
Эргэлдээд гарч
Араас чис хар
Модон шингээний
Саадгаан авч
Хаяад явнаа
Алхаад эргээд
Ороод явнаа
Алтуулж мэргэн хаан
Далай цагаан өргөөнийхөө
Баруун гол
Суурийн эхэн талд нь
Сууж байв л.
Хариутай төрсөн
Гунан Харбодон
Босго тотгын
Ар л талд
Төөн өвдөг газардуулаад ёслов
Төт хар
Толгой тонголзуулаад ёслов.
Өвдөг толгой газардуулаад ёслов.
Өнчин сүвээ махилзуулаад ёслов.
Хаан сайхан аав та
Хатан сайхан ээж та
Амар сайн уу гэж
Амар мэнд л мэдээд
Хажуу талдаан

Эргэлдээд суув л.
Ар талд нь
Алтуулж мэргэн хаан
Таван согтуу
Улаан түшмэддээн
Хайхираад хэлэв л:
Хол газраас
Явсан өнгөтэй
Хортон дайсантай
Харгалдсан шинжтэй
Нүүр талдаа галтай
Нүдэн талдаан цогтой
Багахан баатар
Баал улаан хөвүүнд
Өтөр шулуун
Айга унд өгийт.
Алтай өргөн нутаг
Алдар богд нэр
Хэт зоригий нь
Асуугаад авнаав гэв л.
Таван согтуу
Улаан түшмэд
Яаралгүй босоод
Ядаж түдэлгүй
Далан хүмэн
Дамжилдмаар том
Дангын ногоон шаазанд
Шинэ л сайхан
Чигээний дээжээс
Хийж л барихад
Гунан Харбодон
Хашин хар
Архадын амыг
Өөдөөн татуулалгүй

Дав дээрээн
Далан гурав хүргэж
Донгодоод байв
Хатуу амттай
Хар архины
Дээжээс хийгээд барихад
Хавчиг хар
Хөхүүрийн ам
Өөдөөн татуулалгүй
Нав дээрээн
Ная хүргэж донгодоод
Аянгын улаан
Дүүвэр болоод суув л.
Алтуулж мэргэн хаан
Хайхираад асуув л:
Ирэхий чинь халайхаар
Хүмүүс байдалтай
Идэж уухы чинь
Халайхаар
Баатарын шинжтэй
Нүүр талдаан галтай
Нүдэн талдаан цогтой
Багахан баатар
Баал улаан хөвүүн
Алтай өргөн нутаг
Алдар богд нэр чинь
Хэн гэдэг билээ?
Хэн гэдэг
Хүний үр садан
Хэн гэдэг хүмэн
Чи болдог билээ?
Хэтэм хол
Хэрэг зориг
Хэнд л билээ?

Хэлээд өг л гэв
Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Хэлдэг энэ л билээ л:
Өмнө наран
Эргээд гардаг
Зүгт байдаг
Товчилоод хэлэхээр
Төсөр хол л
Газарт байдаг.
Тоолоод дүгнээд хэлэхээр
Гурван ерэн есөн
Жилийн газрын
Цаахан талд байдаг
Алтайн далан
Долоон хар л
Уул нутагтай байдаг.
Долоон муж л
Хүрээд үлэгсэн
Албайттайхан байдаг.
Тавин дөрөө
Дамжсиж мордмоор
Тас хар л
Хээр морьтой
Талын Харбодон *гэдэг*
Хүмэн сайн эр бол
Хаан сайхан
Аавынаа минь
Алдар богд л
Нэр нь тэр билээ л.
Өвөр биеэнэм
Алдар нэр нь болохоор
Талын Харбодонгийн хөвүүн

Гунан хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Гэдэг хүмэн
Би болдог билээв.
Хэтэм хол л
Хэрэг зоригом болохоор л
Хаан сайхан аавынхаа
Өндөрт нь гарч л
Харуусы тань
Харсав гээд ирлээв.
Өргөнд тань гарч л
Мөр л хэрчээжий тань
Утасал гээд ирлээв.
Хажир их
Дайсанд тань
Дэм л болсов [=болъё]
Гээд ирлээв
Хатуу амттайхан
Хар архинд тань
Сөн болъё гээд ирлээв.
Алтанхөвч ***дагины тань***
Залаад авсал [=авъя]
Гээд ирлээв гэгээд
Яаралгүй босоод
Ядалгүй алтан
Хавтагъынаа амыг
Эвшээлгээд явнаа
Алд дүнгийнээ
Аюуш цагаан
Хадгийг гаргаад барив л.
Алтууж мэргэн хаан
Хуруувч болсон
Бараан өөдөөн

Хажигнатал хаяад явнаа
Дараа талд нь
Хариултай төрсөн
Гунан Харбодон
Босго тотгоон
Ар л талд
Боол тулгын
Өмнө л талд
Төөнө өвдөг газардуулаад ёслов.
Төтөл хар л
Толгой тонголзуулаад ёслов.
Өвдөг толгой газардуулаад ёслов.
Өнчин сүвээ махилзуулаад ёслов.
Өөдөөн иргээд суув л
Өдий төдий
Цагийн үе
Өнгөрч л байхад
Гунан Харбодон
Алхаад эргээд
Гараад явнаа.
Гунан хар
Хээр морин дээрээн
Хаян торолж мордоод
Алтууж мэргэн хааны
Алтанхөвч дагины
Алтан шил цонж л
Байшинг чиглээд
Гараад явнаа
Алтанхөвч л дагины
Алтан шил цонж л
Байшингийн үүдэн
Талд нь ирээд
Холби тусан
Буугаад явнаа

Гунан хар
Хээр морийг
Хад дамжуулаад
Хайр гишгүүлээд
Уяад явнаа л.
Алхаад эргээд
Ороод явахад
Алтанхөвч дагины
Тавин хүүхний ахлаач
Тамсаг улаан хүүхэн
Аагтай сайхан
Цайгийг л чанаж
Далан хүмэн
Дамжилдмаар том
Дангийн ногоон
Шаазанд л хийж
Эвтээ баривал
Эрхий дундуур
Чихээ баривал [=зөв баривал]
Чигчээ дундуур хийж
Бариад явнаа
Тавагтай идээгээн авч
Тавгий нь дүүргээд
Тавиад явнаа
Хорин найман хөлтэй
Хоймор талын
Ширээн дээр
Тавьж л жилэвкээд
Дараа талд нь
Алтанхөвч дагина
Гунан Харбодон
Тавин хүүхэн дахуултайгаан
Шагай, шатар, даамыг л
Тавьж наадаж

Жаргаад байхад
Арван таван хоногийн
Адаг өнгөрч л явтал
Алтууж мэргэн хаан
Гунан Харбодонг
Иржл цай уу
Гэдэг чимээн ирэв л.
Яаралгүй босоод
Ядалгүй хувцаслаад явнаа
Алхаад эргээд
Гараад явнаа
Гунан хар
Хээр морин дээрээн
Хаян торолж мордоод
Алтууж мэргэн хааны
Далай цагаан өргөөний
Үүдэн талд л ирж
Холби тусан буугаад
Гунан хар хээр морио
*Алтан шар морин*ы л
Хажуу талд л
Уян сүүдэрлүүлж хаяад
Алхаа эргээд
Ороод явнаа
Хаан сайхан аавынхаа
Хажуу талд л ирээд
Суудаг нь энэ билээ л
Аагтай сайхан цайг л
Чанаж хийгээд
Амттай сайхан
Алим өргийг
Алаглатал өрөөд явнаа
Авч л ид уу гэж
Шахаад явнаа

Дараа талд нь
Алтууж мэргэн хаан
Хайхираад хэлэв л:
Гунан Хар
Хээр морьтой
Гунан Харбодон
Алтанхөвч дагина
Та хоёрын хуримлах
Сарын сайныг
Сахиж хүлээгээд байхад
Болоод өнгөрөх л
Гэж байнаа
Өдрийн сайныг
Өнжиж л хүлээгээд байхад
Өлзийтэй сайн
Өдөр чинь болоод
Өнгөрөх гэж явнаа
Халиахаар минь
Хар нүдний минь
Цөцгий бологсон
Хар л ганц
Хүүхээрээн хамт л бид
Чиний далан
Долоон хар л
Уулд чинь хүрч нутагланаав
Долоон муж л
Албаттай чинь хамт
Нийлж нутагланаав.
Алтайн алаг
Балбуулжин улаан
Уулынхаа орой дээр
Есөн үетэй
Ендэр бариад
Алтанхөвч л дагина

Гунан Харбодон
Та хоёртой хамт л
Нүүгээд гарнаав гэв л.
Алтайнаа алаг
Балбуулжин улаан
Уулынаа орой дээр л
Есөн үетэй
Ендрийг бариад босгов.
Таван зүсэм
Малынхаа ясыг
Түлээд түлээд
Таван тансаг
Идээний дээжийг
Өргөөд өргөөд
Таван зүсэм малыг
Таван өнгийн
Хив хадгаар сэтэрлээв.
Алтайнаа алаг
Балбуулжин улаан
Уулдаан дархан
Тавьж туулав.
Дээжээн өргөж
Дэлхийгээ тахив.
Нүүгээд гарч л
Байнаав гэж шившээд
Алтайн алаг
Балбуулжин улаан
Уулынаав савдаг
Ардаас аварч өршөөгийт
Нүүгээд хүрч байгаа
Далан долоон
Хар л уулын савдаг
Өмнөөс өршөөж
Хайрлыт гэгээд

Дээжийг өргөлөөв.
Албат өргөн
Нутаг минь л ихдээд
Алтайн алаг
Балбалжин улаан
Уул нутаг минь
Багадаад нүүж
Байгаа хэрэг биш л
Энээ дунд
Замба тивийн
Хорон шүү нь ихдээд
Хортон дайсан
Олзолдоод байхад
Гунан Харбодон*гийн*
Далан долоон
Хар уулд л
Хүрч л нутаглanaaв.
Гунан Харбодон*той*
Хамт л нэг л
Газар нутагтъя
Гэж байнаав гэж мөргөөд
Хариу эргэж ороод
Адал мал цуглуулаад
Ачаа бараа дэглээд
Ачилганыхаа сайхан
Атан тэмээ
Уналганыхаа сайхан
Унаа хүлэг морийг Барин уяж л
Сойгоод явнаа
Түүнээ мангадарын
Өрүүн шар гэрлээр
Дэлэм дээс
Дэлтэрийн эсгий
Хаялгүй ачуулаад явнаа

Самнаатай даага
Сахалтай ишгэ
Хаялгүй туулгаад явнаа
Гунан Харбодон
Алтанхөвч дагина
Тавин хүүхэн дахуултайгаа
Далай цагаан өргөөгөөн
Зуун атан тэмээний
Борвиноос л өөдөөн
Бөхнөөөсий уруугаан
Ачаад явнаа
Эвэртэй жороо
*Хөх бор мори*йг л
Алтанхөвч дагина унаад
Зуун атан тэмээний
Хамар бурантагийг аваад
Түмэн албатынхаа түрүүнд
Урд өмнөх л амхаан
Цагаан хөтлийг
Чиглээд гарав л
Амхаан цагаан
Хөтлийг л даваад
Арвин шар л
Говийн өрийг
Гаталж л нүүлгээд явнаа
Арван хар
Гол болж л
Аргамжилж нүүлгээд
Таван хар
Гол бодоол
Тагнайлаад тасарч
Нүүлгээд явнаа
Хоо шар л
Хөтөл даваад

Хотгор шар
Хөдөөн өрийг л
Гаталж нүүлгээд явахад
Сайн арван
Таван хоногийн
Газар нүүлгээд явахад
Гунан бор
Цоохор морьтой
Хүчтэй Улаанбодон
Хөтөл-өндөр хааны
Олон муж л
Албатыг нүүлгээд
Хүрэлалтан
Дагиныг залаад
Бас л нүүлгээд
Очиж явав л
Гунан Харбодон
Хүчтэй Улаанбодон хоёр
Хоёр их гүрнийг нүүлгээд
Хоёр их хааны
Адал мал
Албат нутгийг
Хамт нийлүүлж нүүлгээд
Алтайн далан
Долоон хар л
Уулаа тэмцээд
Нүүлгээд гараад явнаа
Гурван ерэн есөн
Жилийн газрын
Буттайд нь үдэлж
Буулгаж нүүлгээд
Будантайд нь саатан
Сүүдэрлүүлж нүүлгээд явнаа
Хадтай газарт нь

Буугаад явнаа
Устайд нь буугаад
Өвстэйд нь өнжиж
Нүүлгээд явахад
Далан долоон
Хар л уулынхаа
Наахан талын
Амхаан цагаан хөтөлөөр нь
Арван хар л
Гол болон
Аргамжилж нүүлгээд
Таван хар
Гол болон
Тасартал нүүлгээд оров л
Нүүгээд ирж байгаа
Шинэ нутгийнхаа
Бүүр бүүрийг олж л
Буугаад явнаа
Нүүгээд ирсэн
Шинэ нутгийн малыг
Бэлчээр бэлчээрт нь
Тавиулаад явнаа.
Ар дараа нь
Довон Харбөх баатар
Луузан Тив хаан
Тэвэг Алтанбүс
Төмөрзүрхэн баатар
Талын Харбодон
Хүрэл-Арслан Магнай зургаа
Далай цагаан
Өргөөний баруун талд
Данхан хөх
Ширгийн өр л дунд ирээд
Хангай цагаан сумыг

9725. Харвaад тавихад
Хангай цагаан сумны
Хатгагдаад очсон газарт
Гунан Харбодон
Хүчтэй Улаанбодон хоёрын
9730. Ачааг өргөлцсөн
Зуун манхан тэмээг
Эргүүлж хэвтүүлээд
Ачаа барааг
Тайлаад явнаа
9735. **Гунан Харбодон**
Хүчтэй Улаанбодон хоёрын
Далан найман тэрэмтэй
Долоо найман
Зуун уньтай
9740. Далай цагаан өргөөг
Далбайж дүнхийтэл
Барьж байгуулаад явнаа
Алтууж мэргэн хааны
Далай цагаан өргөөг
9745. Далбааж дүнхийтэл
Байгуулж бариад явнаа
Дараа талд нь
Довон Харбөх баатрын хөвгүүдийн
Албат нутаг
9750. Шинэ гэрийн найр
Шинэ бэрийн найр
Хийнэ гэгээд
Далай болсон архи
Чигээг бэлтгээд
9755. Даранх болсон
Мах идээг
Бэлтгээд явнаа
Сарын сайныг

Саатаж хүлээгээд
Өдрийн сайныг
Өнжиж хүлээгээд явнаа.
Өлзийтэй сайн
Өдөр нь болоход
Нарийн шар
Бүрээгээн татаад явнаа.
Найман түмэндээ
Дохио чимээгээн
Өгөөд явнаа.
Урт шар бүрээгээн
Татан сунган
Үлээгээд явнаа
Олон түмэндээн
Дохио чимээгээн
Өгөөд байхад
Олон түмэн цуглараад явнаа
Агт гэдэг юман
Асага тогтоод байв л
Далай цагаан
Өргөө дотор
Бараа гэдэг нь
Багтаж ядан
Цуглараад явнаа.
Бага хар отгодууд нь
Багал [=сахал] хар өвгөчүүл
Саглайлдаад явнаа
Баадантай бэрэгчүүд нь
Зөрөлдөөд явнаа
Тогосын сүүл отгодууд нь
Саглайлдаад явна
Ар л талд
Уялга сайхан дуугаан
Дуулаад явнаа

Ут сайхан найрыгаан
Эхлээд явнаа
Тэр өдрийг
Тэсэн найрлаад явнаа
Тэр л шөнийг
Дөлөн найрлаад явахдаа
Амаргүйхэн сайн
Арван таван хоногийн
Адаг өнгөртөл
Найрлаад явнаа
Орох ын нарыг
Улаан [=жаргах] өнгөөр нь
Тэмдэглэж найрлаад
Гарах ын нарыг
Ганц цолмонгоор нь
Тэмдэглэж найрлах ад
Хүмэн эр
Хүлэг морины санаан амрав.
Хүмэн эр
Морин хүлгийн
Нуруун амрав.
Эр л хүний
Гар амрав.
Ирт зэвсгийн
Бариул амрав.
Найр наадам
Жаргал цэнгэлийн
Ард л ороод
Жаран жилийн
Жаргал хийгээд
Жаргалын ихээр
Жаргал сэргэлээ гүйцээгээд
Найрын ихээр наадан сууж
Найрлаад байв л.

Газрын хөвгүүн довон Харбох
Довон Харбөхийн хүү
Тэнгэрээс заяатай талын Харбодон
Талын Харбодонгийн хүү
Гунан Харбодон, Луузан Тив хаан,
Луузан тив хааны хүү
Гунан Улаанбодонгийн
Гурамсан тууль төгсөв.



Махагала

Цагаан шүхэрт

ЦАГААН ШҮХЭРТ СУДРЫН ТУХАЙ.

Монголын их эзэнт гүрний хаан төрийн нандин шүтээн. Цагаан шүхэрт сахиусыг монголчууд эртнээс шүтдэг байжээ. 1270 онд Хубилай хаан Пагва ламын зөвлөснөөр өөрийн ордондоо байдаг хаан ширээн дээрээ Цагаан шүхэртэй охин сахиусны цагаан шүхрийг Их Монгол улсын хааны ордонд мандуулан залжээ. Энэхүү цагаан шүхэр дээр зурмал алтаар санскрит үсгүүдийг дармаллан бичсэн гэнэ. Их охин сахиус Цагаан шүхэртэй нь Монголын Их эзэнт гүрний хаан төрийг сахин хамгаалахын бэлгэдлийг илэрхийлсэн гүн утга төгөлдөр сахиус нандин шүтээн болсон байна. Цагаан шүхэртэйн цогц бие нь ариун цагаан өнгөт олон мутар олон тэргүүнтэй бурхан эхийн дүртэй болой. Гол мутрын баруун мутар нь очир бариад, зүүн мутар нь урт бариултай, их цагаан шүхэр өргөжээ. Бэлхүүсээр ороосон уужим бэлхэмжийн доор түг түмэн амьтныг хумин дарсан дүрээр илэрмүй.

Бурхны номд өгүүлснээр хутагт хамаг түүнчлэн ирэгсдийн оройн уснирээс гарсан цагаан шүхэртэй Эх болбоос бусдад үл ялагдах их хариулагч гэрэл бадрангуй хэмээх ба их цагаан шүхрээ дэлгэсэн нь Самиягийн дүрсээр хамаг амьтан зургаан зүйлийг бүрхжээ. *Цагаан шүхэрт хэмээх бурхан эхийн цагаан шүхэр болбоос бурхан багш хамаг бурхан бодисунгийн өмнө ном номлох үе, Бурхан багшийн уснир орой зулай дээр Хүрдэн орчуулагч хааны хэлбэрээр хувилан илэрч, хамаг түүнчлэн ирэгсдийн уснир болж, ариун цагаан их нигүүлсэх үй асрахуйгаар дээд номын орныг бүрхэн зохиосон нь болой*[1] гэжээ.

Хутагт цагаан шүхэр (Аюуш гүүшийн орчуулга) ШУА-ийн Хэлзохиолын хүрээлэнгийн монгол номын сан хөмрөгт 6842 гэсэн дугаар бүхий 30.5x9 хэмжээтэй болгомол цаасан дээр хулсан үзэг, хар бэхээр бичсэн xutuγ-tu čaγan sikür гэдэг гарчигтай худма-монгол гар бичмэл судрын утга агуулга бүтцийн тухай өгүүлье. Энэ ном 24 хуудастай. Номын 1-р хуудас мөргөлийн шүлгээр эхлэнэ. Дараа нь номын Энэтхэг, Төвд, Монгол гарчиг бий. Судрын монгол нэр нь *Хутагт түүнчлэн ирэгсэний оройгоос гарсан Цагаан шүхэртэй бусдад үл ялагдах их эд хариулагч дээд бүтэгсэн нэрт тарни* гэжээ. 2-17 (а) тал д ад, хорлол арилгагч их сахиус тахих учрыг тодорхойлсон. Хутагт Цагаан шүхэрт тогтоол, тарнийн ачлал, увдисыг (17а-20б тал) дэлгэрүүлж,

1. Чойжи. Монголын бурхан шашны түүх I дэвтэр:283. II дэвтэр:284-285

- *Нэгэн өдрийн хижиг өвчин, хоёр өдрийн хижиг өвчин, гурван өдрийн хижиг өвчин, дөрвөн өдрийн хижиг өвчин, долоон өдрийн хижиг өвчин, насдын хижиг өвчин, хий, цөс, бадгана, хур, урхаг хижиг, хамаг өвчин, тархи өвдөхийг арилган соёрхох*
- *Бие өвдөх, хоолой зангирах, нүд, хүзүү, хамар ам, чих, шүд, зүрх, хавирга, нуруу, бэлхүүс, давсаг, чөмөг, жилбэг, шилбэ, гар, хөл, гишүү, үе өвдөх, элдэв хижиг өвчнөөс хамгаалж хариулга үйлдэж соёрхох*
- *Хор өгөгч мангас, илжирхий яр, өчүүхэн гөвдрүү, хулгана өвчин, үлд, боом, хатангир, харшлын өвчнүүдээс сахин хамгаалах*
- *Хилэнцэт хорхой, могой, солонго, арслан, бар, өнөг, бүга, гөрөөс, матар зэрэг амьтнаас сахин хамгаалж, цаг бусын үхлээс авран өршөөх болно гэжээ.*

Цагаан шүхэрт уншлага тарнийг цаас, бөс, модны хальсанд бичээд бие буюу хүзүүндээ зүүвээс сайн гэжээ. Энэ тарнийг бас нээн уншвал, уншуулбал гал, ус, мэсний хорлол хараал, цаг бусын зүүрдын үхлээс аврагдана. Ад, лусын хорлол, өвчин, харшлын хариулга болгож үйлдвэл Цагаан шүхэрт гэдэг Бусдад үл ялагдагч их харин хариулагч сайтар бүтсэн хэмээх тогтоол тарнийн ачлал үвдис энэ мөн гэжээ. 20б-24-р талд төгсгөлийн шүлэг бий. 20б талд:

Хамаг бурхан бодисадва нар ба тэнгэр хүн, тэнгэр бус хүн, үнэр идэштэн лугээ ертөнц дахин баясч, ялж төгс нөгчсөн бурхны зарлигийг илт магтав:: Хутагт хамаг түүнчлэн ирэгсэний оройгоос гарсан Цагаан шүхэртэй бусдад үл ялагдагч их эд хариулагч дээд бүтээгсэн нэрт тарни төгсөв: Аюуш гүүш орчуулав:: гэжээ.

Олон тарни агуулсан бурхны зарлигийн номлол энэ сургаалийг орчуулсан Аюуш гүүш бол XVI зууны үеийн монголхэлшинжлэлтэн, *Али-Гали* хэмээх монгол галиг үсгийн тогтолцоог боловсруулсан их дуун ухаанч, эрдэмтэн багш-лам мөн болов уу.

Зонхов Богдын зохиосон хутагт Цагаан шүхэрийн Төгсгөлийн шүлэг. Аюуш гүүшийн орчуулсан Хутагт Цагаан шүхэр номын 20б-24 талд сийрүүлэн бичсэн Зонхов богдын зохиож айлдсан төгсгөлийн шүлэг монгол хэлний бичгийн галигт буулгав. Энэхүү яруу шүлэг Хутагт цагаан шүхрийн агуулгыг өргөмжлөн шүлэглэж, эрхэмсэг соёрхлыг оршоон зарлигчлан хүндэтгэсэн магтаал, ерөөл болой. Уншигтун! Бишрэгтүн!

(20r) kijaγalal ügey luu-yin qan: labai qadaγalaγči luu-yin qan: yeke qara luu-yin qan: terigüten čaγ čaγ-tur qura oruγu-luγu: čaγ čaγ-tur egülen quriyaqu boluγad: čaγ čaγ-tur luus-un daγun-i γarγayu: qamuγ könügegdesen čaγ-tur burqan-i bilšilγan üiledjü

γurban-ta ögülegdekü buyu: qamuγ burqan bodisung nar ba: tngri kümün tngri busu unür idesiten lüge yirtinčü (20v) dakin bisirečü: ilaju tegüs nögčigsen burqan-u jarliγ-i ilete maγtabai:: qutuγtu tegünčilen iregsen-ü oroi-ača γaruγsan čaγan sikürtei busud-ta ülü ilaγdaγči yekede qariγuluγči degedü bütügsen nere-tü tegüsbe:: : :: ayisi guusi orčiγulba:

doluγan γoldi ilaγuγsan qutuγ-tan nügüd-iyer:
tunumal arvis tarni bariγči arsi eserun qurmusta:
doγsin aγula-yin köbegün selte qurical ügei-yin köbegün lüge
doluγan ijaγur ijaγur-tu arban sayibur oduγsan mahagala:
tedeger mörgükü-yin orun boluγsad-ta mörgüjü bürün: (21r)
tegünčilen iregsen-ü usiner-eče γaruγsan niγučas-un üges-i :
degedü boγda sayisiγan nöküd-tür-iyen jarliγ boluγsan:
tegüs čoγtu čaγan sikürtei eke-yi maγtabai :
ükül ügei erke-tü-yin emün-e deki nom-un ordu qarsi-dur :
uduriduγči šakiy-a-yin qaγan-u oroi-yin usner-eče :
öbesüben γaruγ=san simnus-un ijaγur-tur ülü ilaγdaqu:
öd ügei činadusun esergülügčid-i qariγuluγči:
busud-ta ülü ilaγdaqu čaγan sikürtei sidedebadari eken kemēn:
bükü γurban γajar-un mandal-dur oγuγata aldarsiγsan:
bürin=e γurban čaγ-un qamuγ ilaγuγsad-un γaγčakü eke :
(21v) bökeyijü mörgümü ilaju tegüs nögčigsen eke bi čimadur::
ada todqar terigüten grag odod-un qoor-ača
ayul kiged čaγ busu-yin ükül nigültü maγui jegüden-i ba:
aliba qoor mese γal usun-u qoor-a kiged:
amurliγuluγči eke čimadur-iyan qočorli ügei mörgümü:
bey-e-yin mandal činü aqui yekede:
barasi ügei olan düri-tü mingγan toγatan terigütü:
badarangγui belges-i bariγsan tegüs mingγan mutur-tu:
ba bürün γurban γajar-un mandal büküi-yi ejelegsen::
γadaγadu qorin qoγar mutur-un čiγulγan terigüten:
γadangγui qoor-tan-i nomuqadqaqui üiles-tür törbel ügei:
qara jüg-ün (22r) ayimaγ nügüd-i tobraγ bolγaγči:
γayiqamsiγ arvis tarni-tu ükin tngri-yin čiγulγandur mörgümü::
čaγ busu-yin ükül kiged ebečin-ü ayul terigüten :
čaγ busu-un kümün ba kümün busu irged-i ayuγulbasu-bar:
čamayi yuγan duraduγad itegel yabuγulbasu-bar:
čaγlasi ügei čiber qamuγ ayul-ača nasuda sakin soyurq-a:
tngri luus asuri ner nügüd selte kiged:

tedürü yeke ada čoγ jibqulang öngge čarai
tegünčilen umai ba: miq-a čisun idegči bügüdeger-i:
deged čimayi duraduγsan-u tedüiken-iyer qariγul-un soyurq-a::
ilaju tegüs čaγan sikürtei-yin burqan-u : (22v) čiγulγan nuγud: törbel ügei auγ-u küčütü boluγad : nigülesküi-ber irügel-ün küčün batuddaγ=san-i : bibei jalbariγsan=čilan : burqan-u sasin delgere=kü kiged : qamuγ amitan amuγulang-tu boltuγai :: siltaγan barilduγsan öglige-yin ejen nökür seltes-ün : yeke doγsin aγul-i qariγulun soyurq-a :: maγui jegüden maγui yoru-a-yi qarigul : maγui belge lüge sitün barilduγsan-i qariγul : dayisun čödkür-ün maγu sanaγan-u barildulγ-a-yi qariγul : naγan dörben maγu yoru-a-yi qariγul : γurban jaγun jiran sedkil buliyaγči-yi qariγul : dörben jaγun dörben ebedčin-ü jüil-i qariγul: (23r) naγan mingγan toγ- a- tu todqur-un jüil-i qariγul :γurban jaγun jiran adas-un jüil-i qariγul : nilqas-un arban tabun yeke ada-yi qariγul : čaγ busu-yin naiman jüil-ün ükül-i qariγul : deger-eče simnus ködelküi-yi qariγul : door-a-ača buγ bosqui-yi qariγul: qaγačaγuluγči erlig-üd nögčiküi-yi qariγul : ečige ebüge-yin ükeger-ün buγ ködelküi-yi qariγul : kumün-dür ebedčin bolqui-yi qariγul : mal-dur čamsiγ bolqui-yi qariγul : oγtarγui-ača kejig γamsiγ tügeküi-yi qariγul : γajar-un qoortu sumun ködelküi-yi qariγul : mengge saγudal maγu bolqui-yi qariγul : todqar kiged qokiraγuluγči buγ bosqui-yi qariγul : qarsi-yin siltaγan jidker bükün-i : (23v) qariγul : sayin čiγulγan bükün-i delgergül-ün soyurq-a ::
ülü boltuγai doγsin aburi-tu arad-ber :
öber busud-un sayin-i buliγči arvis tarnis-un čiγulγan-iyar :
oγtaluγad badaranγui γadasun-iyar
qočurli ügegüy-e üdter böged qadaqu üiles jokiyan soyurq-a::
quriya=basu ilaγuγči eke niγučas-un čiγulγan-iyar:
qutuγ γuγuju enerin jalbariγsan-iyar:
qurdun-a maγui siltaγan bügüde-yi ügei bolγaju ele :
qočurli ügei sayin siltaγan-i sedkigsen yosuγar bütügen soyurq-a :
sayibur (24r) oduγsad-un usner-eče γaruγsan čaγan sikür-tei: ükin tngri kemen:
saγataγuluγči ada todqar büdiner-ün čiγulγan-i:
sandaraγulun ünesün tobraq bolγaγči čoγ jibqulang-tu eke :
šakimuni burqan-u sasin-i masi sayitur delgeregülün soyurq-a : manγalam
/Төвдөч Б.Няммягмар галигчлав./

Аюуш гуушийн орчуулгын төгсгөлийн шүлэг нь Ойрадын Зая бандидын орчуулгаас дэлгэрэнгүй юм. Доорх и 40 мөр шүлэг тод-монгол хувилбарт байх гүй.

Ялж төгс цагаан шүхэртэй бурхны чуулганууд:
Төрбэл үгүй ауга хүчит болоод нигүүлсэхүй бээр:

Өрөөлийн хүчин батадсныг: Би бээр залбирагсанчилан:
Бурхны шишин дэлгэрэх хийгээд:
Хамаг амьтан амугуулант болтугай:
Шалтгаан барилдагсан өглөгийн эзэн нөхөр сэлтэсийн:
Их догшин шоулыг хариулан соёрхо:
Муу зүүдэн муу ёрыг хариул:
Муу бэлгэ лүгээ шүтэн барилдсаныг хариул:
Дайсан чөтгөрийн муу санааны барилдалгыг хариул:
Наян дөрвөн муу ёрыг хариул:
Гурван зуун жаран сэтгэл булаагчийг хариул:
Нялхсын арван таван их адыг хариул:
Цаг бусын найман зүйлийн үхлийг хариул:
Дээрээ шимнус хөдөлхийг хариул:
Доороос буг босохыг хариул:
Хагацуулагч эрлэгүүд нөгчихүйг хариул:
Эцэг өвгийн үхээрийн буг хөдөлхийг хариул:
Хүмүнд өвчин болохыг хариул:
Малд гамшиг болохыг хариул:
Огторгуйгаас хижиг гамшиг түгээхийг хариул:
Газрын хорт суман хөдөлхийг хариул:
Мэнгэ суудал муу болохыг хариул:
Тодхор хийгээд хохируулагч буг болохыг хариул:
Харшийн шалтгаан зэтгэр бүхнийг хариул:
Сайн чуулган бүхнийг дэлгэрүүлэн соёрхо::
Үл болтугай догшин авирт араат бээр:
Өөр бусдын сайныг баригч арвис тарнийн чуулганаар:
Оттолгоод бадрангуй гадсаар
Хоцрол үгээгүү яа үтэр бөгөөд
Хадах үйлс зохион соёрхо::
Хураавасу илагун эх нууцсын чуулганаар:
Хутуг гуйж энэрэн залбирсанаар:
Хурданаа муу шалттаан бүгдийг үгүй болгож элэ:
Хоцролгүй сайн шалтгааны сэтгэсэн ёсоор бүтээн соёрхо:
Сайбур одогсдын усниээр гарсан Цагаан шүхэртэй:

Үхин тэнгэр тэнгэр хэмээн:
Саатуулагч ад тодхор бүдинэрийн чуулганыг:
Сандруулан үнсэн товрог болгогч цог жавхлант эх:
40. Шакимуни бурхны шашныг маш сайтар дэлгэрүүлэн соёрхо:
Мангалам

Хутагт цагаан шүхэрт хэмээх оршив. (Ойрадын Зая бандида Намхайжамцын орчуулга) Алтайн урианхай-туульчид Талын Харбодон туулийг нэг удаа хайлан өгүүлэхэд Цагаан шүхэртийн тогтоол тарнийг гурван удаа уншиж, уншуулсантай тэнцэнэ хэмээн сүсэглэн биширч, төвд, тод-монгол бичмэл, барын Цагаан шүхэрт судрыг гэртээ тахидаг уламжлалтай байжээ. Ойрад-монголчууд тод-монгол бичгийн Цагаан шүхэртийг монгол хэлээрээ уншиж, уг номын утга учрыг сайн мэддэг юм. Бас айл гэрийн арван цагаан буян энх амгаланг сахин хамгаалахын бэлгэдлийг илэрхийлсэн ид шидэт бурхан Цагаан шүхэр барьсан охин сахиус бол хүн амьтныг энэрэн тэтгэхийн бэлгэдэл хэмээн гэрийн хоймортоой залж тахин шүтэж байжээ. Ойрад-монголчуудын сүм хийд нэг бүрт Ойрад Намхайжамцын орчуулсан сайн бүхний эх үүсвэр гэгээрэхүй нигүүлсэхүйн бэлгэдэл бүхнийг гэтэлгэгч тод-монгол Цагаан шүхэрт судар байжээ. Энд хавсаргасан тод-монгол гар бичмэл Цагаан шүхэрт судар бол 1778 онд тогтоосон Дашгүнчинлэн хутагтын гэгээн Намхайжамцын хүрээний шүтээн буюу одоогийн Ховд аймгийн Манхан сумын Цагаан бадма хийдийн хамба лам Ядамжавын ном.

Намхайжамцын XVII зууны эхээр орчуулж, өөрийн зохиосон тод-монгол үсгээр бичиж түгээсэн *Бурхан багшийн дээд үсниргэс бүтээсэн Бусдад үл ялагдагч их харин хариулагч сайтар бүтсэн Хутагт Цагаан шүхэрт* гэдэг бурханы сургаал зохиол нь агуулгаараа урианхайн Талын Харбодон туультай адил. Намхайжамцын орчуулсан Цагаан шүхэрт судар дөрвөн үндсэн хэсэгтэй.

Эхний дөрвөн хуудсанд Хурмастаар ахлуулсан 33 тэнгэр, бас бус олон олон тэнгэр, бурхдад залбирч зөвөөр *ажс төрөх өд* өршөөл, хайраа ивээн соёрхож туслахыг гуйж наминчилжээ. Цагаан шүхэртийн алдарт ерөөл, уншлага, номлолыг монгол хэлээрээ дахин дахин уншсаны сүүлд хүмүүн төрөлхтөнд тохиолддог зовлонг хэрхэн гэтэлж, сэтгэлийн амар амгаланг бүтээх увдис төгс хариулга ерөөл, уншлагын учир утгыг ухаардаг. Мөн "Хамаг амьтан, ялангуяа хүмүний төрөлхтөн жаргалыг хүсдэг, өвчин зовлон

хүсдэггүйд л гол учир байгаа юм" гэж айлдсан сургаал номлол сэтгэлийг гэмддэг гэсэн номлолтой. Яагаад гэвэл Бурхан багшийн суурь сургаалд Хутагтын дөрвөн үнэн:

- Зовлон байна
- Зовлонгийн шалтгаан байна
- Зовлонг таслан зогсоох боломж байна
- Зовлонг гэтлэх зам мөр байна гэжээ. Өөртөө ба гэр бүл, амьдрал ахуйдаа тохиолдсон, тохиолдож болох бэрхшээлийг таслан зогсоох, зовлонг гэтлэх зам мөрийг зөв сонгож амар амгалангаар амьдрахын төлөө гэмээ арилгах ёстой юм гэдгийг урианхай хүмүүс ухаарч Талын Харбодон тууль хайлуулж, Цагаан шүхэрт судрыг монгол хэлээрээ уншиж, уншуулдаг гэнэ.

Өвчин, үхэл, хорлол, хорын аюул, ад зовлон, хорт сэтгэлийн аюул адын хорлолоос зуун жил, зуун намар сахин хамгаалж өршөөхийг 33 тэнгэрийн орноос гуйжээ. Гучин гурван тэнгэрийн орон гэдэг нь Сүмбэр уулын дээр орших эдийн найман тэнгэр,догшин арван тэнгэр,арван хоёр нар,тагаржибү хоёр лүгээ тэнгэрийн эрхэт гучин хоёр бөгөөд хурмаст тэнгэрийг оруулаад нийт гучин гурван тэнгэр нарын наадан цэнгэх (Ө.Бүрнээ нар.,2004.130) орон.

Тод-монгол бичгийн Цагаан шүхэрт монгол судрын 14б-17-р талд Зовлонгийн үнэнийг өөртөө шингээсэн Оршихуйн гурван шинж чанарын эхнийх нь гэж сургадаг, мөнх бус ,зуурдын үхлээр амь алдаж болзошгүй элдэв өвчиний аюулт зовлонгоос урьдчилан сэргийлэн хамгаалж Өршөөхийн мөр үүсгэхийг гуйсан ерөөл,тарниуд байна. Бас үр сад хүсэгчид, Луун дуу дуурсхаж тэнгэрээс хур бороо гуйгчид ,хамаг хор хөнөл хөнөөлөөс зайлсхийж амарлин ахуйг хүсэгчид бурхан юугаан сэтгэн бодож харин хариулагч Ухаан тарнийн хатан Цагаан шүхэрт судрыг гүнээ сүсэглэж бишрэн уншиж, уншуул гэжээ.

Хилэнцэт хорхой, могой, солонго, арслан, бар, өтөг, буга, гөрөөс, матар зэрэг амьтнаас сахин хамгаалж цаг бусын үхлээс авран өршөөхийн хариулга гуйж унших арвис тарни, Энэ уншлага тарнийг цаас, бөс, модны хальсанд бичээд бие буюу хүзүүндээ зүүвээс сайн гэжээ. Энэ тарнийг нээн уншвал, уншуулбал гал, ус, мэсний хорлол хараал, цаг бусын зуурдын үхлээс аврагдана. Энэ бүх үйлдлийг завсаргүй таван удаа хариулга болгож үйлдвэл Цагаан шүхэрт гэдэг бусдад үл ялагдагч их харин хариулагч сайтар бүтсэн хэмээх тогтоолын ачлал увидас энэ мөн гэжээ.

Судрын дөрөвдүгээр хэсэг нь хоёр зүйл төгөсгөлийн шүлэг болно. Нэгдүгээр шүлэг 60 гаруй мөр. Энэ нь Цагаан шүхэртийн тухай Богд Зонховын яруу сайхан соёрхлын магтаал. Хоёрдугаар Ба-толгойт үсгээр эхэлсэн дөрвөн мөр шүлэг бол бурхны шашны тойн Ойрадын Зая бандида Намхайжамц Цагаан шүхэрт судрыг төвд хэлнээс ойрад-монголын хэлэнд орчуулсан тухайгаа зохиож айлдсан төгсгөлийн шүлэг болно.

Зонхов Богдын айлдсан төгсгөлийн магтаал шүлэг (Ойрад аялгуугаар) Цагаан шүхэрт судрын ерөөл, уншлага, тарниудыг Илагун төгсгөсний уснир дотроос, Тэгүнчлэн бологсоны уснираас гаргасан, Сайбээр орогсны уснираас гаргасан гэх буюу Бурхан багшийн Дээд уснирийн бэлгээс бологсон хэмээн тодорхойлжээ. Судрат өгүүлсэн олон тарни нь алив хүсэл санааг дом шившлэгийн хүчээр бүтээгч, муу бүгдээс аврах, хамгаалах, сэтгэлийн мөн чанарыг анагаан арилгаж тэтгэх хүч, увидастай тарни сэтгэлийг ивээгч уншлага байна. Зөвхөн самгарди хэлээр л номлодог заавар сургаалтай эдгээр тарни нь их гэрэл гаргаж олон амьтныг зовлонгийн аюулаас ангижруулж хүслийг бүтээхэд зориулсан номын (үгийн) шившлэг гэнэ.

Оюун ухаан, эрдэм мэдлэг цогцолсон ухааны (=арвис) тарни, тогтсон тарни, нууц тарни гээд эдгээр тарнийг Бурхан багшийн тэргүүний зулайн туг үсний (Дээд уснирын) бэлгээр бүтсэн хэмээн хүндэлж дээдлэн номлодог гэнэ.

Увс аймгийн Бөхмөрөн сумын туульчин-лам Цагаадайн Зодов Цагаан шүхэртийг гурвантаа уншин сонсгоход Луун дуу дуурсч, огторгуйд цахилгаан үе үе гялавхийн үүлний шим, аршааны хур асгаран бууж, эрт цагт Бурхан багшийг мэндлэхэд анх дэлбээлсэн хамаг өвчнийг анагаагч шимтэй, шуламсыг дарагч Удамбар, Тэнгэрийн цэцэг (=голт бор), угаалын гүш өвс баясан цэцэглэдэг юм гэж багш лам минь надад сургаж айлдсан юм. Ийнхүү би туулиа эхлэх, төгсгөхдөө Цагаан шүхэртийн ерөөлийг шившдэг гэжээ.

Цастын Мэргэдийн оройн чимэг Богд Зонхова багш Цагаан шүхэрт судрын ач тусыг айлдан шүлэглэсэн магтаалыг төвд хэлнээс монгол хэлэнд Намхайжамц хутагтын яруу сайхан орчуулсныг соёрхон цэжилэн, уншиж тогтооно уу.

Долоон голди [=арван сая живаа] *илагүгсад хийгээд*
Хутагт нөхөд

Ухаан тарни баригч арши хийгээд
Эсрүн хурмастан:
Догшин изуурт хөвүүн хийгээд
Баха үхэйн [=quričal ügei-yin] хөвүүн төгс сайн харин
Долоон изуур арван
Сайбээр одогсон:
Мөргөхү зохист нүгүүдад сүзүлүн мөргөөд
Сайбээр одогсоны үсниraac [=толгойн үс, гэзэг]
Нууц тарнийн үг гаран:
Хэн магтахуй нөхдөд зарлиг бологсон
Цогт Цагаан шүхэртийг магтан үйлдмүй::
Үхэл үгүйн эрхтийн өмнөд номын сайн оронд
Шакяан хааны дээд бэлгэ үсниraac сайтар гаран:
Шумнушийн аймаг үл чадан
Чинад хамаг эсрэгцэгсэнийг
Харин харицулан:
Бусдад үл ялагдагч
Цагаан шүхэрт хэмээн:
Гурван газар бүгдэд огоот
Түгээмэл алдаршсан
Гурван цагийн хамаг илагүгсдын ганц эх
Илагүн төгсөгсөн чамд мөргөмүй:: Би:
Над хийгээд явахуй одон гаригийн
Цаг бусын үхэл хийгээд
Хилэнцэт зүүдэн хорон мэс хийгээд
Гал усны хор тэргүүтнийг
Хоцролгүй амурлиулан:
Үйлдэгч чамд мөргөмүй::
Биеийн мандлын эн аугаа маш өргөн:
Олон адагтай мянган тэргүүн хийгээд:
Бадрангүй мутрын бэлгэ төгсөгсөн
Мянган гарт гурван газрын
Мандал бүгдэд
Эрхшин үйлдэгч их хүчит тэргүүтэн

Хорин хоёр нөхөд
Хортныг номхтгохуй үйлэд түрбил үгүй:
Харын аймгийг тоосон болгон үйлдэгч
Ухаан тарнийн
Охин тэнгэрийн чуулганд мөргөмүй:
Цаг бусын үхэл хийгээд өвчний аюул тэргүүтэн:
Хүмүүн хийгээд хүмүн бус:
Буаднэрийн [чөтгөр шулам, хүн бусын адууд] *үүсгэсэн аюул санаж:*
Чамайг ивээл барих улаа:
Хамаг аюулаас насад сахин соёрх:
Тэнгэр Луу Асури тэргүүтэн:
Их аднууд хийгээд:
Цог заль өнгө булаан:
Умай хийгээд мах цус идэгч бүхний чинь
Гэгээний санагсаны төдүйд аялан соёрх::
Бидний сайн амгуулан булаахуй хэнтэгт:
Төрөлхтний ухаан тарни тэргүүтнийг
Амьтны үүднээ: хоцролгүй таслан
Бадрангүй гадсаар тэднүүдэд шаамуй
Үйл үйлд::
Товчилх улаа мутрын чуулган
Илагүн төгсөгсөн эх:
Чамайг ивээн барин үйлдэхүй
Энэ хоосныг айлдаж
Хагацахын шалтгаан бүгдийг амурлиулан
Зохилдохын шалтгааныг хоцрол үгүй
Сэтгэгсээр бүтээн үйлд::
Сайбээр одогсоны үсииураас гарсан
Цагаан шүхэрт охин тэнгэр хүмүүн
Ад томгорын аймаг буаднэрийн чуулган лугаа
Сэлтэс хамаг хумаг болгон
Шилэвхэхүй цог зальт
Илагүн төгсөгсөн эх чи
Чидагчийн шажныг дэлгэрүүлэн үйлд: : ::

Ойрадын Зая бандида Намхайжамцын зохиосон төгсгөлийн ерөөл

Бурхан багшийн дээд усниришн бэлгээс бологсон
Бусдад ул ялагдагч Цагаан шух эртийн тогтоол үүнийг
Бусдын тул Пэча (бэча) билигийн
Надун(нидун) хэрэглэгч Бат мөнх тайж дурдсанд
Бурханы шакиян (Sakya-yin) тойно Раб-жам за-яа Бандида орчуулвай: Энэ буянаар Зонкаба-ийн шажин арван зуг дэлгэртүгэй:

Энэ төгсгөлийн шүлгээс арай дэлгэрэнгүй, Намхайжамцын зохиож айлдсан өөр хувилбар:

Бурхан багшийн дээд усншийн бэлгээс бологсон:
Буруу ад тодх ор зовлон нисванис бүх нийг амурлиулан:
Буян хувь төгсөгсөдийн дээд бодх и эрдэм өргөжүүлэн:
Бнуди-нуудад ул чадагч Цагаан шух эртийн тогтоол үүнийг:
Балай олон галавт хурагсан буяны аугa хүчинээр:
Барамидын шутээн бие олж баатаруудын манлай болон:
Бат сүзүг төгсөгсөн шажиныг баригч
Хөндлөн Убашийн зургадугаар хөвүүн:
Панча билигийн нүд хэрэглэгч
Батмөнх тайж дурдагсанд:
Аривн сүзүгт
Ад томх ороос гэтлэн:
Ашид хэрэгт арга билигийн хөлгөнийг олож:
Аряа бурханы хутаг олохын тул:
Аяха тахимлиг Зая бандида
Цэрэн Рабжимба найруулан орчуулавай:
Ариш Зонхабын шажин:
Арван зүгт дэлгэртүгэй энэ буянаар .:..:.гэжээ.

Цогт Цагаан шух эрт сургаалыг ойрад-монголын улс төр, соёлын зүтгэлтэн, дөрвөд Хөндлөн Убашийн 6-р хүү Батмөнх тайжийн хүсэлтээр Намхайжамц орчуулж, Бурхан Зонхавын шажин омог нийт монгол хэлтэнд дэлгэрүүлэх ийг дээдлэн ерөөжээ.

☯ Арван гурван сан оршив.

Ом аа хум. [Гурвантаа өгүүл].
Арван зүгийн хамаг лам нар ирэн соёрх:
Арван зүгийн хамаг бурхнууд ирэн соёрх:
Арван зүгийн хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Арван зүгийн хамаг хутагт хуврагууд ирэн соёрх:
Арван зүгийн хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Арван зүгийн хамаг заяач нар ирэн соёрх:
Арван зүгийн хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Арван зүгийн хамаг сахиус нар ирэн соёрх:
Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Гурван цагийн хамаг лам нар ирэн соёрх:
Гурван цагийн хамаг бурхнууд ирэн соёрх:
Гурван цагийн хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Гурван цагийн хамаг хутагт хуврагууд ирэн соёрх:
Гурван цагийн хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Гурван цагийн хамаг заяач нар ирэн соёрх:
Гурван цагийн хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Гурван цагийн хамаг сахиус нар ирэн соёрх:
Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Дөрвөн зүгийн хамаг лам нар ирэн соёрх:
Дөрвөн зүгийн хамаг бурхнууд ирэн соёрх:
Дөрвөн зүгийн хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Дөрвөн зүгийн хамаг хутагт хуврагууд ирэн соёрх:
Дөрвөн зүгийн хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Дөрвөн зүгийн хамаг заяач нар ирэн соёрх:
Дөрвөн зүгийн хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Дөрвөн зүгийн хамаг сахиус нар ирэн соёрх:
Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Найман хүллийн хамаг лам нар ирэн соёрх:
Найман хүллийн хамаг бурхан нугууд ирэн соёрх:
Найман хүллийн хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Найман хүллийн хамаг хутагт хуврагууд ирэн соёрх:

Найман хүллийн хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Найман хүллийн хамаг заяач нар ирэн соёрх:
Найман хүллийн хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Найман хүллийн хамаг сахиус нар ирэн соёрх:
Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Арван хоёр жилийн хамаг лам нар ирэн соёрх:
Арван хоёр жилийн хамаг бурхнууд ирэн соёрх:
Арван хоёр жилийн хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Арван хоёр жилийн хамаг хутагт хувраггууд ирэн соёрх:
Арван хоёр жилийн хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Арван хоёр жилийн хамаг заяач нар ирэн соёрх:
Арван хоёр жилийн хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Арван хоёр жилийн хамаг сахиус нар ирэн соёрх:
Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Жаран өнгийн хамаг лам нар ирэн соёрх:
Жаран өнгийн хамаг бурхнууд ирэн соёрх:
Жаран өнгийн хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Жаран өнгийн хамаг хутагт хувраггууд ирэн соёрх:
Жаран өнгийн хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Жаран өнгийн хамаг заяач нар ирэн соёрх:
Жаран өнгийн хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Жаран йнгийн хамаг сахиус нар ирэн соёрх:
Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Есөн мэнгэний хамаг лам нар ирэн соёрх:
Есөн мэнгэний хамаг бурхнууд ирэн соёрх:
Есөн мэнгэний хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Есөн мэнгэний хамаг хутагт хувраггууд ирэн соёрх:
Есөн мэнгэний хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Есөн мэнгэний хамаг заяач нар ирэн соёрх:
Есөн мэнгэний хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Есөн мэнгэний хамаг сахиус нар ирэн соёрх:
Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Долоон одны хамаг лам нар ирэн соёрх:
Долоон одны хамаг бурхнууд ирэн соёрх:

Долоон одны хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Долоон одны хамаг хутагт хуврагууд ирэн соёрх:
Долоон одны хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Долоон одны хамаг заяач нар ирэн соёрх:
Долоон одны хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Долоон одны хамаг сахиус нар ирэн соёрх:

Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:

Хийморийн хамаг лам нар ирэн соёрх:
Хийморийн хамаг бурхнууд ирэн соёрх:
Хийморийн хамаг билиг бирамидын шашин номууд ирэн соёрх:
Хийморийн хамаг хутагт хуврагууд ирэн соёрх:
Хийморийн хамаг тэнгэр нэр ирэн соёрх:
Хийморийн хамаг заяач нар ирэн соёрх:
Хийморийн хамаг лусын хаад нар ирэн соёрх:
Хийморийн хамаг сахиус нар ирэн соёрх:

Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:

Барс жилтний заяа Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Туулай жилтний заяа Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Луу жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Могой жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Морь жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Хонь жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Бичин жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Тахиа жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Нохой жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Гахай жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Хулгана жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Үхэр жилтний Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:

Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:

Арван хоёр жилийн заяа Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Арван хоёр сарын заяа Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Арван хоёр өдрийн заяа Сахиусан тэнгэр бурхан энэ өдөр ирэн соёрх:
Өдөр шөнийн арван хоёр цаг сахигч энэ өдөр ирэн соёрх:

Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:

Хий ри лам нар аа
Хамаг лам нарт ариун тахилаар тахимуй:
Хамаг бурхнуудад ариун тахилаар тахимуй:
Хамаг билиг бирамидын шашин номуудад ариун тахилаар тахимуй:
Хамаг хутагт хуврагуудад ариун тахилаар тахимуй:
Хамаг тэнгэр нэрт ариун тахилаар тахимуй:
Хамаг заяач нарт ариун тахилаар тахимуй:
Хамаг лусын хаанд ариун тахилаар тахимуй:
Хамаг итгэл номын сахиусанд ариун тахилаар тахимуй:
    Ом аа хум. Энэ ариун тахилыг амсан соёрх:
Энэ ариун тахилуудыг хамаг лам нар ихэд тахимуй::
Энэ тахилуудыг Шакьямуни бурхнууд хамаг бурхад ихэд тахимуй:
Энэ тахилуудыг билиг бирамидын шашин номуудад ихэд тахимуй:
Энэ тахилуудыг хутагт хуврагт ихэд тахимуй:
Энэ тахилуудыг Эсрүн хурмаст тэнгэр нэр ихэд тахимуй:
Энэ тахилуудыг Цагаан өвгөн тэргүүтэн хамаг заяач ихэд тахимуй:
Энэ тахилуудыг Анабад лусын хаад тэргүүтэн хамаг лусууд ихэд тахимуй:
Энэ тахилуудыг итгэл номын сахиус ихэд тахимуй:
Энэ ариун тахил зооглон соёрх:
    Ом аа хум.
Лам, ядам, сахиус бүгдээр энэ аугаа их ариун дээд тахил аваад
Егүзэр, багш, шавь, нөхөд хийгээд
Үүтгэл үгүй жавхлант биеийн хишиг өгөн соёрх:
    Хуруй хуруй хуруй:
Жаран үет зарлигийн хишиг өгөн соёрх:
    Хуруй хуруй хуруй:
Хязгаараас хагацсан хир үгүй зүрхний хишиг өгөн соёрх:
    Хуруй хуруй хуруй:
Ялгуусны бие зарлиг зүрхний хишиг өгөн соёрх:
    Хуруй хуруй хуруй:
Насны үйл дэлгэрүүлэгч үхэлгүй насны хишиг өгөн соёрх:
    Хуруй хуруй хуруй:
Амитаба бурхны хишиг өгөн соёрх:
    Хуруй хуруй хуруй:

Далайд их дагинасын хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Амт төгс идээ ундааны хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Өмсөх зүүхэд сайхан зөөлөн хувцасны хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Бэх бат хуяг хийгээд хурц болд мэсний хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Барс саадаг хийгээд тас өдөт сумны хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Арбас хуумагч бөх хүчит нумны хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Өмсөх зүүхэд сайхан алт, мөнгөн эд тавaар эрдэнийн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Өлзийт бат эмээл хазаарын хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Хүчит бат зэмсгийн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Их хүчит хурдан морины хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Хүчит баатрын хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Өнгө төгс баясгалан нөхрийн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Аугаа сайхан дуут нохойн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Өвчин, ад тотгор, чөтгөр, зэтгэр, шимнус, хортон дайсныг амруулан дарагч адистидийн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Их амгалангийн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Алтан хийд хийгээд арван зүгийн лам, бурхан, номын хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Гурван ертөнцийг эрхэт харвагч хатуу их хүчний хишиг өгөн соёрх:

Хуруй хуруй хуруй:
Чухал хураах хүчний хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Гоо үзэсгэлэнт биеийн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Сонсох сайхан дууны хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Хоёр хөлт хүний хишиг йгйн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Дөрвөн хөлт малын хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Үргэлж рашааны усаар ханах хишиг йгйн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Дөрвөн сүрэг адуусны хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Дэл ихт азарганы, дэлэн ихт гүүний хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Төгрөг эвэрт цагаан хуц бэр дунлай хонины хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Бугалаг дуу ихт бухны хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Төгрөг эвэрт дун цагаан шүдэт дэлэн ихт үнээний хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Зогдор ихт буур, төлгөн тэмээний хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Төгс өлзийн хутгийн хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Түүрвэл үгүй дөрвөн хошуу малын хишиг өгөн соёрх:
Хуруй хуруй хуруй:
Дар лам нарт мөргөн залбирмуй:
Хамаг ламын өлзий хутаг орштугай:
Шакяамуни бурханд мөргөн залбирмуй:
Хамаг бурхнуудын өлзий хутаг орших болтугай:
Хамаг билиг бирамидын шашин номд мөргөн залбирмуй:

Хамаг шашин номын өлзий хутаг орших болтугай:
Хамаг Эсрүн хурмаст тэнгэрт мөргөн залбирмуй:
Хамаг тэнгэрийн өлзий хутаг орших болтугай:
Цагаан өвгөнд мөргөн залбирмуй:
Хамаг лусын хаадын өлзий хутаг орших болтугай:
Хүсэл хангагч чандманий өлзий хутаг орших болтугай:
Хотол төгссөн бурхдын өлзий хутаг бат орших болтугай:
Ом ма ни пад мэ хум.
Сарва мангалам.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

УРИАНХАЙ ТҮМНИЙ БИЧГИЙН СОЁЛ

Урианхай хэл аялгуу судалсан туршлага. Урианхай нь дээр цагаас Алтай, Тагнын уулаар нутаглаж байгаад XVII зууны эцсээр зарим нь Манжид дагаар орж одоогийн монгол нутагт суурьшжээ. Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан сумын урианхай, Баян-Өлгий аймгийн Булган, Алтай, Алтанцөгц, Сагсайн зарим нутгийн урианхайг монгол судлалын бичиг зохиолд Алтайн урианхай гэж тэмдэглэх болов.

Монголын түүх соёлын дурсгалт бичигт XII-XII зууны заагийн ойн урианхад, жарчиуд аданхан уранхан, түрэг угсааны монголжсон алтай урианхай гэсэн урианхан, урианхай хэмээх хоёр нэр гардаг. Эдний ойн урианхад, аданхан урианхан нь язгуурын монгол овог аймаг, XIII зууны үед, их гүрний бүрэлдэхүүнд яваад сүүлд феодлын бутралын үед монголын зургаан түмний нэгэнд багтав. Одоо Монгол улсын нутагт өөрсдийгөө урианхан, урианхай гэдэг хоёр хэсэг хүмүүс байна. Урианхан нь тус улсын Ховд, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Дорнод зэрэг аймгийн халх, хасаг нартай хамт оршин суудаг. Эднийг их урианхан, бага урианхан, аданхан урианхан, урианхан гэж ялгадаг халх-урианхайчууд болно. Урианхан нь монголын түүх дурсгалын бичигт X зууны үеэс тэмдэглэгдсэн эртний монгол аймгийн нэг.

Алтайн урианхай бол монгол-ойрадын нэгэн салбар аман аялгуутан болно. Ховдын монгол урианхай нь Дөрвөд, Торгууд, Захчин салбар аман аялгуунаас авиа зүй, үгийн сангийн хувьд онц ялгаагүй. Харин хэлзүйн хувьд ойрадын бусад салбар аман аялгуунд байхгүй үйл өгүүлэгдэхүүнийг бие ялган хэлэлцдэг[1].

Хойно алтай урианхайн аман аялгууг судалсан зарим дүнгээс өгүүлэх болно.

1. Х.Лувсанбалдан, Корни место имения minu, činu, inu в торгутским и урянхайском говорях: Studia Mongolica, t.II. fasc. 21, p.54.

Урианхайн аялгууны талаар 1971, 1973 онд бүрдүүлсэн хэрэглэгдэхүүнээ:

- Тод-монгол үсгийн цагаан толгой, тод-монгол номын тухай шинэ мэдээ
- Урианхайн салбар аман аялгууны авиазүйн онцлог
- Урианхай аялгууны газар усны дэвсгэр нэр, үнэг - араатан бие бүтцийн нэр гэж ангилав.

Тод-монгол үсгийн цагаан толгойн урианхай дуудлага. Тод-монгол үсэг бол монгол бичгийн түүх, ялангуяа монгол хэл аялгууны авианы хувьсал хөгжлийн түүхийг судлахад ихээхэн ач холбогдолтой юм. 1750 оны үед Манжийн ноёрхолд орсон урианхай нь баруун монголд төр шашны хэргийг хөтөлж байсан тод-монгол үсгийг дөрвөд, торгууд нараас дутахгүй өргөн хэрэглэж байжээ. Урианхайн настайчууд ойрад аялгуугаар тод-монгол үсгээр бичсэн шашны орчуулгын утга зохиолыг шүтэн биширэх сэтгэлээр уншиж хэрэглэж байжээ. Тод-монгол үсгийг уншиж бичдэг настай эмэгтэй хүн урианхад хэд хэд байсан. Мөнххайрхан сумын төвд суудаг Санж овогтой Наадгай тод үсгийг эцгээрээ заалгажээ. Наадгай гуайд тод-монгол үсгийн цөөн ном байлаа. Наадгай олон үлгэр ярьж, урианхай найрын дуу чадамгай дуулж байлаа. Наадгайн мэддэг үлгэрийн нэг нь Гэсэрийн туужийн Гэсэр хаан арван хоёр толгойтой аттар хар мангастай байлдсан, Гэсэр хаан Андалман хаантай хүч тэмцэлдэн байлдсан Гэсэрийн туужийн найм, есдүгээр бүлэг юм. Урианхайд амаар дэлгэрсэн Гэсэрийн туужийн энэ хоёр бүлэг баруун монголд тод-монгол бичмэлээр байдаг. Урианхайчууд тод-монгол үсгийг эхлэн суралцахдаа цагаан толгойг нь сурахад дөхмийг бодолцож үсгийг зурмын хэлбэрээр нэрлэдэг, дэвсгэр үсгийг өгүүлэх эрхтний оролцохоор нь нэрлэж дууддаг хоёр хэлбэр байжээ. Наадгай гуайд эцэг нь тод-монгол үсгийн цагаан толгой зааж сургахдаа тод үсгийн цагаан толгойн доорхи хэдэн нэрийг хэлж өгчээ.

(a) - хоёр араа (xoyar arân),
(e) - дэгээ хөл [дэгээ сүүлтэй] (degê köl),
(i) - хийсвэр сүүлт (kis"ur sült),
(o) - дөрвөлжин гэдэс (dörwölžin gesêň),
(u) - битүү гэдэс уруу өргөс (bütü gesêň urūgân ürgêsêň),
(ü) - битүү гэдэс (bütü gesêň),

(ö) битүү гэдэс өөдөө өргөс (bütü gesêň ödē ürgêsêň),

(da) давхар эрүү (dawxar örgöň),

(de) давхар эрүү дэгээ хөл (dawxar örgöň degē köl)

(do) давхар өргөс дөрвөлжин гэдэс (dawxar örgöň dörwölžin gesêň),

(du) давхар өргөс битүү гэдэс уруу өргөс (dawxar örgöň bütü gesêň urūgāň ürgêsêň),

(dü) давхар өргөс битүү гэдэс (dawxar örgöň bütü gesêň),

(dö) давхар өргөс битүү гэдэс өөдөө өргөс (dawxar örgöň bütü gesêň ödē ürgêsêň) гэх зэргээр нэрлэжээ. Тэмдэглэх нь гийгүүлэгч үсгийг нэрлэн дуудахдаа гийгүүлэгч бүрт оноосон нэрийтгэлийг хэлээд залгуулан ямар эгшгээр амь авч байна, уг эгшгийг тусгай нэрээр нь давхар дууддаг байна. Жишээ нь:

du dawxar örgöň bütü gesêň urūgāň, ürgüsün

lö - ökgur öwör bütü gesêň ödö ürgêsêň гэх мэт болно. Монгол улсын үндэсний төв номын санд эх бичиг нь байгаа <<todu mongγol kemēkü üsüg orosubai>> гэсэн монгол, төвд хадмал гарчигтай гурван хуудастай судартт тод-монгол үсгийн цагаан толгойг өөрөөр нэрлэжээ. Зөрүү нэрийг нь хойнох хүснэгтээс үзнэ үү. Уг судартт байгаа тод-монгол үсгийн нэрийг С.Наадгай гуайгаас бичиж авсан мэдээтэй зэрэгцүүлэхэд u, ö, d, t, m, l, y зэрэг эгшиг, гийгүүлэгчийг УУҮ- номнэрлэсэн нь хоорондоо ялгаатай юм байна. Үүнд:

Тод үсэг		МУҮ- номын санд байгаа тод-монгол судартт байгаа нэр	С.Наадгайгаас сонссон нэр
(u)	-	moγolcog gedesütei	bütü gesêň ōdē ürgêsêň
(ö)	-	dörbeljin gedesün	bütü gesêň ōdēn ürgêsêň
(da)	-	uruγu toloγaitai nige arayatai	daqxar örgön xoyar arāň
(ta)	-	tarayan toloγai nige arayatai	bütü tolxā xoyar arāň
(la)	-	ögede-ben ebere-tei qoyar arayatai	ökgōr öwōr
(ma)	-	matayar toloγai-tai qoyar arayatai	mat'xar öwōr
(ya)	-	yamaγan xangsayartai nige arayatai	yatxar xonšâr

Тод монгол бичгийн цагаан толгойн эгшиг, гийгүүлэгч үсгийн урианхайн дуудлага. Баян-Өлгий аймгийн Сагсай сумын үлгэрч Х.Үлэмжээс 1973 онд бичиж авав. 1971 онд Ховд аймгийн Урианхайн үлгэрч С.Наадгайн мэддэг тод-монгол үсгийн дуудлагатай зэрэгцүүлэн үзнэ үү.

а - хоёр араан (=хоёр араа шүд);
э - дэгээ көл (=дэгээ хөл);
и - кийсүүвэр сүүлт (=хийсвэр сүүлт);
о - дөрүүлжэн гэсэн (=дөрвөлжин гэдэс);
у - бүтүү гэсэн уруугаан үргэсэн (=битүү гэдэс доошоо өргөс);
ү - бүтүү гэсэн (=битүү гэдэс);
ө - бүтүү гэсэн хоораан үргэсэн (=битүү гэдэс хойшоо гэдэс);
да - давхур өргөн (=давхар эрүү);
дэ - давхур өргөн дэгээ хөл (=давхар эрүү дэгээ хөл);
ди - давхур өргөн кийсүүвэр сүүлт (=давхар эрүү хийсвэр сүүлт);
до - давхар өргөн дөрүүлжин гэсэн (=давхар эрүү дөрвөлжин гэдэс);
ду - давхур өргөн бүтүү гэсэн уруугаан үргэсэн (=давхар эрүү битүү гэдэс уруу өргөс);
дө - давхур өргөн бүтүү гэсэн хоораан үргэсэн (=давхар эрүү битүү гэдэс хойшоо өргөс);
дү - давхур өргөн моголцог бүтүү гэсэн (=давхар эрүү бөөрөнхий битүү гэдэс) гэх мэт.

Гийгүүлэгч үсэг нэг бүрийн оноосон нэрийтгэлийн дараа үе бүтээгч эгшгийн нэрийтгэлийг залгуулж давхар дуудаж байлаа.

б - бүтүү толхаат нэг араатаа (=битүү толгойтой нэг шүдтэй);
м - матхар толхаат нэг араатаа (=махир толгойтой нэг шүдтэй);
н - хоёр араат өмнээн нүдэн цэгтээ (=хоёр шүдтэй өмнөө цэгтэй);
х - гурван араат өмнээн хоёр нүдэн цэгтээ (=гурван шүдтэй хоёр цэгтэй);
к - дэгээ көлт кэлэндээ үргэстээ (=дэгээ хөлт хэлэндээ өргөстэй);
г - гуруун араат өмнээн бондгар цэгтээ (=гурван шүдтэй өмнөөн дугариг цэгтэй);
гэ - матхар толхаат дэгээ көлтээ (=махир толгойтой дэгээ хөлтэй);
ка - катгар ка, гээдэн ка (=гэдгэр ка);
д - уруу толхаат (=урагшаа толгойтой);
т - тараан толхаат нэг араатаа (=тариан толгойтой нэг шүдтэй);
з - цацуу өргөнт (=чацуу эрүүт);
ч - дутуу өргөнт (=дутуу эрүүт);
я -ямаан хоншаарт нэг араатаа (=ямаан хоншоорт нэг шүдтэй);

р - хоншаардаараан үргэст нэг араатаа (=хамар дээрээ өргөстэй нэг араатай);
л - өкгүр өвөрт хоёр араатаа (=өөдөө эвэртэй хоёр шүдтэй);
с - көндлүн толхаат хоёр араатаа (=хөндлөн толгойтой хоёр шүдтэй);
ш - көндлүн толхаат шилдээн хоёр нүдтээ (=хөндлөн толгойтой ардаа хоёр цэгтэй)

Тод-монгол урианхайн зурма зурлагын үсэгзүйн өмнөх нэрс нь "Тод-монгол хэмээх үсэг" гэдэг цагаан толгойн ном, дөрвөд, захчин дуудлагаас өөр юм. Урианхай аялгуунд ö эгшгийн нэр нь "бүтүү гэсэн, бүтүү гэсэн хөөргөн ургэсэн өөдөө эргэсэн", з үсгийн дуудлага нэр нь Ховд аймгийн Алтай, Манхан сумын захчинд "моголцог гэдэстэй, өөдөө татсан өргөстэй", ü (ү) эгшиг "моголцог гэдэстэй", гэх мэт нэр томъёоны ялгаатай болно.

Тод үсгийн дэлгэр толгой хэмээх номын тухай. Ховд аймгийн төвд зураач, соёлын гавьяат зүтгэлтэн М.Амгалан тод үсгийн цөөн номын хамт муутуу цаасан дээр бичсэн нэг захиа бидэнд үзүүлэв. Тэр захианы үгийг галиг үсгээр сийрүүлбэл:

kamba qutugtu-ber:
jaqčin-u demči darja-i-yin amur-I erijü jakiqu-anu:
Mönöken uridu jakiγsan čam-un kereqsel züil bütügsen ba ülü bütügsen jerge, jüil-i man-u ene yabuγsan kümün-iyer egekü jam-du jerge-yin küriy-e-ber tosoju jakiqui γuyuxu-ača γadan-a, todu mongγol-un delger toluγai, baγa idegeltei xamtu olju yabuγulxu ajiyamu: egün-ü tula jakibai sayin edüre гэжээ.

Энэ захианы мэдээгээр бол тод-монгол үсгийн судалгаанд мэдэгдээгүй "Тод үсгийн дэлгэр толгой" гэдэг тод-монгол үсгийн цагаан толгойн тусгай ном байжээ.

Төмөр тахиа жилд барласан бурхан шашны өөр нэг ном үзлээ. Элдэв ургамал, чулууны нэрийг жагсааж төвд үсгээр нэрийг нь хадсан, оноосон гарчиггүй 43 хуудастай хулсан үзгийн бичмэл өөр нэгэн ном нилээд сонин юм. Номын төгсгөлийн үг нь:

Tere metü yasamal soroyin em γurbun ündüsüni dotor curiü yesüni nomlon duusbai гэжээ. Энэ ном хоёр үндсэн хэсэгтэй юм. Нэгдүгээр хэсэг нь цэцэг ургамлын нэрийг тод-монгол үсгээр бичээд хажууд нь төвд нэрийг нь хадаж тайлбарласан байна. Үүнд: boro xuciyin öbör [бор хуцын эвэр] namčin moγolcog

boro ceceqni ulbar boro, išiyin kündöi ut, γurban taltai nigen züq-eče ceceqni xucu...
öbör metü xuyiluqsan bui:: гэж Бор хуцын эврийн ургах байдлыг тодорхой...
ямар өвчинд, зарим ургамлыг яаж хэрэглэдэг заавры г бичсэн байна. Жиш...
нь:

qoyin šariljin [хонины шарилжин]-yer cösön ebečinidün sarlaqui-gi ariIγaqu: kemēn ... cayān, xaraxoyor, xara-inu: yarxu γazar xara soroi dotor urγuxu: agi metü üner yeke-čü ... xara eyeldeg mongtoxor išin tuγuliyin söül metü ceceq üre ulān agi adali amtan üčüüken ... γašuun čidal-yēr xorxoi ebečini xočili ügei ariIγaqu išini toqoi düüren nigen sōm kürtele ... urγuqu kelbexi tarān dotor γarsan olosuni üre metü bui:: (11-р талд) гэжээ.

Энд зуугаад ургамлын нэр жагсааж ургамлын шинж, хаана ургадаг, ямар өвчин эмгэгийг эмчилэхэд хэрэглэдэг аргачлалыг тодорхой дурджээ. Номын 32-р хуудасны (v) талд:

Tere metü ündüsün namči išni, ceceq, üre selte oγōto tögüs tüükü-dü zokistoi ündüsün x... tabuni dotor zuun selte tabin dolōni delger nomlon duusabai гэсэн нь номын нэгдүгээр хэсгийн төгсгөлийн үг. Хоёрдугаар хэсэг нь [чулууны эмийн нэрс] ödögei-in čilüun emeyin ayimaq nomloxui-du гэжээ.

Урианхайн салбар аман аялгууны авиазүйн зарим онцлог. Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан, Баян-Өлгий аймгийн Алтай, Булган, Алтанцөгц зэрэг сумын монгол-урианхай, түрэг угсааны монголжсон мончоо... урианхайчуудын аялгуу нь дундад үеийн монгол хэлний онцлогийг хадгалж байна. Үгсийн сангийн бүрэлдэхүүнд нь казак хэлний гэр ахуй, хувцас хунар, мал аж ахуйн холбгдолтой ухагдахууныг илтгэсэн үг олон. Ховд аймгийн Буянт сумын халхчуудтай хамт суудаг түрэг хэлтэй мончоого хэмээх монголын тува урианхайчууд зэргэлдээх Дуут сумын урианхай аялгуугаар ярилцаж байлаа. Ховдын Тува, Баян-Өлгийн Тува нарыг хоёр хэлтэн, бас урианхайн салбар аман аялгуутан гэж болно.

Урианхайн салбар аман аялгуунд чанга, хөндий, үгийн эхэн, дунд орсон орчин цагийн монгол бичгийн хэлний хамжин шүргэх dz, dž, гийгүүлэгч авиаг шүргэх z, ž авиагаар дуудаж байна. Жишээ нь:

Сонг.бич.хэл.	Тод-монгол	Ур.аялг.	Орч.цаг.бич.хэл	
jorig	zöriq	zörig~zöroq	зориг	(dzorig)
jula	zula	zulâ	зул	(dzula)

jüg	züg	zük~züge	зүг (dzug)
jarlig	zarliq	zarliq	зарлиг (dzarlig)
jiran		žiri	жар (džarâ)
jobolang	zobolong	zowlăň	зовлон (dzowlon)
jebe	zebe	zew	зэв (dzewê)
jil	jili	žilê	жил (džil)
jokimji	zokimji	zokâmž	зохимж (dzoximdž)
jüil	züil	zül	зүйл (džüêlê)
üjeyül	üzöül	üzül	үзүүл (üdūl)
medejü	medeji	medêžê	мэдэж (medêdžê)
öljei	ölzöyi	ölzē	өлзий (öldzi)

Нийт монгол хэлэнд j гийгүүлэгч ихэд тагнайшсан d'авиа, эсвэл шүдний сулхан эхлэлтэй j авиа байжээ гэдэг таамаглалын сүүлчийнх нь үнэн байдалд арай илүү ойр юм.

Орчин цагийн монгол хэлний нэгэн үгэнд орсон эгшиг авиа нь нарийн байршилтай бөгөөд өргөлтөт үеийн эгшиг өргөлтгүй үеийн эгшигдээ хүчтэй нөлөөлдөг. Үгийн тэргүүн үед орсон уужим эгшиг тэргүүн биш үеийн уйтан эгшгээ ижилсүүлэх замаар монгол бичгийн хэлний өргөлттэй үеийн i эгшиг зарим тохиолдолд орчин цагийн халхын аялгуунуудад a, e зэрэг уужим эгшиг болон ижилссэн, уужимшин ижилших, уужимших зохицол урианхайн салбар аман аялгуунд болоогүй байгаа юм. Жишээ нь:

Сонг.бич.хэл.	Тод-монгол	Ур.аялг.	Орч.цаг.бич.хэл
xasir	xašir	xašir	хашир (xašar)
asig	asiq	ašig	ашиг (ašâg)
nabčitu	nabčitu	naptšīt	навчит (nabtšât)
urin	urin	üriň	уран (uraň)
xujir	xažir	xužīr	хужир (xudžâr)
tusixu	tusux	tusīxxī	тусах (tusax)
urusig		urššig	уршиг (uršâg)

Монголын сонгодог бичгийн хэлний a-i, e-i, u-i, ü-i, i-i гэсэн нэгэн цуваанд орсон өргөлттэй, өргөлтгүй үеийн эгшгийн дараалал нь орчин цагийн монгол бичгийн хэл, халхын аялгуунд a-a, e-e, u-a, ü-e, i-e болон хувирсан бол урианхайн салбар аман аялгуунд монголын сонгодог бичгийн хэлний байдал

хэвээр байна. Монг.бич.хэл. ajil Ур.аялг. ažil Халх adžal., Монг.бич.хэл. kerkin Ур.аял. kerkiň Халх. xer^kēň ~ xerkēň., Монг.бич.хэл. qujir Ур.аял. xužir Халх xudžâr., Монг.бич.хэл. bürin Ур.аял. bürīn~bürüň Халх. büren., Монг.бич.хэл kiling Ур.аял. kilīň Халх. xilēň~xilēň болно. Баруун монголын салбар аман аялгуунуудад a, e, u, ü, i зэрэг өргөлтөт үеийн эгшиг бүтэх байр аргын хувьд хэлний урд этгээдийг илүү хөдөлгөөнд оруулж урдуур хэлэгддэг.

Урианхайн салбар аман аялгуу â, a, ê, ī, ō, ü, ō, ü, ī, ē гэсэн арван урт эгшигтэй. Энэ арван урт эгшгээс ī, ē -гээс бусад 8 урт эгшиг нь үгийн аль ч үед тохиолдно. ī, ē хоёр нь зөвхөн үгийн хоёрдугаар үеэс хойш тохиолдоно. Урианхай аман аялгууны урт эгшгийн өгүүлэгдэх байдал, бүтэц нь дөрвөд, торгууд, захчны салбар аман аялгууны урт эгшгээс нилээд ондоо, монгол хэл аялгууны урт эгшигтэй илүү ойр мэт сонсогдож байна. *eb>*ew ээс уламжлагдсан монгол бичгийн хэлний eü гэсэн хосорхог нийлбэр урианхайн салбар аман аялгуунд бусад торгууд, захчин аялгууны урт эгшиг үүсгэлгүй ö'ü~ö^wō гэж дуудагдаж байна. Жишээ нь: (*eb > *ew > eü) ke'ün ke'ün-ü, Монг.бич. keün Ур.аял. kü' ün~ köwōn, Мог. köün, Дар. xō гэх мэт. Мөн үүнтэй төстэй орчин цагийн монгол бичгийн хэлний хүүхэн, хөөрхий зэрэг үгийг Монг.бич.хэл kögerükü > Ур.аял. küürkün köworküs.; Монг.бич.хэл ögere Ур.аял. ewērē~e^wērē гэх зэргээр *öbe>öge гэсэн нийлбэр орчин цагийн монгол хэлэнд ō, халх, буриад, ойрдын аялгуунд урагшилсан урт ө болсон байхад урианхайн салбар аман аялгуунд ö'ü, e^we~ e^wē зэрэг бүтэцтэй хэлэгдэж байгаа нь эртний ба дундад үеийн монгол хэлний *öbe> öge гэсэн нийлбэрт илүү ойрхон юм.

Орчин цагийн монгол хэлний уулзах гэсэн үгийг урианхайн аман аялгуунд uwâlzâx гэж хэлдэг. Энэ үгийг "Монголын нууц товчоо" a'ulcahu(a'uljahu), монголын сонгодог бичгийн хэлэнд ayuljaqu бичдэг бөгөөд буриад, халх, халимагт эхний үеийн ayu- нийлбэр урт у болсон байхад урианхайн салбар аман аялгуунд uwâ- байгаа нь эртний хэлбэр болно.

Урианхайн салбар аман аялгууны гийгүүлэгч авиа тагнайшдаг. Эртний монгол хэлэнд чанга эгшиг хэлний угийн хэсэгт бүтэж байсан учир монгол хэлний авиа тагнайших нь хожмын үзэгдэл юм. Баруун монголын урианхай зэрэг олонхи салбар аман аялгуунд монгол бичгийн хэлний qari, ami, bodi, uni, uli, sakil, čabi, qoni, jail зэрэг үгийн хэлэгдэх нь халх, буриад зэрэг аялгуунаас

өөр юм. Бидний ажигласнаар дээрхи хэдэн үгийн заримыг урианхайд xäri (zäri), ämi, tsäwi, ürēn̆ (ürēn̆ dulān̆ tsag- урин дулаан цаг улирал)-д тэргүүн үеийн эгшгүүдийг урагшлуулан уйтан ä, ö, ü авиагаар хэлж байна. Орчин цагийн монгол бичгийн хэлэнд хэлний урдуурхи а, о, у эгшгийг дээрхи тохиолдолд хэлний урдуур, тагнайшуулж хэлдэг. Урианхайн салбар аман аялгууны эгшиг тагнайшихад хойнох гийгүүлэгч ямар ч нөлөөгүй бөгөөд bödi(бодь), un̆in (унь), uliru (уль) tot (тоть), sakal(сахил) гэсэн үгийн унь, уль хоёрын н, л гийгүүлэгчийг хэлний дундуур хэлж uli, uni гэдэг үгийг уна, ул гэсэн үгнээс утга ялгаруулж байгаа авиа нь хэлний дундуурхи l, n авиалбар болно. Өгүүлэх эрхтний хоёр өөр оронд бүтэж байгаа l, l', n, n' нь тус тусдаа авиалбар юм. sakal (сахил), tot (тоть) гэсэн хоёр үгийн l, t авиа урианхайд энэ тохиолдолд тагнайшдаггүй. Монгол хэл аялгууг судалсан эрдэмтэд монгол хэлний авиа тагнайшихын учрыг нэг хэсэг нь хоёрдугаар үеийн урагшилсан и эгшгийн нөлөөгөөр өмнөх авиа нь тагнайшдаг гэх буюу, зарим эрдэмтэд орчин цагийн монгол хэлний амь, бодь, хувь, сахил, уль зэрэг үгийн төгсгөлийн гийгүүлэгч авиаг хатуу, зөөлөн хэлж (энэ нь тагнайшсан, эс тагнайшсан) хоёр гийгүүлэгч, улмаар өргөлтөт үеийн эгшиг нь тагнайшдаг, гуравдахь нь эрдэмтэд xąrįn: xąrīn гэдэг хоёр үгийн утга ялгаж байгаа нь юуны урьд нэгдүгээр үеийн а, à хоёр эгшгээр илэрч байна гэх зэргээр нэгэн мөр саналгүй байна. Бидний бодоход урианхайн салбар аман аялгуунд авиа тагнайшихад өргөлтгүй үеийн урагшилсан i эгшиг, үгийн утга ялгаруулах үүрэггүй юм.

Үнэгний бие бүтцийн хэдэн нэр:

nidün - nidün-yēr nara sara-yin burtagi ariulamui: Үнэгний нүдээр нар сарын буртгийг ариулмуй: Kal. nüdŋ R.Kwb 282a; хальм. нүдн. Б.Му. 388 (в): Oir. nüdün. Ж.Цол. 1988:680; nüddün; nid D.Kara. 1959:152; mong. nidün. Бур. нюдэ(н)

čikin - čikin-yēr dēdü sakuusun burtaglagsani ariulamui: Үнэгний чихээр дээд сахиусан буртагласныг ариулмуй:: Kal. tšikn̆ R.Kwb. 439(a); хальм. чикн. Б.Му. 649(в) Oir. tšik-n: Ж.Цол. 1988:854; tšikin, tšikkin D.Kara. 1959:165; Бур. шэхэн К.Чере. 751; МонБур. šexe, tšexe (tson) tseki (kham) Г.Ган.1988:2314 mong. čikin L.čikin (64b); IM. čiken (213), H. čiki (I.23r) [čiken; čag. osm. čikin, čäkä 'schläfen', gesichtsseite'] R.Kwb. 439(a,b)

xabar - xabar-iyēr ekeneriyin sakuusun burtagi ariulamui:: Үнэгний хамраар эхнэрийн сахиусан буртгийг ариулмуй:: Kal. xamr̥ R.Kwb.146(б); хальм. хамр

Б.Му.573; Oir. xonšär, xoŋšör Ж.Цол. 1988:431; xamar, xammar D.Kara.1959; xoŋ... D, xoŋsör, xoŋγosör И.D.Kara 1959:143; Бур. хамар К.Чере. 542; mong. qab... сарны зурхайн ёсны нэг, хоёр, гуравдугаар гурван сар; өвлийн дараа ир... улирал, qamar, qabar үнэрийн сэрэгдэхүүнийг мэдрэх эрхтэн Я.Цэ. 634, 6... [qabar, qamar: vgl. qaŋsijar, qaγurasun;> tel. qamur. nasenscheide]. R.Kwb. 164(...)

eligen - eligen-yēr ogtorguiyin gilbelgeni burtagi ariulamui:: (Үнэгний) элг... огторгуйн гялбаа цахилгаан буртгийг ариулмуй:: Kal. elkn; elgn̈ R.Kwb. 119(b), халь. элкн печень Б.Му. 1977:697; элгн [элген] родственник, 1977:696; Oi... Elkn, elk-n, elik Ж.Цол. 1988:295; elkin D, elik U. (foie, poitrine, ventre.) D.Kara 1959:137; Бур. эльгэн. К.Чере.764; МонБур: eligen, eligü (Kham). Г.Ган 1988:1871-1872 mong. eligen, elige, heligen; L.helegen (68a), IM. heligen (21...), SH.helige (2903). [eliken, eleken; vgl. čuw al, niere' und mo. eligen] R.Kwb 119(b), Элигэн печень эвенк. Элигэн [<mo.]. (элэгэн Hрг) печень. Сравни.сл... 1977:447(a) Oyir. elken.

åliken - eliken-yēr hada-yin burtagi ariulamui: (Үнэгний) элгээр хадны буртгийг ариулмуй::

zürken - zürken-iyēr urin erketü ene burtagi ariulamui:: (Үнэгний) зүрхэнээр урин эрхэт энэ буртгийг ариулмуй:: Kal.zürkn̈ R.Kwb. 483-484; халь. зүркн зүркен Б.Му. 260; Oir.dzürkên zürkin Ж.Цол.1988:280; dzürkün D,dzürkên, Dz.dzürkün, zürkǔn И, kho D.Kara.1959:136. Бур. зүрхэн. К.Чере. 268 МонБур. zürxe, dzürxe (Kham). Г.Ган. 1988:1830 jirüken, SH.jirüge, Öürügen, Muk. jürüken, H.jürüken, L.jürke.64b, jürüke 213, [jirüken, tü, jürük] R.Kwb. 483-484. Oyir.züruken, zürken.

osaki- osaki-yēr casutu oulayin burtagi ariulamui:: (Үнэгний) уушгиар уулын буртгийг ариулмуй:: Kgl. öškâ [=kolur] R.Kwb 242(b), 243(a); халь. оошк [оошк...] көөлүр. чодгру'док (напрву быка) Б.Му. 400, 317; Oir. öšak (Dö., Ba.,Kho), oãšag (Dö., Dz.,T., Ö., M.,) уушги Ж.Цол. 1988:701; Бур. уушха(н) К.Чере. 482; МонБур. ūšxa(n), ūdki (Kham), mong. aγuski, aγuski, ouski, SH. a'ušigi, Mu.a'ušiki, L. awuski (64b), IM. H. a'ngi I: (24) Oyir. uusigi, öški, öška, öška, ösgi, ouški

gedesün - gedesün-a-yēr tere küüriyin burtagi ariulamui:: Гэдсээр тэр хүүрийн буртгийг ариулмуй:: gesn̈ R.Kwb.135(a): халь. гесн [гэсэн] Б.Му.140; Oir.gesên Ж.Цол. 1988:324; gessê (Dž.,T.,), gessen (Dö.,Dž., U.,), gesen (Dž). D.Kara.139; Бур. гэдэһэн, гэтэһэн К.Чере. 168,174; gedehen (Khori., Aga., Bar.,), güdehen

(Tunk.), gedes (Tson.), gedesü (Kham) Г.Ган. 1988:1900 mong. gedesü Oyir. gedesün, gesün, gesen;

küzüün - küzüün-iyer dalayin burtagi ariulmui: (Үнэгний) хүзүүгээр далайн бурт гийг ариулмуй:: Kal. küzun R.Kwb. 249(a); хальвкүзүн Б.Му. 323; Oir.küdzun(Dö., Ba., Kho., Dž), küzun (T.,U.), Ж.Цол. 1988:590; küzun (U.) D.Kara. 1959:149; Бур. хүзүүн К.Чере 1973:615; mong.küjügün, küjügü Oyir.küzöün, küzöün, küzöün, küzun.

maxan - maxan-yer yazariyin burtagi ariulmui:: Махаар газрын бурт гийг ариулмуй:: Kal. maxan R.Kwb. 254; халь. махн [махън] Б.Му: 345; Oir. maxan Ж.Цол 1988:605; Бур. мяхан К.Чере 1973:314; МонБур. màxaŋ, m'ixa (Kham.), mong. miqan, L. miqa 64a, SH. miqa 621, IM. mixa, Oyir. maxan

nōson - nōson-yer xamug moduni budisayin burtagi ariulmui:: ноосоор хамаг модны бодисын бурт гийг ариулмуй:: Kal. nōsn R.Kwb. 279; халь. ноосн [ноосън] Б.Му. 381; Oir. nōsaň nōsun. 1988:674; nōson (U). D.Kara. 152; nōhon; К.Чере. 331; nōhon., nōson (Kham., Tson.) Г.Ган. 1988:2157; mong. noosun, noyosun, *nungqasun; Oyir. nōsun.

nuryan - döčin dörbön nurgun üyes-yer:: дөчин дөрвөн нурууны үесээр:: Kal. nurgan R.Kwb. 281; халь. нурhи. Б.Му. 386; Oir. nuryan. Ж.Цол. 1988:679; nuryun (Dö., U). D.Kara 152; Бур. нюрган К.Чере 343; МонБур. ňüryan, ňirū, niroyū (Kham), ňurū (Bar.), ňorū(Tson.) Г.Ган. 1988:2161; mong. niruyun, L. nirun 68a, SH. niru'un (4231), niryun Im., Oyir. nuruyun, nuryun, nuruu, nuryuni.

xabirya - baroun xabirya-yer..., zöün xabirya-yer: баруун хавиргаар..., зүүн хавиргаар... Kal. xäwγa хажуу тал, хэсэг R.Kwb.178(b), халь. хаврh Б.Му. 588; Oir. xäwräγä 1988:411; mong. qabirγ-a, Oyir. xabirya

xabusun - ünegeni kedün xabusun-yer... Үнэгний хэд хэдэн хавсанаар... kal. xawsn (xäwsn) R.Kwb. 174(b); халь. хавсн [хавсън] ребро. Б.Му. 562; Oir. xawsan 1988:397, Бур. хабhан К.Чере. 527; МонБур. хабаhан (Khori., Aga.), xabasu (Kham.), xabirya (Tunk., San., Tson.) хавирга: ребро Г.Ган. 1988:1922; mong. xabirya qabisun; Oyir. xabasan, xabasun, xābasu, xabirya.

üsün - üsün-eče zarimud kilyasuni үснээс нь зарим хялгасыг нь..., Kal. üsn (nōsn, nolγ, kilγasn, bulu) R.Kwb. 460; халь. үсн. Б.Му. 555; Oir. üsüŋ, üs 1988:893; D.Kara 1959:168; Бур. үhэн К.Чере 519-520; МонБур. ühen (Khori., Aga., Tunk.,

San.), ühü (Bar.), üse (Tson., Kham.,) 1988:2451; mong.üsün, SH. hüsün (31, 827), istam. hüsün (149a), IM. hüsün (153), H. hüsün (1.23), L. hüsün (64b), Muk. üsün (382), Zimi. üsü; Oyir. üsün.

kilγasun - Kal. kilγasñ, kilaγsñ R.Kwb. 231; халь. килhсн [килhсън] Б.Му. 300; Oir. kilγăsän, kilγisin Ж.Цол. 1988:549; kilγas, külγâs, D.Kara. 197; Бур. хилгааhан К.Чере. 571; МонБур. xilγāhan (Khori., Aga., Tunk., San.) kilγāsu (Kham.), xalγōso (Tson.,) kilγasun; Oyir. kilγasun, kilγasu.

cusun - cusun-eče mini nigen dusal цуснаас минь нэгэн дусал., Kal. tsusñ, R.Kwb. 434; халь. цусн [цусън]. Б.Му. 641; Oir. tsusun, tsus D.Kara. 1959:165; Бур. шуhан К.Чере. 736; МонБур. šühan (Khori., Aga., Tunk., San.), tšoso (Tson.), tšisu (Kham.), šühu (Bar.); mong. čisun; Oyir. cusun, cusu.

yasun - yasun-eče mini nigen kelterkei kigēd яснаас минь нэгэн хэлтэрхий хийгээд. Kal. hasñ R.Kwb. 217; халь. ясн [ясън] Б.Му. 711; Oir. yasan Ж.Цол. 1988:506; yas, yasñ D.Kara 1959:156 mong. yasun; Oyir. yasan.

xingšour - xongšour mini axur ogotor boluqčī хоншоор (=амьтны хамрын шонтгор үзүүр) минь ахар оготор болсон нь: Kal. xoŋšār, xoŋšar R.Kwb. 186; халь. хоншāр мо'рда, рыло Б.Му. 596; Oir. xoŋšār, xönšār Ж.Цол. 1988:431; Бур. хоншоор К.Чере. 585; [mon. xongsiyar, čag, qumšum, tel. qoŋyr nasensattel] R.Kwb.186

aman - aman šara boluqsani ам минь шар болсон нь; Kal.amñ R.Kwb.9; халь.амн [амън] Б.Му. 40, Бур. аман К.Чере. 46. V mong. aman, Oyir. aman, ama.

omoroun - omoroun mini cagan boluqsani. омруу минь цагаан болсон нь: Үнэгний хоёр суганы өмнө өвчүүний ойсын (=өвчүүний доод хувийн дундхи яс) нийлэлтийн газар ургасан цагаан үс. Kal. omrūn D. omrū Ö, R.Kwb. 285-286, халь. омрун 1. груд. 2. выступ (горы) Б.Му. 397; Oir. omrūn Ж.Цол. 1988:688; Бур. оморюун грудина (лошади) К.Чере. 355; МонБур. omorūn (Khori., Aga.) Г.Ган. 2175; [mong. omurayun, omorun, SH. omori'ut (3307), tü. omūz; > kir.omrau, koib. omryy] R.Kwb. 286(a)

öyöküi - öyöküi mini cayān boluqsan өехий минь цагаан болсон; өехий 1. адгуус амьтны өвчүүнээс доошхи газар; 2. зарим амьтны арьс ширийг өвчихөд

умдагнаас эрүү хүртэл тусгай зурваслан хуулсан арьс. mong. öyükei, öyüke; Oyir. öyöküi. öyöke.

xonggi - mini xonggiyin nōsun kökü boluqsan миний хонгын ноосон хөх бологсон нь. Kal. xoŋ (=böksīn ögzeg) R.Kwb. 185(b); mong. ögejeg.

nōsuni üzüür - min ī nösuni üzüür söüdertei inu миний үсний үзүүр сортой нь; сор mong. sor.

aru - aru-inu ulān boluqsan-inu. ар минь улаан болсон нь: Kal.ara, aradaka R.Kwb.12(b); халь.ар [аръ] Б.Му.46; mong.aru; Oyir.aru, ara.

zō - mini zō sōxor boluqsan inu миний зоо болсон нь; Kal.zô, (D.) zôn (Ö) 1. nurgan, nurgad, zōyīn (zōnē) maxan; R.Kwb. 477(a), халь. зо Б.Му. 249; Oir. dzō, zō. Dzoā. Ж.Цол. 1988:258; Бур. зоо седалищный нерв К.Чере. 256; МонБур. zō. Mong. jō., Oyir. zō, zoā.

söül - mini soul-inu jō urtu boluqsan inu миний сүүл гоо урт болсон нь: Kal.söl. R.Kwb. 342(a), халь. сүүл Б.Му. 467(a), Бур. һүүл К.Чере. 699; МонБур. hūl (Khori. Aga., Tunk., San., Bar.), sūl (Tson.) mong. segül, Oyir. söül, süül

Монгол урианхайн бичгийн соёлын нэг чухал бүрэдэхүүн бол урианхайн ардын шашны уран зохиол тод-монгол үсгээр бичсэн сангийн судрууд юм. Энд үнэгний сангийн сударт өгүүлсэн үнэгний бие бүтцийн 30-аад нэр харьцуулж бичив. Бичихийн учир нь хүний бие бүтцийн зарим нэрээр тод-монгол үсгийн Цагаан толгойн үсэгзүйн зурам махбодыг, бас газар усны дэвсгэр нэйиг оноож тус тус хүмүүнчилж (=бурханчилж) нэрлэдэг юм.

ХАВСРАЛТ 1.

АЮУШ ГҮҮШИЙН ОРЧУУЛСАН ЦАГААН ШҮХЭРТИЙН ХУДМА-МОНГОЛ ХУВИЛБАР









[illegible]



[illegible]









[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

ХАВСРАЛТ 2.

НАМХАЙЖАМЦЫН ОРЧУУЛСАН ЦАГААН ШҮХЭРТИЙН ТОД-МОНГОЛ ХУВИЛБАР





[illegible]



[illegible]





[illegible]







[illegible]





[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

ХАВСРАЛТ 3.

Notes on mongol uriankhai vocabulary[1]

The first mention of the ethnonym Uriankhai is probably the Wu-niang-kai of the Liao-shih[2]. Sources dealing with Mongol history and culture at the turn of the 12th and 13th centuries give several varients of the same ethnonym which has been borne by different ethnical groups in different places of the Mongol word. Rashid-ad-Din mentions the Forest *Uriyanqad*[3], in the Secret History we find *Uriangqai, Uriangqadai, Jarči'ud Adangqan Uriangqajin* (9, 12, 38, 97, 120, 170, 183), the form *Uriangqan* occurs in the Hua Yi Yi Yü Documents (b5r) (ed. Ligeti, *MLMC* III).

In later times the term Altai Uriangqai was attached to Mongol- and Tuwa-speaking ethnical groups of Western and North-Western Mongolia as well as of Tuwa.

The forest *Uringqad* and *Adangqan Uriangqad* may be considered tribes or clans of the genuine Darligin Mongols and belonging to the 13th century Mongol Empire[4]. In the 16th century they are found among the Mongols of the Six Tümens[5].

In the Mongolian People's Republic there live two ethnical groups bearing the ethnonym Uriankhan or Uriankhai. The Uriankhans inhabit the provinces Xovd, Xövsgöl, Zavxan, and Bayanxongor, on the Western and Southwestern borderland of the country. Some Uriankhans may also be found in Dornod and other provinces of the Eastern frontiers, among Khalkha population, forming isolated groups, called *ixe urianxan, baga urianxan, adanxan* and *urianxan*[6]. These Khalkha Uriankhans are the probable decendants of those lived in the 10th century.

The Western group, that of the Uriankhais inhabited the mountains of Altai and Tagna (Tanglu, Tangnu) up to the end of the 17th century. A part of them accepted Manchu supremacy in the 18th century, others settled down in the territory which is now the Mongolian People's Republic. Uriankhais today reside in Duut, Mönxxairxan sumuns

1. Энэ өгүүлэл 1976 онд Унгар улсын Шинжлэх Ухааны Академийн АОН сэтгүүлийн XXXII ботид хэвлэгдсэн болно.
2. See K.Wittfogel-Fêng Chia-shêng, *History of the Chinese society: Liao* 907-1125, Philadelphia 1949, p.98; D.Gongor, *Khalkh tovčoon* I, Ulaanbaatar 1970, pp.48,49,108.
3. Rašid-ad-Din, *Sbornik letofisei* I, Part 1, p.123.
4. Gongor, *Loc. Laud.*
5. N.P.Šastina, *Šara tuuji, Mongoliskaya letopisi XVII v.*, Moscow 1957, p.97.
6. Gongor. Loc. Laud.

of the Xovd aimak in large grouos, and in Sagsai, Buyant, Altai and Bulgan sumuns of Bayan-Ölgii aimak in isolated groups. They are called Altai Uriankhai in Mongolian scholarly literature.

Uriankhai is a subdialect of the Oirat dialect. Concerning phonetics and vocabulary there are no market differences among the Uriankhai, Dörböt, Torgut and Zaxchin subdialect, but Uriankhai has some special suffixes indicating the person of the predicate[7]. Though this subdialect is nearly unin-vestigated[8], folklore researches recorded abundant material of the Uriankhai lore[9]. Some epic songs were published in phonetic transcription[10].

The present paper is based on meterials collected in Sagsai, Cengel and Buyant sumuns of Bayan-Ölgii aimak in the Mongolian People's Republic in September 1973.

Some topographical terms, onomatopoeic words imitating the different sounds of cattle, terms for shearing and tying up differ from Khalkha. Some of them derived regularly according to the phonethical development of the Mongolian language. E.g. *jilaγ-a >džilâgâ ~ žalga; denji ~ den ~ denž; kübürkei ~ güwerkē ~ küwrkē ~ kövörkii.* Others, such as *alān uya-* (= Khal. *üxüülž uja-*); *tomdī-* (=Khal. *toono tuši-*) show lexical differences.

Topographical Terms

ama «am; xoyr uulyn xoorondox nam xöndii gazar: valley: low area between two mountains» - Kalm. *ūlin amn̆* «ein kleines Bergtal» (Rams.), Khal. ama «padj, vpadina, ustje padi, uščeljja» basic meaning: «rot, otverstie» (Kaz.), WM *aman*, Oir. *aman*

bagâtšâ «bogoč; uul davaany namxavtar oni xötöl: smaller mountain pass or col» *Ulān bogâtša* (toponym), *bogâtšār dawâχχâ*, WM *bogoči*

bel «bêl; uulyn xažuugyn šuvtrax naluu gazar: slope, sloping mountain side» - Kalm. *ūlyn bel* «der Abhang des Berges», cf. *ūlyn šil*, (Rams.), D. *bel* (Kara), Kal. *bel* «sklon,

7. Kh.Luvsanbaldan, *Korni mestoimenii minu, činu, inu v torgutskom i uriankhaisom govorax: Studia Mongolica*, t. VI, fasc. 21, p.54.
8. Ž.Coloo, *Urianxai ayalguug sudalsan zarim dn: Xêlzokhiol sudlal*, t. IX. facs. 7, pp.57-63
9. Baruun mongolyn baatarlag tuulis: Studia Folklorica, t. VI, fasc. 2.
10. Mongols call sheep, goats, camels, horses and horned cattle *tavan xuuu mal.* 11.

skat gory bliže podnožiyu, otlogostj, kosogon» (Kaz.), WM *bele*, oir. *bel beltšər* «bêlčir; žalga, gol zam amny uulzvar, niilber gazar, golyn bêlčir, dörvön zamyn bêlčir: junction of precipices, rivers or roads» - Kalm. belčêr «Vereinigungsstelle» (Rams.), U.*beltšir* (Kara)[11], Khal. *belčer*«mesto sliyaniya rek, ručiev» (Kaz.) WM *belčir*, Oir. *belčir*

daw[12] «dav, žalganaas arai uužim, bogino, nam, buuc xorootoi č baiž boldog davaany am gazar: the valley of a mountain pass, somewhat wider than a chasm, short and low», *šara dawən amən* (toponym)

dewsêg, dewssê[13] «devsêg; orčnyxoo gazraas öndörxön têgš gazar; dêv dêvsêg; a plain somewhat higher than the surrounding area» - Kalm. *dews* (Ramst.), Khal. *dews* «sklon, skat gory, ustup (Zap. Mong)» (Kaz.), WM, Oir. debeseng

del «dêl; uul tolgodyn oroi, xažuugaar dellež xamarlan togtson nariin zurvas cuvraa xad: a narrow line of rocks on the top and slopes of a hill or a hillock» - Kalm. *del*, Khal.*del* «okstraya veršina xrebta, kamenistaya griva» (Kaz.); WM *del* «mane»

de η «dênž; nam dor gazraas arai öndörlög büxii têgš gazar: a completely flat area, a little higher than the surroundings», *golən de η* «the terrace of a river», *χoə de η* (toponym) - Kalm. *dendži* (Rams.), Khal. *denji* «krutoj vozvyšennyj bereg, terrasa» (Kaz.), WM *denji*

denül[14] «dêgnüül, dov; nuga, namagt baidag ovgor, tovgor gazar: a bumpy place with meadows, marshes and bogs», Kalm. *deηnül, deηnür* (Rams.) D *deηnültə* «inégal, raboteux (sol)» (Kara), WM *dengnegül*

dow «dov, dovon, dovcog, boldog; tolgodoos nam žižig, tasarxai togtson tovgor gazar: a flat, isolated, slightly elevated placa, lower than a hillock», Kalm. *dowń, dow η* (Rams.), *dowdər gartš χarüslənə*. Khal. *dobə* «nebolišaya gorka, xolm, kurgan, nasypi» (Kaz.) WM *dobo, dobung*, Oir. *dobun*

döroldž «dörölž; uul, uxaa, xamar gazryn talbiun bilčêêriin gudas xötöl : a hillock with wide pastures», Kalm. *dörldži*, Ö «Bergabsatz, Treppe», *namχan dawən* (Rams.), WM *dörölji*

11. This word also denotes the junction of the three straps of the hobbles.

12. Uriankhai *daw* = Oir. *sangirtsgən daw.*

13. Khal. *dəvsəg* = Oir. *dewse*.

14. Oir. -*ηn*- Khal.. -*gn*- as in the modern forms of WM *mangnai, manglai*

džilgi «žalga; baigalias togtson suvag, guu: a natural ravine or ditch», Kalm. *džilγa* «Flussbett ; trockenes Flussbett (mit hohen Ufern), Bach, steiler Abhang» (Rams.), WM *jilljγa* (Golst.)

γaŋγâ «ganga; xoyor êtgêêdêêsêê öndör êrs êrgêêr šaxagdsan xavčig suvag: a narrow ditch bounded by high steep sides» Kalm. *gaŋga* «hohes Ufer, Kluft, hoch, steil»(Rams.), Khal. *bōm* «vysokij bereg, obryv» (Kaz.), WM *γangγ-a*

γanū «boom; kömlöös namxan, bogino bogočoos öndör xötöl: an elevation, lower than a hillock, higher than a short mountain pass», U *γanū* «are de l'attache du pied, couture ternaire dans la tête de la botte» (Kara), Khal. *bōm* «krutoj i vysokij mys, vydasčajasja v storonu skala na beregu reki: *baranii lob* (Zap. Mong.)» (Kaz.)

γū «guu; žalganaas nam dor, bogino suvag; a short ditch, less deep than a precipice», *gū džilgâ* (hendiadyoin), Kalm. *gū* «Kanal, grosser Wasserleitungs-kanal, syn. *buχu*, Vertiefung, Grube» (Rams.), Khal. *gō* [=*gū*] «rov, kanava» (Kaz.), Ord. *gū* «fosse» (Most.,), WM *γau, γuu*

güwē «güvêê; urtavtar güvgêr zoo gazar: longish, protruding place, hillock», Kalm. *göwē* «ein kleiner flacher Hügel, niedriger Übergang von Tal zu Tal» (Rams.), Khal. *güwē* «uval meždu ovragami» (Kaz.)

χamâr «xamar; güvêênêês öndör, davaanaas namxan xušuuran togtson güvgêr gazar: nose; a humpy place place of natural origin, higher than a rise, lower than a pass», Kalm. *χamar* «Vorgebirge» (Rams.), Khal. *χamâr* «vystup gory meždu dolinami, uščeljjami, mys, otrog» (Kaz.) WM *qabar* «nose; spur of a mountain, promontory»

xurγâd «xurgad; žižig tolgod: small hillocks», *ulān χurγâd* (toponym.), cf. also Russ. *kurgan*

χabtsâl «xavcal: uulyn bêrk čuxal, gün žalga amsartai boomt gazar: a place with a very narrow and deep mountain gorge», D *χabtsḷ* «precipice, guaffre» (Kara), Khal. *χabcal* (Kaz.), WM *qabčil, qabčal*

χondâ «xond; ail nutaglaž baigaad bolison buuc nutag buyu xavar, namryn ulirald otor, tuuvryn malaar xonoglox gazar: mön oršuulgyn gazryg xond gek ni bii: a place where one more yurts (ail) stood or where catle spend the night at driving out to the pastures: they call the cemetery xond, too». Cf.Kalm. *χondḍtsâg* «das dicke Fleisch am Rückenende, auch Name eines Berges», etc. (Rams.)?

kew «uul davaany šuvtarga naluu gazar: a sloping place at the end of the hill or a hillock»: *ūlān kewd orâχχâ*

kedrē «tašlaga, xêdrêê: terrain difficult to go on», cf. Kalm. *ked*[o] «unebene Gegend, unfahrbarer Weg», etc. (Rams.), Dz. *kedre η* «impracticable, raboteux» (Kara), Khal. *χedreχ*, WM *keder* «obstinate», etc.

kerlêg «kêrlêg, tašlaγa: a place or road difficult to go on»: *kerlêg zamâ* «a road difficult to go on»

kir «xyar; uulyn oroi, nuruuny žuram: mountain ridge, the line of the top and the slopes of a hill», Kalm. *kir*[ə] Ö «Bergwiesen» (Rams.), WM *kira*

kisā̄ «xyâsaa; uul, xadny xalil irmêg, guu, žalgand xušuuran togtson xadan xušuu: the sharp edge of a hill or a rock, protruding from a ditch or a precipice», WM *kisaγ-a*

köndē «xöndii; xoër xêšêg uul nuruu, tolgod golyn xoorondox ürgêlžlen togtson têgš tawiu gazar: a wide plain place between two hillsides, hillocks or rivers» Kalm. *köndē* «hohl, leer: grosse Talsenkung, Steppe; fern» (Rams.), WM *köndei*

kötöl «xötöl; uul nuruuny dölgöön buusan nam naxis gazar: a lower, usually rounded elevetion», Kalm. *kötļ* «Hügel, Anhöhe, Steigung, niedriger Bergübergang» (Rams.), WM *kötel*

kǖšê «küüš; nar tusdaggui, süüdêrtêi, xad uulyn ar ërool, ar xažuu gazar: the shaded northern side of a rock or hill where the sun never shines». Cf. Kalm. küškür «Leichnam» (Rams.)

naksā «naxis; orčmyn gazraasaa öndörlög, žim zamtai oni xötöl: a mountain-pass with a small path, higher than the environment»

nakû «ganuugaas ündür, xötlöös namxan, nariin ulbaa zamtai suunag oni xötöl büxii têgš gazar: a flat place, higher than a rise, lower than a hillock with misty mountain passes and narrow paths», Kalm. *nakū, gaz*[a]*ryn nakū*. syn. *χot*[o]*γār gazŗ* «Vertiefung in der Erde» (Rams.), WM *naki-*

ölkön «êngêr; uul, xyaryn övör êtgêêd: the southern mountainside», *χadān ölkön* «the southern side of a rock», *ülān ölkön* «the southern side of a hill», *botχānā ölkön* (toponym), WM *ölke*

ötög «buuc, malyn xot buuc xêvtêr: the pen of the cattle», *kök ötög* «the autumn pen of the cattle», *ötögnāni kīts'sin* «the frozen manure of a pen», *šarā ötög* «the spring stable of the cattle», Kalm. *ötög* «Briketts aus die Argal, der Kuhmist wird mit den Füssen oder

mit Tieren bearbeitet und die weiche Masse entweder in Formen gepresst oder nach dem Trocknen in grosse ziegel-formige Stücke geschnitten» (Rams.), WM *ötög*

öm «uužim, zamtai, uužim dêlgêr bêlčêêriin gazar: a wide pastureland with a wide road» Ö *tsagān dugānā ñi omēn dūrēd nalānā*

sār «sair, žižigkên xair čuluutai gol usny sav gazar, keer talaaraa namxan dênž büxii bêlčêêrt toxiromžtoi bogino xöndii: a river valley with small ballasts; a short, low valley suitable for driving cattle on», Kalm. *sār'* «steiniger Fluss, Flussbett» (Rams.), Khal. *saêr* «suxoe ruslo vodnogo potoka; inogda – otrog gory, xolm» (Kaz.), Ord. *sār* «petit caillou» (Most.), WM *sayir*

šil «šil gazar; uulyn öndörlög, xyanga gazar, uul tolgodyn nam xotos gazar: plateau; the level top of a hill», Kalm. *šili; ūl īn šilēr yowχā* «Nacken, die grünen Bergwiesen . . .; die Abhänge des Berges entlang reiten» (Ramst.), Khal. *šil* «ploskaya vozvyšennosti: gora, xolm; vysokoe nagorye, verchnyaya èasti xrebta, gornogo massiva; ploskogorye, uval» (Kaz.), WM *sili*

tašlâγâ «tašuu; uulyn xêlbüü, xazgai žišüü gazar: the sloping part of a hill», Kalm. *tašād odχâ (otχâ)* «schief herabrutschen» (Rams.), cf. WM *tasiγu*

tōm «toom: the path of wild animals», tōmār tōsâŋ γarnâl, *tom-l šarγān tōs ŋ keptēlé; tōmnād yowâχχâ; ūlān tōmār γarād odâχχâ*. Cf. WM *tom, tomoŋ* «track or path of wild animals» Lessing

zūχχâ «žižig, bogino žalγa, žalγa, zuux. Êls but, šawag büxii žalγanaas bogino nam dor gazar: a small, short precipice. A sandy, bushy piece of land, a depression shorter than a precipice»

© Terms concerning animal husbandry. Words indicating the cries of horned cattle:

mārō- «mööröx; ünêê, šar, bux, tugal, byaruuny žiriin baidald duugarax duug têmdêglêsên üg: general term denoting the cries of bovines», Kalm. *mōr-* (Rams.), WM *mögere-*

urâmdâ- «uramdax; zövxön mongol üxriin buxyn duugarax duug têmdêglêsên üg: word denoting the cry of the Mongol bull only. Usually *bugâ urâmdâ-* is the common term in Mongolian», cf. Kalm. *uramd*- urmd*-* «Lust haben, gern sehen, . . .» (Rams.), WM urumda-

orkârâ- «orchirox; mongol ünêênii bux oroony üydêê arai čanga duugarax duug têmdêglêsên üg, mongol xêlênd bars, buγa, ilžig zêrgiin amitny duugarax duug *orχiro-gêž kêldêg*[15]: the loud cry of cows produceed during mating time. In Mongolian *orχiro-* is used to indicate the cries of tigers, deers, donkeys, etc.», Kalm. *orkŗ- orkļ-* (Rams.)

χakši- «uramdax, sarlagyn buxyn oroony üydêê duugarax duug têmdêglêsên üg: word indicating the cry of a yak's bull during mating time».

The following words denote the cries produces by male, female and castrated camels, in different circumstances.

būli- «builax; ingê, at botgo, torom žiriin nöxcöld ižil sürêg êx ürêê êrên uyangalan duugarax duug têmdêglêsên üg: word indicating the mumbling cry of a male or female foal; the melodious low of the mother to her foal», Kalm. *būli-* (Rams.)

barkârâ- «bakirax, orilox; buur, ingê, torom þerçg têmêê ain cočiž tavgüidên duugarax duug ni têmdêglêsên üg: the cry of camels in fear and desperation», Kalm. *barkŗ-* (Rams.), WM *barkira-*

kürkêrê- «xürxêrêx, buurny oroo üyiin duug têmdêglêsên üg, mongol xêlênd buur xürxêrêx, bars xürxêrêx žêrgêêr amitny xüržignên duugarax sürlêg duug têmdêglêsên *kürkire-* gêsên üg baina: the cry of the camel stallion during the mating season, in Mongolian kürkire- is used to denote the threatening cry of camel stallions, tigers, etc.» Kalm. *kürkŗ-, kürkür-* «knurren» (Rams.), WM *kürkire-*

χakši- «oroo buuryn xüržignên duugarax sürlêg duug têmdêglêsên üg: the threatening cry of the mating camel-stallion». See above *χakši-*

➒ Words indicating the cries of stallions:

intsχā- «yancgaax; azraγa, güü, mori, unaγa, daaγany ižil surge êrên duugarax duug têmdêglêsên üg: the word designating the cry of stallions, mares, foals and colts when calling their mates», Kalm. intsᵃγā- «wiehem (das Pferd)» (Rams,), WM *inčaγa-*.

kükêrdê- «üürsêx, mori, azraγa biy biydêê dotnočlon duugarax duu: the cry of stallions and steeds when intimate ro each others».

The word *mäl'nā* is used to denote the cry of sheep and goats; *bawtnâ-* (WM babaduna-) is said of the bleating of billy-goats (Uriankhai: *tek*). This word indicates the longing *ba-ba* bleating of billy-goats in Mongolian.

The Uriankhais call their cattle by special pet-names. They repeat the following onomatopoeic words: *χōw-χōw* for horned cattle, *kös-kös*, *tüššê*, *tör-tör* for camels, *gurī-gurī*, *bogātšā* for horses, *tögö-tögö* for sheep, *džidži-džidži*, *tšög-tšög* for goats, etc. These words are used on a concrete occation of a particular animal. E.g. When milking a cow *kör-kör*,

when drivingback *χōw-χōw* is uttered. When you want to stop a recoiling camel, or you want him to come back *tišš-tišš* must be shouted. When milking the camel-mare *kōš-kōš*, when watering, grazing or making her urinate tōr-tōr is uttered. Driving a camel the driver says: *χā xodž.*

© **The Mongol nomads use their special terms for ferring cattle.** The terms differ from each other from region to region and from dialect to dialect. A grour of these words can be used for all kinds of domestic animals, but the other group consists of terms the use of which is limited to a species. Let us begin with the common terms.

arχâlâ- «arγamžlax; tavan xušuu malyg küzüü, zöv ömnö xöl, čödriin bêlčir zêrgêês urt dêês, sur, arγamžaar uyaž togtoox üiliin nêr: to bind the neck and the right front leg of cattle with a rope of hair or a strap or a leather-string longer than a hobble», Kalm. *arcᵃl-* «das Pferd mit einem langen Stricke an einem Pfahl anbinden, tüdern» (Rams.), Ord. *arγamdži* (Most.), WM *arγamji*

χolbâ- «xolbox; tavan xušuu malyn küzüügêêr ols, dêêsêêr xolbož uyax üiliun nêr: to bind the neck of an animal with a hemprope or a rope of hair», *χolbādsā-* «to bind cattle by their necks to each other face to face», Kalm. *χolwā-* (Rams.), Ord. *χolbo-* (Most.), WM *qolba-, qolbo-*

tawâglâ- «tawaglax; têmêê, aduuny xölöös ni uyaž torgox üiliin nêr; urianxaid xoni, yamaa, üxêr tawaglaž uyax gêž xaayaa kêlêlcdêg: to bind a camel or a horse at the feet; the Uriankhais rarely use the word meaning 'to bind' the sheep, goats or horned cattle at the feet»

tušši- «tušix; tavan xušuu malyn zövxön ömnö xoër xöliig ols dêêsêêr tušiž togtoon torgox üiliin nêr: to bind only the front legs of the cattle with a hobble, hemp-rope or a rope of hair».

The Uriankhais designate the actions of binding different animals at the feet or at the head with different terms. They bind the camel at the nose, hobble a horse, put a ring into the horned cattle's nose and fasten or fetter a sheep or a goat. They call the ways of binding the different cattle by different names.

dörlödž uyâ-, dörēr uyâ- Uriankhais used to prick the gristle in the cow's or camel's nose and put a wooden peg into it. The peg and the lead in the horned cattle's nose are called *dör*. The peg in the camel's nose is the *būl'i-*. WM dörölekü

tšödörlö- «čödörlöx; aduuny ömnö xoër xöliig xoit zöv xöltêi (sur, dêêsêêr xiisên tšödör gêdêg nêg züiliin xêrêgsêl) xolbox üiliin nêr: to bind the horse's front legs to his right hind leg (tšödōr is the name of th hobble made of straps or ropes of hair)», U *tšüddür,* DzM *tšiddir* «entrave» (Kara). This is a verb of restricted use in the Uriankhai

subdialect. E.G *burū örəldi-* «to bind the left front leg and the right hind leg slantwise», *burū tšödörlö-* «to put the hobble on a distance-going horse's hind legs and his front right leg, turning the ropes to the left», *χəg ňi dardž tšödörlö-* «to fasten the hobble on in the following way: putting on the front right hobble chain you turn the front left chain twice to the left and put it to the right front leg».

ganūdâ- «têmêêg xêvtüülêêd ömnö xoër xöliig xüzüütêi ni xolbon darž uyax buyuu üxêr, xoni, yamaany zöv ömnö xöliig örgöž xüzüütei ni xolbon uyax üiliin nêr. Orčin cagiin oird ayalguuny olonxi salbar aman ayalguuny *ganu* gêdêg üg xêdên salbar utgatai: I. *γutlyn boom*, II. *Têmêênii xüzüünii xonxor xêsêg*, III *xötlöös nam, bogino, bogočoos öndör xötöl*; to chain a camel's front legs with his neck after having laid him or to fasten the neck of a horned cattle, sheep or goat to his raised front right leg. ganū has several side meanings in the present Oirat subdialects: I. shoe-lace, II. the pitted part of a cattle's neck, III. a low elevated ground smaller than a hillock.»

The names of the different binds and ropes constitude a remarkable set in the vocabulary of the Uriankhai subdialect.

alân uyâ- «üxüülž uyax; yumyg maš sain bêxlêž, boox üiliin zaasan üg: to bind sg too tight»; the Oirat *alân* is a particular, emphatic word which means «especially», similar to *masi, nigemüsün, bürimüsün*. E.g. *alân aw-* «to take for ever», alân yow- «to go once», *alân uyâ-* «to bind too tight». *bütūuyâ-* «bitüü uyax: to bind sg fast», WM *bitegüü*

güwêrkə uyâ- «xövörxii uyax; yumny uyaa zangilaag zangidalgüi tataž, tailaxad xyalbarxan aldarč tailagdax zangi biš uyaa: to bind with no knot on the strap; it loosens easily if you stretch it», WM *kübürkei*

taŋχâ uyâ- tassâ uyâ- «üxüülž uyax: to bind too tight». In the Uriankhai and other dialects *taŋχâ* has the meaning: «absolutely, for ever». E.G. *taŋâ düli* «stone deaf».

toptšō uyâ- «uyasan mêt dür üzüülž uyax: to show himself bound». The phrase *dömödž uyâ-* has a very similar meaning.

torγâ- «torgož uyax; togtož, torox, tödiixön uyax üiliin nêr: to stop and fasten cattle loosely». Kalm. *torγâ- torγâd uy-* «zusammennähen (ein Loch), befestigen (einen Knopf)» (Rams.).

tōmdi «toono tušix: to put a fisherman's knot on». Kalm. *tōmdᵇ-* «mit einen» Schlinge zubindeb, zuknoten» (Rams.).

tš īl uyâ- tš īlêrkē uyâ- «yumyg maš sain uyaž bêxlêx, üxüülž uyax: to bind sg too tight».

Uriankhais milk the sheep and goats from behind, embracing their head. Camels are milked half seated after having hobbled them, embracing their right leg. The wild mare is milked half seated, embracing her right hind leg after having fastened her upper lip with special straps and ropes called *tsorūdâ* and her right front leg bent by a bogâtš. Cow is milked from her side. The front legs of the wilder cows are hobbled when milked.

There are several words denoting the action of shearing animals. They shear the of sheep, goats, horned cattle, camels and horses, but they differentiate them in the following way:

kȫwörlö- for horses and horned cattle
zogdârlâ- for camels
kȫwörlö-kilg ăslă- for horses
aχârlâ- for shearing sheep in the autumn.

Ж.Цолоо, А.Мөнхцэцэг нарын эрдэм шинжилгээний хээрийн судалгааны замын зураг



1. Ж.Цолоо (1971 он)
   УБ - Ховд - Манхан - Мөнххайрхан - Манхан - Дуут - Ховд - УБ
2. Ж.Цолоо (1973 он)
   УБ - Өлгий - Сагсай - Цэнгэл - Буянт - Өлгий -УБ
3. А.Мөнхцэцэг (2007 оны 06 сар)
   УБ - Арвайхээр - Баянхонгор - Алтай - Дарви - Цэцэг - Мөст - Булган - Мөнххайрхан - Манхан - Ховд - Мянгад - Улиастай - Цэцэрлэг - Хархорин - УБ
4. А.Мөнхцэцэг (2007 оны 08 сар)
   УБ - Баянхонгор - Алтай - Манхан - Эрдэнэбүрэн - Өлгий - Цагааннуур - Улаангом - Цэцэрлэг - Хархорин - УБ

ТӨГСГӨЛИЙН ҮГ

Монгол улсын Ойрад монголын нэгэн гол ястан нь Алтайн урианхай юм. Алтайн урианхай нар эрт дээр цагаас монголын умард нутгийн баруун хойд хилээр нутаглаж байсан ойн гөрөөчин аймаг болно. Тэднийг X зууны үеэс Баруун хойд урианхай, XII- XIII зууны үеэс Ойн урианхай гэж сурвалж бичиг, судалгааны ном зохиолд тэмдэглэн бичдэг. Монгол угсааны урианхайг Халх урианхан, Алтай урианхай хэмээн хоёр ангилан хэлэлцэж болно.

Алтай урианхайчуудын хэл аялгуу , ахуй амьдрал, зан заншил нь Дөрвөд, өөлд захчны аялгуутай адил. Тэднийг өөлөг урианхай, өөлд урианхай, алтай урианхай гэж нэрлэдэг. Алтай урианхайчуудыг Манж нар 1755 онд эзэрхэн захирав. Тэр үед Урианхай нар 1000 гаруй өрхи айл, 4400 илүү хүн амтай байжээ Ховдын Манж сайдын хатуу захиргаанд орсон Урианхайчуудыг засаг захиргааны нэгжээр долоон хошуу болгон эмхлэн байгуулжээ. Энэ долоон хошуу урианхайн нэр бүхий дөрөв нь монгол-алтай урианхай, гурав нь түрэг угсааны урианхай юм . Тэднийг Манж амбан захирч Зүүн амбаны 4 хошуу, Баруун амбаны 3 хошуу гэжээ. Урианхай хошууг сум ард =цэрэг, сул хамжпага, лам гэж гурав ангилан хэлэлцдэг байжээ. XVIII - XIX зууны заагт урианхайн нэгэн хошуунд цэрэг =сум ард 586, сул хамжлага өрх 265, лам 5О орчим байсан гэнэ.

Урианхай долоон хошууд:

1. Зүүн амбаны хошуу нь Богд хаант Монгол улсын үеийн Итгэмжит гүний хошуу. Одоогийн Баян-Өлгий аймгийн Буянт, Алтай сум ,

2. Зүүнгарын Мээрэн зангийн хошуу нь Богд хаант Монгол улсын үеийн Зүтгэлт гүний хошуу. Одоогийн Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сум ,

3. Зүүнгарын Сүжигт гүний хошуу, Богд хаант Монгол улсын үеийн Эет гүний хошуу. Одоогийн Цэнгэл сум ,

4. Баруун амбаны хошуу нь Богд хаант Монгол улсын үеийн Дархан бэйсийн хошуу. Одоогийн Баян Өлгий аймгийн Булган , Дэлүүн сум , Ховд аймгийн Мөнххайрхан , Дуут сум,

5. Гомбо даагийн хошуу нь Богд хаант Монгол улсын үеийн Саруул

гүний хошуу. Одоогийн Баян Өлгий аймгийн Толбо, Дэлүүн, Ховд аймгийн Дуут сумын зарим нутаг,

6. Хар Соёны хошуу нь Богд хаант Монгол улсын үеийн Зоригт гүний хошуу. Одоогийн Баян Өлгий аймгийн Цэнгэл сум,

7. Баруун гар Шар даагийн хошуу нь Богд хаант Монгол улсын үеийн Ёст гүний хошуу. Одоогийн Цэнгэл сум.

Монгол урианхай хошууг 1936 он хүртэл Ховд хотод сууж байсан Засгийн газрын төлөөний сайд захирч байлаа. 1924, 1936, 1942, 1959 онуудад Ховд, Баян-Өлгий аймагт монгол урианхайн сумдыг тогтоов.

♦ Алтанцөгц сум 1924 онд байгуулсан нутаг нь 2 мян км, хүн ам нь 3 мян 1988 онд үүнээс хасаг 76% урианхай 24% Төв нь Цагаан түнгэ суурин Мал аж ахуй эрхлэн амьдардаг 70 гаруй мянган толгой малтай.

♦ Алтай сум 1959 онд байгуулсан нутаг нь 3 мян. км; 1988 оны байдлаар 3,7 мян хүнтэй; үүнээс хасаг 71% урианхай 29% Төв нь Чигэртэй суурин . 75 мянга орчим толгой малтай.

♦ Булган сум 1952 онд байгуулсан нутаг нь 5, 0 мян.км хүн ам нь 5.5: хасаг голлох боловч цөөн тоотой монгол урианхай бий. 91,8 мянган толгой малтай. Төв нь Жаргалант суурин.

♦ Толбо сум 1938 онд байгуулсан нутаг нь 3, 2 мян.км, хүн ам нь 4,1мян; хасаг, урианхай нар хамтран аж төрдөг. Мал аж ахуй эрхэлдэг. Төв нь Жаргалант суурин.

♦ Баян-Өлгий аймгийн Сагсай, Цэнгэл суманд хасаг, мончоого хэмээх Тува урианхай нартай айлссан цөөн тоотой монгол урианхай бий. Тэд монгол урианхай аялгуу бас хасаг хэл, тува хэлээр ярилцаж байлаа.

♦ Дуут сум Ховд аймагт байдаг. 1952 онд байгуулсан нутаг нь 1,5 мян км хүн ам нь 1,8 мян зөвхөн монгол урианхайчууд бөөнөөрөө нутаглаж мал аж ахуй эрхэлдэг. Төв нь Дуут суурин.

♦ Мөнххайрхан сум Ховд аймгийн Манхан Дуут сумаас салбарлан сүүлд байгуулсан монгол урианхайчууд бөөнөөрөө суурьшиж мал аж ахуй эрхэлэн амьдардаг. Монгол улсад суугаа Алтайн монгол урианхайчууд 25000 орчим болж өсөн үржжээ.

XX зууны эхээр Алтай урианхайгаас тасарсан 5000 шахам урианхайчууд БНХАУ-ын Шинжаан уйгурын өөртөө засах орны Алтай аймгийн Алтай хошуунд суудаг мэдээ бий.

1958, 1962, 1963, 1967, 1971, 1973, 1987, 1989, 1996, 2003 онуудад монгол урианхайн аялгуу, аманзохиол сурвалжлан судлах шинжилгээний анги албан томилолтоор Ж.Цолоогийн явж бүрдүүлсэн баялаг хэрэглэгдэхүүн ШУА-ийн Хэл зохиолын Хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөгт байна. Үүнээс 1971 оны өвөл Ховд аймгийн Мөнххайрхан сумын ард үлгэрч С.Наадгай (эмэгтэй), туульчин-анчин Б.Уртнасан, Б.Авирмэд, 1973 оны намар Баян-Өлгий аймгийн Сагсай сумын ард анчин-бөө, дархан О.Хуяг, анчин Х.Үлэмж нарын 5 урианхай хүнээс сонсож тэмдэглэсэн үндсэн хэрэглэгдэхүүн, 2007 онд А.Мөнхцэцэг нарын Ховд, Баян-Өлгий аймагт явсан хээрийн судалгааны материалд түшиглэн **Урианхайн өв соёл** гэдэг номоо бичив.

Урианхайн цагаан идээ, гэр ахуй, хувцас, малын тоног хэрэгсэл, ардын аман яруу найргийн баялаг өв соёлыг угсаатны судлал, хэлшинжлэлийн аргазүйгээр судлах нь нүүдэлчдийн соёлын түүхийн нэгэн бүрэлдэхүүн болох юм.

Тэмдэглэх нь

Цагаан шүхэрт судрын Аюуш гүүшийн орчуулга (Хавсралт1), Ойрадын Зая бандида Намхайжамцын орчуулга (Хавсралт 2), догшин Махагала бурхны хөрөг, энэрэнгүй сэтгэл асрал хайрлалыг үйл хэрэгтээ хүчдэлгүй хэрэгжүүлж чадах билиг ухаан хүч чадалтай гэгээрсэн бурхан Цагаан шүхэртэй эхийн бурхан хөргүүдийг энэ номд залсан юм. Учир нь "Амьдрал эхлэлгүй учраас анхны бурхан гэж байхгүй. *Бурхан* бол билиг билгүүн хийгээд энэрэл нигүүлсэхүй сэтгэлийн төгөлдөржилтөнд хүрсэн *хүн* юм. Түүхэн бурхныг Шагжамуни бурхан багшаар төлөөлүүлдэг.

Бурхан гэдэг нь сэтгэлээсээ зовлонгийн үндсэн шалтгааныг арилгаснаар айх аюул, зовлонгоос бүрэн гэтэлж гарсан *хүнийг* хэлнэ. Тэгээд ч намайг дан ганц хүндэлсэн учраас миний сургаалд шууд бүү орогтун. Дархан хүн алтыг худалдаж авахын өмнө сайтар шинжилдэг шиг нарийн шалгаж үзээрэй гэж Бурхан багш айлджээ. Нарийн шалгаж үзээрэй гэсэн гол үг нь сүсгийн орон зөв байна уу, үгүй юу гэдгийг тогтоогоорой гэсэн үг. Шашны нэр томъёоны хувьд сүсэг гэдэг үг хүн, хэн нэгэндээ учруулах төсөөлж болохуйц аймшиг

бүрийг зөвтгөсөн бохир нэр болж хувирсан юм. Хүн төрөлхтөнд бие сэтгэлээ хэрхэн засахад дэмждэг сүсгийн гурван орон нь Бурхан [=хүн], Бурханы ном [=дарма], Бурханы зарлиг [=чуулган] гурав" (Гэлэн лам Түвдэнжамц, Буддизм бидний амьдралын хэмнэлд УБ. 2004:920) юм гэсэн эрхэм сургаалаар энэ номоо өндөрлөж байна.

Нуман тамгатай

Хүмүн [=Бурхан] уриатай өөлөг Урианхай. (2008.)

НОМ ЗҮЙ

1. АГХД Цолоо, Ж. Арван гурван хүлгийн дуун. Монгол аманзохиолын чуулган 9 р дэвтэр. Редактор. Х.Сампилдэндэв. УБ., 1987.
2. Баатар, Ц. Гантулга, Ц. Алтайн Урианхайн гарал үгсаа, түүхийн асуудалд. Өлгий, 1990.
3. Бира, Ш. Их Монгол улсын түүх угсаатны зүйн зарим онцлог. УБ., 2006.
4. БНМАУ-йн угсаатны зүй. 1-3 боть. УБ., 1988-1999.
5. Буряд-Ород словарь. Бурятско-русский словарь составил К.М.Черемисов М., 1973.
6. Бүрнээ, Д. Энхтөр, Д. Монголын бурхан шашны түүхэн сурвалж. I. УБ., 2004.
7. Ганболд, Д. Монгол ман тахилгын судар үгийн урлагийн туурвил болох нь. УБ., 2006.
8. Гонгор, Д. Ховдын хураангуй түүх. УБ., 1964.
9. Грум-Гржимайло Западная Монголия и урянхайский край. т2 СПб. 1930.
10. Der Fuchs in Kultur Religion und Folklore Zentral und Ostasiens. Teil. I. 2001.
11. Муниев, Б. Калмыцко-Русский словарь. / Хальмг-Орс толь. М., 1977.
12. Kara, G. "Mongol Uriankhai riddles" AOH. XLI. 1987.
13. Лувсанбалдан, Х. Тод үсэг ба түүний дурсгалууд. Редактор. Ц. Дамдинсүрэн. УБ., 1975.
14. Монголын нэвтэрхий толь. 1, 2 боть. УБ., 2000.
15. Нямбуу, Х. Монголын угсаатны зүй. Удиртгал. УБ., 1992.
16. Норжин, Ж. Монгол хэлний толь. Хөххот. 1999.
17. Очир, А. Монголын Ойрдуудын түүхийн товчоон. УБ., 1993.
18. Пунцагдорж, Б. Алтай урианхайн аманзохиолын цоморлиг. Өлгий. 1990. Редактор. Ж. Цолоо.
19. Rams, Kw. Kalümvkisches Wörterbuch von G.J.Ramstedt. Helsinki. 1935.
20. Sarkozi, A. Calling the Soul of the Dead. 2004.
21. Цэвээн, Ж. Дархад, Хөвсгөл нуурын урианхай Алтай урианхай, Хамниган нарын гарал, үндэс байдлын тухай. УБ., 1934.
22. Цолоо, Ж. Арван гурван Алтайн ариун сангууд оршвой. УБ., 1999.
23. Coloo, J. "Notes on Mongol Uriankhai vocabulary" AOH XXX. 1976.
24. Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1956.

ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛБАР

1. SM. - Монголын нууц товчоо. - Igor de Rachewiltz. Index to the Secret History of the Mongols. Bloomington: Indiana, 1972.
2. Hy. - Хуа-й-й-юү толь хэмээх хятад-монгол толь.
   - Lewicki, M. La langue mongole des transcriptions chinoises du XIV e siècle. Le Houayi yi-yu de 1389. Wroclaw, 1949.
3. IM. - Ибн-Муханы толинд орсон монгол Үгс.
   - Н. Н. Поппе Монгольский словарь.
4. Ist. - Истанбулын монгол толь.
   - Ligeti, L. "Un vocabulaire mongol d'Istanboul" AOH (1962).
5. L. - Лейдений гар бичмэл толь.
   - Poppe, N. Das Mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift 1927, 1928.
6. Mu. - Мукаддимат ал-Адаб толийн монгол хадмал орчуулга.
   - Поппе, Н. Н. Монгольский словарь. Мукаддимат ал-Адаб г. I - II, М - Л, 1938.
7. Zhiyuan yiyu.
   - Kara, G. "Zhiyuan yiyu Index alphabetiques des mots Mongols" AOH (1990).
8. Kal. R.Kwb.
   - Kalmückisches Wörterbuch. von Ramstedt, G.J. Helsinki, 1976.
9. Халь. Б.Мун. - Хальмаг хэл.,
   - Кальмыцко-русский словарь / хальмг-орс толь. Под редакцией Муниева, Б. Д. Москва. 1977.
10. Ord. Most. – Mostaert, A. Dictionnarie Ordos. I. II. III. Peking, 1941-1944.
11. О.Кова. – Ковалевский, О. Монгольско-Русско-Французский словарь. Казань, 1844-1849.
12. Бур. К.Чере. - Черемисов, К. И. Бурят - Монгольско - Русский словарь. Москва, 1951. Бур. Буряд - монгол.
13. Монбур. Г.Ган. - Монгол улсын буриад- монголчууд.
   - Гантогтох, Г. БНМАУ-дахь Монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. III. Буриад аялгуу. Улаанбаатар, 1988.
      Aga. - Аган буриадын аялгуу.
      Khori. -Хори буриадын аялгуу.
      Bar.- Барга буриадын аялгуу
      Tunk. -Тункин буриадын аялгуу

Tson. - Цонгоол буриадын аялгуу
San. - Санага буриадын аялгуу
Kham. - Хамниганы аялгуу

14. Ж.Цол.(1988). - Цолоо, Ж. БНМАУ-дахь Монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. II. Ойрад аялгуу. A-W. Улаанбаатар, 1988.
Oir. - Монгол хэлний Ойрад аялгуу
Ba. - Баядын аялгуу.
Dö,D. - Дөрвөдийн аялгуу.
T. - Торгуудын аялгуу.
U. Ур.аял.- Урианхайн аялгуу.
Ö. - Өөлдийн аялгуу.
Dž, Dz - Захчины аялгуу.
DzM. - Манхан сумын захчин.
Kho. - Хотон аялгуу.
M. - Мянгад аялгуу.

15. G.Kara. - Kara, G. "Notes sur les dialectes oirat de la Mongolie Occidentale" AOH. 1959.
16. Kha. - Халхын аялгуу - Амаржаргал, Б. БНМАУ-дахь Монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. I. Халх аялгуу. a-w. Улаанбаатар, 1988.
Дар. - Дархад аялгуу.
Дари. - Дариганга аялгуу.

17. Oyir. - Ойрад бичгийн хэл (=тод-монгол бичгийн дурсгал). Materials for an Oirat- mongolian . to English citation dictionary. Krueger, John. R. I (1978), II (1984).
- Лувсанбалдан, Х. Тод үсэг ба түүний дурсгалууд. Улаанбаатар, 1975.
18. Я. Цэ. - Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар, 1966.
19. Ж. Норжин нар. - Mongol kelen-ü toli. Хөххот, 1999.
20. О.Сэццогт. - Sečenčoγtu. Mongγol üges-ün i-jaγur-un toli. Begejin, 1981.
21. О.Сүх. Сүхбаатар, О. Монгол хэлний харь үгийн толь. Улаанбаатар, 1997. I хэв.
22. Голс. - Голстунский, К. Монголо - Русский словарь. I. II. III. Петербург, 1894-1898.
23. Сравни. сло. 1977. - Сравнительная словарь тунгусо - маньжурских языков. Ленинград, I (1975), II (1977).

24. Д.Тө.

- Төмөртогоо, Д. Монгол хэлний түүхэн хэлзүй. 1. Улаанбаатар, 1992.
- Төмөртогоо, Д. Монгол хэл шинжлэлийн онол түүхийн асуудлууд. Улаанбаатар, 2002.

25. Ш.Лув.

- Лувсанвандан, Ш. "Дөрвөлжин, тод үсгийн зөв бичих дүрэмд монгол хэлний урт эгшгийг хэрхэн тэмдэглэсэн нь" ХЗ. 1969. (VII)

26. Д.Цэрэн.

- Цэрэнсодном, Д. Монголын бурхан шашны уран зохиол. Улаанбаатар, 1987.

27. Ч.Да.

- Далай, Ч. Ойрад Монголын түүх. Тэргүүн боть. Улаанбаатар, 2002.

28. Сонг.бич.хэл. - Сонгодог монгол бичгийн хэл

Орч.цаг.бич.хэл. - Орчин цагийн монгол бичгийн хэл

29. AF. - Asiatische Forschungen, Wiesbaden
30. AOH. - Acta Orientalia hungarica, Budapest
31. ХЗ - Хэл зохиол судлал

3.

Зураг 1. Урианхай эмээл
Зураг 2. Урианхайн анчдын үүшүүр тоглоом
Зураг 3. "Арван гурван атаа тэнгэр
Хорин гурван хаан тэнгэр" хэмээн сийлсэн цацал

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи
Хэлзохиолын хүрээлэн

УРИАНХАЙН ӨВ СОЁЛ

Алтайн урианхайн угсаатны судлал- хэлшинжлэлийн цоморлиг (тайлан)

Ойрад судлалын чуулган - VI

Хэвлэлд бэлтгэсэн Ж.Цолоо
А.Мөнхцэцэг

English foreword: Gaby Bamana

УЛААНБААТАР. 2008



ADMON
PRINTING, PUBLISHING & MORE ...
Tel: 976-329253, 327251
www.admon.mn

ISBN 978-99929-0-525-5
9 789992 905258 >